

ОРХОН АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/д	ЗОРИЛТ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ ХШҮ (хувь)
							Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
НЭГ.ҮНДСЭНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ											
Зорилго 1. Эх хэл, түүх соёлыг дээдэлсэн, эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн “Эрдэнэтийн иргэн”-ийг төлөвшүүлнэ.											
Зорилт 1.1. Эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн, хотын соёлыг тээгч, зөв хүн болгон төлөвших үйл ажиллагааг иргэдийн дунд олон талт хэлбэрээр зохион байгуулна.											
1	1.1.1.Аймгийн нутаг дэвсгэрт түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, сурталчлан өвлүүлнэ.	2020-2025	НБХ, СУГ	Орон нутгийн төсөв	12.0	11 өрх	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалдаг өрхийн тоог 20 болгоно	10.0	Орон нутгийн төсөв 24.0	2021 онд аймгийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хамгаалж буй 12 айл өрхтэй гэрээг шинэчлэн байгуулж, гэрээгээр хамгаалах бүсчлэлийг шинэчилсэн бөгөөд 2022 оноос гэрээгээр хамгаалах өрхүүдийн тоог нэмэгдүүлж Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 20 өрхтэй гэрээ байгуулж нийт 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж 2022-2025 онд орон нутгийн төсвөөс өрхүүдийн урамшуулалд 24.0 сая зарцуулсан байна. Эдгээр түүх соёлын дурсгалт газруудыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж оруулах ажлыг зохион байгуулж байна. Мөн аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 19/02 дугаар тогтоолоор түүх, соёлын үл хөдлөх дурсгалт 8 газрын 162 дурсгалыг Жаргалант сумын хамгаалалтад авсан.	100
2	1.1.2.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, орон нутаг судлалыг шингээсэн хичээлийг орон нутгийн онцлогтой уялдуулан сургууль, цэцэрлэг бүр өөр өөрийн хөгжлийн хөтөлбөрөөр зохион байгуулна.	2020-2025	НБХ, БШУГ	-	-	-	Сургууль, цэцэрлэгт эх орон, өв уламжлал, ёс заншлыг агуулсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	-	-	ЕБС-ийн суралцагчдад Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлалыг сурталчлах, төрөлх хот, орон нутгаараа бахархах бахархлыг төрүүлэх зорилгоор "Түүхэн тэмдэглэлт өдрүүд" сургалтын хөтөлбөрийг боловсруулж, жил бүр хэрэгжилтийг ханган ажилласан. Уг хөтөлбөр нь "Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр", "Монгол бахархлын өдөр", "Эрдэнэт хотын өдөр", "Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр" гэсэн 4 дэд хэсгээс бүрдсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд явагдсан хичээл сургалтын үйл ажиллагаанд жил бүр 25000 орчим сурагч хамрагдсан. Мөн сурагчдыг байгаль орчноо хамгаалах, багаар ажиллах чадварт сургаж тогтвортой хөгжлийн боловсрол олгох, хүүхдийн сонирхол, авьяасыг нээн илрүүлэх зорилгоор "Би Монгол хүн" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж 5-р ангид "Миний Эрдэнэт хот", 6-р ангид "Миний хот - Бидний түүх", 7-р ангид "Бидний өв соёл- Миний хот", 8-р ангид "Эко аялал - Интеграци хичээл", 9-р ангид "Бидний өв соёл - Би монгол хүн", 10-р ангид "Мэргэжил сонголт", 11-р ангид "Эх оронч аялал- Орон нутаг судлал" гэсэн 7 агуулгын хүрээнд хэрэгжүүллээ. Мөн бага боловсролын 4, 5-р ангийн суралцагчдад "Иргэний ёс зүйн боловсрол", "Хүн орчин", "Хүн байгаль" зэрэг олгосон мэдлэгийг хэрэглээ болгох зорилгоор "Малчны хотонд" эко аялал, Эрдэнэт хоттой танилцах "Явган аялал" арга хэмжээнүүдийг жил бүр зохион байгуулж хэрэгжүүлж 6000 гаруй сурагч хамрагдсан байна.Тайлант хугацаанд 3-12-р ангийн суралцагчдын дунд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа, орон	100

										нутагт байгаа хөшөө дурсгалуудтай танилцах, судлах, экскурс хичээлийг тогтмол зохион байгуулж хэвшсэн.	
3	1.1.3.Монгол үндэсний соёлын онцлогийг агуулсан үндэсний сор брэнд бүтээлүүд, шинэлэг уран бүтээлийн төсөл, санал, санаачилгыг дэмжиж, Эрдэнэтийн иргэдийн хүртээл болгоно.	2020-2025	НБХ, СУГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Улсын хэмжээний 2 шилдэг уран бүтээлийг иргэдийн хүртээл болгоно.	20.0	Орон нутгийн төсөв 110.0	2022 онд УДЭТ-ын уран бүтээл "Анна Каренина" жүжгийг, 2023 онд "Соёлыг түгээе" аяны хүрээнд Монгол улсын филармоний Морин хуурын чуулгын шилдэг уран бүтээлийн 3 удаагийн тоглолтыг, 2024 онд Монгол улсын филармонийн "Баян Монгол" чуулгын шилдэг уран бүтээлийн 3 удаагийн тоглолт, 2025 онд Монгол улсын филармонийн Симфони оркестрын "Сонгодог үдэш" 2 удаагийн тоглолтыг орон нутгийн иргэдийн хүртээл болгосон.	100
4	1.1.4"Бид-Эрдэнэтчүүд" уриа дор соёл, спортын төрөл бүрийн арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулна.	2020-2025	НБХ, СУГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Жил бүр 1 арга хэмжээ зохион байгуулсан байна.	40.0	Орон нутгийн төсөв 286.0	2022 онд аймгийн Соёл, урлагийн газар, Орхон аймгийн Бүжгийн холбоод хамтран "Бүжин наадъя" бүжгийн фестиваль. Орхон, Булган аймгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд "Хангинахын шугуйн шагайн тойром" соёл, спортын үйл ажиллагаа, 2023 онд "Бүргэдийн баяр-2023" арга хэмжээ, "Зэс фестиваль", 2024 онд "Луу жилийн мөсөн шагайн хишиг харваа" тэмцээн, аймгийн Биеийн тамир спортын газраас "Эрдэнэт мөнгөн өвөл" спортын наадам, "Эрдэнэтийн бал" цэнгээнт бүжгийн наадам, 2025 онд "Зэс фестиваль", "Соёлынхон" спортын тэмцээн зэрэг орон нутгийн онцлог бүхий соёл, урлаг, спортын арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Иргэд, хүүхэд залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа хандлага бүхий ухамсарт зан үйл, соёлд суралцуулах, иргэдийн амьдралд хотын соёл-хамтын соёлын хэм хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор "Соёлыг түгээе" аяныг 2021-2025 онуудад 5 удаа зохион байгуулсан. Аяны хүрээнд жил бүр төвийн болон орон нутгийн соёл, урлагийн байгууллага, иргэд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран боловсрол, эрүүл мэнд, спорт, гэр бүл, хүүхэд залуучууд, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ зэрэг нийгмийн томоохон салбаруудад болон төрийн албан хаагчид, иргэд хүүхэд, залуучуудад чиглэсэн сургалт, лекц, соёл, нөлөөллийн олон талт арга хэмжээг төлөвлөн зохион байгууллаа	100
Зорилт 1.2. Байгууллага, иргэдийн дунд үндэсний монгол хэл, бичгээ эзэмших, ашиглах, сурталчлах ажлыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулна:											
5	1.2.1.Монгол хэл, бичгийн боловсролыг сурагчдад эзэмшүүлэх арга технологи, орчин бүрдүүлэлтийг сайжруулан, сургалтын чанарыг дээшлүүлнэ.	2020-2025	НБХ, БШУГ	-	-	Монгол хэл, бичгийн чанарын үнэлгээний дунджийг ахиулна /улсын дундаж 45.8/	52 хувь	-	-	Тайлант хугацаанд эх хэлний сургалтын чанарыг сайжруулах багшлах боловсон хүчийг чадвэржуулах чиглэлээр багш, сурагчдад чиглэсэн олон талт үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулсан. Тухайлбал монгол хэл, уран зохиолын 113 багшийг сурагчдын унших, бичих, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх давуу чадамж, багшийн арга зүй, хэрэгцээнд нь тулгуурлан 14 мэргэжлийн бүлэгт хуваарилан, 9 судалгаат хичээл, 24 хөгжүүлэх сургалт үйл ажиллагаа, 17 үзүүлэх хичээлийг зохион байгуулж багш нарын мэргэжил арга зүйг хөгжүүлсэн. Мөн багшийн арга зүй, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор давтан сурах, туршлага солилцох, идэвхжүүлэх зорилгоор1-5 жил ажиллаж байгаа багш нарын онолын мэдлэгийг дээшлүүлэх 8 удаагийн сургалт, сурагч төвтэй сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх арга зүйн 5 удаагийн сургалт, туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх уулзалт, 9 удаагийн хэлэлцүүлгүүдийг тус зохион	100

										байгуулсан байна. Эдгээр ажлын үр дүнд 2025 оны байдлаар Монгол хэлний хичээлийн 9,12 дугаар улсын шалгалтын аймгийн дундаж 80.1%, анги дэвших шалгалтын дундаж 74.2 %-тай байгаа ба улсын болон анги дэвших шалгалтын гүйцэтгэлийн дундаж 77.1 хувь болж өмнөх оноос 4.75 функтээр өссөн байна. Монгол хэлний хичээлийн анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор анги нийтийн чанарын уралдааныг жил бүр зохион байгуулж байна. 2025 онд Монгол хэлний анги нийтийн чанарын уралдааныг Боловсролын газар, ерөнхий боловсролын 3 дугаар сургуулиуд хамтран 2 үе шаттай зохион байгуулж, 20 сургуулийн 6-12 дугаар ангийн давхардсан тоогоор 26157 сурагчид оролцсон. Уралдааны I шатны гүйцэтгэлийн дундаж 39.4%, II шатны гүйцэтгэлийн дундаж 48.3%, харьцуулахад 8.9%-аар ахисан байна. Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ”-ний 9 дүгээр ангийн сурагчдын монгол хэлний хичээлийн бичгийн шалгалтын дундаж 2024 онд 49% байсан бол 2025 онд 54.08% буюу 5.08%-иар ахисан байна. 2025 онд Монгол хэл, бичгийн шалгалтад 10-р ангийн 1071 сурагч хамрагдаж хэмжээст онооны аймгийн дундаж 515.2, 11 дүгээр ангийн 1534 сурагч хамрагдаж, хэмжээст онооны дундаж 443.6, 12 дугаар ангийн 1472 сурагч хамрагдаж хэмжээст онооны дундаж 543.9 байна. ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчдын дундаж оноог өмнөх онтой харьцуулахад босго оноо аваагүй сурагчийн тоо 50%-аар буурсан байна.	
6	1.2.2. Монгол хэл, бичгийг нийтийн албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх “Эх хэл-Эрдэнэт” төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2020-2025	НБХ, БШУГ	Орон нутгийн төсөв	78.4	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 50 хувьд хүргэнэ.	20.0	Орон нутгийн төсөв 74.1	Аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор “Эх хэл-Эрдэнэт” хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 2021 онд 84.6 хувь, 2022 онд 82.3 хувь, 2023 онд 85.4 хувь, 2024 онд 90 хувьтай тус тус үнэлэгдсэн байна. 2021-2024 онд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүнд төрийн байгууллагуудын 90 хувь нь, хувийн хэвшлийн байгууллагуудын 15 хувь нь хос бичгийн хаягтай болж, төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудас 100 хувь хос бичигт шилжсэн байна. Мөн 2021-2024 онд монгол бичгийн анхан, дунд шатны сургалтуудад давхардсан тоогоор нийт 39 байгууллагын 1287 албан хаагчийг хамруулж, үндэсний бичгийн анхан, дунд шатны мэдлэг олгосон байна. Үндэсний статистикийн хорооноос 2021 онд явуулсан “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-нд хамрагдсан төрийн албан хаагчдын 23 хувь нь “Үндэсний бичгийн мэдлэггүй” гэж хариулж байсан бол 2024 онд 20.4 хувь болж 2,6 хувиар буурч, “Үндэсний бичгийн анхан шатны мэдлэгтэй” гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 25.8 хувь байсан бол 2024 онд 31.1 болж 5.3 хувиар, “Үндэсний бичгийн дунд шатны мэдлэгтэй” гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 31.3 хувь байсан бол 2024 онд 33.3 хувь болж 2 хувиар, үндэсний бичгийн мэдлэг “Маш сайн”, “Сайн” гэж хариулсан албан хаагчийн хувь 2021 онд 9.9 хувь байсан бол 2024 онд 11.7 хувь болж 1.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус судалгаанд 2024 онд хамрагдсан 4652 төрийн албан хаагчийн 64.4 хувь нь буюу 2995 албан хаагч үндэсний бичгийн анхан, дунд шатны мэдлэгийг эзэмшсэн гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 116 төрийн байгууллагын хэвлэмэл хуудсыг хос бичигт шилжүүлж албан хэрэгт ашиглах боломжийг бүрдүүлсэн. ЕБС-ийн сургуулийн Монгол хэлний хичээлийн масс сургалтын чанар 2020 онд 45.3	100

хувь байсан бол 2021 онд 47.3 хувь, 2022 онд 53.4 хувь, 2023 онд 53.6 хувь, 2024 онд 57.4 хувь болж өссөн байна.

Зорилт 1.3. Иргэд, хүүхэд, залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа, хандлага бүхий ухамсарт зан үйлд суралцуулна:

7	1.3.1.Нийгэмд ёс зүйг дээдлэх, харилцаа хандлагад эерэг өөрчлөлт гаргах олон талт ажил үйлсийг дэмжинэ.	2020-2025	НБХ, СУГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Жилд 2-с доошгүй эерэг өөрчлөлт гаргах ажлыг дэмжсэн байна.	550.0	Орон нутгийн төсөв 441.9	Иргэд, хүүхэд залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа хандлага бүхий ухамсарт зан үйл, соёлд суралцуулах, иргэдийн амьдралд хотын соёл-хамтын соёлын хэм хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор "Соёлыг түгээе" аяныг 2021-2025 онуудад 5 удаа зохион байгуулсан. Аяны хүрээнд жил бүр төвийн болон орон нутгийн соёл, урлагийн байгууллага, иргэд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран боловсрол, эрүүл мэнд, спорт, гэр бүл, хүүхэд залуучууд, нийтийн тээвэр, тохижилт үйлчилгээ зэрэг нийгмийн томоохон салбаруудад болон төрийн байгууллага, төрийн албан хаагчид, иргэд хүүхэд, залуучуудад чиглэсэн сургалт, лекц, соёл, нөлөөллийн олон талт арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийгмийн эерэг хандлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжсэн байна.	100
8	1.3.2.Монгол хүний амин /давуу/ чанарыг эрхэмлэж, үндэсний ёс заншил, уламжлалыг түгээн дэлгэрүүлнэ.	2020-2025	НБХ, СУГ	-	-	1	Хэрэгжүүлсэн зорилготой үйл ажиллагааны тоо 15	-	-	Аймгийн СУАЖЗГ-аас "Угийн бичиг-Удмын түүх" сургалтыг нийт 10 удаа зохион байгуулж "Эрдэнэт үйлдвэр"ТӨҮГ-ын "Эрдэнэт" цогцолбор дээд сургууль болон лицей сургуулийн 380 оюутан, сурагчид хамрагдаж, угийн бичиг хөтлөх арга зүй, чадварт суралцсан. Уламжлалт аргаар угийн бичиг хөтөлсөн 5 иргэнийг соёлын өвийн бүртгэлд бүртгэж, сурталчилсан. Мөн Эрдэнэ багийн иргэн н.Пүрэвийн хөтөлсөн 2 төрлийн угийн бичиг, угийн шастирт тайлбар хийлгүүлж цахим хичээл бэлтгэн нийтийн хүртээл болгосон. Аймгийн Музейгээс гар урлал, үндэсний уламжлалт тоглоомын чиглэлээр 14 удаагийн сургалт зохион байгуулж, ЕБС-ийн 512 сурагчийг хамруулсан. "Эгшиглэн" соёлын төвөөс "Билигт өв уламжлал" ТББ-тай хамтран Баян-Өндөр, Жаргалант сумын 25 багийн 456 иргэнд "Угийн бичиг хөтлөх нь" сургалтыг зохион байгуулж, угийн бичиг хөтлөх арга зүйг түгээн дэлгэрүүлсэн байна. Мөн тус төвөөс "Эрдэнэт" цогцолбор дээд сургуулийн харьяа ахлах сургуулийн 35 сурагчид "Амьдрал зохиохоосоо өмнө" сургалтыг хийж цус ойртолтын талаар ойлголт болон угийн бичиг хөтлөх, удмын зураглал хийх мэдлэг, чадварыг олгосон байна. 2021-2025 онд үндэсний ёс заншил, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр аймгийн СУАЖЗГ-аас 15 үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 20335 иргэнийг хамруулсан байна.	100
9	1.3.3.Иргэдийн аж төрөх байдал "Хотын соёл-Хамтын соёл" хэм хэмжээг төлөвшүүлнэ.	2020-2025	НБХ, СУГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Эерэг, өөрчлөлт гаргах олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тогтмолжуулсан байна.	140.0	Орон нутгийн төсөв 441.9	Иргэд, хүүхэд залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа хандлага бүхий ухамсарт зан үйл, соёлд суралцуулах, иргэдийн амьдралд хотын соёл-хамтын соёлын хэм хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор "Соёлыг түгээе" аяныг 2021-2025 онуудад 5 удаа зохион байгуулсан. Тус аян нь 2021 онд "Хотын соёл-Хамтын соёл", 2022 онд "Хувийн соёл-Байгууллагын соёл-Хотын соёл", 2023 онд "Эерэг хандлага-Эрдэнэтээс", 2024 онд "Хандлагаа өөрчилъё", 2025 онд "Зөв хандлага –Хотын соёл" уриатайгаар тус тус явагдсан бөгөөд жил бүр аяныг зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, түүний дагуу нийгэмд чиглэсэн 20-30 үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан. Аяны хүрээнд "Хотын соёл-Хамтын соёл"-ын энгийн хэм хэмжээний талаарх ойлголтыг нөлөөллийн	100

										олон талт үйл ажиллагаагаар иргэд, олон нийтэд хүргэсэн нь аяны гол үр дүн юм.	
ХОЁР. ЭРҮҮЛ, БҮТЭЭЛЧ, ХӨГЖИХ ТЭМҮҮЛЭЛТЭЙ-ЭРДЭНЭТ ХҮН											
Зорилго 2.Гэр бүлд ээлтэй, хүний хөгжилд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, оюунлаг, ёс суртахуунтай, байнгын орлоготой, дэлхийд үнэлэгдэх “Эрдэнэтийн иргэн” төлөвшүүлнэ.											
Зорилт 2.1. Боловсролын үйлчилгээг тэгш, чанартай зохион байгуулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ:											
10	2.1.1. 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.	2020-2025	НБХ, БШУГ	-	-	91.1%	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 95%	-	-	2021-2024 онд 4, 11, 18 дугаар цэцэрлэгийн өргөтгөл, Баянбулаг багийн 27 дугаар цэцэрлэг, Яргуйт багийн 28 дугаар цэцэрлэг, Чандмань багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгуудыг тус тус ашиглалтад оруулсан 2025 оны жилийн эцсийн байдлаар СӨБ-ын хамран сургалтын 98.9 хувьд хүрсэн. Сүүлийн 5 жилд 5 настай хүүхдийг жил бүр 100% хамруулсан байна.	100
11	2.1.2.“Багш” төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, мэргэжлийн үр чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг хангана.	2020-2025	НБХ, БШУГ	Орон нутгийн төсөв	548.0	92.1%	Багш нарын мэргэжлийн үр чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг хангах ажлуудыг хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.	160.0	Орон нутгийн төсөв 460.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар тогтоолоор “Багш” хөтөлбөрийг 3 зорилт 17 арга хэмжээ, 20 үйл ажиллагаатай баталж, багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, анги удирдсан багшийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, багш, ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, Математик, Монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг олон шинэлэг арга хэмжээг тусган хэрэгжүүлээ. Хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт 88.2, 2022 оны хэрэгжилт 93.3, 2023 оны хэрэгжилт 94.7, 2024 онд 97.8 хувьтай тус тус үнэлэгдсэн. Хөтөлбөрийн хүрээнд явагдсан ЭЭШ-ын чанарыг дээшлүүлэх олон талт арга хэмжээний үр дүнд хэмжээст онооны аймгийн дундаж 2020 онд 507 байсан бол 2021 онд 547.55, 2022 онд 550.33, 2023 онд 553.0, 540.8 болж тогтмол өссөн байна. Багш, ажилтнуудад чиглэсэн төрөл бүрийн сургалт үйл ажиллагааны үр дүнд сургууль, цэцэрлэгүүдийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь дээшилсэн байна. Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулал авч буй ЕБС, СӨББ-ын багшийн тоо 2022 онд 536 байсан бол 2024 онд 639, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дундаж үнэлгээ 2022 онд 88.02 хувь байсан бол 2024 онд 88.9 хувь, ЕБС-иудын үнэлгээ 2022 онд 74.3 хувь байсан бол 2024 онд 75.9 хувь болж тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн сургалтын чанарын үзүүлэлт 2020 онд 80.5 хувь байсан бол 2021 онд 89%, 2022 онд 82.6%, 2023 онд 85.2%, 2024 онд 85.4% хувь болж өссөн байна.	100
12	2.1.3.“Эко сургууль”, “Ногоон цэцэрлэг” аян хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүхий сургууль, цэцэрлэгийн барилга барина.	2020-2025	НБХ, БШУГ	Улсын төсөв Орон нутгийн төсөв	7350.0 2500.0	47	3 сургууль, 3 цэцэрлэг ашиглалтад орно.	7350.0 2500.0	Улсын төсөв 53400.0 Орон нутгийн төсөв 3050.0	БОАЖЯ, БШУЯ, Швейцарын хөгжлийн агентлаг, Байгаль орчин сургалт мэдээллийн төвтэй хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөл аймгийн хэмжээнд 4 сургуульд үргэлжлэн хэрэгжиж байна. Үүнд: 4-р сургууль “Ардын ёс заншил” төсөл; 5-р сургууль “Дотоод агаарын чанар” төсөл; 14-р сургууль “Цахилгааны хэмнэлт” төсөл; 15-р сургууль “Байгалийн ухаан” төсөл тус тус хэрэгжиж байна. Дээрх 4 сургуулиас олон улсын “Эко сургууль”-ийн алтан гэрэгэ, ногоон тугийн болзлыг 14, 15-р сургуулиуд, хүрэл гэрэгэний болзлыг 4, 5-р сургуулиуд тус тус хангасан. Тус 4 сургуульд төслийн үргэлжлэх хугацааг 1 жилээр сунгаж, 3 дэд төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг 3 дэд төслийг хэрэгжүүлснээр сургууль тус бүрд 15.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, суралцагчдад экологийн боловсрол	90

									<p>олгох үйл ажиллагаа тогтвортой үргэлжилнэ.</p> <p>2020-2025 оны хооронд олон улсын "Эко сургууль, цэцэрлэг"-хөтөлбөрт 11,22,24, Бялзуухай цэцэрлэгүүд, 13,20, Орхон-Эмлати сургуулиуд 1-2-р шатны сургалтад хамрагдаж батламж авсан. Энэхүү сургалтад цэцэрлэг сургуулийн 180 багш, удирдах ажилтан, багш, сурагчид хамрагдсан.</p> <p>Энэхүү хөтөлбөрт хамрагдсан цэцэрлэг, сургуулиуд байгаль, нийгэмд ээлтэй сургуулийн орчныг бүрдүүлж, суралцагчдад экологийн боловсрол олгох жишиг сургалтын хөтөлбөртэй болж хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд "Тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага", олон улсын "Эко сургууль цэцэрлэг" хөтөлбөрт 7 сургууль, 7 цэцэрлэг, 1 политехник коллеж, нийт 15 байгууллага хамрагдаж батламж авсан. "Тогтвортой хөгжлийн боловсрол- II" төсөлд 4,5,14,15-р сургуулиуд хамрагдаж, бусад сургуулиуд болон улсын хэмжээнд арга туршлагаа түгээн дэлгэрүүлж, өвлийн хүлэмж, ёс заншлын өргөө, дотоод агаарын чанарыг сайжруулах тоног төхөөрөмж, эдийн засгийн хэмнэлттэй гэрэлтүүлэгтэй болсон.</p> <p>2021-2025 онд 4, 11, 18 дугаар цэцэрлэгийн өргөтгөл, Баянбулаг багийн 27 дугаар цэцэрлэг, Яргуйт багийн 28 дугаар цэцэрлэгийн барилга, Чандмань багийн 150 хүүхдийн цэцэрлэг, 1 дүгээр сургуулийн өргөтгөл, "Ирээдүйн одод" сургуулийн спорт заалны өргөтгөл, "Уран эгшиг" сургуулийн өргөтгөл, 320 хүүхдийн суудалтай 8-р сургуулийн өргөтгөлийн барилга, Политехник коллежийн хичээлийн байрыг тус тус ашиглалтад оруулсан</p>	
13	<p>2.1.4.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, инженерийн боловсрол олгох суурь үйл ажиллагааг "Эрдэнэт цогцолбор" сургууль, орон нутгийн их, дээд сургуулийг түшиглэн зохион байгуулж өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх, орос сургууль, цэцэрлэгийг гадаад хэлний сургалттай жишиг сургууль, цэцэрлэгийн хэмжээнд хүргэх, бусад сургуулийг байгалийн ухаан, математик, гадаад хэл, спорт, урлагийн боловсрол олгох чиглэлээр төрөлжүүлж</p>	2020-2025	НБХ, БШУГ	Орон нутгийн төсөв	790.0	-	<p>Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр сургалт болон бусад үйл ажиллагааг зохион байгуулсан байна.</p>	<p>Орон нутгийн төсөв 591.0</p>	<p>Аймгийн хэмжээнд 6-9-р ангийн сурагчдад ирээдүйн мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, 10-12-р ангийн сурагчдад сонгох мэргэжлийн дагуу сургалтын хөтөлбөрийг судлах, мэргэжилд өөрийгөө бэлтгэх, их дээд сургуульд элсэх бэлтгэлийг хангах зорилгоор ЕБС-ийн сурагчдад зориулсан "Мэргэжил сонгох хөтөлбөр"-ийг боловсруулж 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэ ажлын хүрээнд 2021-2024 онуудад ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдад болон их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудад мэргэжлээ хэрхэн сонгох болон гадаадын 7 улсын Засгийн газрын тэтгэлэг, түүнд хэрхэн хамрагдах талаар зөвлөгөө мэдээлэл өгөх "Тэтгэлэг залуус бидний амьдралд- цахим лекц"-ийг 1 удаа, БШУГ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулиуд хамтран "Мэргэжил сурталчлах аялал"-ыг 2 удаа зохион байгуулж 761 сурагч, Төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонголтыг оновчтой хийлгэх зорилгоор "Нээлттэй хаалганы өдөр"-ийг орон нутгийн болон Улаанбаатар хотын их дээд сургуулиудтай хамтран 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 6400 гаруй иргэд, төгсөгч, сурагчид хамрагдаж зөвлөгөө мэдээлэл авсан байна. Мөн багш, ажилтнуудад чиглэсэн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх 3 төрлийн сургалтад 421 анги удирдсан багш, 111 удирдах ажилтан тус тус хамрагдсан.</p> <p>Тайлант хугацаанд мэргэжил сонголтын танхимын 22 сургалтад 2709 суралцагч, "Оюу толгой" ХХК, аймгийн Прокурорын газар, бизнесийн байгууллагуудтай хамтарсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 1177 суралцагч хамрууллаа. Мөн "Шинэ үеийн сонголт-хүүхдээ хэрхэн дэмжих вэ?" ахлах ангийн хүүхэдтэй эцэг, эхийн сургалтад 110 эцэг, эх, асран хамгаалагч, 8, 9 дүгээр ангийн анги удирдсан 74 багшид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг сурагчдад хэрхэн хүргэж ажиллах талаарх чиглүүлэх сургалтыг тус тус зохион байгуулсан байна.</p>	100

	хөгжүүлнэ.									<p>Мөн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр "Эрүүл хүүхэд", спорт, техник технологи, урлагийн боловсрол олгох чиглэлээр "Хүүхдийн хөгжил", хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр "Тэгш боломж" төслүүдийг 2022 оноос хэрэгжүүлж, төслүүдийн хүрээнд багш хичээл заах, дугуйлан секц, клуб хичээллүүлэх багш нарыг Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаа, сургалтуудад үе шаттайгаар хамруулсан.</p> <p>2022-2025 онд "Тэгш боломж" төслийн хүрээнд нийт 11 сургуульд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв", "Эрүүл хүүхэд" төслийн хүрээнд 3 сургуульд "Эрүүл мэндийн жишиг кабинет" тус тус байгуулагдсан бол "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын бүх сургуулиудад хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнүүд олгогдож хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж байна.</p> <p>Тайлант хугацаанд "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнүүдийн ашиглалтыг нэмэгдүүлэх, үр дүнг тооцох зорилгоор ЕБС-ийн сурагчдын дунд "Степ, аэробекийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн", "Аз жаргалтай аялгуу" үкүлэлэ, гитар хөгжмийн аймгийн аварга шалгаруулах уралдаан, "Сурагч театр" сонгодог жүжгийн дүрийн тоглолтын уралдаан, "Өглөөний цайг өөртөө" хүнс боловсруулах уралдаан, "Эерэг хандлагыг өөрөөсөө" комик ном бүтээх уралдаан зэрэг шинэлэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан. "Тэгш боломж" төслийн хүрээнд байгуулагдсан 11 төвүүдээр 100 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлж, боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.</p>	
14	2.1.5.Сурагчдын зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөдөлмөрт суралцуулах, хамтарч ажиллах чадвар эзэмшүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний үйл ажиллагааг дэмжинэ.	2020-2025	НБХ, БШУГ	Орон нутгийн төсөв	36.0	1	-	Орон нутгийн төсөв 36.0	<p>Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газрын дэргэдэх "Янзага" Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэдэх "Найрамдлын эрдэнэс" хагас бүтэн өнчин хүүхдийн "Энэрэл" зусланд хүүхдүүдийг амраах, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөх, хөгжүүлэх үйл ажиллагааг хийж байна. Жилд дунджаар 57-3200 гаруй хүүхдүүд тогтмол хамрагддаг.</p> <p>Булган аймгийн Бугат сумын нутагт баригдаж буй "Эрдмийн сан" сургуулийн дэргэдэх хөдөлмөр зусланг ашиглалтад оруулсан. Жилийн 4 улиралд зуслан ажиллах ба 1 ээлжид 150 хүүхэд хүлээн авна гэж төлөвлөсөн. Тус зуслан ашиглалтад орсноор хүүхдүүд амарч амьдрах арга ухаан, хөдөлмөр, ёс заншил, өв уламжлалаасаа суралцах боломж бүрдэнэ. "</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Энэрэл" зусланд тус төвийн 60 хүүхэд 2 сарын хугацаанд амарч хүнсний ногоо тариалах, цагаан идээ боловсруулах зэрэг амьдрах ухааны сургалтуудад хамрагдсан. ХГБХХГ-ын дэргэдэх "Янзага зуслан"-д сурагчдыг хүлээн авч, Улаан загалмай, эрүүл мэнд, цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтран сурагчдад анхны тусламж үзүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ,дадлага сургалтыг зохион байгуулсан.</p> <p>2021-2025 онд аймгийн хэмжээнд Баян-Өндөр сумын "Ёс заншлын өргөө"-ний дэргэдэх болон "Эрдмийн сан" сургуулийн дэргэдэх хөдөлмөр зусланг байгуулсан. 2024 онд Баян-Өндөр сумын "Ёс заншлын өргөө"-ний дэргэдэх хөдөлмөр зулан 2-3 удаагийн ээлжийн амралт зохион байгуулж 150 орчим хүүхэд хамрагдсан. Эдгээр зуслангуудад Жилд дунджаар 57-3200 гаруй хүүхдүүд тогтмол хамрагддаг. Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газрын</p>	100	

										дэргэдэх “Янзага” зусланд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 970.0 сая төгрөгийн санхүүжилтээр засвар үйлчилгээ хийсэн.	
15	2.1.6.Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулна.	2020-2025	НБХ, БШУГ	Орон нутгийн төсөв	12.6	-	ЕБС-иуд цахим системд холбогдсон байна.	12.6	Орон нутгийн төсөв 12.6	2021-2024 онд ерөнхий боловсролын 25 сургуулиудаас “Eskhool” системийг -2, “Их нүүдэл” системийг -13, “Амжилт” системийг -1, “Esis” системийг -9 сургууль тус тус ашиглаж байна. Үүний үр дүнд багш нар цахим хичээл бэлтгэн байршуулж, сурагчийн хичээлийн оролцоо нэмэгдэж, хичээл сургалтын үйл ажиллагаа дахь эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоо сайжирсан. Боловсролын үйлчилгээг цахимжуулах, оновчтой төлөвлөлт, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Боловсролын мэдээллийн технологийн төв”-ийн esis.edu.mn үндсэн системд төрийн болон төрийн бус өмчийн 25 сургууль, 39 цэцэрлэгийг статистик мэдээллийн баазад нэгтгэж, сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж байна. 2023-2024 оны хичээлийн жилд сонголтын бүлэг үүсч буй сургуулиуд танхимаар, сонголтын бүлэг үүсээгүй сургуулиуд судлагдахуунаар “Мэдлээ” цахим сургуульд сурагчдыг хамруулан суралцуулсан. Бага боловсролын математикийн хичээлээр “Эдүтэн” цахим платформ, англи хэлний хичээлээр “Пийрсон” хөтөлбөр, математикийн хичээлээр “Сураад” платформуыг хэрэгжүүлж, ерөнхий боловсролын 17 сургуулийн 3-12 дугаар ангийн 345 бүлгийн 14706 сурагч, 245 багш хамрагдаж байна. Дээрх цахим платформуудыг хичээл сургалтын үйл ажиллагаанд ашигласнаар сурагчид хоцрогдлоо оношлох, арилгах, хөгжих, бие даан суралцах, багш нар хичээл, хэрэглэгдэхүүн, даалгавар бэлтгэх, цаг хэмнэх, сонирхолтой аргаар хичээл зохион байгуулах, эцэг эх асран хамгаалагчид хүүхэдтэйгээ хамтран хичээл хийх, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд хяналт тавих, идэвхтэй оролцох, хүүхдийнхээ сурлагын үнэлгээтэй танилцах боломж тус тус бүрдсэн байна.	100
16	2.1.7.Орон нутгийн онцлогт тохируулан сургууль, цэцэрлэг, багшийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх аргачлал боловсруулан хэрэгжүүлэх, бүх шатны сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2020-2025	НБХ, БШУГ	Орон нутгийн төсөв	40.0	20 багш, ажилтан	Багшийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх боломжийг бүрдүүлж, урамшуулсан байна.	29.0	Орон нутгийн төсөв 90.0	Боловсролын салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, онцгой амжилт гаргасан салбарын албан хаагчдыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/496 дугаар тушаал, Боловсрол, соёл урлагийн газрын 2017 оны А/27 дугаар тушаал, Боловсролын газрын 2025 оны А/41 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн шагнаж урамшуулдаг. Шинэ арга зүй, өөрийн арга туршлагад тулгуурлан сургалтын чанарыг ахиулах, хүүхдийн төлөвшил, өсөлт хөгжилт, авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэхэд амжилт гаргасан болон тив дэлхий, олон улс, улсын чанартай олимпиад уралдаан тэмцээнүүдэд багш өөрөө болон бэлтгэсэн шавь нар, анги хамт олон нь амжилттай оролцсон багш, удирдах ажилтнуудыг шагнаж урамшуулж, алдаршуулдаг. 2021- 2024 онуудад жил бүр Мэргэжлийн аварга 20 багшийг БНХАУ-ын Хөх хот, Ордос хотоор туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулж, жил бүр 18.4 сая төгрөгийг зарцуулсан. 2025 оны Багш нарын баярын арга хэмжээнд БТА-34, Боловсролын яамны “Жуух бичиг” 67, Аймаг, сумын шагналаар 103, Боловсролын газрын шагналууд болон мэргэжлийн аварга, шилдэг илтгэлийн уралдаанд шалгарсан 224 багш ажилтан шагнагдаж, шагналд нийт 10.6 сая төгрөг зарцуулсан. Амжилт гаргасан салбарын багш удирдах ажилтнуудыг журмын дагуу шагнаж урамшуулснаар багш нар хөгжих, өөрийгөө	100

										<p>хөгжүүлэх боломж бүрдэхээс гадна, суралцагчдын сурлагын амжилт, авьяас чадвар тодорхой хэмжээгээр өсөж, Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний аймгийн дундаж 77.57%, СӨБ-ын багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 94.68%-тай байгаа нь улсын дунджаас 0.5 – 3.0%-иар өндөр үзүүлэлттэй байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 2021 онд 535.6 байсан бол 2024 онд 552.7 болж өссөн.</p> <p>Жил бүр багш нарын баярыг угтан боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй, амжилт гарган ажиллаж буй албан хаагчдын шагналын материалыг нэгж байгууллагуудаас хуваарийн дагуу нэгтгэн авч шагналын хэлэлцүүлэг хийн ажилласан. 5 жилийн хугацаанд төрийн дээд одон шагнал- 21, БТА- 84, яамны Жуух-390, Аймаг, сумын шагнал- 935, Боловсролын газрын тэмдгүүд-1025, Мэргэжлийн аварга багшаар- 105, шилдэг илтгэгч багш нарт шагнал олгосон. Жил бүр 15.0-18.0 сая төгрөг буюу нийт 75.0 -90.0 сая төгрөг зарцуулсан.</p>	
17	2.1.8.Сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг онлайн, зайны сургалтад хамруулах, сургууль, цэцэрлэг бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэн, багш, ажилтанд дэмжлэг үзүүлнэ.	2020-2025	НБХ, БШУГ	Орон нутгийн төсөв	150.0	1 сургууль, 1 цэцэрлэг	Сургалтын 10 байгуулагад, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих танхим" байгуулж, суралцах орчинг бүрдүүлнэ	150.0	Орон нутгийн төсөв 550.0	<p>2021 онд багш нарын мэргэжил дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг чадавхжуулах 14 удаагийн сургалтад 379 багш, 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт тэгш хамруулах, шаардлагатай хүүхдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр нийт 640 гаруй багшийг тус тус сургалтад хамруулсан.</p> <p>Сургууль, цэцэрлэгийн "Дэмжлэгийн баг"-уудын үйл ажиллагаа тогтмолжиж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах ажлын хүртээмж нэмэгдсэн. Орон нутагт энэ чиглэлээр ажиллах боловсон хүчнийг нэмэгдүүлж үндэсний сургагч багш 1, орон нутгийн сургагч багш 60 бэлтгэгдсэн. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 12, ерөнхий боловсролын сургуулиудад 60 гаруй багш "Ганцаарчилсан сургалт"-ын төлөвлөгөөг хэрэгжүүлж, хуульд заасны дагуу үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдлийг олгож байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах "Тэгш боломж" төслийн хүрээнд 4 удаагийн сургалтад сургууль, цэцэрлэгийн 162 багш, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаанд ЕБС-ийн сургалтын менежер, СӨБ-ын арга зүйчид тус тус хамрагдсан. Уг төслийн хүрээнд 2022-2024 онуудад 1, 2, 4, 7, 13, 8, 17, 18, 20 дугаар сургуулиудад "Хүүхдийн хөгжлийн танхим"-ыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ганцаарчилсан сургалтыг явуулж байна. Тус төвүүдэд ажиллаж буй багш нарын урамшууллыг төслийн хүрээнд шийдвэрлэж олгосон. Төслийн хүрээнд Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтарсан сургалтад 62 багш хамрагдаж, үндэсний сургагч багш 1, орон нутгийн сургагч багш 62 бэлтгэгдсэн байна.</p> <p>"Багшлахуй ба хүүхдийн хөгжлийн бэрхшээл" сэдэвт сургалтыг МУБИС-тай хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтад ерөнхий боловсролын сургуулийн тэгш боломж хүүхдийн хөгжил хариуцсан ажилтан, дэмжлэгийн багийн ахлагч, ялгаатай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллаж буй сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн 75 багш, удирдах ажилтан хамрагдаж мэргэжлээ дээшлүүлсэн. Энэ хичээлийн жилд тусгай хэрэгцээт боловсролын 2 багш шинээр ажилд орсон. Аймгийн</p>	100

									<p>боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлөөс 2025-2026 оны хичээлийн жилд 3,5-р сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих, орчин нөхцөл бүхий “Хүүхдийн хөгжлийн танхим”-ийг 100,0 сая төгрөгөөр байгуулсан. Орхон аймагт нийт 11 танхимд 260 гаруй хүүхэд 220 багш ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, бага ангийн багш, тусгай хэрэгцээт боловсролын 220 багш нарт “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний журам”, Брайл бичиг” дадлага сургалт, “Портеж хөтөлбөрийн арга зүй” сургалтуудыг зохион байгуулсан. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг багш нарын дунд “Сайн туршлага-2025” эрдэм шинжилгээний бага хурлыг анх даа зохион байгуулахад нийт 71 багш материал ирүүлсэн байна. Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Хөдөлмөр засал”, “Сонсьё, хайрлая, хүндэлье” өртөөчилсэн хэл, хөдөлгөөн заслын сургалтыг 160 эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигч нарт зохион байгуулсан. Улаанбаатар хотын 70-р сургуулийн багш нар манай аймгийн биеийн тамирын багш, захирал, дэмжлэгийн багийн гишүүдэд дасан зохицлын болон спорт тоглоомоор дамжуулан ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй сэдвээр 1,5 өдрийн дадлага сургалтыг зохион байгуулсан.</p> <p>“Адина” төслийн хүрээнд хилийн чанадад байгаа гэртээ асаргаанд байдаг хүүхдүүдэд онлайн болон зайн хэлбэрээр хичээл сургалтыг зохион байгуулахад “Мэдлээ” тn-д хичээлээ байршуулахаар 8-р сургуулийн 3 багш шалгалт өгч тэнцсэн.</p> <p>Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, тусгай хэрэгцээт боловсролын 70 багш нарыг Улаанбаатар, Дархан-Уул аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв, хөгжлийн төв, тусгай 29,116,83-р сургуулиудад туршлага судлах, хамтарч ажиллах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан. Монгол тусгай олимпын хороотой хамтран цэцэрлэгийн болон сургуулийн насны оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг спорт, урлагаар хөгжүүлэхэд хамтарч ажиллаж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд жил бүр хүүхдийн цэцэрлэгт 6 настай 12 -19 хүүхдийн эцэг эхийн хүсэлтийг харгалзан давтан байна. Хөгжлийн бэрхшээлтэй 1-р ангид элсэн суралцуулах хүүхдийн тоо 59,6%-иар нэмэгдсэн байна. Гэртээ асаргаанд байгаа 40 хүүхэд “Явуулын багш” үйл ажиллагааг хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй ялгаварлалгүй хүргэсэн. Нийт 11 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх “Хүүхэд хөгжлийн танхим”-ыг Орон нутгийн төсвийн 550.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулсан . Эдгээр танхимд 14 багш ажиллаж, 160 гаруй хүүхэд суралцаж байна. Тайлант хугацаанд нийт 15 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2378 хүн хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй 1-5 насны хүүхдийн 86.6%, 6-18 насны хүүхдийн 53.2% нь сургалтын байгууллагад хамрагдаж байна.</p>		
18	2.1.9.Хүүхэд харах үйлчилгээг дэмжин, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	2020-2025	НБХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Орон нутгийн төсөв	88.0	1407	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр олон талт	88.0	Орон нутгийн төсөв 314.0	ГБХНХЯ-аас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд хилийн заставууд болон СӨБ-ын хүртээмж багатай байрлалд хүүхэд харах үйлчилгээг явуулах болсонтой уялдан манай аймагт зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандсан үйлчилгээг үзүүлж байна. 2021-2025 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, 7 хүүхэд харагчийг сургалтад хамруулан бэлтгэж, Найдвар төвийг түшиглэн 9-17 насны 21 хөгжлийн хүнд	100

							<p>үйл ажиллагааг зохион байгуулах</p>			<p>хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулж байна.</p> <p>Орхон аймгийн нийт хүн амын 51.0% нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт 13869 байгаа нь хөдөлмөр эрхэлж буй хүн амын 44.6%-ийг эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 67.6% нь эмэгтэйчүүд байна.</p> <p>2021-2024 нийгэмд эерэг харилцаа, дадлыг төлөвшүүлж, эмэгтэйчүүдийн хөгжил, манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр 15 төрлийн сургалт, үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 21700 гаруй охид, эмэгтэйчүүдийг хамруулсан.</p> <p>2023 онд "Хөдөлмөр эрхлэлт бидний амьдралд" эмэгтэйчүүдийн өдөрлөгийг 2 өдөр зохион байгуулж 179 эмэгтэйчүүд оролцсон. "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд мэргэжлийн чадамжийн гэрчилгээ, цахим ур чадварын сертификат олгох 21 хоногийн цахим сургалтыг зохион байгуулж 40 эмэгтэйд 6.6 сая төгрөг олгож, 5 ажлын байр бий болсон. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын зөв хэв маяг, хандлагыг төлөвшүүлэх, нийгэм дэх манлайлал, хөгжил, оролцоог дээшлүүлэх зорилготойгоор аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдөөс санаачлан "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2024 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил манлайлал, оролцоог нэмэгдүүлэх зөвлөгөөн сургалт 11 төрлийн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, 4600 гаруй охид эмэгтэйчүүдийг хамруулж, хөтөлбөрийн хэрэгжилт 98 хувьтай байна.</p> <p>Эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн сургалт нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулахаар 6 төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Үүнд</p> <p>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан "Хайр нэмье" сэтгэл зүйн өдөрлөг, хууль хүчний 6 байгууллагын дунд "Мөрдөстэй бүсгүйчүүд" арга хэмжээг зохион байгуулж 800 гаруй эмэгтэйчүүдийг хамруулсан.</p> <p>Гадаад дотоодын төсөл хөтөлбөрт эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, холбон зуучлах, хөдөлмөрт зуучлах, гоо зүйн чиглэлээр "Монгол дахь гоёлын шивээс нүүр будалтын холбоо" НҮТББ-ын хамтран артист гоёлын шивээсний сургалтыг 3 сарын хугацаанд үе шаттай зохион байгуулж, давхардсан тоогоор 45 эмэгтэйг хамруулан, амжилттай суралцсан 10 эмэгтэйг ажлын байраар хангаад байна.</p> <p>Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах" төрийн бус байгууллагатай хамтран гар урлалын төрөл, хийцийг өргөжүүлэх судалгаа хийж, туршлага судлан гар урлалын 3 шинэ төрлийг нэвтрүүлэн урлангийн ээжүүдэд 5 удаагийн сургалтыг зохион байгуулж 120 гаруй эмэгтэйчүүдийг хамруулснаар анхны бүтээлээ гаргаж салбар дэлгүүрээр дамжуулан худалдаанд гаргаж байна.</p> <p>Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах чиглэлээр Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Хойд бүсийн зөвлөгөөн" зохион байгуулан Хөвсгөл, Булган, Орхон аймгийн 200 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хамрагдаж, туршлага судалж, бизнес</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

санаагаа дэлгэрүүлсэн.

Эрүүл мэнд

Зорилт 2.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна:

19	2.2.1.Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулна.	2020-2025	НБХ, ЭМГ	Орон нутгийн төсөв	175.0	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан 12.5% Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны 7.9%	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан 12.9% Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтан 17%	175.0	Орон нутгийн төсөв 720.5	<p>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр аймгийн ИТХ-ын 2021 оны 08-р тогтоолоор "Эмч" хөтөлбөрийг батлуулж, 2021-2024 онуудад нийт 517.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдан жил бүр хэрэгжүүлэн ажилласнаар 3569 эрүүл мэндийн ажилтан сургалт болон эрүүл мэндийн чиглэлээр дэмжлэгт хамрагдан Эмч" хөтөлбөрийн 2021-2024 оны хэрэгжилт 97.8 хувьтай хэрэгжиж дууссан.Тухайлбал 415.0 сая төгрөгийн санхүүжилтээр нийт 1973 албан хаагч хамрагдсанаас 105 эмч,эмнэлгийн мэргэжилтэн гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт, хурал, чуулган, зөвлөгөөнд оролцоход нийт санхүүжилтийн 40.7 хувийг, дотоодод туршлага судлах болон мэргэшүүлэх, боловсролын зэрэг олгох сургалтад 47 эмч,эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан нийт санхүүжилтийн 8.6 хувийг, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын тэмдэглэлт өдөр болон эрдэм шинжилгээний хурал , чуулган зохион байгуулахад төсвийн 20.3 хувийг, салбарын 905 эмч,эмнэлгийн мэргэжилтнүүдийг эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээнд хамруулахад төсвийн 24.0 хувийг, бусад арга хэмжээнд төсвийн 6.4 хувийг тус тус зарцуулсан байна.</p> <p>2021-2024 онд төрийн болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 500 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн суралцсанаар төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 2.6%-иар нэмэгдэж, төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 12.5%-д хүрсэн байна. Мөн орон нутагт нэн шаардлагатай 23 мэргэшлээр 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаснаар нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92.0% болж, суурь түвшнээс 22 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>2025 онд Эрүүл мэндийн ажилтны сургалт хөгжлийн үйл ажиллагаанд Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2025-2028/-оос албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 120 сая, Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрөөс 3.5 сая төгрөг, Эрүүл мэндийн байгууллагуудын зардлаас 80.0 сая төгрөг нийт 203.5 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 2.4%-аар нэмэгдсэн байна.Улсын төсвийн санхүүжилтээр 60 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, БОЭТ-ийн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн яаралтай сувилахуй 17, эрчимтний сувилахуйгаар 4 эмнэлгийн мэргэжилтэн, ажлын байрны болон алсын зайн 112 удаагийн сургалтад нийт 275 мэргэжилтэн хамрагдаж, төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 12.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Дэлхийн эмч, сувилагчдын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан бага хуралд 199 судлаач оролцож, 49 илтгэл хэлэлцүүлэн Эрдэм шинжилгээний бага хурлаас шалгарсан шилдэг илтгэлүүдээр "Анагаах увдис" сэтгүүлийн 9 дэх дугаарыг 300 ширхэг хэвлүүлсэн. БНСУ-д болсон Ази, Номхон далайн өрхийн эмч нарын чуулганд 8 төвийн 11 эмч, Австри, БНСУ-д нийт 12 эмч,эмнэлгийн мэргэжилтэн мэргэжил дээшлүүлсэн байна.</p> <p>2025 онд Эмч, ажилчдын нийгмийн баталгааг хангах ажлын</p>	100
----	---	-----------	----------	--------------------	-------	---	--	-------	--------------------------	--	-----

										хүрээнд Жаргалант сумын ЭМТ-ийн 2 их эмчийг орон сууцаар хангаж, орон сууцны урьдчилгаа 30%-ийг Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн жолоочид олгон, хувийн хэвшлийн байгууллагууд 92.4 сая төгрөгийг нийгмийн баталгаанд зарцуулсан бөгөөд нийгмийн дэмжлэгт хамрагдалт 17.0 хувьд хүрч, хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт 97.8 хувьтай байна .Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт мэндийн салбар байгууллагуудын 78.4% буюу 1639 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан, 13.7 сая төгрөгийн аминдэмжүүлэлтэд хамруулан дэмжлэг үзүүлсэн байна.	
20	2.2.2.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжин хөгжүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	Орон нутгийн төсөв	125.0	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 38.1%	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 40%	125.0	Орон нутгийн төсөв 4481.0	Эрүүл мэндийг дэмжих сан 29.5	100

										байгууллагуудын удирдлага, ажил олгогч нарыг ажилтан албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах чиглэлээр идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлант хугацаанд 122 байгууллагын 15319 ажилтан, албан хаагчийг урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 39.5%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна. БОЭТөвийн Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвд нийт 5083 иргэн хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан. 2025.09.07-нд Хойд бүсийн ХСҮТ-ийн салбар нээгдэж, мэргэжлийн 3 эмч ажиллан 111 иргэнд үзлэг, зөвлөгөө үзүүлж бүсийн хэмжээнд хавдрын эрт илрүүлгийн чадавх нэмэгдсэн. 2025 онд хүн амын дунд иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 6 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 37 аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус 6 байгууллагатай хамтран нийт 36801 иргэнийг эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх сургалтад хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна	
21	2.2.3. Анхан болон лавлагаа шатлалын оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	Улсын төсөв Орон нутгийн төсөв ЭМД-ын гүйцэтгэлийн санхүүжилт	5.1 210.0 141.0	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 85% БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 75%	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 85% БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 75%	5.1 210.0 141.0	Улсын төсөв 607.1 Орон нутгийн төсөв 210.0 ЭМД-ын гүйцэтгэлийн санхүүжилт 141.0	2023 оны байдлаар лавлагаа шатлалд 9 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн. 2024 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулатори болон төрөх тасагт 500.0 сая төгрөгийн эмэгтэйчүүдийн суурин болон зөөврийн эхо аппарат, 129.6 сая төгрөгийн чих хамар хоолойн үзлэг болон төвөнхийн харалтын иж бүрэн дуран, 150.0 сая төгрөгийн ургийн гажгийг эрт оношлох ЭХО тоног төхөөрөмжүүд бүрэн нийлүүлэгдэн ашиглагдаж байна. 2025 онд Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5092:2017 стандартын дагуу 8 багц 69 төрөл тоног төхөөрөмж байх шаардлагатайгаас хангалтын хувь 96.5 хувь, ашиглалтын хувь 96 хувьд хүрээд байна. -Бамбайн даавар, витамин Д, глюкозын гурван сарын дундаж үзэж, сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна. -Улс, орон нутгийн хөрөнгөөр 173.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 31.5 сая төгрөгийн өртөг бүхий ECG S120 эрт илрүүлэх хийх зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, гэрийн эргэлт хийх, дуудлагад явах автомашин олгосон байна. -Орон нутгийн 141.5 сая төгрөгийн санхүүжилтээр: o Шарлагын аппарат-Мөнх сүндрэл, Анхны Оч o Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат -Анхны Оч o Мобайл технологи-Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв o Жаргалант суманд иммунологийн аппарат, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдэл, поток, искра аппаратууд нийлүүлэгдэн анхан шатлалын ЭМБ-уудын тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. Орхон аймагт 2021-2025 онд нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн ашиглалт хүртээмж, үр дүнг тооцон, тайлант хугацаанд: -Хавдрын оношилгоог чадваржуулах хүрээнд 602,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжруулсан бөгөөд доорх дэвшилтэт технологиудыг тогтвортой нэвтрүүлэн лавлагаа шатлалд явах урсгалыг 30,0%-иар бууруулсан байна. Үүнд: -Харвалт шигдээсний төвийг 2021 онд байгуулан 2025 онд 1000 дахь хүндээ хийснээс зүрхний титэм судасны ангиографийн оношилгоо, эмчилгээг тайлант хугацаанд 406 хүнд, элэгний хавдрын тэжээгч судас бөглөх эмчилгээ 44, тархины судасны оношилгоо эмчилгээ 34, зүрхний хэм алдагдлын байнгын суулгац 1, хавдрын хими эмчилгээний үеийн вений судасны порт 12 хийсэн	100

										<p>байна.</p> <p>-Түргэн тусламжийн дуудлага, цаг товллын үйл ажиллагааг цахимжуулахад орон нутгийн төсвөөс 75 сая төгрөгийг шийдвэрлэн амбулаторит цахим бүртгэлийн системийг нэвтрүүлсэн байна.</p> <p>-НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр эмнэлгийн аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх Sterilwave-100 төхөөрөмжийг БОЭТөвд суурилуулан аймгийн хэмжээний ЭМБ-уудын аюултай хог хаягдлыг устгалд оруулж байна.</p> <p>-Халдварт, яаралтай тусламжийн тасгуудад орон нутгийн төсвөөс 130.0 сая төгрөгөөр нэн шаардлагатай 3 нэр төрлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>-Мухар олгойг дурангаар авах мэс заслыг 11 хүнд, Шээлгүүрийн дурангаар 5 хүнд шээлгүүрт стент тавих, чулуу авах 2 үе шаттай хагалгааг хийсэн байна.</p> <p>-Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 23 нярайд хийж, 82.6%-ийн үр дүн өгсөн.</p> <p>Ингэснээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96.0%, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 96.5%-тай байна.</p>	
22	2.2.4.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	Орон нутгийн төсөв	25.0	Хариу арга хэмжээний чадавх 75%	Хариу арга хэмжээний чадавх 90%	25.0	Орон нутгийн төсөв 145.0	<p>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 2021 онд 85%, 2022 онд 90%, 2023 онд 95% байна. 2024 онд тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавх нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хариуцсан 40 мэргэжилтэн бэлтгэгдэж, эрүүл мэндийн 3 байгууллагад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандарт эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO31000:2018 стандарт нэвтрэн, томуу, томуу төст өвчний дэгдэлтийг хүндрэл бэрхшээлгүй даван туулсан.</p> <p>ХӨСҮТ-д нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээ хийх төвийн сургалтад ЭМГ-аас 2 мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. ОБЕГ-аас зохион байгуулсан Стратеги команд штабын сургуулилтад эрүүл мэндийн албаны 15 гишүүн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэргэжлийн ангийн 55 бие бүрэлдэхүүн оролцож, 2 удаагийн жагсаалын бэлтгэл хийн, Онцгой байдлын газраас өгөгдсөн 7 удаагийн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшигийн үеийн нөөцийн хангалт дунджаар 95% байна.</p> <p>2025 онд Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын дагуу томуу томуу төст өвчин, Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед Эрүүл мэндийн салбар байгууллагууд “тохиолдол” -удирдлагын тогтолцоонд 3 удаа шилжин хариу арга хэмжээнд салбар дундын оролцоог ханган, эрсдэлийн үнэлгээг 6 удаа хийж, АОК-оос 120.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, хариу арга хэмжээний хэрэгжилт 95.6 хувьтай байна.</p> <p>2025 онд улаанбурхан өвчний сэжигтэй 86 тохиолдол бүртгэгдэн, 66 тохиолдол батлагдаж, сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьталд тандалт судалгаа хийж, голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих 347 /96.9 хувь/ хүнийг дархлаажуулалтад хамруулан хариу арга хэмжээг шуурхай авч ажилласнаар 2025 оны 9 сараас хойш он дуустал хугацаанд улаанбурхан өвчний сэжигтэй, батлагдсан тохиолдол</p>	100

										бүртгэгдээгүй байна. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо” сургалтад аймгийн ЗДТГ, ОБГ, ЦГ-ын удирдлага, мэргэжилтнүүд, сум, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллага, хүүхдийн байгууллагын эмч зэрэг нийт 145 хүнийг хамруулан чадавхжуулсан.	
23	2.2.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	Орон нутгийн төсөв	30.0	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо 1	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо 2	30.0	Орон нутгийн төсөв 70.0	<p>Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиниктэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн байгууллага нийт үзлэгийн 15.0% орчмыг хийж, нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 49.1%-ийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцаж байна. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиник томуу томуу тест өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж, хамтран ажиллаж байна. Үүнд:</p> <p>-Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиникүүд оролцож 2023-2025 онд 16-49 насны 3779 эмэгтэйг үзлэгт хамруулан 38.5% -ийг нь бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 12051 эмэгтэйг илгээсэн байна.</p> <p>-Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулахаар орон нутгийн төсвөөс жил бүр 30.0 сая төгрөгийн төсвийг шийдвэрлэн, сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадагдал зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд 2021-2025 онд нийт 460 хүүхдийг хамруулан эрүүлжүүлэх ажил тогтмолжсон байна.</p> <p>-Тайлант хугацаанд Засаг дарга өрхийн эрүүл мэндийн 8 төвтэй анхан шатны тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж, хэрэгжилт 89,9%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6,8%-иар буурсан байна.</p> <p>-2025 онд ЭМГ, сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, шүдний 13 клиниктэй гэрээ байгуулан сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх шүдний илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2433 хүүхдээс 94.4% -ийг хамруулсан. Мөн “Зорилтот бүлгийн хүн амд хүргэх тусламж үйлчилгээг сайжруулъя” төслийн хүрээнд иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулаар хүргэхэд хувийн хэвшлийн 6 байгууллагатай хамтран ажилласан.</p> <p>-Гемодиализийн тусламж үйлчилгээний ачаалал, чирэгдлийг бууруулах зорилгоор төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд засвар үйлчилгээ, цахилгааны нөөцийн эх үүсвэрийн зардалд 678,6 сая төгрөгийг Засаг даргын аваарын зардлаас шийдвэрлэсэн байна.</p>	100
24	2.2.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулна.	2020-2025	НБХ, ЭМГ	-	-	Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт 88%	Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт 95%	-	-	<p>Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн тоо 2020 онд 77, 2021 онд 81, 2022 онд 85, 2023 онд 80, 2024 онд 76, 2025 оны жилийн эцсийн байдлаар 74 эмийн сан үйл ажиллагаагаа явуулж байна. 2020 онд 1-р зэрэглэлийн эмийн сан 52, 2025 оны байдлаар 46 болж 11%-иар буурсан, 2-р зэрэглэлийн эмийн сан 25 -аас 28 болж 12%-иар нэмэгдсэн.Ингэснээр хотын төвд байрлалтай эмийн сангийн төвлөрөл буурч, гэр хороололд байрлах эмийн сангийн тоо өсөж, алслагдсан багийн иргэдэд хүргэх эм зүйн тусламж үйлчилгээ ойртсон байна.</p> <p>2020-2025 онд шинээр 29 эмийн санд тусгай зөвшөөрөл олгож, 72 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг сунган, 15 эмийн сангийн хаягийн шилжилтийг хийсэн бөгөөд стандартын шаардлага</p>	97.1

									<p>хангаагүй болон өөрийн хүсэлтээр үйл ажиллагаагаа зогсоосон 37 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцалсан байна. Эрүүл мэндийн даатгалын сантай гэрээтэй хөнгөлөлттэй үнээр эм олгодог эмийн сан 2020 онд 28 байсан бол 2025 онд 53 болж 52,8%-аар нэмэгдсэн байна. “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд Эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт 2021 онд дунджаар 88.9% 2022 онд 88.1%, 2023 онд дунджаар 93.5%, 2024 онд 94.2%, 2025 онд 95.7% байгаа нь 2020 онтой харьцуулахад 6.8%-аар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/108 тоот тушаалаар “Эмийн чанар, аюулгүй байдлын орон тооны бус салбар зөвлөл” 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. Эмийн чанар, эмийн гаж нөлөөний сургалтад 86 эрхлэгчийг хамруулж, “Антибиотик эмийг жороор олгоё” 3 сарын аянд 71 эмийн сан нэгдэн антибиотикийг 100% жороор олгон, 111 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулан гарын авлагаар хангаж, антибиотикийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөмжийг 2516 хүнд өгсөн байна. 2024 онд эмийн зохистой хэрэглээний 10 хоногийн хүрээнд 40 эмч, эм зүйчийг сургалтад хамруулж, иргэдэд хандсан сургалт сурталчилгааг эрчимжүүлэн ажиллаж байна. 2025 онд “Анзаар-2” аяны хүрээнд ЭМГ, Тагнуулын газар, Цагдаагийн газар хамтран бүх нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудад мансууруулах сэтгэц нөлөөт эмийн борлуулалтад хяналт хийсэн байна. Хяналтаар 6 байгууллагад зөрчил шалган шийдвэрлэж, бүх эмийн сангуудад хяналтын дүгнэлт, зөвлөмж хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. “Эмийн зохистой хэрэглээг сайжруулъя” 10 хоногийн аян зохион байгуулж, эмийн зохистой хэрэглээтэй холбоотой иргэдэд хандсан 8 брошюр, цахимд 10 мэдээлэл хүргэсэн байна.</p>		
25	2.2.7. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	-	-	Алсын зайн оношилгооны техник хэрэгслийн хангалтын хувь 17%	Алсын зайн оношилгооны техник хэрэгслийн хангалтын хувь 37.9%	-	Орон нутгийн төсөл 30.0	<p>Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг erdenet.mn, or.mohs.gov.mn, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээ мэдээллийг байршуулан, иргэдэд түгээсэн. Цахимаар иргэдэд хүргэж буй үйлчилгээг авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газар, ЭМЯ-наас E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлтийг нэгдсэн журмаар зохион байгуулж байгаа бөгөөд тус "E-Mongolia" системээс эрүүл мэндийн 19 төрлийн үйлчилгээг иргэд авч байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, эмийн жор бичилт зэрэг 7 үйлчилгээг "E-Mongolia" системээс авах боломжтой болсон. - Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвд цаг товлох, түргэн тусламжийн дуудлагын үед цахим программд үзлэгийн бүртгэл, цахим өвчний түүх хөтлөх ажиллагааг хялбаршуулан, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичиж, кодыг олгох зориулалтаар ашиглах зөврийн таблет ашиглаж хэвшсэн байна. -2025 онд Засгийн газрын 100 хоногийн ажлын хүрээнд em.hdc.gov.mn сайтад улс даяарх бүх эмийн сангийн байршил болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийн үнийн мэдээлэл байршсан үүнээс Орхон аймгийн 74 эмийн сангийн байршил, үнийн мэдээлэл орсон байна. 	100

									<p>Алсын зайн оношилгоо, телемедицин, хиймэл оюун ухааны техник тоног төхөөрөмж ашиглаж байгаа 11 байгууллага байгаа бөгөөд алсын зайн оношилгооны техник хэрэгслийн хангалтын хувь 38.3%-д хүрч, суурь үзүүлэлтээс 21.3%-аар нэмэгдсэн.</p> <p>Тайлант хугацаанд БОЭТ нь 26 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан 3 дахь шатлалын эмнэлгүүдээс оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна.</p> <p>БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсанаар 2023-2025 онд нийт 32 өвчтөнд зөвлөгөө авсан байна</p> <p>Телемедициний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 62 хүний мэдээллийг оруулсан.</p> <p>Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт 15 үйлчлүүлэгчид үзүүлсэн байна.</p> <p>Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг нь цээжний зургийн рентген оношилгоо, эсийн ПАП шинжилгээнд хиймэл оюун ухааныг ашиглан оношилгооны хүлээгдлийг бууруулж байна.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад ДЭМБ-ын халдварт бус өвчин, зүрх судасны өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц арга хэмжээ (PEN/HEARTS)-ыг нэвтрүүлэх “МонПэн” санаачилга хэрэгжиж, Орхон аймагт 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр нээлтээ хийж, хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт 352 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. 2019-2025 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад мобайл технологийг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна. Орон нутгийн төсвөөр 2024 онд 3 өрхийн эрүүл мэндийн төвд, 2025 онд Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвд олгож, Орхон аймгийн 7 (77.8%) анхан шатны эрүүл мэндийн байгууллагад мобайл технологийг нэвтрүүлж, өмнөх оны мөн үеэс мобайл технологийн хангалт 11.1 хувиар нэмэгдсэн байна. Мобайл технологийн зөөврийн эхо, зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийг гэрийн эргэлт болон урьдчилан сэргийлэх үзлэгүүдэд ашиглаж байна. Тайлант хугацаанд мобайл технологиор 2025 онд 2360 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:Эхо-204, ЭКГ- 2156 хүнд хэвтрийн, байнгын асаргаа шаардлагатай 51 ахмадад давхардсан тоогоор 204 удаа зөөврийн эхо оношилгоо хийсэн Зөөврийн ЭКГ-ээр 2156 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс ахмад-291 (13.5%), ХБИ-35 (1.6%), залуучууд-1830 (84.8%) байна</p>			
26	2.2.8.Анхан болон лавлагаа шатлалын барилга, өргөтгөл, их засварын ажлыг үе шаттайгаар хийж, стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	Орон нутгийн төсөв	40.0	БОЭТ-ийн барилга их засвар СЭМТ-ийн засвар	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн Сум,	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн сум, өрхийн эрүүл	40.0	Орон нутгийн төсөв 6,424.6	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь лабораторийн тасгийн засварыг 274.8 сая төгрөг, амбулаторийн 3,4-р давхрын засварыг 372.8 сая төгрөгийн байгууллагын санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд Жаргалант сумын төсвөөс 20 сая төгрөг шийдвэрлэн стандартын дагуу болгож засварлах урсгал засвар хийгдсэн. - Улсын төсвөөс Бүсийн оношилгоо эмчилгээний төвд мэс заслын Вакум хагалгааны өрөөний их засварт 1.4 тэрбум, Цагаан чулуут багт Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга 1.8 тэрбум төгрөгөөр засварласан. - Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын нэгдсэн тасгагт 533.3 сая төгрөг, Гэмтлийн тасгийн их засварт 305.2 сая төгрөг, эмчилгээний 	100
					647.6				647.6	ЭМД-ын гүйцэтгэлийн санхүүжилт 647.6		

						өрхийн эрүүл мэндийн төв- 7	мэндийн төв- 9			<p>хоолны тасгийн дээврийн засварт 44.0 сая төгрөгийн их засварын ажлууд хийгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> - 2021 онд улсын төсвийн 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Энхжихмандариваа өрхийн эмнэлгийн барилга, 2022 онд орон нутгийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвийн барилга ашиглалтад орсоноор стандартын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлсэн байна. - Орон нутгийн төсвийн 253.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны Оч өрхийн эрүүл мэндийн төвийн дээврийн болон дотор засвар, Мөнхийн Гэгээ өрхийн эрүүл мэндийн төвд 24.8 сая төгрөгийн дээврийн завсар, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 356.0 сая төгрөгийн их засвар хийгдсэн. - Аймгийн Засаг Даргын гурвалсан гэрээний дагуу 2025 онд өрхийн эрүүл мэндийн 8 төвийн тогтмол зардалд 327.8 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. - Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийн гадна шугамыг хэсэгчлэн шинэчлэхэд 196.7 сая, Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийн дээврийн засварт 253.0 сая төгрөгийг тус тус шийдвэрлэн 100 гүйцэтгэлтэй хийгдсэн байна. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нийт 1,125.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, байр ашиглалттай холбоотой санхүүжилт 1,033.4 сая төгрөг, урсгал засварын санхүүжилт 92,3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, дэмжлэг үзүүлсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт орон нутгаас 20.0 сая төгрөг батлагдаж зураг бүрэн зурагдсан байна. 	
27	2.2.9.Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага болон даатгалын байгууллагын уялдаа холбоог сайжруулах замаар хүлээгдэл, чирэгдлийг бууруулж, эрүүл мэндийн үйлчилгээний нээлттэй, хөнгөн шуурхай, цогц байдлыг хангах, хянах нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	-	-	Хүлээгдэл /7-10 хоног/	Хүлээгдэл /1-2 хоног/	-	-	<p>Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиникүүдтэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үзлэг хийгдсэн нийт үзлэгийн 15.0%-ыг, хэвтэн эмчлүүлэгчийн 49.1%-ийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Хүлээгдэл дунджаар 2-3 хоног болж буурсан байна.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүд 2018 оноос эхлэн Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр гэрийн, уламжлалт сэргээн засах, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ гэсэн 4 нэр төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ачааллыг 35-40%-д бууруулсан байна.</p> <p>Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан.</p> <p>Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 124 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.</p> <p>Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиник оролцож 16-49 насны эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулсан. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх 90.0%-тай байна.</p> <p>2025 онд тусламж үйлчилгээний хүлээгдлийг бууруулах хүрээнд нөхөн үржихүйн клиник 1, хүүхдийн клиник 1, уламжлалын клиник 1 шинээр нээгдэн журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан байна.</p>	87.5

										Эрүүл мэндийн даатгалын сантай гэрээтэй хөнгөлөлттэй үнээр эм олгодог эмийн сан 2020 онд 28 байсан бол 2025 онд 53 болж 52.8%-аар нэмэгдсэн байна.	
28	2.2.10.Иргэдийг хөдөлгөөний хомсдол, сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл, төрөл бүрийн донтолт, хамаарлаас урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжүүлнэ.	2020-2025	НБХ, ЭМГ	Орон нутгийн төсөв	4.0	Хэрэгжүүлсэн төслийн тоо 1	Хэрэгжүүлсэн төслийн тоо 3	4.0	Орон нутгийн төсөв 104.0	Тайлант хугацаанд иргэдийг хөдөлгөөний хомсдол, сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл, төрөл бүрийн донтолт, хамаарлаас урьдчилан сэргийлэх дараах төслүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд: - Сэтгэлийн анир III төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 100 эцэг эх, 8 -12 ангийн 726 хүүхдийг сэтгэл зүйн судалгаанд хамруулж, 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө, 150 иргэнд бүлгийн ярилцлага, 78 иргэнд сургалт зохион байгуулж, 15 шторк, 2 контент, 3 нэвтрүүлэг, 47 цахим зөвлөмжийг бэлтгэн нийт давхардсан тоогоор 5600 гаруй иргэнд цахимаар хүргэсэн. - “Сонсьё, мэдэрье, ойлгоё” аяны хүрээнд ерөнхий боловсролын 23 сургуулийн 16000 гаруй бүх насны сурагчид сэтгэл зүйн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн. “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” аяны хүрээнд 3 төрлийн сургалтыг СЭМҮТ-тэй хамтран төрийн байгууллагын албан хаагч, 2 сургуулийн 2 болон 7-р ангийн сурагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч болон багш нар нийт 345 иргэд хамрагдсан. - “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд жин бууруулах 1 сарын уралдаанд 10 байгууллагын 60 хүн хамруулж зохион байгуулснаар аяны хугацаанд оролцогчид нийт 93.4 кг жин хаясан. - Аймгийн Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд “Би хорт зуршилгүй залуу” аяны хүрээнд ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн сурагчдад электрон тамхины хор нөлөөгөөр сургалт зохион байгуулсан. - “Эрүүл эрдэнэт хүн” төслийн хүрээнд “Эртэч Эрдэнэтчүүд” аяныг зохион байгуулж 3 байршилд 5 төрлийн дасгал хөдөлгөөнд давхардсан тоогоор 3121 иргэн хамрагдсан. Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж 4 удаагийн явган алхалт зохион байгуулж 1000 иргэн хамрагдсан. “Энэ жилдээ эрүүл жиндээ 2” аяны хүрээнд “Түмэн дасгал”-д 3121 иргэн хамрагдсан. - Биеийн тамир спортын газартай хамтран төрийн өмчит хувьцаат компанийн ажилтан албан хаагчдын дунд ажлын байрны дасгал хийх цахим уралдааныг 2 сарын хугацаанд зохион байгуулан 33 байгууллагын давхардсан тоогоор 7384 ажилтан албан хаагчид ажлын байрны дасгал хөдөлгөөнд оролцсон байна. - Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний хүрээнд 38 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 12 удаагийн өдөрлөгөөр 4602 иргэнд зөвлөмж, зөвлөгөө, мэдээлэл хүргэж, 10 төрлийн сургалт, үйл ажиллагаанд 13405 иргэнийг хамруулж, 10 төрлийн гарын авлага, зөвлөмжийг давхардсан тоогоор 11907 иргэнд түгээсэн байна. - “Ариун саруул бат”, “Сэтгэлзүйн цогц боловсролын төв” зэрэг 2 төрийн бус байгууллагатай хамтран 2 удаагийн үйл ажиллагаанд 3000 гаруй хүнд сургалт болон сэтгэлзүйн зөвлөгөө өгч ажилласан. - Орхон аймгийн явган алхалтын холбоотой хамтран “Орхон 100 км”, “Туг аялуулах хөтөлбөр”, “Эрүүл мэнд эко гороо аялал”, “Эмчтэй хамт алхъя”, “Таны хөл бол эмч юм”, “Бүх хайраа гэр бүлдээ – 100 км” гэх мэт алхалтыг иргэдийн дунд зохион	100

										байгуулсан. - Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн – “Эрдэнэт Марафон 2025” бүх нийтийн гүйлтийн тэмцээнийг 2 удаа зохион байгуулж 5 төрлийн зайд нийт 478 тамирчин оролцсон. - Өрхийн ЭМТ, Ахмадын хорооны чийрэгжүүлэлтийн танхимд 800 ахмад хийн дасгалд тогтмол хамрагдаж байна. - Аймгийн хэмжээнд фитнес, иог, бүжгийн зэрэг 20 төрлийн клубүүдтэй хамтран ажиллаж, өссөн дүнгээр 117,600 иргэн дасгал хөдөлгөөнд хамрагдаж, долоо хоногт 2–3 удаа 1400 иргэн тогтмол хичээллэж байна.	
Гэр бүл											
Зорилт 2.3. Гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог дээшлүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, салбар дундын уялдаа холбоог сайжруулан, залуучуудын идэвхэжсэн хандлагыг дэмжинэ:											
29	2.3.1.Гэр бүлийн хөгжлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлж, зорилтот гэр бүлд чиглэсэн үйлчилгээг сайжруулна.	2020-2025	НБХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Улсын төсөв 15.0 Орон нутгийн төсөв 28.0	Зорилтот 20 гэр бүл хамрагдсан	Зорилтот 70 гэр бүлд үйлчилгээг хүргэх	3.0 30.0	Улсын төсөв 77.0 Орон нутгийн төсөв 65.0	Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан Жендерийн хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагааг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран явуулсан 62 гаруй удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, 9821 өрх, давхардсан тоогоор 15000 хүнийг хамруулсан. Мөн гэр бүлийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалах, чадавхжуулах, хямралыг даван туулахад нь туслах, холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх чиглэлээр “Алхам алхмаар” хөтөлбөр, зорилтот бүлгийн иргэнийг архины донтох эмгэгээс ангижруулах эмчилгээ, үйлчилгээнд хамруулах, хоол хүнс, эм, хувцас, түлээ нүүрс өгөх, хүүхдүүдийг шүдний эмчилгээнд хамруулах, зуслан хөтөлбөрт хамруулах, даатгал, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ахуйн осол гэмтлээс сэргийлэх цахилгааны зөрчлийг арилгуулах зэрэг ажлыг хийж, нийт зорилтот өрхийн /8405 өрх/ 3362 өрх буюу 42 хувийг хамруулжээ. 2021-2025 онд зорилтот бүлгийн гэр бүлд чиглэсэн "Гэр төсөл", "Алхам алхмаар хөтөлбөр", "Бид хамтдаа зуслан хөтөлбөр", эрсдэлт бүлгийн гэр бүлүүдэд сэтгэл заслын үйлчилгээ хөтөлбөр, "Сайн уу үр минь", "Хосын болзоо" өдөрлөг, эрүүл мэнд, хууль хяналтын байгууллагад холбон зуучлах үйлчилгээ, амьдрах ухааны сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээнд давхардсан тоогоор 7017 иргэн буюу 1754 өрх хамрагдсанаар зорилтот гэр бүлийн 38 хувийг хамруулсан. 2025 онд Гэр бүл цуцлалтын шалтгаан тогтоох судалгаанд хамрагдагсдын 44.3% нь гэр бүлийн зан харилцаа таарахгүй гэсэн дүнг үндэслэн Шүүхийн Тамгын газартай хамтран "Гэр төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд гэрлэгчдэд сэтгэл зүйн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, уулзалт хийх, гэр бүлийн хөгжил боловсрол, тогтвортой байдлыг дэмжиж сургалт, зөвлөгөөг явуулах, гэр бүл цуцлалтын тоог бууруулах чиглэлээр ажилласны үр дүнд шүүхийн шатнаас 52 гэр бүлийг эвлэрүүлсэн үр дүн гарсан.	100
30	2.3.2.Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж, урамшуулал, хариуцлагын тогтолцоог бий болгоно.	2020-2025	НБХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Улс Орон нутгийн төсөв	Улсын төсөв 2.5 Орон нутгийн төсөв 40.0	-	Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.	2.5 40.0	Улсын төсөв 14.5 Орон нутгийн төсөв 268.3	Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын 28 хамтарсан баг, нийт 202 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хамтарсан багаар дамжуулан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг нийт 2430 иргэн авснаас 1339 хүүхэд хамрагдаж, нэн шаардлагатай хамгааллын үйлчилгээг авсан байна. 2021-2025 онд хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх чиглэлээр	100

										<p>давхардсан тоогоор 26 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, нийт гишүүдийн 95 хувийг хамруулсан.</p> <p>Сум, багийн хэмжээнд хүүхэд гэр бүлийн 24 нийгмийн ажилтан ажилласнаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээллийн санд бүртгэх, тэдэнд хөгжлийн болон хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг хийж, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд 2021 онд-1499, 2022 онд 384, 2023 онд 329, 2024 онд 611 хүүхдийг нэгдсэн мэдээллийн санд бүртгэж үйлчилгээ үзүүлж байсан бол 2025 онд 936 хүүхдийг нэмж бүртгэн үйлчилгээг үзүүлсэн. Мэдээллийн санд бүртгэлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчийн хэрэгцээнд нийцсэн дэмжлэг, тусламж, эрүүл мэнд, хууль эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээг давхардсан тоогоор 1,778 хүүхэд, эцэг эхэд үзүүлсэн бөгөөд тэдгээрээс өндөр эрсдэлтэй 297 хүүхэд шаардлагатай үйлчилгээг 100 хувь үзүүллээ. Тухайлбал, 66 хүүхэд, 40 эцэг эхийг сэтгэл заслын үйлчилгээнд хамруулж, 232 хүүхэд хичээлийн хэрэгсэл, хөгжлийн хэрэглэгдэхүүнээр дэмжлэг үзүүлж, 100 хүүхдийн шүдийг эмчлүүлэн эрүүлжүүлсэн. Мөн 90 хүүхдийг Зуслан хөтөлбөрт хамруулж 117 хүүхэд гэр бүлийн орчинд нь хоол хүнс, хувцас, түлээ, эмийн дэмжлэг хүргэсэн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.</p> <p>Хамтарсан багийн гишүүдэд орон нутгийн төсвөөс 2021 онд 11 сая, 2023 онд 5.3 сая, 2024 онд 242 сая, 2025 онд хүүхэд хамгааллын зардлаас 10 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.</p>	
31	2.3.3.Хүүхдийг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хандлагыг төлөвшүүлэхэд байгууллагын эцэг, эхийн зөвлөлөөр дамжуулан хамтран ажиллана.	2020-2025	НБХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Улсын төсөв	60.0	Хамрагдсан иргэдийн тоо 8970	Хамруулсан иргэдийн тоо 12681	60.0	Улсын төсөв 60.0 Орон нутгийн төсөв 30	<p>2021-2025 онд 108 утсанд нийт 1262 дуудлага ирсний 98 хувийг, шийдвэрлэсэн байна. Ирсэн дуудлагын 90 гаруй хувь нь хүүхэд хамгааллын дуудлага бөгөөд гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн дуудлага эзэлж байна. Дуудлагын шийдвэрлэлтийн чанар, хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын "Хүүхдийн тусламжийн 108 утас"-ны үйлчилгээний төвийн ажилтнуудтай хамтран практикт суурилсан сургалтыг Баян-Өндөр сумын 27 багийн нийгмийн ажилтныг хамруулан зохион байгуулж, дуудлага тус бүрийг багийн нийгмийн ажилтан шууд хүлээн авч, түргэн шуурхай үйлчилгээг хүргэн ажиллах арга зүйд суралцсан.</p> <p>2021-2025 онд жил бүр хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор "нэгдүгээрт хүүхэд", "найз байя", "хүчирхийллийг мэдээлдэг байя", хүүхдээ зэрэг нөлөөллийн аян, хүүхдийн тусламжийн 108 утсыг олон нийтэд таниулах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах цахим нөлөөллийн ажил, сургалт ээлжит хяналт, шалгалт, хууль ёсны төлөөлөгчийн зөвлөгөө үйлчилгээ зэрэг Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус 19 байгууллагатай хамтран 57 удаагийн сургалт, олон талт арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 31422 хүүхэд, давхардсан тоогоор 40000 гаруй насанд хүрэгчдийг хамруулсан байна.</p> <p>Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Аврагч мазаалай", "Гүүмби Жүүмби" видео сургалтаар 9,321 хүүхэд хамрагдаж, "Аюулгүй амьдрах ухаан" хөтөлбөрийн хүрээнд 1,521 сурагчийг сургалтад хамруулсан. "Өсвөрийн сэргийлэгч" явган аялал, дадлага сургуулилтад 200 гаруй сурагч оролцсон бөгөөд ахуйн ослоос урьдчилан сэргийлэх теле хичээлийг 11,000 гаруй хандалттайгаар олон нийтэд хүргэсэн.</p> <p>Мөн байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхдийн</p>	100

										аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлээс хамгаалах чиглэлээр 1000 гаруй постер зөвлөмжийг хийж, байгууллагын фэйж хуудсаар дамжуулан эцэг, эх, иргэд, олон нийт, хүүхдүүдэд хүргэдэг. Хандалт давхардсан тоогоор 550000 гаруй байна.	
32	2.3.4.Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг сайжруулах ажлыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.	2020-2025	НБХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Улс, орон нутгийн төсөв	Улсын төсөв 130.0 Орон нутгийн төсөв 15.0	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо 15	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо 100	8.0 30.0	Улсын төсөв 18.0 Орон нутгийн төсөв 181.0	<p>2021 онд Залуучуудын ордны үйл ажиллагааны зардал болон гадна тохижилтын ажилд орон нутгаас 457.0 сая төгрөг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр лед дэлгэц, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх дундын оффис байгуулах зэрэг ажлууд хийгдэж, тус ордоор дамжуулж 20 багц арга хэмжээний хүрээнд 9000 гаруй залуучуудыг хамруулсан.</p> <p>2022 онд 60 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, 16000 гаруй залуучуудыг хамруулж, цахим хандалт 42740 байсан.</p> <p>2023 онд Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад чиглэсэн урлаг, спорт, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулсан.</p> <p>Залуучуудын ордонд сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх өрөөг тохижуулан, "Сэтгэл нэмье" төслийг хэрэгжүүлж, 250 гаруй эрчүүдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хүргэсэн. Мөн дартсын Эрчим клуб, Анза дуу бичлэгийн студи, бүжгийн Social dance клуб, шагай харваа, бийрэн бичиг, амьд хөгжмийн 1 хамтлаг хичээллэж хамтарсан ажлууд зохион байгуулж, 11 сонирхлын клубийн 200 гишүүд хамрагдаж байна. 2023 нийт санхүүжилтийн 82% нь сургалт нөлөөлөл олон нийт үйл ажиллагаа, залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, 18% нь тэтгэлэгт хөтөлбөрт зарцуулагдсан. 2023 онд нийтдээ 134 арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>2024 онд Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 37 багц сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 6298 залуучуудыг хамруулсан байна. Уг арга хэмжээнд "Уянга өдөр өнжүүлэх төв"-ийн багш нарт "Хандлага ба Харилцаа", "Залуу манлайлагч хөтөлбөр"-ийн сургалт, гар урлалын "Лаа хийж суръя", "Зорилготой хүүхэд-Бидний ирээдүй", байгууллага хамт олны бүлгийн уулзалт сургалт, өсвөрийн сэтгүүлч клубийн чадавхжуулах сургалт, слайд буюу PPT-хэрхэн загварлаг бэлтгэх мэдлэг олгох сургалт, Ерөнхий боловсролын 7-12 ангийн сурагчдад "Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог" , Орхон аймгийн Дартсын холбооны дэргэдэх дартсын спорт сонирхдог өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, Canva программын анхан шатны мэдлэг олгох, Тольт жиргээ өсвөрийн сэтгүүлч клубтэй хамтран уншсан номоо хамтдаа ярилцъя , арьс арчилгаа, нүүр будалт make up-ын сургалт, Хятад хэл, Солонгос хэл болон Unitel Hub-Хүүхдийн зохион бүтээх чадварыг хөгжүүлэх Робот угсралт инженерчлэл, Эх оронч залуу гэх мэт олон талт сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулснаар 10560 иргэн хамрагдаж нийт залуучуудын 48% хамруулсан.</p> <p>2025 онд Залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн 23 арга хэмжээнд, давхардсан тоогоор 12545 нийт залуучуудын 42 хувийг хамруулж ажилласан байна "Гэр бүлийн үнэ цэн" сургалтыг зохион байгуулж, 230 залуучуудыг хамруулсан. "Эрүүл оюутан-Эрүүл ирээдүй" аяны хүрээнд Эрүүл мэндийн газартай хамтран урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөөнд 2000</p>	100

										<p>залуучуудыг хамруулсан. Сэтгэл судлаач Б.Бямбасүрэнтэй хамтран ажиллаж, нийт 520 залуучуудад сэтгэл заслын ганцаарчилсан, сонирхлын бүлгүүдэд сэтгэл зүйчийн мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан</p> <p>Хамтран ажилладаг залуучуудын төрийн бус байгууллага 6-аар нэмэгдэж төрийн бодлого шийдвэрийг хамтран хэрэгжүүлж байна. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн 2025 онд орон нутгийн төсвөөр нийт 91 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>2021-2025 онд давхардсан тоогоор нийт 274 арга хэмжээг зохион байгуулаад байна.</p>	
33	2.3.5.Залуучуудын хөгжил, идэвхэжсэн хандлага, оролцоог дэмжинэ.	2020-2025	НБХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Улсын төсөв Орон нутгийн төсөв	60.0	Хамрагдсан залуучуудын тоо 5950	Хамрагдсан залуучуудын тоо 16000	60.0	Орон нутгийн төсөв 820.6	<p>2021 онд сайн дурын ажил хийх сонирхолтой 51 залууг бүртгэж, сайн дурын ажилд 30 залуучуудыг холбон зуучилж ажилласан. 2022 онд 60 гаруй байгууллага, 22 багийн залуучуудын салбар зөвлөл нэгдэн 80 гаруй сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулснаас бүтэн өнчин 19 настай залууг амьдрах гэртэй болгож, хашааны газрыг нь шийдэж, ажил орлоготой болгосон. Үйл ажиллагаандаа идэвхтэй оролцдог 15 гишүүнийг үнэмлэхжүүлсэн. "Чадах зүйлээрээ тусалъя" аяныг эхлүүлж өөрсдөө лаа, саван хийж борлуулалтын орлогыг Дундговь аймгийн "Ид шидийн уут" аянд хандивласан. Сайн дурын клубүүдтэй хамтран нийтдээ 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>2023 онд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, сайн дурын ажил хийх идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Гүие Түүе-Эко гэр бүл" бүх нийтийн гүйлт цэвэрлэгээ зохион байгуулж 100 гэр бүл, тамхины иш түүх, мэдлэгээ хуваалцах, тус дэм больё зэрэг 6 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж 1000 гаруй залуучууд, хүүхдийн тоглоомын талбайг засаж сайжруулах, тохижилтын ажил, сайн үйлсийн аян зэргийг зохион байгуулж 100 гаруй залуучууд, Жаргалант суманд малчин айлын малын тэжээлийн хашааг цэвэрлэх ажилд 50 гаруй залуучууд, "Сайн дурын ажил болон түүний ач холбогдол"-ын талаар ойлголт хэлэлцүүлэгт "ОРХОН-МСҮТ", "ХАА-н МСҮТ"-ийн суралцагчид 100 хүн тус тус хамруулсан. "Бүх хайраа гэр бүлдээ", "Талархлын 7 хоног", "Урам түгээх 7 хоног" сэдвүүдийн хүрээнд 12 постер мэдээллийг цахимд байршуулж 9263 хандалт авсан. Сайн дурын клубүүдтэй хамтран англи хэл, номын өдөрлөг, гадаадад суралцахаар зорьж буй хүүхэд, залууст ielts, toefl шалгалтад хэрхэн бэлдэх, шинэ цагийн илгээлтийн эзэд малчин, тариаланчдад туслах сайн дурын ажил, цаасны дахин боловсруулалт зэрэг сайн дурын ажлуудыг өрнүүлж 400 хүнийг хамруулсан байна. Сайн дурын клубүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлснээр сонирхлын бүлэг, клубийн тоо нэмэгдэж, шинээр олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж хамрагдалт 2300, цахим хандалт 9263 болсон.</p> <p>2023 онд Залуучуудын ордон, сайн дурын клубүүдээр дамжуулан 134 удаагийн арга хэмжээнд 17760 залуучуудыг хамруулсан нь аймгийн хэмжээний нийт залуучуудын 59 хувийг эзэлж байна.</p> <p>2024 оны залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй залуучууд болон өсвөр үе залуучуудад чиглэсэн арга хэмжээ спортын тэмцээн, өдөрлөг нийт 32 төрлийн нөлөөллийн аян, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 6650 залуучуудыг хамруулсан байна. Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 48 сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 4200 залуучуудыг хамруулсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт,</p>	100

										<p>гарааны бизнес сайн дурын ажлыг дэмжих холбон зуучлах ажлын хүрээнд "Ирээдүйн эзэд" мэргэжил сонголтын үндэсний аяныг зохион байгуулсан. Аяны үйл ажиллагаанд ерөнхий боловсролын 8 сургуулийн 9-12 дүгээр ангийн 150 гаруй сурагчид оролцсон. Залуучуудын ордны дэргэдэх сонирхлын 9 клубын залуучуудыг идэвхжүүлэх сургалт нөлөөллийн 10 багц ажлыг хамтран зохион байгуулж 1020 залуучуудыг хамрууллаа. Тайлант хугацаанд 72 удаагийн арга хэмжээнд 13200 залуучуудыг хамруулсан нь нийт залуучуудын 58 хувьд хүрч ажилласан байна.</p> <p>2025 онд залуучуудын боловсрол, хөгжлийг дэмжин 14 оюутанд 17.6 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг олгож, идэвх санаачилга гарган нийгэмд манлайлал үзүүлсэн 4 байгууллагыг шагнаж урамшуулсан. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог хангах чиглэлээр нийт 45 арга хэмжээ зохион байгуулж 28,209 залуучуудыг хамруулсан.</p> <p>1.Залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөлөөллийн 23 арга хэмжээг зохион байгуулж, 12,545 залуучуудыг хамруулж, 797,981 цахим хандалт, 4 байгууллага 6 албан хаагчдын нийгмийн баталгааг ханган нийт 11,620.5 мянган төгрөг зарцуулсан.</p> <p>2.“Залуучуудын соёлын фестиваль”-ийн хүрээнд 15 үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 10,150 залуучуудыг хамруулсан.</p> <p>3.Аймгийн хэмжээнд “MNS 7012:2023 – Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээний нийтлэг шаардлага” стандартыг хэрэгжүүлэхэд 5 арга хэмжээг зохион байгуулж 5160 иргэнийг хамруулсан.</p> <p>4.“Эх оронч залуу”, “Иргэний андгай өргөх ёслол” арга хэмжээнүүдэд нийт 354 залуучуудыг хамруулсан.</p>	
Шинжлэх ухаан, технологи, инновац											
Зорилт 2.4. Шинжлэх ухаан, технологийг аймаг, хотын тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай инновацыг хөгжүүлнэ:											
34	2.4.1.Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих, шинэ технологи нэвтрүүлэх, дамжуулах, судалгаа хөгжүүлэх, инновацыг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ЭШУТП	Орон нутгийн төсөв	270.0	Инновацыг дэмжих 10 төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлсэн.	Инновацыг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлсэн байна.	270.0	Гадаадын төсөл хөтөлбөр 32.0 Орон нутгийн төсөв 270.0	<p>2022 онд цаас, хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж түлш үйлдвэрлэх төсөл буюу "Агдир бүтэмж" ХХК, яс дахин боловсруулах үйлдвэр "Хос луу баян" ХХК, арьс шир боловсруулж "Handmade" бүтээгдэхүүн үйлдвэрлэх "Өндөрлөл" брэнд зэрэг 3 бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний технологийн хөгжүүлэлт, зах зээлд гаргах дээр бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж дэмжин ажилласан.</p> <p>2023 онд хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн төслийг инновацын төслөөр хөгжүүлэхээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. "Баяжуулагч-Одод" ХХК-ийн хатаасан аарц, "Идэрбаялаг" ХХК-ийн давсалсан махны хатаамал зэрэг инновац шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд тус бүр 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Цаасны хог хаягдлаар эко түлш боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй "Агдир бүтэмж" ХХК гарааны бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж үйлдвэрлэсэн түлшээ нөөцлөхөд зориулж 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. 11 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нэгдэн хоршоо байгуулж мөөг ургуулах хөрс үйлдвэрлэж байна. Ингэснээр сард 500 кг мөөгийг ургуулах боломж бүрдүүлээд байна. Иргэн Зулчимэгийн амттаны үйлдвэрлэл, "Ган компас" ХХК-ийн экспортын тоглоом үйлдвэрлэл, "Мөөг кластер" ХХК-ийн чипс үйлдвэрлэл, тариалалтын ухаалаг чингэлэг үйлдвэрлэл, эмийн мөөг тариалалт, "Бидэрт манхан" ХХК-ийн хуванцар эдлэл үйлдвэрлэл, "БМОМ" ХХК-ийн биомасс боловсруулах зэрэг 9</p>	100

										<p>төслийг дэмжин хөгжүүлж байна. 2024 онд Рийч органик косметик, Ган компас, Steam сургалт, Экора грийн гоулд, Ойстер гровинг субстрат, Бидэрт манхан, Талхны цех, Пенофасад, Мөөг кластер, Эко будаг гэсэн нийт 9 бизнес эрхлэгчид оффис, үйлдвэрлэлийн нийт 1,200 кв ажлын байр ашиглуулж, улирал тутамд сургалт, арга хэмжээнд оролцуулан ажиллаж байна. БШУЯ-ны Эрдэм хакатон арга хэмжээнд Экора грийн гоулд ХХК шилдгээр шалгарч 20 сая, ХНХЯ-аас зохион байгуулсан улсын уралдаан"-нд Ган компас компани шилдгээр шалгарч 20 сая төгрөгийн грант тус тус авсан.</p> <p>2025 онд ЭШУТП-аас инновацын сургалтыг 3 удаа зохион байгуулж 50 бизнес эрхлэгчийг хамруулсан. Нэхмэл болон цаасны хаягдал ашиглан барилгын дүүргэгч материал үйлдвэрлэх технологийн туршилт, судалгаа хийж бизнес эрхлэгчид дамжуулах ажлыг зохион байгуулсан. ЭШУТП-аар дамжуулан 150 иргэнд кластер үйлдвэрлэл, бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслийн тоног төхөөрөмж гэрээгээр ашиглуулах, хяналт тавих ажил хийгдсэн. "Өнгө нэм" ТББ-тай хамтран дахивар бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр гарааны компанийн арга хэмжээ зохион байгуулж 5 бизнес эрхлэгчийг бүртгэн үе шаттай зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.</p>	
35	2.4.2.Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн паркыг түшиглэн боловсрол, эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгох, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ,Э ШУТП	Орон нутгийн төсөв	33.0	5 оюутан, судлаач	Боловсрол, эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгох, оюутан, судлаачдыг хөгжүүлэх	33.0	Орон нутгийн төсөв 33.0	<p>Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн хүүхдүүдийг байгалийн ухааны хичээлд сонирхолтой болгох, улмаар ирээдүйн чадварлаг инженерүүдийг төрүүлэх зорилгоор ЕБС-ийн физик, мэдээлэл зүйн хичээлийн агуулгад тохирсон туршилтуудыг сонирхолтой хэлбэрээр хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй, системтэй мэдлэг олгоход анхааран ажиллаж байна. STEAM боловсрол олгох ШИМТ+ЭРДЭНЭТ дугуйлан энэ онд 5 мэргэжлийн багш, 150 орчим хүүхдүүдэд сургалт өгсөн. "Судлаач-Энтрепренер" хөтөлбөр хэрэгжүүлж инновацын төсөл, гарааны компани хөгжүүлэх 18 залуу судлаач, оюутны төсөл хүлээн авч, оролцогчдыг 2 сарын турш сургалтад хамруулан сонгон шалгаруулалтаар 1 дүгээр шатанд шалгарсан ШУТИС-ийн 2 оюутныг төслөө хэрэгжүүлэхэд ажлын байраар хангаж, 1 төсөлд нь 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн 120 оюутны дунд гарааны бизнесийн уулзалт зохион байгуулж, 20 оюутны баг бүрдүүлэн зөвлөн ажилласан. Хүүхэд залуучуудад программ, код хөгжүүлэх сургалт явуулж буй "Код лаб" сургалтын төвд орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн өртөг бүхий 12 ширхэг зөөврийн компьютер олгосон. Тус сургалтын төвөөс 62 сурагчийг программ, код хөгжүүлэх сургалтад хамруулж чадавхжуулсан. 2024 онд Орхон политехник коллеж, Эрдэнэт ШУТП-ийн удирдлага, албан хаагчид хоёр талын ажилтай танилцан 3 удаагийн уулзалт зохион байгуулж "Хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд багш, ажилтан, оюутнуудын гарааны бизнест дэмжлэг үзүүлэхээр оёдлын 8 ширхэг тоног төхөөрөмж гэрээгээр ашиглуулж эхэлсэн. Мөн коллежийн дэргэд гарааны бизнес хөгжүүлэхээр залуу ажилтнуудын төслийн багтай хамтран ажилласан.</p>	100
36	2.4.3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг салбар бүрд нэвтрүүлэхэд	2020-2025	ХБТХОХ, ЭШУТП	Орон нутгийн төсөв	185.0	Орон нутгийн цахим шилжилтийн индекс	Орон нутгийн цахим шилжилтийн индекс 1	185.0	185.0	<p>Дижитал эдийн засаг Smart-Эрдэнэт платформын хөгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хувийн хэвшилтэй хамтран Эрдэнэтэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Erdenet.24 аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд сурталчлах, борлуулах ажил хийгдэж байна. Орон нутгийн цахим шилжилтийн индекс 0.9 байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь Аймгийн хэмжээнд үйл</p>	90

	дэмжиж ажиллана.					0.5				ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, сургууль цэцэрлэг, Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, сумдуудын Засаг даргын Тамгын газрын баримт бичиг, албан хэргийн хөтлөлт, цахим архив зэрэг нэн шаардлагатай программ хангамжуудыг нэгтгэсэн И-Оффис системийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нэг удаа төлбөр төлөн 2018 оноос нэвтрүүлэн цахим, онлайн системийг ашиглан ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн 2023 оны I улирлаас улсын хэмжээнд төрийн байгууллагуудтай цахимаар албан бичиг солилцох нөхцөл боломжийг бүрдүүлж үйл ажиллагааг нь дэмжин улсын хэмжээнд албан бичиг солилцооны дундын систем болох https://docx.gov.mn -д холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. И-Оффис системийн цахим гарын үсгийн дэд системийг аймгийн хэмжээнд 21 байгууллага ашиглаж байна. Энэ онд нийт 2329 албан бичиг тоон гарын үсгээр баталгаажих илгээгдсэн байна	
Хүнд ээлтэй амьдрах орчин											
Зорилт 2.5. Эрүүл, аюулгүй, баталгаат орчныг бий болгоно:											
37	2.5.1. Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшигийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдийг нүүлгэн шилжүүлэх аюулгүй бүс тогтоож, үүсэж болзошгүй аваар, ослыг бууруулна.	2020-2025	ТЗУХ, ОБГ	Орон нутгийн төсөв	10.0	-	Иргэдийг нүүлгэн шилжүүлэх бүс тогтоож, үүсэж болзошгүй аваар, ослоос урьдчилан сэргийлэх	10.0	Орон нутгийн төсөв 29.7	<p>2021-2023 онд Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Баян-Өндөр сум, Хот тохижуулах газар зэрэг байгууллагууд хамтран сар бүр 2 удаа төлөвлөгөөт үзлэг хийж 66.3 км шороон сувгийг сэргээж ухах, жилд 4 удаагийн үерийн сувгийн их цэвэрлэгээг зохион байгуулан 5763м3 хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн давхардсан тоогоор авто замын 42ш гарц хог хайргаар бөглөрснийг цэвэрлэсэн. Мөн үерийн үед дрон нисгэж эрсдэлийг үнэлэн иргэдэд тухай бүрд мэдээ мэдээллийг өгч сэрэмжлүүлэн ажилласан.</p> <p>УЦУОШТ-өөс гаргаж байгаа цаг агаарын болон орчны бохирдлын анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг масс мессежээр аймгийн Онцгой комиссын 36 гишүүд, ААНБ-ын 25 дарга, 29 багийн Засаг дарга, Жаргалант сумын ИТХ, сумын ЗДТГ-ын 11, БЗА, Барилга, замын компани 22, Жаргалант сумын малчид, тариаланчид, ногоочид 83 хүнд Утсаар-7 байгууллага, аж ахуй нэгжид, G-mail хаягаар, E-office программаар 2460 төрийн албан хаагчдад 11424 удаа, мэйл хаягаар 3192, Orkhon.weather.gov.mn, Байгууллагын Фэйсбүүк хаяг, Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв пэйж хаягаар мэдээлсэн.</p> <p>Хагас хоног, 1, 5 хоногийн мэдээ 334 удаа, 7 хоногийн мэдээ 47 удаа, сарын төлөв 11 удаа, улирлын төлөв 11 удаа, анхааруулах мэдээ 40 удаа, сэрэмжлүүлэх мэдээ 15 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ 1 удаа, нислэгийн цаг агаарын замын мэдээ 24 удаа, 3 төрлийн урьдчилсан мэдээ 138 удаа, ой хээрийн түймрийн анхааруулах мэдээ 107 удаа, сэрэмжлүүлэх мэдээ 80 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ 51 удаа зохиосон байна. Өнгөрсөн хугацааны 1 хоногийн тойм мэдээ 334, 7 хоногийн тойм мэдээ 47 удаа зохиосон.</p> <p>Ой хээрийн түймрийн анхааруулах мэдээ 107, сэрэмжлүүлэх мэдээ 80, урьдчилан сэргийлэх мэдээ 51 удаа гаргаж ОБГ, БОГ, Сум дундын ойн ангийн мэргэжилтэнд өдөр бүр мэдээлж байна. Нэн аюултай буюу урьдчилан сэргийлэх түвшинд хүрсэн тухай бүр сайт болон фэйсбүүк, мэйлээр анхааруулах мэдээ зарлаж байна.</p> <p>ETzone.mn, Enguun.mn гэсэн 2 сайттай гэрээ байгуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 төрлийн видео шторк, гал унтраагуур хэрхэн ашиглах заавар зөвлөмж нийт 3 төрлөөр бэлтгэн Орхон аймгийн Онцгой байдлын газар фэйсбүүк пэйж хуудас болон 2 сайт, 2 тв-ээр дамжуулан түгээж, гамшгаас</p>	100

										хамгаалах урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх чиглэлээр нийт 331 мэдээллийг түгээж, давхардсан тоогоор 2.752.379 иргэний хандалтыг авсан байна. Орхон аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд түр хоргодох байраар ашиглах боломжтой барилга сургууль, цэцэрлэг, спорт заал нийт 21 байгууламжийг 12930 орны хүчин чадалтай байхаар төлөвлөн, гамшгийн үед шаардлагатай бүх төрлийн нөөцийн тооцоо судалгааг Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран гаргаж тодотгол, бүртгэл хийж ажиллалаа.	
38	2.5.2.Гэр хорооллыг дахин төлөвлөж байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга, байгууламжийг нэмэгдүүлэх, дэд бүтэц барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	-	-	-	Гэр хорооллыг дахин төлөвлөж, ногоон барилга, дэд бүтцийг үе шаттайгаар барина.	-	Орон нутгийн төсөв 1050.0	Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах зорилгоор 2022 онд 49 өрхөд, 2023 онд 60 өрхөд, 2024 онд 73 өрхөд, 2025 онд 63 өрхөл тус тус монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгож гэр хорооллын яндангийн тоог 1245 ширхгээр бууруулсан. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 2024 онд Хабрид хаус ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн 3500 м3 талбай бүхий 28-р цэцэрлэг, 3397 м3 талбай бүхий төрийн байгууллагуудын байранд халаалтын зориулалт бүхий 50 кВт-ын дулааны коллектор, цахилгаан эрчим хүчээр хангах 20 кВт-ын нарны зайн системээр дэмжигдсэн газрын гүний дулаанаар шийдвэрлэх 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг Smart Энержи ХХК гүйцэтгэсэн. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллан туршилт тохируулгын ажил явагдаж байна. Туршилт тохируулгын үеэр уурын зуухны галлагаа хийгдээгүй ба Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн халааж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэж байна.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд БОУАӨЯ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Баян-Өндөр сумын гэр хорооллын 19 м.кв хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусган айлуудтай гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. 17-р сургуулийн уурын зуухыг шинэчлэх, бие даасан эрчим хүчний үүсвэртэй болгож, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор "Гор газ" ХХК бүрэн автоматжуулагдсан 1400 квт-ын хүчин чадалтай, тохируулга бүхий хяналт удирдлагын систем, хийн түлшний усан халаалтын зуухыг суурилуулсан. Мөн гэр, байшингийн халаалтын эх үүсвэрээ өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалтаар шийдвэрлэж, яндангаа буулгасан 184 өрх нэмэгдсэнээр өссөн дүнгээр 379 өрх эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлээ.	100
39	2.5.3.Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	Орон нутгийн төсөв	163.9	-	Инженерийн хийцлэлтэй үерийн сувгийг нэмэгдүүлэх	163.9	Орон нутгийн төсөв 163.9 Гадаад зээл тусламж	Аймгийн хэмжээнд 72.8 км шороон үерийн суваг байгаагаас инженерийн хийцлэлтэй 10.2 км, далд 11.0 км, 51.6 км нь байгалийн гуу жалга болон авто замын ус зайлуулах хаялга байна. Болзошгүй аваарын зардлаар Их залуу багийн Баруун задгай 18, 19 дүгээр гудамжны үерийн суваг 165м суваг, Даваат багийн Зураагийн 1, 2 дугаар гудамжинд 153м суваг шинээр хийгдсэн. 2021-2023 онд Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Баян-Өндөр сум, Хот тохижуулах газар зэрэг байгууллагууд	100

									10.3 сая доллар	<p>хамтран сар бүр 2 удаа төлөвлөгөөт үзлэг хийж 66.3 км шороон сувгийг сэргээж ухах, жилд 4 удаагийн үерийн сувгийн их цэвэрлэгээг зохион байгуулан 5603 хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн давхардсан тоогоор авто замын 42ш гарц хог хайргаар бөглөрснийг цэвэрлэсэн.</p> <p>2024 оны 05 дугаар сараас 07 дугаар сарыг дуустал хугацаанд инженерийн хийцлэлтэй үерийн далан, байгалийн судаг, шуудуунд тогтмол үзлэг хийж ажиллаж, нийт давхардсан тоогоор 55 км урт далан шуудуунд үзлэг хийж 160м3 хог шороо цэвэрлэж тээвэрлэсэн. Мөн хавар, намрын улиралд 23.4 км урт шороон суваг, шуудууг сэргээж ухах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хотын доторх үерийн сувгийг сэргээн засварлах, Зэст, Уртбулаг, Согоот багуудад байрлах үерийн усны трап засварын ажлыг хийж гүйцэтгэж, үерийн үед дрон нисгэж эрсдэлийг үнэлэн иргэдэд тухай бүрд мэдээ мэдээллийг өгч сэрэмжлүүлэн ажиллаж байна.</p> <p>"Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй хот" төслийн хүрээнд хийгдэх үерийн даланг шинэчлэх ажил 2025 онд Баян-Өндөр сумын хэмжээнд 5 байршилд хийгдэж байгаа ба суваг-А 60 хувь, суваг-D 70 хувь, суваг-Е 20 хувь, суваг-В 90 хувийн гүйцэтгэлтэй байна. 2А хороололд хийгдэх Н сувгын ажил 2026 онд хийгдэхээр төлөвлөж байна. Нийт 12.8 км үерийн бетонон суваг 3 байршилд усан сан барихаар төлөвлөж ажил хийгдэж байна.</p>	
40	2.5.4.Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ.	2020-2025	ТЗУХ, ОБГ	Орон нутгийн төсөв	37.0	-	Ашиглалтад оруулснаар	37.0	Орон нутгийн төсөв 351.9	<p>Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бие бүрэлдэхүүний чадавхыг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд шуурхай албаны тусгай зориулалтын Бонго загварын авто машинтай болсон. Алба хаагчдын ажиллах орчныг сайжруулах чиглэлээр Гал түймэр унтраах аврах 81 дүгээр ангид 2.6 сая төгрөгийн засварын ажлыг хийж, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг чадавжуулах дадлага, сургалтын 4 давхар цамхаг барих ажлыг бүрэн дуусгаж, гадна 100 м гүйлтийн асфальтан замтай болоход нийт 149.8 сая төгрөг зарцуулсан. Мөн гамшиг, ослын үед гал унтраах бодис зөөвөрлөх, тээвэрлэхэд ашиглах 71.5 сая төгрөгийн өртөг бүхий нисгэгчгүй нисэх төхөөрөмж, 28.0 сая төгрөгөөр хөдөлгөөн, дулаан мэдрэгчтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмж тус бүр нь 25 сая төгрөгийн өртөг бүхий 4ш дулаан, хөдөлгөөн мэдрэгчтэй 2 нүдний дуран худалдан авч гамшигийн үед үүрэг гүйцэтгэх чадавхаа нэмэгдүүлсэн. Гал түймэр унтраах, аврах 68 дугаар ангийн газрыг аймгийн Засаг даргын 2025 оны А/58 дугаар захирамжаар 20 жилийн хугацаатай баталгаажуулж, кадастр, газар эзэмших гэрчилгээг гаргуулан 33724 м/кв газарт Архитектур төлөвлөлтийн даалгавар хийлгэж бэлэн болгосон. Эрэн хайх, аврах цогцолборт баригдах 7 объектын барилгын ажлын зураг Гал түймрийн улсын хяналтын байцаагчаар хянагдан баталгаажсан. Галын аюулгүй байдлын тухай хууль холбогдох дүрэм, журам, стандарт зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага, иргэнд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэн ажиллаж байна.</p>	100
41	2.5.5.Хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.	2020-2025	ХБТХОХХХ ААГ	Орон нутгийн төсөв	2.0	Гэрчилгээ эжиж, баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хувь 70	Гэрчилгээ эжиж, баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хувь 80	2.0	Орон нутгийн төсөв 22.0	<p>Аймгийн хэмжээнд 92 үйлдвэрлэл, 481 үйлчилгээ тогтвортой ажиллаж байгаагаас СХЗХ-ээс 20 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 186 хүнсний чиглэлийн үйлчилгээ, Мон Майнинг Сертификат ХХК -наас 5 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 9 хүнсний чиглэлийн үйлчилгээ, нийт 221 үйлдвэр, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгон баталгаажуулснаар өссөн дүнгээр нийт 43 аж ахуйн нэгж, иргэний /46,7 хувь/ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 448 /93 хувь/ хүнсний чиглэлийн үйлчилгээ нийт 85.6% нь тохирлын баталгаатайгаар зах</p>	100

										<p>зээлд нийлүүлэгдэж байна. Үйлдвэр, үйлчилгээнд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулах дотоод хяналтын тогтолцоо, зохистой дадлыг хэрэгжүүлэх арга зүйгээр хангаснаар 186 цэгт стандартын хэрэгжилт хангалттай түвшинд /81 хувиас дээш/ хүргэж гэрчилгээжүүлсэн, өссөн дүнгээр 533 цэг тохирлын баталгаатайгаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, 351 буюу 57.9 хувь нь стандартыг хангалттай түвшинд хэрэгжүүлсэн байна.</p> <p>Тус аймгийн 1374 ААН, иргэний 6283 сорьцод 18433 үзүүлэлтээр хими, нян судлал, үр хорио цээрийн шинжилгээг хийж гүйцэтгүүлсэн. Эерэг үзүүлэлттэй гарсан 322 сорьцын хариуг холбогдох улсын байцаагчид хүргүүлсэн. Сорилтод хамрагдсан нийт дээжийн 94.8% нь стандартад нийцсэн байна.</p> <p>Аймгийн хэмжээнд Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019, Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР) буюу MNS CAS /RCP 1:2003 стандартыг хэрэгжүүлэн гэрчилгээжсэн мал төхөөрөх, мах боловсруулах 3 үйлдвэр ажиллаж байна. Хүнсний худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэлд зохистой дадлыг хэвшүүлэх сургалтыг 2024 онд 264 аж ахуйн нэгж, байгууллагын 351 хүнд зохион 2025 онд 266 байгууллагын 302 хүнд зохион байгуулж мэдлэг олголоо.</p> <p>Аймгийн Засаг даргын 2024 оны А/353 тоот захирамжийн дагуу Хүнсний худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэлд зохистой дадлыг хэвшүүлэх сургалтыг 264 аж ахуйн нэгж, байгууллагын 351 хүнд, хүнсний 5 үйлдвэрлэлд НАССР болон Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, хүнсний чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгч 19 аж ахуйн нэгж, 4 иргэн, үйлчилгээ эрхлэгч 244 аж ахуйн нэгж, 5 иргэний үйл ажиллагаанд холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, стандартын хэрэгжилтийн түвшнийг дээшлүүлэх арга зүйгээр хангаснаар нийт 19 аж ахуйн нэгж, 4 иргэний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 244 хүнсний чиглэлийн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. 2025 онд хүнсний чиглэлийн 195 үйлчилгээ, 25 үйлдвэр, нийт 220 үйлдвэр, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгон баталгаажуулснаар өссөн дүнгээр нийт 43 аж ахуйн нэгж, иргэний /46,7 хувь/ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 448 /93,0 хувь/ хүнсний чиглэлийн үйлчилгээ, нийт 491 цэг тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж байгаа нь 85.6 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэгтэй 18 байгууллагын 31 нэр төрлийн 247 бүтээгдэхүүн, "Баталгаажсан үйлчилгээ" тэмдэгтэй 5 нэр төрлийн 17 аж ахуйн нэгжийн 19 үйлчилгээ байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, орон сууцанд амьдрах боломжийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг тэлэн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилт 3.1. Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ:

42	3.1.1.Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх, ахмадын хөгжлийн төвүүдийг нэмэгдүүлж, тэдгээрийн ажиллагааг дэмжинэ.	2021-2025	НБХ, ХХҮГ	Орон нутгийн төсөв	40.0	Ахмадын хөгжлийн төвүүдийн тоо 9	Ахмадын хөгжлийн төвүүдийн тоо 14	40.0	Орон нутгийн төсөв 40.0	<p>Аймгийн хэмжээнд сум, багийн ахмадын хороо, зөвлөл 32, аж ахуйн нэгж, байгууллагуудын дэргэдэх ахмадын хороо, зөвлөл 24, мэргэжлийн болон бусад чиглэлээр ахмадын үйл ажиллагаа явуулдаг 10 ТББ, нийт 66 хороо, зөвлөл тогтмол ажиллаж байна. Үүнээс Баян-Өндөр сумын 15 баг ахмадын байртай бөгөөд 2025 онд Жаргалант сумын Ахмадын ордон ашиглалтад орж үйл ажиллагаа эхэлсэн. Аймгийн Ахмадын ордонд ахмад настанд зориулсан алжаал тайлах өрөө, номын сан, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөг шинээр тохижуулан ажиллуулж өдөрт 30-45 ахмад тогтмол үйлчилгээ авч байна. Мөн номын сангийн фондыг нэмэгдүүлэн 1500 орчим номоор баяжуулсан. Сэтгэл</p>	100
----	--	-----------	-----------	--------------------	------	----------------------------------	-----------------------------------	------	-------------------------	--	-----

										зүйн танхимаар бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөг 1300 гаруй ахмадад, ганцаарчилсан зөвлөгөөг 85 ахмадад үзүүлсэн.Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээний хүрээнд 800 ахмадад сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө, үйлчилгээг мэргэжлийн байгууллагатай хамтран үзүүлсэн.	
43	3.1.2.Ахмад настанд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2021-2025	НБХ, ХХҮГ	Орон нутгийн төсөв	35.0	-	Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	35.0	Орон нутгийн төсөв 210.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор ахмад настны Ач санах” хөтөлбөрийг батлуулан, тайлант хугацаанд ахмад настанд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан. Эрүүл мэндийн үзлэгт 15.4 мянга, өдрийн үйлчилгээнд 1013, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 134 хүнд 144.7 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгт 92 хүнд 535.5 мянган төгрөг, нийтдээ төрөл бүрийн сургалт, урлаг спорт, бусад үйл ажиллагаанд давхардсан тоогоор 37.0 мянга гаруй ахмад хамрагдаж хөтөлбөр хэрэгжих хугацаанд 250.0 сая төгрөг орон нутгийн төсвөөс зарцуулж хөтөлбөрийн хэрэгжилт 91.4%-тай үнэлэгдсэн. Ахмадын зуны саам сувиллын үйл ажиллагаанд жилд 250 ахмад, сар шинийн хүндэтгэлд 3300 гаруй ахмад хамрагдаж орон нутгийн төсвөөс санхүүжилтийг шийдвэрлэсэн. 2025 оны байдлаар 6632 ахмад насны хишиг, алдар цолтой 116 ахмад, халамжийн тэтгэвэр авагч 258 ахмад, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 15.3 мянган ахмад, байнгын асаргаатай 1.1 мянган ахмад, зорилтот бүлгийн 600 гаруй ахмад настанд холбогдох хууль, журмын дагуу тусламж үйлчилгээг тогтмол олгож байна.	100
44	3.1.3.Ахмад настан болон анхдагч илгээлтийн эздэд зориулсан төсөл хэрэгжүүлж, залуу үеийн залгамж холбоог хангана.	2021-2025	НБХ, ХХҮГ	Орон нутгийн төсөв	65.0	Анхдагчд ад чиглэсэн арга хэмжээний тоо 5	Анхдагчдад чиглэсэн арга хэмжээний тоо 11	65.0	Орон нутгийн төсөв 65.0	Ахмад настан болон анхдагч илгээлтийн эздэд зориулсан Анхдагч хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд ахмад настнуудад чиглэсэн соёл урлаг, спортын уралдаан тэмцээн, аялал жуулчлал, олон нийтийг хамарсан сургалтууд, шинээр ахмад настны өрөөг тохижуулах, хүндэтгэл үзүүлэх зэрэг арга хэмжээг анхдагч илгээлтийн эздэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг “МАНЗ-Баатар” холбоо, Төрийн байгууллагуудын “Соёмбо” холбоо, “Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо”, “Барилгачин дайчдын холбоо”, “Залуу насаа эргэн дурсахуй” холбоо, “Эрдэм” зэрэг 6 холбоодод бүртгэлтэй 2000 гаруй анхдагч ахмадад чиглэсэн үйл ажиллагаанд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж 180.0 сая төгрөг орон нутгийн төсвөөс зарцуулсан. Анхдагч, илгээлтийн эздийн 50 жилийн ойн тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Эрдэнэт үйлдвэрийн дэмжлэгээр 2.3 тэрбум төгрөгийн урамшууллыг нийт ахмадуудад олгож, 3000 анхдагч ахмадуудыг 50 жилийн ойн медалиар шагнасан. Андагчдын дунд 30 гаруй удаагийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 6000 гаруй анхдагч, ахмадууд хамрагдсан.	100
45	3.1.4.Ахмад настны оюуны болон мэргэжлийн туршлага, чадавхыг ашиглах, нийгмийн амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээ үзүүлж хувь нэмрээ оруулахад нь дэмжлэг үзүүлнэ.	2021-2025	НБХ, ХХҮГ	Орон нутгийн төсөв	10.0	-	Ахмадыг зөвлөх үйлчилгээнд хамруулж, мэдлэг чадвар туршлагыг хуваалцана.	10.0	Улсын төсөв 298.0 сая, Орон нутгийн төсөв 191.9	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд 2021 онд 17, 2022 онд 21, 2023 онд 30, 2024 онд 44, 2025 онд 39 ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдаж 144.7 сая төгрөгийн санхүүжилт авч, эрх зүй, сэтгэл зүй, гар урлал, угийн бичиг сургалт, Монгол бичиг сургалт, зодог шуудаг урлал, сүү цагаан идээ боловсруулах, ахмадын манлайлал зэрэг чиглэлээр сургалт зөвлөгөөг иргэд, ААНБ-д өгч ажилласан. Мөн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 92 ахмад хамрагдаж 535.5 сая төгрөгийг зарцуулсан.	100
Зорилт 3.2.Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот											

бүлэгт хүргэж, ил тод, нээлттэй байдлыг хангана:

46	3.2.1.Нийгмийн халамжийн үйлчилгээг шаттайгаар цахимд шилжүүлнэ.	2020-2025	НБХ, ХХҮГ	УТ	-	85%	100%	-	-	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 08 дугаар сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь ehalatj.mn цахим системд үе шаттайгаар шилжиж эхэлсэн. 2020 онд 6, 2021 онд 26, 2022 онд 40 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлснээр 2023 оноос нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээ 100% цахимжсаны үр дүнд иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд цахимаар хамрагдаж, өргөдөл хүсэлтээ гаргах боломж бүрдсэн.	100
47	3.2.2.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.	2020-2025	НБХ, ХХҮГ	Орон нутгийн төсөв	137.9	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 431	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 438	137.9	Орон нутгийн төсөв 881.5	2020-2023 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 532.7 сая төгрөг батлагдсан. Онцгой тохиолдлын тэтгэмжид 161 иргэнд 188.8 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд 12 төрийн бус байгууллагатай хамтран 1239 иргэнийг хамруулсан зорилтот арга хэмжээнд 306.5 сая төгрөгийг зарцуулсан. 2024 онд онцгой тохиолдлын тэтгэмжид 48 иргэн хамрагдаж, 57.6 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 5 байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлж, 355 иргэнийг хамруулан 80.3 сая төгрөгийг зарцуулсан. Нийтдээ 403 иргэнд 137.9 сая төгрөг зарцуулсан. "Аминчхан яриа" ТББ-тай гэрээ байгуулан байнгын асаргаа шаардлагатай иргэдийн асран хамгаалагч болох 60 иргэнд асаргааны сургалт зохион байгуулж 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөлд 12 бүлгийн 24 иргэний төсөл шалгарч 18.4 сая төгрөгийн дэмжлэгийг буцалтгүйгээр олгосон. 2025 онд Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 192.5 сая төгрөг батлагдсанаас гэр оронгүй тэнэмэл иргэдийг түр байрлуулах үйлчилгээг 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 02 дугаар сарын хооронд зохион байгуулж 30 иргэнийг хамруулан нийгмийн халамжийн сангаас 27.6 сая төгрөгийг зарцуулсан. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламжид 31 иргэн хамрагдаж, 37.2 сая төгрөгийг зарцуулсан.	100
48	3.2.3.Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг батлагдсан аргачлалын дагуу явуулна.	2020-2025	НБХ, ХХҮГ	Улсын төсөв	16.2	2017 онд 19378	ХХҮЕГ-аас ирүүлсэн жагсаалтын дагуу судалгааг авсан байна.	16.2	Орон нутгийн төсөв 21.2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай" А/36 тоот тушаал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16-А/04 тоот хамтарсан тушаал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/84 дугаар тушаалыг тус тус үндэслэн Аймгийн хэмжээнд "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох хосолмол аргачлал"-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж 1078 өрхөөс судалгааг авч мэдээллийн санд оруулсан. Төрийн байгууллагуудын холбогдох мэдээллүүдтэй тулгаж, өрхийн үнэлгээг хийх ажлыг ХНХЯ-аас хийж гүйцэтгэсэн. Мөн уг судалгааг аймгийн хэмжээнд 2025 оны 02-р сарын 03-наас 02 дугаар сарын 17-ныг дуустал хугацаанд 15 хоногийн хугацаанд	100

нийт 4428 өрхөөс мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулан ажилласан. Уг мэдээллийн санд үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг тодорхойлох болон хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний босго оноо шинэчлэн батлагдсан.

Орлогод нийцсэн орон байр

Зорилт 3.3. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах бодлогыг дэмжинэ:

49	3.3.1.Иргэдийг зээлийн нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох төсөл хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ХББЗА, ОНӨГ	Орон нутгийн төсөв	12049.3	-	Орлогод нийцсэн орон сууц хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх.	12049.3	Орон нутгийн төсөв 3920.2	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Орон сууцны хөтөлбөр”-ийг батлуулсан бөгөөд энэ ажлын хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Уртын гол багт 5 блок бүхий 260 айлын орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Тус барилгын төсөвт өртөг 27.4 тэрбум төгрөгөөс 24.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласнаар одоогийн байдлаар 4 блок 100 хувийн гүйцэтгэлтэй ашиглалтад орлоо. Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны А/462, 2023 оны 11 сарын 15-ны өдрийн 867 дугаар захирамжаар тус тус 260 айлын орон сууцны байрыг ашиглалтад орсны дараа орон нутагт хүлээн авах, иргэдийн өргөдлийг шийдвэрлэж оруулах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. 2023 оны 07 дугаар сард эхний ээлжийн 2 блок 104 айлын, 2024 оны 02 дугаар сард 3 дугаар ээлжийн 52 айлын, нийт 156 айлын орон сууцны байрыг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авч иргэдийг оруулах ажлыг зохион байгуулсан. 4 дүгээр ээлжийн орон сууцны барилгыг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисс 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 27/2024 дугаартай "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт"-ээр хүлээн авч 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр smarterdenet.mn сайтаар уг байрнаас худалдан авах хүсэлтэй иргэдийг бүртгэсэн бөгөөд 1024 иргэн бүртгүүлснээс шаардлага хангасан 45 иргэнд байрыг худалдан борлуулсан. Орон сууцны үнэ м.кв нь 1.9 сая төгрөг буюу зах зээлийн ханшнаас 30-40%-иар хямд байна. 5 дугаар блокийн байр 2026 оны 1 дүгээр улиралд ашиглалтад орох бөгөөд тухайн байрыг ашиглалтад орсны дараа иргэдэд худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан. Орон сууцны үнэ м.кв нь 1.9 сая төгрөг буюу зах зээлийн ханшнаас 30-40%-иар хямд байна.	100
50	3.3.2.Айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгох дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад дэмжлэг үзүүлж ажиллана.	2020-2025	ХБТХОХ	Орон нутгийн төсөв	2900.0	-	Айл өрхийг инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсох нөхцөлийг бүрдүүлэх	2900.0	Орон нутгийн төсөв 8000.0 Улсын төсөв 4470.0	Дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд Их залуу багт 40.8 га, Эрдэнэ багт 2.4 га Уртын гол багт 1.8 га Чандмань багт 3 га. Найрамдал багт 11.9 га Оюут багт хоёр байршилд нийт 52 га, Говил 22.6 га Баянцагаан багт 8.5 га Уурхайчин багт 1.3 га талбайд хот дахин төлөвлөлтийн байршлаар сонгон орон сууцжуулах төслийг эхлүүлэн ажиллаж байна. Цагаанчулуут багт 11.9 га, Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийг хийж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхлүүлснээр хэрэгжилт 40 хувьтай, Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төслийг хийлгэж 2025 оны 12-р сарын 04-ний өдрийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Мөн Эрдэнэ багт 2.5 га талбайд Эрчим хүчний хэмнэлтэй амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр Хабридаус ХХК шалгарч гадна инженерийн шугам сүлжээний ажил бүрэн хийгдсэн. Нийт ажлын явц 30 хувь. Мөн Оюут багт	100

										<p>Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна.</p> <p>Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багт Уурхайчин-1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10га талбайд хийлгэж байгаа ба зураг төсөл боловсруулах ажил 95 хувьтай. Барилгын хөгжлийн төвөөр магадлалаар хийлгэхээр хүлээгдэж байна.</p> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2.9 тэрбум төгрөгөөр гэр хорооллын 7 багт инженерийн шугам сүлжээний ажил хийсэн. Булаг багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.943 км, цэвэр усны 0.943 км, бохирын 0.489 км, Рашаант багт Дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 1.63 км, цэвэр усны 1.63 км, Наран багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 1.14 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.52 км, Цагаанчулуут багт бохир усны 0.76 км, , Баянцагаан багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.98км, Дэнж багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.88 км, цэвэр усны 0.88 км, бохир усны 0.26 км, Говил багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 2.22 км, нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Ингэснээр 1245 өрх ИШС-нд холбогдох нөхцөл бүрдлээ.</p>	
Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес											
Зорилт 3.4 Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ:											
51	3.4.1.Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	ажил,	2020-2025	НБХ, ХХҮГ	Улсын төсөв	47.9	-	47.9	Улсын төсөв 204.4	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс жил бүр баталж хэрэгжүүлдэг "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр"-ийн хүрээнд 2020-2025 онуудад мэргэжил олгох сургалтыг аймгийн Орхон, ХАА-н МСҮТ-үүдтэй хамтран хийж, цахилгаанчин, тогооч, барилгын засал чимэглэлч, гагнуурчин, үсчин, оёдолчин 13 мэргэжлээр нийт 446 иргэнийг хамруулан ур чадварын гэрчилгээ олгож, сургалтын зардалд 134.3 сая төгрөг зарцуулсан. 2020-2023 онуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, ганцаарчилсан болон бүлгийн сургалт зэрэгт 6273 иргэн хамрагдаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 47.1 сая төгрөгийг зарцуулсан. 2023 оноос хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээ, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээг шинээр нэвтрүүлж 800 иргэнийг хамруулсан. Орхон аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтарч бүлгийн сургалтыг ерөнхий боловсролын 8, 9 дүгээр ангийн 24 бүлгийн 636 сурагчдад, ажил олоход хүндрэлтэй хорих 437 дугаар нээлттэй ангид хүмүүжигч 120 иргэнд, нийт 6 удаагийн сургалтаар 756 иргэнд мэргэжлийн сургагч 3 багш сургалтыг зохион байгуулж 4.4 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтыг ажилгүй 150 иргэдийг хамруулан зохион байгуулж, 4.5 сая төгрөг зарцуулсан. "Монголын удирдлага шинэчлэл менежментийн академи" НҮТББ-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 100, хөгжлийн бэрхшээлтэй 50 иргэнийг төсөл бичих 1 өдрийн, бизнесээ хөгжүүлэх 2 өдрийн сургалтад нийт 150 иргэнийг хамруулсан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг Орхон аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төвийн захиалгаар Уран зангилаа ХХК-ны дэргэдэх Уран гар сургалтын төвтэй хамтран гар урлал мэргэжлээр 9 иргэнийг сургалтад хамруулж 6.0 төгрөгийг зарцуулсан. Орхон</p>	100

										аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02/16 дугаар тогтоол, Засаг даргын 2025 оны А/652 дугаар захирамжаар батлагдсан "Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийн арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд эмэгтэйчүүдийн бүлгийг чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайлал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор цахим ур чадварын сургалтыг бүртгэл тооцоо хөтлөл, гар урлалын мэргэжлээр 30 эмэгтэйг хамруулж чадамжийн гэрчилгээ олгож сургалтын зардалд орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөг тус тус зарцуулсан.	
52	3.4.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээс өрхийн үйлдвэрлэл, бичил бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангана.	2020-2025	НБХ, ХХҮГ	Улсын төсөв	830.0	Өрхийн үйлдвэрлэл, бичил бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. /санхүүжилтийн хэмжээгээр/ 87	Өрхийн үйлдвэрлэл, бичил бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. /санхүүжилтийн хэмжээгээр/	830.0	Улс, орон нутгийн төсөв 3493.6	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг Орхон аймгийн ХХҮГ-ын пэйж хуудас, багуудын ажлын алба, цахим хуудас болон мэдээллийн самбар, гэрээт орон нутгийн телевизээр зар мэдээллийг хүргэж, 2 үе шаттайгаар зохион байгуулж 2020-2023 онуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, ажлын байр дэмжих, малжуулах, ахмадын хөдөлмөр эрхлэлт, залуучуудын хөдөлмөр эрхлэлт зэрэг 5 хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт нийт 298 иргэний төсөлд 2.0 тэрбум төгрөгийг 24-48 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгож 345 байнгын ажлын байр бий болсон.</p> <p>2024 онд уг үйл ажиллагааг мөн 3 үе шаттайгаар зохион байгуулж арьс шир, эсгий, төмөр, мод модон эдлэл, хүнсний мөөг, оёдол, сүлжмэл, хүнсний хагас боловсруулсан бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 20 иргэнд 100.0 сая төгрөг, иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 14 иргэнд 140.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 13 иргэнд 130.0 сая төгрөг, малжуулах арга хэмжээнд 8 хүнд 64.0 сая төгрөг, шилдэг старт залуучуудын бүлэгт 1 төсөлд 10.0 сая төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 45 ахмадад 48.6 сая төгрөг, нийт 110 иргэнд 594.6 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгож, үүний үр дүнд 134 ажлын байр хадгалагдаж 86 шинэ ажлын байр бий болсон байна.</p> <p>2025 онд уг үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгуулж арьс шир, эсгий, төмөр, мод модон эдлэл, хүнсний үйлдвэрлэл, оёдол, сүлжмэл, хүнсний хагас боловсруулсан бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа - Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 21 иргэнд 197.0 сая төгрөг, - Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 40 иргэнд 400,0 сая төгрөг, - Залуучуудын "Старт-Ап" аймаг, бүсийн шилдэг гарааны бизнесийн дэмжих санхүүгийн дэмжлэгт 5 багт 82.0 сая төгрөг, - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 20 иргэнд 200,0 сая төгрөг, нийт 86 иргэнд 879.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд 86 ажлын байр хадгалагдаж 60 шинэ ажлын байр бий болсон байна.</p> <p>-Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс эрх авсан Эм эс девелопмент консалтинг ХХК-ны сургалтын төвтэй хамтран санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа</p>	100

										болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 130, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэнийг төсөл бичих 1 өдрийн, бизнесээ хөгжүүлэх 2 өдрийн сургалтад, нийт 170 иргэнийг хамруулсан.	
53	3.4.3. “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ЭШУТП	Орон нутгийн төсөв	270.0	Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь	Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь	270.0	Орон нутгийн төсөв 810.0	<p>"2023 онд аймгийн ЗДТГ, Эрдэнэт ШУТП хамтран орон нутгийн төсвийн 810 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг 112 төсөлд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон. Төслүүд нь оёдол, гар урлал 20, газар тариалан 5, хүнсний үйлдвэрлэл 24, металл хийц 3, модон хийц 10, мал, амьтны аж ахуй 4, хог хаягдал дахин боловсруулах 11, үйлчилгээ 17, бусад 18 салбар байна. 2023 оны гүйцэтгэлээр бизнес эрхлэгчдийн төслийн хэрэгжилт 80 хувь, шинээр бий болон ажлын байрны тоо 250, хадгалагдсан ажлын байрны тоо 135, шинээр бий болсон бүтээгдэхүүний тоо 87 байна. 2021, 2022 оны хөрөнгө оруулалтын эргэн төлөлт 2023 оноос эхэлж 7 иргэний зээл бүрэн хаагдсан. Зээлийн эргэн төлөлт Эрдэнэт санд төвлөрч байна.</p> <p>Тус хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Орхон аймгийн Засаг дарга, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга нарын хамтарсан 2024 оны 240807/06-646 тоот гэрээний дагуу төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд зарлаж, шаардлага хангасан 4 төсөлд 597.5 сая төгрөгийн зээл олгогдохоор шийдвэрлэгдсэн. Тус ажилд орон нутгийн төсвөөс 400.0 сая төгрөг зарцуулсан.</p>	100
54	3.4.4. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв” /start-up/ -ийг түшиглэн залуучуудыг бизнес эрхлэх, зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.	2020-2025	НБХ, ХГБХХГ	Улсын төсөв	10.0	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох тоо 1	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох тоо 1	10.0	Улсын төсөв 122.0	<p>Монгол Улсын хэмжээнд “Бизнес эрхэлэе” сургалтыг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой гэрээлэн ажиллаж байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар болон Ажил олгогч эздийн холбоо хамтран сургалтыг зохион байгуулж сургалтад бизнес эрхлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгч болон албан бус салбарын нийт 60 залуучууд 2 өдрийн турш хамрагдсан. Сургалтын үр дүнд иргэд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн “Бизнес эрхлэх хүсэл эрмэлзэлтэй байя” модулиар бизнес санаагаа сонгох, бизнесийн хэрэглэгчийг сонгох, төлөвлөлт хийх үйл явц, бүтээгдэхүүний үнэ тогтоох, үйл ажиллагааны төлөвлөгөө болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээллийг авсан. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох (start up) арга хэмжээний хүрээнд шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг гарааны бизнес эрхлэгч залуу болон залуучуудын багийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулж 2020-2025 онд старт залуучуудын бүлэгт 6 төсөлд 70.0 сая төгрөгийн дэмжлэгийг буцалтгүйгээр олгосон. Мөг уг арга хэмжээг бүсийн хэмжээнд “Бест метод” ТББ-тай хамтран зохион байгуулж Хөвсгөл, Булган, Орхон аймгийн 111 залуучуудыг бүртгэж, 3 өдрийн сургалтыг зохион байгуулж 1-р шатны сонгон шалгаруулалтад Булган аймаг 1, Хөвсгөл аймаг 2, Орхон аймаг 4 нийт 7 баг шалгарч 5 долоо хоногийн хугацаатай хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж, эцсийн сонгон шалгаруулалтаар 3 багт 52.0 сая төгрөгийн 36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон.</p>	100
55	3.4.5. Их, дээд сургуулийн дэргэд “Хөдөлмөр эрхлэлтийн төв”-ийг бий болгож, оюутан	2020-2025	НБХ, ХХҮГ	-	-	150	300	-	-	<p>Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын дагуу орон нутгийн 100 ба түүнээс дээш ажилтантай 7 байгууллага, 2 их, дээд сургуулийн хүний нөөцийн ажилтнууд, сургалт хариуцсан менежерүүдтэй цахим уулзалтыг зохион байгуулж оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмыг танилцуулсан. Үүний үр дүнд 1 байгууллагад 12 оюутан цагаар хөдөлмөр эрхлэхээр зуучлуулж 12 түр ажлын байр</p>	100

	залуучуудыг цагийн ажилд зуучлах, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.								бий болсон. 2023 онд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа барилгын болон худалдаа үйлчилгээний Люксвүүд групп, Чанар бөөний худалдааны төв, "Эрдэнэт хивс" ХХК, Эрдэнэт мах маркет, "МЖЛ" ХХК, "Хангарьд ажнай" ХХК, үр тариа, хүнсний ногоо тариалсан иргэн аж ахуй нэгжээс цагийн болон өдрөөр ажиллах ажлын байрны захиалга ирүүлсний дагуу Орхон, ХАА-н МСҮТ-ийн давхардсан тоогоор нийт 300 орчим суралцагчид өдрийн 50.0-70.0 мянган төгрөгөөр цалинжин ажилласан. 2024 онд ХХҮГ-аас сул чөлөөтэй ажлын байрны мэдээллийг их, дээд сургууль, коллежид хүргүүлж холбогдох мэдээллээр хангаж ажилласан. Тайлант хугацаанд 21 аж ахуй нэгж байгууллагаас цагийн болон түр ажлын байрны захиалгыг албан тоотоор болон цахимаар хүлээн авч ХХҮГ-ын цахим хуудас, багийн ажлын албаар дамжуулан нийтэд мэдээлсэн. Цагийн болон сул чөлөөтэй ажлын байрны захиалгын дагуу Орхон Политехникийн коллежоос цагийн ажлын байранд ажиллах оюутны судалгаа гаргуулан авч Bozzolo, CU, GS25, "Төгс дизайн" ХХК, Миний сүлжээ дэлгүүр, Ноён пицца, авто угаалгын газарт 9 оюутанг цагийн ажилд, 2 аж ахуй нэгж, 10 иргэний хүсэлтээр 95.5 га талбайд Орхон Политехникийн коллежийн 438 оюутныг 3-5 хоногийн хугацаатай ногоо хураалтын түр ажлын байранд тус тус зуучилсан. 2025 онд Монголын Хүний нөөцийн менежментийн холбооны дэргэдэх хувийн хөдөлмөрийн биржтэй хамтран "JOB CENTER" төвийг нээсэн. Тус төв нь үүсэн байгуулагдсанаас хойш ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 18 иргэнд, бүлгийн зөвлөгөөг 14 дүгээр сургуулийн 9,11 ангийн 70 сурагчид өгсөн. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд 20 иргэнийг хамруулж, хувийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэд нь дэмжлэг үзүүлсэн. Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Онто гранд ХХК, Өргөө кино театр, Presting Beauty гоо сайхны дэлгүүр, Тод Өнгө ХХК зэрэг 20 аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 23 ажлын байрны захиалгын дагуу мэдээллийг "Ажил Зуучлал" нэртэй Facebook хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна. Ажлын байрны захиалгын дагуу 10 иргэнийг ажил олгогчийн ярилцлагад зуучилж, 7 иргэнийг түр ажлын байранд дадлагажуулан ажиллуулж байна. 2025 онд Орхон аймгийн хэмжээнд гурван "Самушил" төв шинээр байгуулагдан, иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Тус төвүүд нь түр болон цагийн ажлын байранд зуучлах, анкет бүртгэх, ажлын байрны захиалга хүлээн авах зэрэг үйлчилгээг иргэдэд хүргэж байна.		
56	3.4.6.Хоршоо эрхлэгчдийг бодлогоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ХХААГ	Орон нутгийн төсөв	10.0	-	Хоршоо эрхлэгчдийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлсэн байна.	10.0	Гадаадын төсөл, хөтөлбөр 10.0 Орон нутгийн төсөв 60.0 Банк 6400.0 ХХС 1600.0	Аймгийн хэмжээнд мал аж ахуй, газар тариалан, худалдаа, нийтийн тээвэр, оёдлын чиглэлээр 115 хоршоо бүртгэлтэй байдгаас тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 47 хоршоо байна. 2022 онд мал аж ахуйн чиглэлийн "Арга билиг арвин сүрэг" хоршоо, 2023 онд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн "Арвин сүргийн өгөөж" хоршоо шинээр байгуулагдсан. Арга билиг арвин сүрэг хоршоо нь Оюут багт өөрийн нэрийн дэлгүүрээ нээн 10 гаруй нэр төрлийн цагаан идээгээр иргэдэд үйлчилж байна. "Арга билиг Арвин сүрэг" хоршооны технологичийг ӨМӨЗО-д туршлага судлахад дэмжлэг үзүүлсэн. Энэ хоршоо нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн PROGRES төслөөс 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн, "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд сүү сүүн бүтээгдэхүүний тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Ингэснээр үйл ажиллагаагаа өргөжүүлж 9 ажлын байр шинээр нэмэгдсэн. "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III"-	100

										ыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилт, 11 арга хэмжээ тусган ажилласан. Хоршоодыг чадавхжуулах 6 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 170 хүнийг хамруулсан. 2021-2025 онд 1330 гишүүнтэй 115 хоршоонд байнгын ажлын байр 115, түр ажлын байр 1215 байна. Шинэ хоршооны хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд 47 хоршооны 174 малчин 6.4 тэрбум төгрөгийн зээлд, Хоршоо хөгжүүлэх сангаас 2021-2025 онд 9 хоршоо 1.6 тэрбум төгрөгийн зээлд хамрагдан үйл ажиллагаа явуулж байна.	
57	3.4.7.Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн сан, хүртээмжийг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөрт хамрагдах, санхүүгийн зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2025	НБХ ХБТХОХ ХХААГ	Улсын төсөв	15917.0	-	Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлд зээл олгох замаар дэмжиж санхүүгийн зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	15917.0	20600.0 ХААҮДС, 3560.3 ЖДҮС, 1972.7 Хоршоо хөгжүүлэх Сан, 5100.0 Төсөл хөтөлбөр Шинэ хошоо 1300.0	2021-2022 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 9 аж ахуйн нэгжид 3.1 тэрбум, 53 иргэнд 1.2 тэрбум буюу нийт 4.3 тэрбум төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1 аж ахуйн нэгжид 94.3 сая төгрөг, аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1 аж ахуйн нэгж хамрагдаж 50.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгож 33 ажлын байр хадгалагдаж, 4 ажлын байр шинээр нэмэгдсэн. 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас журмын шаардлага хангасан 5 төсөлд 894.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд нийт 14.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон байна. 2024 онд ЖДҮХС-аас 8 аж ахуйн нэгж 1,271.5 сая төгрөг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоо 250.0 сая төгрөг, Өрхийн болон ЖДҮ эрхлэгчдийн дэмжих тусгай сангаас 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 265.8 сая төгрөг, 2025 онд ЖДҮХС-аас 10 төсөлд 1.3 тэрбум төгрөг, "Атар-4" тариалангийн тогтвортой аяны хүрээнд 5 аж ахуйн нэгж, 7 иргэнд 1.2 тэрбум төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 5 хоршоонд 422.7 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 6 хоршооны 16 малчин өрхөд 529.0 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 29 иргэнд 290.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	100
Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг											
Зорилт 3.5. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын зөв хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, спортоор хичээллэх ээлтэй орчныг бүрдүүлнэ:											
58	3.5.1.Спортын болон фитнес клубуудыг магадлан итгэмжлэлд хамруулах, эрүүл мэндийн даатгалаар идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ иргэдийн авах нэмэгдүүлнэ.	2021-2025	НБХ, БТСГ	-	-	Магадлан итгэмжлэлдсэн клубын тоо 0	Магадлан итгэмжлэлдсэн клубын тоо 3	-	-	Аймгийн хэмжээнд 2021 онд 13 фитнес клубт 1650 иргэн, 2022 онд 14 фитнес клуб 1800 иргэн, 2023 онд 14 фитнес клубт 1900 иргэн тогтмол хичээллэж байсан бол 2024 онд 15 фитнес клубт 2000 иргэн, 2025 онд 15 фитнес клубт 2210 иргэн тогтмол хичээллэж байна. Эдгээр фитнес клубүүдээс 3 клуб нь Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд эрхээ авсан боловч фитнес клубээр үйлчлүүлсэн иргэдэд эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлт үзүүлэх үйл ажиллагаа улсын хэмжээнд 2021 оноос хойш хийгдээгүй.	0
59	3.5.2.Хийн болон эрүүл мэндийн	2021-2025	НБХ, БТСГ	ОНТ	10.0	Дасгалд хөдөлгөөн	Дасгал хөдөлгөөнд	10.0	Улсын	"Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аянд 2021 онд 15954, 2022 онд 44856, 2023 онд 16739, 2024 онд 24650 иргэн тус тус хамрагдсан.	100

	дасгал хөдөлгөөн өрнүүлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, санаачилгыг дэмжинэ.					д 7000 иргэнийг хамруулсан	хамрагдах иргэдийн тоог 1000-аар нэмэгдүүлж 8000-д хүргэх		төсөв 12.2 Орон нутгийн төсөв 23.4	2025 онд тус аяны хүрээнд биеийн тамир, чийрэгжүүлэлт, спортын өдөрлөг, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 78 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 49644 иргэнийг хамруулсан. Арга хэмжээнд улсын төсвийн 12.2 сая төгрөг, орон нутгийн төсвийн 23.4 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан.	
60	3.5.3.Жил бүр спортын их наадмуудын анхан шатны тэмцээнийг орон нутагт зохион байгуулж, тамирчдын амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025	НБХ, БТСГ	ОНТ	40.0	Монголын бүх ард түмний спортын зуны XV наадмын анхан шатны тэмцээнийг зохион байгуулсан	Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын анхан шатны тэмцээнийг 15-аас доошгүй төрлөөр зохион байгуулах	40.0	Орон нутгийн төсөв 458.8	<p>Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын зуны VII наадамд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын баталсан нэгдсэн зааврын дагуу спортын 20 төрлөөр 217 өсвөрийн тамирчин оролцож багийн дүнгээр 2-р байр эзэлж мөнгөн медаль хүртсэн. Нэгдсэн зааврын дагуу анхан шатны тэмцээнийг спортын 15 төрлөөр, мөн 5 сорилоор тус тус зохион байгуулж, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 2115 өсвөрийн тамирчдыг хамруулсан. Анхан шатны тэмцээний төрөл: байт харваа, волейбол, жүдо, сагсан бөмбөг 3x3, 5x5, таеквондо, хөл бөмбөг, чөлөөт бөх, шатар, ширээний теннис, буудлага, даам, уулын дугуй, уран сайхны гимнастик, усанд сэлэлт, хөнгөн атлетик.</p> <p>2022 онд Монголын бүх ард түмний спортын зуны XV наадмын анхан шат буюу аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 24 төрлөөр зохион байгуулж, 1330 тамирчдыг оролцуулсан. Шигшээ тэмцээнд Орхон аймаг спортын 21 төрөлд 216 тамирчнаа оролцуулж, 21 аймгаас багийн дүнгээр Орхон аймаг 2-р байр эзэлж, мөнгөн медаль, цом, өргөмжлөлөөр шагнагдсан.</p> <p>Монголын үндэсний спортын VII наадмын анхан шатны тэмцээнийг өвлийн 2 зуны 6 төрөлд нийт 8 төрлөөр зохион байгуулж, 394 тамирчин оролцуулан зохион байгуулсан. Шигшээ тэмцээнд Орхон аймаг спортын 6 төрөлд 96 тамирчнаа оролцуулж, 21 аймгаас багийн дүнгээр 1-р байр эзэлж, алтан медаль, цом, өргөмжлөлөөр шагнагдсан.</p> <p>2023 онд Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг "Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт" уриа дор 21 аймгаас анх удаа аймагтаа амжилттай зохион байгуулсан. Тус наадмуудад 12 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө спортын өвлийн 6 төрлөөр өрсөлдсөн. Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Орхон аймаг спортын өвлийн 6 төрөлд 49 тамирчнаа оролцуулж, багийн дүнгээр 2-р байр эзэлж, мөнгөн медаль, цом, өргөмжлөлөөр шагнагдсан. Монголын хүүхдийн спортын зуны VII наадамд Орхон аймаг спортын 20 төрөлд оролцохоос анхан шат буюу аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр зохион байгуулж 2115 өсвөрийн тамирчин хамруулсан. Тус наадмын шигшээ тэмцээнд Орхон аймаг спортын 20 төрөлд 217 өсвөрийн тамирчнаа оролцуулж, 21 аймгаас багийн дүнгээр 2-р байр эзэлж, мөнгөн медаль, цом өргөмжлөлөөр шагнагдсан.</p> <p>2025 онд Монголын хүүхдийн спортын зуны болон өвлийн VIII дугаар наадам, Монголын бүх ард түмний зуны спортын XVI наадам зохион байгуулагдаж, Орхон аймгийн баг тамирчид амжилттай оролцсон. Үүнд:</p> <p>-Монголын хүүхдийн спортын зуны VIII дугаар наадмын анхан шатны тэмцээнийг спортын 20 төрлөөр зохион байгуулж, нийт 2146 тамирчин, шигшээ тэмцээнд Орхон аймгаас спортын 30 төрөлд 297 тамирчин, 51 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, алтан медаль 15, мөнгөн медаль 15, хүрэл медаль 25, нийт 55</p>	100

										<p>медаль авч, 21 аймгийн багийн дүнгээр 1-р байр; -Монголын хүүхдийн спортын өвлийн VIII дугаар наадамд Орхон аймгаас үндсэн 6 төрөлд 75 тамирчин, 10 дасгалжуулагчийг бэлтгэн оролцуулж, алт 10, мөнгө 13, хүрэл 9, нийт 32 медаль хүртсэн амжилтаар аймгуудын дүнгээр 2-р байр эзэлж, цом, өргөмжлөлөөр шагнагдсан. -Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадамд Орхон аймгаас спортын 26 төрөлд 256 тамирчид, дасгалжуулагчид амжилттай оролцож, алт 23, мөнгө 14, хүрэл 35, нийт 72 медаль хүртсэнээр 21 аймгийн багийн дүнгээр 1-р байр эзэлж, цом, өргөмжлөлөөр шагнагдсан амжилтыг тус тус үзүүлсэн. Спортын их наадмуудын анхан шатны болон шигшээ тэмцээнд орон нутгийн төсвийн 401.0 сая төгрөгийн хөрөнгө санхүүг зарцуулсан</p>	
61	3.5.4.Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн төрлийг тогтоон, дасгалжуулагчдыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, спортын хэрэглэл, материалаар иж бүрэн хангана.	2021-2025	НБХ, БТСГ	ОНТ	65.0	Спортын 15 төрөлд 168 тамирчин хичээллэсэн	Спортын төрлийг 1-ээр, тамирчдын тоог 196-д хүргэх	65.0	Орон нутгийн төсөв 510.4	<p>Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багт 2021 онд 14 төрөлд 154 тамирчин хичээллэж байсан бол жил бүр спортын төрөл, тамирчдын тоог нэмэгдүүлж 2024 онд спортын 16 төрөлд 196 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалтаа тогтмол хийж байна. Шигшээ багийн тамирчдын ур чадварыг сайжруулах зорилгоор өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр спортын 13-17 төрлөөр зохион байгуулж байна. 2024 онд 13 төрлөөр зохион байгуулж, нийт 2152 тамирчдыг хамруулсан. Өсвөрийн тамирчид 2025 онд дэлхий, тив, олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 32 төрөлд 1435 тамирчид оролцож 170 алт, 169 мөнгө, 215 хүрэл нийт 554 медаль авсан амжилтыг үзүүлж улсын хэмжээнд зохион байгуулагдсан Монголын хүүхдийн зуны спортын VIII наадамд 1-р байр, өвлийн наадамд 2-р байр эзэлж өндөр амжилт гаргасан. Тухайлбал: -Монголын хүүхдийн спортын зуны VIII дугаар наадамд Орхон аймгаас спортын 30 төрөлд 297 тамирчин, 51 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, алтан медаль 15, мөнгөн медаль 15, хүрэл медаль 25, нийт 55 медаль авч, 21 аймгийн багийн дүнгээр 1-р байр алтан медаль, цом өргөмжлөлөөр, -Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд Орхон аймгаас спортын 6 төрөлд 75 тамирчин, 10 дасгалжуулагчийг бэлтгэн оролцуулж, алтан медаль 10, мөнгөн медаль 13, хүрэл медаль 9, нийт 32 медаль хүртэж, 21 аймгийн багийн дүнгээр 2-р байр эзэлсэн амжилтыг тус тус үзүүлсэн. Өсвөрийн шигшээ баг тамирчдыг тэмцээн уралдаанд оролцуулахад орон нутгийн төсвийн 280.6 сая төгрөг, хэрэглэл материал худалдан авахад 230.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан</p>	100
62	3.5.5.Орон сууцны болон гэр хорооллын дундах амралт, чөлөөт цагийн талбайн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021-2025	НБХ, БТСГ	ОНТ	741.4	Амралт, чөлөөт цагийн 114 талбай ашиглагдсан	Амралт, чөлөөт цагийн талбайг 8-аар нэмэгдүүлж 122-д хүргэсэн байх	741.4	Орон нутгийн төсөв 798.7	<p>Орон сууцны болон гэр хорооллын байршилд 2021 онд амралт, чөлөөт цагийн 114 талбай ашиглагдаж 8 удаа гадаа талбайд уралдаан тэмцээн, арга хэмжээ зохион байгуулж 960 иргэн, 2022 онд 10 удаа арга хэмжээ зохион байгуулж 1060 иргэн, 2023 онд 122 талбай ашиглагдаж 9 удаа гадаа талбайд арга хэмжээ зохион байгуулж 1460 иргэн, 10 удаа гадаа талбайд уралдаан тэмцээн, дасгал хөдөлгөөний арга хэмжээ зохион байгуулж 4760 иргэн тус тус хамруулсан. 2025 онд 124 амралт, чөлөөт цагийн талбай ашиглагдаж, 17 удаагийн тэмцээн уралдаан, арга хэмжээ зохион байгуулж 7910 иргэдийг хамруулсан. Үүнд -"Эртэч Эрдэнэтчүүд" өглөөний дасгалын арга хэмжээнд 642 иргэн; -Хүүхдийн баярын 06 дугаар сарын 01-ний өдрийн арга хэмжээний</p>	100

										<p>хүрээнд сагсан бөмбөгийн 3x3 төрөл, даамын тэмцээнд 500 хүүхэд;</p> <p>-Бүх хайраа гэр бүлдээ арга хэмжээний нээлтийн хүрээнд сагсан бөмбөгийн 3x3 төрлөөр U12 насны тэмцээнд 50 багийн 200 хүүхэд;</p> <p>-“Эрдэнэт марафон-2025”, Шри Чинмойны бүх насны гүйлтийн 2 удаагийн уралдаанд 315 хүүхэд, залуус;</p> <p>-Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын үдэлт, хаалтын арга хэмжээнд спортын 30 төрлийн 350 өсвөрийн тамирчид;</p> <p>-Баян-Өндөрийн овоо тахилгын үндэсний бөхийн өсвөрийн барилдаанд 32 хүүхэд;</p> <p>"Бүх нийтийн явган алхалт","Уурхайн хот 100км"-ын алхалтын 4 арга хэмжээг зохион байгуулж, 620 иргэд;</p> <p>-Залуучуудын сарын аяны хүрээнд "SparkZ" залуучуудын аймгийн аварга шалгаруулах спортын 8 төрөлт тэмцээнд 500 гаруй залуучууд тус тус оролцсон.</p>	
63	3.5.6.Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, боловсон хүчин, материаллаг баазаар ханган "Эрдэнэт-Спорт амралтын хүрээлэн"-г түшиглэн хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025	НБХ, БТСГ	ОНТ	40.0	"Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д мөсөн талбай байгуулсан орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх	40.0	Орон нутгийн төсөв 81.0	<p>2021-2024 онд Сархиа цанын баазад гүйлтийн цана, уулын цана, снөүбоардын зам, мөсөн талбай 1, Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд гүйлтийн тэшүүрийн 400м², шорт трекийн 200м² тойрогт, орос 19-р сургуулийн гадна мөсөн талбай, 2024 онд 15-р сургуулийн гадна талбайд мөсөн зам талбайг тус тус байгуулсан.</p> <p>2025 онд аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, цанын зам 3, мөсөн талбай 3, нийт 6 зам талбай байгуулж, улсын аварга шалгаруулах болон нээлттэй 9 тэмцээн зохион байгуулж, 849 тамирчдыг оролцуулж, хүүхэд, залууст өвлийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.Үүнд:</p> <p>-“Эрдэнэт мөнгөн өвөл” аяны хүрээнд гүйлтийн тэшүүр, уулын цана, гүйлтийн цанын төрлүүдээр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.</p> <p>-Монголын үндэсний Мөсний шагайн шилдэг багуудын аварга шалгаруулах "Эрдэнийн цом" тэмцээнд 8 аймгийн 35 багийн 210 харваач; -"Мөрөөдлийнхөө төлөө-Шударгаар өрсөлдье" уриа дор Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII их наадмын цанын спортын 4 төрлийн тэмцээнийг аймагтаа зохион байгуулж, тэмцээнд 13 аймаг, 6 дүүргийн 209 тамирчин;</p> <p>-Гүйлтийн цанын насанд хүрэгчдийн 2025 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд 10 аймаг, 4 дүүргийн 110 тамирчин;</p> <p>-Авто спортын "Ice drift-2025" улсын аварга шалгаруулах тэмцээнд 50 гаруй тамирчид;</p> <p>-Мөсний сурын харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 6 аймгийн 70 харваач;</p> <p>-Гүйлтийн цанын "Клубүүдийн аварга шалгаруулах тэмцээн"-д 8 аймаг, 2 дүүргийн 100 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.</p> <p>Өвлийн спортын зам талбайд 3 иргэн, аж ахуйн нэгж тэшүүр, цана, чарганы түрээсийн үйлчилгээ үзүүлж 4200 гаруй иргэд үйлчлүүлсэн.</p>	100	
64	3.5.7.Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ердийн болон цахилгаан дугуйн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	2021-2025	НБХ, БТСГ	-	-	Спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээнд 6700 иргэн хамруулсан	-	-	<p>Аймгийн хэмжээнд 2022 онд 3 иргэн, аж ахуйн нэгжийн спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээнд 6700 иргэн, 2023 онд 4 иргэн, аж ахуйн нэгж спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээг 7200 иргэнд үзүүлснээс хот доторх авто замд "Erdenet jet" ХХК 230 ширхэг цахилгаан дугуй /сүтэр/-аар түрээсийн үйлчилгээг нэвтрүүлж, өдөрт дунджаар 40-50 иргэнд, сард 1200-1500 иргэнд үзүүлсэн. 2024 онд 3 иргэн, аж ахуйн нэгж уулын цана, чарга, тэшүүр, дугуйн түрээсийн үйлчилгээг 6800 иргэнд үзүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд 11 багийн нутаг дэвсгэрт төрийн болон хувийн хэвшлийн байгууллага орон сууцны байрнуудын урд нийт 28</p>	100	

										унадаг дугуйн зогсоол хийгдсэн. Мөн Эрдэнэт хотыг тойрог дугуйн зам хийгдэж байна. 2025 онд спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээнд 7200 иргэдийг хамруулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/744 дүгээр захирамжаар “Унадаг дугуйн замын нөхцөл байдалд үнэлгээ өгөх, өргөтгөх талаар судлах” салбар дундын ажлын хэсэг байгуулж ажилласан. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, 2026 оны орон нутгийн төсвийн 293.0 сая төгрөгөөр хотын төвийн 6 бичил хорооллуудад унадаг дугуйгаар зорчих замын нөхцөлийг сайжруулах ажлыг хийхээр шийдвэрлэсэн. Цана, чарга, тэшүүрийн спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээг 4 байршилд үзүүлж тайлант онд 4200 иргэн хамрагдсан.	
Газрын харилцаа											
Зорилт 3.6. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ:											
65	3.6.1.Аймгийн газар зохион байгуулалтын 2021-2037 он хүртэлх 16 жилийн ерөнхий төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	Орон нутгийн төсөв	85.0	84517	15 хувь	-	-	Аймгийн газар зохион байгуулалтын 2022-2037 оны ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллага "Ланд овнер" ХХК-аар гүйцэтгүүлэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12/03 дугаар тогтоолоор батлуулж, 28 арга хэмжээний хүрээнд Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд төсөл үүсгэн арга хэмжээг мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Баян-Өндөр, Жаргалант сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумдын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажилласнаар ерөнхий төлөвлөгөө 40 хувийн хэрэгжилттэй байна.	100
66	3.6.2.Эрдэнэт хотод гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг батлагдсан стандартын дагуу хэрэгжүүлж, барилгажилтыг дэмжихгүй байршлуудыг тодорхойлон иргэдэд мэдээлнэ.	2020-2025	ХБТХОХ	-	-	-	Барилгажилтыг дэмжихгүй байршлыг тодорхойлж, гудамж талбайн хаягжилтыг стандартын дагуу хэрэгжүүлэх	-	-	Барилгажилтыг дэмжихгүй Найрамдал багт 11.9 га, Говил багт 22.6 га, Уурхайчин багт 1.3 га талбайг тодорхойлж газар олгохгүй, шилжилт хийхгүй байх шийдвэрийг гаргуулж, цахимаар иргэдэд мэдээлсэн. Хаягжуулалтын тухай хуулийн дагуу Орхон аймгийн хаягжуулалтын зураг боловсруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд: - Баян-Өндөр сумын ИТХ-ын 2020 оны 06, 40 дүгээр тогтоолуудаар батлагдсан гэр хорооллын 14 багийн 930 гудамжны нэр, Жаргалант сумын ИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан 3 багийн 73 гудамжны нэр, 27037 нэгж талбарыг мэдээллийн санд бүртгэж оруулсан. Зайлшгүй нэр өгөх шаардлагатай 57 гудамж хотын доторх 35 гудамж, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын эзэмшил газар доторх 22 гудамж/ -нд нэр өгөх ажлыг 2023 оны 10 дугаар сард аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл, Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах комиссоор хэлэлцүүлэн сумын ИТХ-ын ээлжит 15 дугаар хурлаар Аврагчдын гудамж, Эрдэнэт үйлдвэр орчмын хэсгийн гудамж талбайн нэршлийг баталсан. Орон нутгийн төсвийн 51.0 сая төгрөгөөр "Межин хишиг" ХХК-тай гэрээ байгуулан Шанд багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 24, хашааны дугаарын тэмдэг 610, Дэнж багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 56, хашааны дугаарын тэмдэг 1200, Рашаант багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 43, хашааны дугаарын тэмдэг 1000 ширхэг хаягжилтыг батлагдсан стандартын дагуу хийлгэн хүлээн авсан. 2024 онд Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлжүүлэх ажлыг "Ланд Овнер" ХХК тендерт шалгарч гэрээ байгуулан ажиллалаа. Уг ажлын хүрээнд аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн систем дэх	100

										<p>4129 гудамжны эхлэл, төгсгөлийг, кадастрын хаягийн мэдээллийн сангийн 25905 нэгж талбарт орц гарцыг зурагласан. Мөн авто замын мэдээллийн санг шинэчлэн 5051 атрибутан мэдээллийг бүрдүүлснээс 3184 замын зураглал үүсгэн бүртгэлжүүлж хүлээн авсан.</p> <p>2025 онд Баян-Өндөр сумын Наран багт гудамжны хаяг-148ш, хашааны дугаар-874ш, Даваат багийн гудамжны хаягийн тэмдэг-116ш, хашааны дугаар-208ш тэмдэгжүүлэлтийн ажил хийгдсэн.</p> <p>ГЗБГЗЗЕГ нь БНСУ-ын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яам, Газар геоматик корпорацитай хамтран ажиллах санамж бичиг байгуулан олон улсын техник шаардлага хангасан замчлалын систем бүхий хаягийн мэдээллийг удирдах дэвшилтэд системийг шинэчилсэн хувилбарт шилжүүлэн, хаяг олгох үйл ажиллагааг автоматжуулах, цахимжуулах ажлын хөгжүүлэлтийг гүйцэтгэж байна. Уг ажлын хүрээнд “Гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлжүүлэх” ажлын зургийн мэдээллийг үүсгэлээ.</p> <p>2025 онд нэр олгогдоогүй гудамж, зам талбайд нэр өгөх шаардлагатай 65 гудамжнаас Аймгийн ИТХ-ын 09-р сарын 18-ны өдрийн 02/41 тогтоолыг үндэслэн Бүрэнбүст багийн 5-15 дугаар орон сууцны барилгын баруун хойд дөрвөн замын уулзвараас Уртбулаг багийн 5-19 дүгээр орон сууцны барилгын зүүн талын гурван замын уулзвар хүртэл 630м урт гудамжийг Цэвээний (Самбуугийн Цэвээн), Зэст багийн 1-1 дүгээр орон сууцны барилгын баруун урд гурван замын уулзвар хүртэл 615м урт гудамжийг Лхагвасүрэнгийн (Дондвоогийн Лхагвасүрэн), Зэст багийн 1-32 дугаар орон сууцны барилгын баруун талын гурван замын уулзвараас 1-13 дугаар орон сууцны барилгын зүүн хойд гурван замын уулзвар хүртэл 236м урт гудамжийг Чекашовийн (Анатолий Васильевич Чекашов) гэх 3 гудамж талбайн нэршлийг баталсан.</p>	
67	3.6.3.Газар ашиглалт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	-	-	15987	Жил бүр 10га	-	-	<p>2021 онд Жаргалант суманд 3 цэгийг шинээр байгуулж, Баян-Өндөр суманд байрлах фотомониторингийн 2 цэг нь шинээр суурьшлын бүс үүссэний улмаас судалгааны зориулалтаар ашиглах боломжгүй болсон тул Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт албан бичгээр хүргүүлэн сүлжээнээс хасуулсан.</p> <p>2023 онд шинээр Жаргалант сумын Дулаан-Уул багт 2 мониторингийн байнгын ажиглалтын сүлжээний цэгийг нэмж байгуулан аймгийн хэмжээнд 10 мониторингийн цэг бүхий 38614.70 га бэлчээрийн газрыг хамруулан судалгааны ажлыг зохион байгуулж бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлсэн ажлын тайлан, хот тосгон бусад суурин газрын байнгын ажиглалтын мониторингийн 10 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэн дүгнэлт тайлан мэдээг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлэн ажиллалаа. 2024 онд аймгийн хэмжээнд байнгын ажиглалтын фото мониторингийн судалгааны ажлыг Жаргалант сумын бэлчээрийн 10 цэгт нийт 38614.97 га газар хийж гүйцэтгэсэн. 2025 онд Жаргалант сумын Дулаан-Уул багийн Согоотын аманд 1285.2 га талбайг хамарсан 1 цэгийг шинээр нэмж байгууллаа. 2025 оны бэлчээрийн газрын өөрчлөлийг фотомониторингийн аргаар үнэлэх хээрийн судалгааны ажлыг 2025 оны 08 дугаар сарын 11-12-ны өдрийн хооронд зохион байгуулан нэгтгэж, газрын мониторингийн цахим системд бүрэн орууллаа.</p> <p>2021-2024 онд Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар</p>	100

										<p>Жаргалант сумын Улаантолгой багийн нутаг дэвсгэр Тасгийн толгойд эвдэрч, эзэнгүй орхигдсон 1.5 га газрын техникийн нөхөн сэргээлтний ажлыг нөхөн сэргээлтний мэргэжлийн байгууллагын эрхтэй "Өү биби таун" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж актаар хүлээн авсан. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр дэх Моогийн айлуудын урд талд ухагдаж эвдэрсэн 0,5 га газарт техникийн нөхөн сэргээлтний ажлыг "Очир төв" ХХК-аар, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ ил уурхайн 3 дугаар овоолго дээр 3,9 га талбайд 500 ширхэг шинэс мод тарьж техникийн болон биологийн нөхөн сэргээлтнийг хийсэн, Баян-Өндөр сумын Говил багийн нутаг дэвсгэрт "Чингэл бөөн цагаан" ХХК-ийн хойд талд 2 га газарт Байгаль хамгаалах сангийн зардлаар, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт "Вондер вон" ХХК-ийн зардлаар 2 га газарт тус тус нөхөн сэргээлтний ажлыг хийж нийт 19.0 сая төгрөг зарцуулсан. Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт элэгдэж эвдэрч эзэнгүй орхигдсон 2.0 га газарт техникийн нөхөн сэргээлтний ажил хийгдэж, талбайн солбицлыг байгаль орчны нэгдсэн мэдээллийн санд бүртгэсэн. Жаргалант суманд 11865.5 га өвөл хаврын бэлчээрийг чөлөөлж, 482 га бэлчээрийг хашиж хамгаалж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Жаргалантын энгэрт 468 га бэлчээр, Хөндлөн намгийн хойно 630 га бэлчээрийн газрыг усжуулах 2 худаг байгуулсан. Мөн Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын зүүн урд энгэрт техникийн нөхөн сэргээлт хийсэн 2 га талбайд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажилладаг Очир төв ХХК, Дэлт хошуу ХХК-иудаар тус бүр 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтнийг гүйцэтгүүлж газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системд оруулж бүртгүүлэн ажиллалаа. 2025 онд Очир төв ХХК-иар байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулсны дагуу Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын урд энгэрт 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтнийг гүйцэтгүүлээ. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар Баян-Овоот, Цагаан чулуутын ам, Хангал гол гэсэн 3 байршилд 10.1 га талбайд мод тарьж, ойн төгөл, ойн зурвас байгуулахаар Баян-Өндөр сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ажилласан. Нийт 2021-2025 онд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өссөн дүнгээр 17593 га талбайд хийгээд байна.</p>	
68	3.6.4.Геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байр зүйн зургийг үе шаттайгаар бий болгоно.	202-2025	ХБТХОХ, ГХБХБГ	-	-	116	Жил бүр 2 цэг	-	-	<p>Геодезийн цэг, тэмдэгтийн үзлэг тооллогыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна. 2021 онд аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдэгтийн тооллогоор Тулгуур сүлжээн 1, Үндсэн 4, Дэд 11, Гравиметр 1, Триангуляци 6, Хадны марк 2, хөрсний репер 3, GPS 81, өндрийн 7 гэсэн 116 цэг тэмдэгтийн судалгааг гаргасан. 2022 онд Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Үйлдвэр технологийн паркийн" байр зүйн зураглалын ажлын хүрээнд "Тэгш хэм" ХХК-аар 33 геодезийн цэгийг шинээр суулгаж улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. 2023 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Дроникс" ХХК шинээр 16 геодезийн цэгийг байгуулах ажлыг хүлээн авч өгөгдлийг геопорталд оруулж бүртгэх ажил хийгдсэн. 2024 онд Жаргалант сумын урд хойд хорооллын дулааны шугам татах, байр зүйн дэвсгэр зураг хийх ажлын хүрээнд "Од геопроект" ХХК компани Улаантолгой, Жаргалант багуудад J0102, J0304 дугаартай геодезийн 2 цэгийг шинээр</p>	100

										байгуулсан. Жаргалант сумын урд хойд хорооллын дулааны шугам татах байр зүйн дэвсгэр зургийн ажлын хүрээнд 400 га 1:1000-ний масштабтай байр зүйн зургийн ажлыг 2024 оны орон нутгийн төсөвт 59.9 сая төгрөгөөр "Од геодпроект" ХХК компани гүйцэтгэн 2024 оны 8 сард хүлээн авсан. Баян-Өндөр суманд 40 га 1:1000-ний масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх ажлыг 2024 оны орон нутгийн төсөвт 42.5 сая төгрөгөөр "Би би кэй эйч" ХХК шалгарч Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт 20 га Баянбулаг баг орчмын нутаг дэвсгэрт 20 га газарт байрзүйн дэвсгэр зургийн ажил хийгдэж байна. "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах" ажлын хүрээнд Их залуу багийн нутаг дэвсгэрт 40.8 га, Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт 11.9 га газар, Хүрэнбулаг багийн нутаг дэвсгэр Уурхайчин-1 хотхоны баруун талд баригдах амины болон цөөн давхар барилгын орон сууцны хотхон хорооллын 10га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд тус тус байр зүйн дэвсгэр зураг хийгдсэн. 2025 оны геодезийн сүлжээний цэг, тэмдгийн үзлэг тооллогоор устсан 4 цэг, гэмтсэн 6 цэгийг шинээр хийлээ. Мөн манай аймагт бүртгэлтэй цэгүүдээс тооллогын үр дүнд хөрсний репер Rp77 дугаартай цэг нь Булган аймаг, Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрт, Rp73 дугаартай цэг нь Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрт харьяалагдаж аймгийн хилийн цэсээс гарсан тул дээрх 2 цэгийг геодезийн цэг тэмдэгийн тооллогоос хассан. Харин шинээр "Баян-Өндөр сум шинэ суурьшлын бүс 40 га талбайд 1:1000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын" ажлын хүрээнд 1 цэг, Жаргалант сум, Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Шинэ хаягдлын сангийн талбайн" том масштабын байр зүйн зураглалын ажлын хүрээнд "Агар Од Инженеринг" ХХК-ийн 28 цэг, Баян-Өндөр сумын 2а болон 7 хороололд "Орон сууцны шинээр баригдаж буй хороололд өндөржилтийн цэг байгуулах" ажлыг хүрээнд "Од геодпроект" ХХК-ийн 8 цэгийг шинээр байгуулан 37 цэг тэмдэгийн хувийн хэргийг төрийн хамгаалалтад хүлээлгэн өгсөн. Ингэснээр аймгийн хэмжээнд улсын нэгдсэн систем болох геопортал цахим системд геодезийн 202 цэг, тэмдэгт бүртгэгдлээ.	
69	3.6.5.Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	-	-	12800 нэгж талбар	22155 нэгж талбар	-	-	Газрын кадастрын системд бүртгэгдсэн Баян-Өндөр сумын 6683 нэгж талбарт 27957.4 сая төгрөгийн ногдуулалт хийж 7701 нэхэмжлэх, Жаргалант сумын 1348 нэгж талбарт 550,62 сая төгрөгийн ногдуулалт хийж 1412 нэхэмжлэхийг тус тус үүсгэн татварын нэгдсэн системд илгээсэн. Газрын үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулах ажлын хүрээнд 2025 онд Баян-Өндөр суманд 16986 иргэнд 33,4 сая төгрөг, Жаргалант суманд 567 иргэнд 162 мянган төгрөгийн ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэлээ.Нийт аймгийн хэмжээнд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй 25584 нэгж талбарт газрын төлбөр, татварын ногдуулалтыг хийж татварын системд илгээсэн.	100
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ											
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, олон тулгуурт эдийн засагтай хот болно.											
Зорилт 4.1. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:											
70	4.1.1.Экспортод чиглэсэн бизнест	2020-	ХБТХОХ	-	-			-	-	2022 онд нийт 12 аж ахуйн нэгжийн 29 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тохирлын баталгаажуулалтад хамруулан,	100

	эрх зүйн хувьд зөвшөөрөгдсөн, боломжит дэмжлэгүүдийг үзүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	2025				2 аж ахуйн нэгжийн 13300 ширхэг бараа, бүтээгдэхүүн экспортод гаргасан.	3 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортолно. (арьс ноос, ноолуур, мах)			тохирлын гэрчилгээ олгож 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортлоход тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон гадаад худалдааны үйл ажиллагааг нь дэмжсэн. 2023 онд нийт 17 үйлдвэрийн 11 нь буюу 64.7 хувь баталгаажуулалтад хамрагдаж 26 нэрийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж баталгаажуулсан. 2024 онд мал төхөөрөх 3, мах, махан бүтээгдэхүүний 8, сүүний 3, гурил, тэжээлийн 4, ноос ноолуурын 4, арьс ширэн бүтээгдэхүүний 2, нийт 24 үйлдвэр ажиллаж, үүнээс сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, нийт 10 аж ахуйн нэгжийн 14 нэр төрлийн 143 нэрийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөхөд болон гадаад оронд экспортлоход нь дэмжлэг үзүүлсэн нь нийт үйлдвэрлэлийн 35.2 хувь нь баталгаажуулалтад хамрагдсан байна. "Эрдэнэт кашмер" ХХК технологийн шинэчлэл хийснээр жилдээ 4400 тн ноос угаах хүчин чадалтай болж өргөжсөн нь өмнөхөөс 2.5 дахин илүү хүчин чадалтай болж, гэр ахуйн хэрэглээний оёмол бүтээгдэхүүн, ноолуур болон ноосон бэлэн хувцсыг үйлдвэрлэж бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлсэн. Мөн тус компанийн сүлжмэлийн үйлдвэрт Герман улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж суурилуулж хүчин чадлаа нэмэгдүүлснээр сүлжмэл хувцасны үйлдвэр жилд 11000 ширхэг цамц, оёдлын үйлдвэр нь жилд 90000 ширхэг оёмол бүтээгдэхүүн, нэхмэлийн үйлдвэр нь жилд дунджаар 50000 метр тэмээ, хонь, сарлагийн ноос, хөөврөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж ОХУ, Европын холбооны орнуудад экспортолж байна. Эрдэнэт хивс ХХК-аас ноолуурын угаах цехэд 2 төрлийн сэгсрэх машин суурилуулснаар хог хаягдлыг хуурайгаар нь ачиж зайлуулдаг болсноор лагийн хэмжээ буурсан. Ажлын гутал, эсгий табчик хийдэг "Мөнх баян алт" ХХК-ийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төсөлд хамруулснаар тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж гар ажиллагааг 40-50 хувь хөнгөвчилж, ажлын бүтээмж нэмэгдэн, жилд дунджаар 2500-3000 хос эсгий табчик үйлдвэрлэн ОХУ руу экспортолж байна. 2025 онд "Эрдмийт", "Эрдэнэт мах маркет", "Жаргалант мах импекс" ХХК-нууд 867.6 тн хонины мах, 455.3 тн ямааны мах, 237.0 тн адуу, 27.2 тн үхрийн мах нийт 1587.1 тонн малын мах Иран, Казакстан, Узбекистан, Тажикстан, ОХУ, Хонконг, Хятад, Катар улсад, Эрдэнэт хивс ХХК 8.8 тонн самнасан хонины ноос ХБНГУ-д экспортолсон. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах тухай бүрт гарал үүслийг баталгаажуулж, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулан тохирлын баталгаажуулалтад хамруулан гэрчилгээжүүлж, гадаад худалдааг хөнгөвчилсөн.	
71	4.1.2. Дулааны цахилгаан станцыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, эрчим хүчээр бүрэн хангана.	2020-2025	ХЗА, "ЭДЦС"ТӨХ К "ЭБЦТС"ТӨ ХК "ЭУДТС"ОН ӨХК	Орон нутгийн төсөв	573.7	-	Цахилгаан станцыг өргөтгөж, эрчим хүчээр хангасан байна.	573.7	Орон нутгийн төсөв 15600.0	Эрдэнэт хотын ДЦС-ын турбогенераторыг СС-50 мВт-аар өргөтгөх ажлыг 2021 онд хийж гүйцэтгэсэн. 2022 онд орон нутгийн 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 35/6кВ-ын ЦРП-Өмнөд дэд станцыг 2х10000кВА-иар өргөтгөх ажлыг "Орхон тек" ХХК хийж дууссан. 2023 онд хуучин Өмнөдийн дэд станцын хэрэглэгчийг шинэ станцад холбох ажил бүрэн хийгдэж ачаалал авч ажиллаж байна. Баян-Өндөр сумын 6/0.4кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил хийгдсэн. 2023 онд Орхон аймгийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим	100

										<p>хүчний хэрэглээг хангах зорилгоор Эрдэнэ багт 35кВ-ын ЦДАШ-ыг барих ажлыг ЭБЦТС ТӨХК өөрийн хөрөнгө оруулалтаар хийж ашиглалтад оруулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх, сайжруулах зорилгоор 35кВ-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд 13.1 тэрбум төгрөг төлөвлөн ажилласан. Уг ажлын хүрээнд Чингэл дэд станцаас 35/10 кВ-ын Даваат дэд станц хүртэлх 35 кВ-ын 13.059 км ЦДАШ барих ажилд "Виртуалсофт" ХХК, 35/10 кВ-ын 2х16 МВА Даваат дэд станц барих ажилд "Меса инженеринг" ХХК, Даваат дэд станцаас 35/10 кВ-ын Булаг дэд станц хүртэлх 35 кВ-ын 5.04 км ЦДАШ барих ажилд "Цацраг цог" ХХК-н гүйцэтгэгчээр шалгарч ЦДАШ барих ажлууд хийгдэж дууссан. Тус ажлын үр дүнд ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож хэт ачааллаас шалтгаалан хязгаарлагдах, Бугат сумын дэд станцад гарсан гэмтлээс шалтгаалан тасралт гарах, эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээнээс шалтгаалсан хүчдэлийн уналт үүсэх зэрэг асуудлууд шийдвэрлэгдэх нөхцөл бүрдсэн.</p> <p>10кВ-ын тойрог схемд оруулах 9 нэрийн ажилд 7.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн 100 хувь дуусаж ашиглалтад бүрэн оруулсан. Тус ажлын хүрээнд 3ш дэд станц /РП/, 10кВ-ын хос 12.05км цахилгаан дамжуулах кабель шугам барих ажлыг хийж гүйцэтгээд байгаа ба уг ажлууд хийгдсэнээр өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс хамаарч хүчдэлийн уналт үүсэх, мөн аваар гэмтлийн үед тасралтгүй эрчим хүчээр хангах нөөц боломж бүрдэж 35/6 кВ хороолол дэд станцын хувь 59% болж буурсан байна.</p> <p>Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын захын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулж, хүчдэлийн уналтыг бууруулах зорилгоор Баян-Өндөр сумын 11 багийн 22 байршилд 10 кВ-ын ЦДАШ, 10/0.4 кВ-ын 250 кВА чадалтай (КТГН) дэд станц барихаар нийт 22 ажил төлөвлөж тус ажлууд 100% дуусаж ашиглалтад оруулсан. Дээрх ажил хийгдсэнээр Эрдэнэ, Дэнж, Яргуйт, Их залуу, Уртын гол, Цагаанчулуут, Рашаант, Даваат, Наран, Баянбулаг, Баянцагаан, Чингэл, Баян-Овоот, Шанд, багуудын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж 3172 хэрэглэгч хүчдэлийн уналтгүй болж хэвийн хүчдэлээр хангагдах нөхцөл бүрдсэн.</p>	
72	4.1.3.Ухаалаг хот төслийг хэрэгжүүлэн тээвэр логистикийн төвийг байгуулна.	2020-2025	ХБТХОХ	-	-	-	Тээвэр логистикийн төвийг байгуулна.	-	-	<p>Хойд бүсийн тээвэр логистикийн төвийг Орхон аймагт байгуулахаар бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан ба ТЭЗҮ хийлгэх төсөв хайж байна. Хойд бүсийн Тээвэр логистикийн төвийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган Говил багт төлөвлөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр байгуулахаар Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад тусган ИТХ-аар батлуулан Төр хувийн хэвшлийн түншлэлийн төвд хүргүүлсэн.</p>	30
73	4.1.4.Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг	2020-2025	ХБТХОХ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	1495.1	-	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл хэрэгжүүлэх	488.5	Хувийн хэвшил 45300.0	<p>Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд дараах 4 төсөл хэрэгжиж байна.</p> <ul style="list-style-type: none"> -Өөрөө нунтаглах хэсгийн шинэ 4 дүгээр шугамын хүчин чадлыг 2 сая тн/жилээр нэмэгдүүлэх, -Нунтаглан баяжуулах хэсэгт хам баяжуулалтын 2, 3 дугаар секцийг шинэчлэх, -Хүдэр бэлтгэлийн I шугамыг шинэчлэх, -Хаягдал өтгөрүүлэх технологийг нэвтрүүлэх төсөл. <p>Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд эхний ээлжид хам баяжуулалтын 5-р секцийг шинэчилсэн бол</p>	85

	байгуулах төсөл хэрэгжүүлнэ.									үргэлжлүүлэн хам баяжуулалтын жилд 12 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 2, 3-р секцийг шинэчлэх төслийг хэрэгжүүлж байна. Тус төслийн гүйцэтгэгчээр FLSmidth Mongolia компани шалгарч 2023 оны 5 дугаар сард гэрээ байгуулан төслийн ажил гэрээ, төлөвлөгөөний дагуу явагдсанаар 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Мөчлөгт урсгалт тээврийн технологийн төсөл 56 хувьтай байна. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн гүйцэтгэл 97 хувьтай байна. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 80 хувь, Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90 хувь, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжийн ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөгөөний дагуу явагдаж байна	
74	4.1.5.Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл, бусад паркийн төслүүдийг хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	167.3	-	Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлнэ.	83.7	Эрдэнэт-Үйлдвэр 10800.0	<p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захиалгаар “Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг “Майнинг Шорт Лонг Терм” ХХК гүйцэтгүүлж, гүйцэтгэгч компани ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай хамтран боловсруулж УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлж дэмжигдсэн. ТЭЗҮ-ээр 109.2 \$ буюу 362.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 мян.тн/жил катодын зэс үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай байхаар байна. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс ялгарах металлургийн хийг боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилтын ажлыг БНХАУ-ын ENFI компани гүйцэтгэж байна. Элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжиан Уйгарын өөртөө засах орны Xinjiang Xinxin Mining Industry компанийн харьяа Karatongke Copper Nickel Mine хайлуулах үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100 хувь дууссан ба “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэн БНХАУ-руу тээвэрлэх ажлыг зохион байгуулан үйлдвэрт хүргүүлж, туршилтын ажлыг эхлүүлж эхний үр дүнгээр үндсэн үзүүлэлтүүд гарсан тул үйлдвэрийн ТЭЗҮ-д тодотгол хийж ирүүлсэн байна.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотголыг АҮЭБЯ-ны дэргэдэх зөвлөлийн 2025.08.12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.</p> <p>ЗБХБҮ-ийн технологийн түвшний үнэлгээний эцсийн тайланг АҮЭБЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх хурлын тов хүлээгдэж байна</p> <p>“ЗБХБҮ-ийг барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын техникийн даалгаврыг батлуулан, сонгон шалгаруулах бэлтгэл хангах үүрэг бүхий” ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2025 оны 60 дугаар захирамжаар холбогдох яам газруудаас төлөөлөл оролцуулан байгуулсан ба тус ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөнд “Төслийн хэрэгжилтийн явц, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хувилбар болон сонгон шалгаруулалтын үйл явцын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийн төслийг хэлэлцүүлэн батлуулах, стратегийн хөрөнгө оруулагчийг сонгох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах” үүргийг ЗГХЭГ, АҮЭБЯ, “Эрдэнэс Монгол” ХХК, “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-д даалгасан. ЗГ-ын хуралдаанаас өгсөн</p>	50

										чиглэлийн дагуу ЗБХБҮ-ийн төслийн Урилга болон Ерөнхий мэдээллийг ГХЯ, ЭЗХЯ, СЯ, МҮХАҮТанхим, МУУҮАссоциаци гэх мэт холбогдох байгууллагуудаар дамжуулан дэлхийн зэс-металлын салбарын тэргүүлэгч 20 улсын 55 компанид, Олон улсын Хөрөнгө оруулалтын 20 санд, Олон улсын байгууллага, Хөгжлийн 20 банкуудад, түүнчлэн өмнөх жилүүдэд төслийн талаар хамтран ажиллах сонирхлоо илэрхийлж байсан хөрөнгө оруулагч нарт ч холбогдох мэдээллийг нээлттэй хүргүүлж, гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр төслийн талаар мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж байна. Мөн олон улсын global.tenders.com тэлбөртэй веб сайтад тендерийн урилгыг байрлуулсан байна.	
75	4.1.6. "Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк"-ийн үйлдвэрлэлийг өргөжүүлэн, чанар, стандартын шаардлага хангасан шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	2020-2025	ХБТХОХ, ЭШУТП	ОНТ	-	-	Чанар, стандартын шаардлага хангасан шинэ төрлийн төсөл шалгаруулж, дэмжлэг үзүүлсэн байна.	-	-	<p>2022 онд "Эрдэнэт ШУТП"-ийн дэргэд технологи дамжуулах төв байгуулж, "Эрдэнэт-2022" инновац, технологийн өдрүүд үзэсгэлэн зохион байгуулсан. 15 бизнес технологийн зөвлөгөө өгч, түлш үйлдвэрлэх, яс боловсруулах үйлдвэрлэл, арьс шир боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх 3 инновацын төсөл шалгаруулж дэмжлэг үзүүлсэн.</p> <p>2023 онд Технологи дамжуулах төв нь дундын оффисын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 40 гаруй аж ахуйн нэгж, 200 иргэнд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн чиглэлээр 1 аж ахуйн нэгжид технологи дамжуулж үйлдвэрлэлийг эхлүүлсэн.</p> <p>Мөн "БМОМ" ХХК, "Мөөг кластер" ХХК-иудад мөөгний технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. БШУЯ-тай 2024 оны 05 дугаар сард инновацын төсөл бүртгэх гэрээ байгуулах, бүс нутгийн хэмжээнд ажиллах кластер байгуулах судалгаа хийх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. ЭТШУТП нь Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран халтиргаанаас сэргийлэх материал, сахар үйлдвэрлэл, дулааны станцын хаягдал үнс дахин боловсруулах чиглэлээр судалгааны ажил хийсэн. Хөдөө аж ахуй, зам, барилгын тоног төхөөрөмж ба резинэн хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд 2025 онд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас хүнс үйлдвэрлэл, газар тариалан чиглэлийн 10 аж ахуйн нэгжид 1.1 тэрбум, барилгын материал буюу салхивч үйлдвэрлэлийн чиглэлийн 1 аж ахуйн нэгжид 262.7 сая, нийт 11 аж ахуйн нэгжид 1.3 тэрбум төгрөгийн зээл олгогдсон.</p>	100
76	4.1.7. Тогтвортой үйлдвэрлэл, инновац зэрэг ногоон хөгжлийг дэмжсэн бүс нутаг, хот, олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ЭШУТП	Төсөл хөтөлбөр	-	-	Инноваци, ногоон хөгжлийг дэмжсэн бүс нутаг, хот, олон улс хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх	-	-	<p>БШУЯ, ШУ-ны Академтай хамтарч "Судлаач энтрепренер" хөтөлбөрийг боловсруулж орон нутгаас 13 бизнес эрхлэгчийг бүртгэн шинжлэх ухааны судалгааг хийсэн. "Хүнсний ногооны үр тариалалт"-ын гарааны компанийг инновац технологийн арга хэмжээнд оролцуулж Грант шагнал авсан. Мөн 12 байгууллага хамтран технологи дамжуулах ажлыг эхлүүлээд байна. Шинжлэх ухаан, технологийн сантай хамтарч Завхан, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай гэсэн 4 аймагт "Инновацыг нутагшуулья" аяны хүрээнд "СТАРТАП МЕНТОРШИП" арга хэмжээ зохион байгуулж гарааны бизнесийн тухай сургалт, инновац, энтрепренер сэтгэлгээ, гарааны бизнес, шинэ санаа хөгжүүлэлт, оюуны өмч, маркетинг сэдвүүдээр сургалт хийсэн.</p> <p>2024 оны II улиралд Хөдөлмөр халамжийн ерөнхий газартай хамтран бүс нутагт шинээр хөгжүүлэх инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, кластерын судалгаа хийж 15 төсөл боловсруулсан. Уг төслүүдийг бүсийн аймгуудын 800 орчим үйлдвэрлэгчдэд танилцуулж сургалт явуулсан.</p> <p>ШУТС-аас Төв, Хэнтий, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай зэрэг 5 аймагт зохион байгуулсан "Шинжлэх ухаан, технологи, инновацыг</p>	80

										орон нутагт нутагшуулья аян"-д паркийн дэргэдэх компаниудын бүтээгдэхүүнийг танилцуулан, гарааны бизнесийн сургалт зохион байгуулсан. 2025 онд ЭШУТП-аас инновацын сургалтыг 3 удаа зохион байгуулж 50 бизнес эрхлэгчийг хамруулсан. Мөн нэхмэл болон цаасны хаягдал ашиглан барилгын дүүргэгч материал үйлдвэрлэх технологийн туршилт, судалгаа хийж бизнес эрхлэгчид дамжуулах ажлыг зохион байгуулсан.	
77	4.1.8.Орон нутгийн импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал, санаачилгыг бүх талаар дэмжинэ.	2020-2025	ХБТХОХ, ХХААГ	ОНТ	5.0	-	Импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн санаачилгыг дэмжих	5.0	Гадаад төсөл, хөтөлбөр 40.0	Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих Прогресс төслийн брэндийн сургалтад хамрагдаж шалгарсан аж ахуйн нэгжүүдэд тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд: "Баяжуулагч Одод" ХХК хатаасан аарц үйлдвэрлэл, "Цэцээ-Өндөрлөг" ХХК савхин эдлэл, Арга билэг Арвин сүрэг хоршоо нь "Бэлгийн багц", Үлэмж нандин ХХК Care kids гэсэн чиглэлээр брэнд бий болгоход дэмжлэг үзүүлсэн. "ITM Mongolia 2023" арга хэмжээнд орон нутгийн арьсан эдлэлийн Өндөрлөг брэнд, гар урлалын Сампин брэнд бүтээгдэхүүнийг оролцуулан үйл ажиллагааг дэмжсэн. Хөгжлийн Шийдэл ТББ-н "BEST" хөтөлбөрөөс "БҮТЭЭЛЧ CEO" сургалт зохион байгуулж нийт 12 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, бүтээгдэхүүнийг хэрхэн хөгжүүлж брэнд бий болгох талаар санал солилцож, хэлэлцүүлэг зохион байгуулсан. "Эрдэнэт хивс", "Эрдэнэт кашмер" ХХК-ийн 4 нэр төрлийн 13 нэрийн бүтээгдэхүүн баталгаажуулалтад хамрагдан, тохирлын гэрчилгээ авч бүтээгдэхүүнээ экспортолж байна. 2024 онд Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлд 2 аж ахуйн нэгж хамрагдаж 900.0 сая төгрөгийн зээл авч, хиаман төрлийн бүтээгдэхүүн, талхны нэр төрөл 3 аар нэмэгдэж, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийсэн. Best хөтөлбөртэй хамтран "Эдийн засгийн ногоон шилжилт" төслийн Ногоон бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөрийн сургалт 1, Хүнсчдийн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх, үйлдвэрлэгчийг чадавхжуулах уулзалт, сургалт 2, нийт 3 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 89 үйлдвэрлэгчийг хамруулан зах зээлд суурилсан эко шошгожуулалт, ногоон баталгаажуулалтын системийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн тэдний дадал, зан төлөвөө өөрчлөн чадавхжих сургалтаар хангаж, ногоон санхүүжилтийн эх үүсвэртэй болгох замаар тойрог эдийн засагт шилжихэд нь дэмжлэг үзүүлсэн. 2025 онд Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны хүрээнд Булган аймагт зохион байгуулагдсан "Түншлэл-Хамтын ажиллагаа" үзэсгэлэнд Орхон аймгаас 25 үйлдвэрлэгчийг оролцуулж, Эрдэнэт хивс ХХК хивсэн бүтээгдэхүүн, Эрдмин ХХК-ний цахилгааны уртасгагч, Орда заан хошуу ХХК-ний сүүт нэрийн бүтээгдэхүүн, Баярмөнх наран ХХК-ний Хүндэтгэлийн багц, Өндөрлөг урлан цех арьсан цүнх гэсэн 5 бүтээгдэхүүн брэнд шалгаруулах уралдаанд нэр дэвшүүлсэн. Гоо сайхны болон ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг "Rich cosmetics" ХХК бараа бүтээгдэхүүнийхээ нэр төрөл, сав баглаа боодлыг шинэчлэн импорт орлох 5 нэр төрөл бүхий нярайн багц, 4 нэр төрөл бүхий арьс арчилгааны багцыг шинээр гаргасан.	90
Үндэсний баялгийн сан											
Зорилт 4.2. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжинэ:											
78	4.2.1.Уул уурхай, хөдөө аж ахуй, зам, барилгын тоног	2020-2025	ХБТХОХ	-	-	-	1	-	Хувийн хэвшил	"Эрдмин" ХХК нь олон үйлдэлт уртасгагч залгуурыг шинэчлэн олон улсын стандартад нийцсэн, орчин үеийн эрэлт хэрэгцээг хангасан QC3.0/18W, PD3.0/20W нэмэлт ухаалаг утас болон таблет,	100

	төхөөрөмж ба бусад төрлийн металл /зэс/, резинэн хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлнэ.									<p>зөөврийн компьютерыг хурдан цэнэглэх боломжтой ERD-2301 загварын уртасгагч залгуурыг 1.5 метрээс 5.0 метрийн сонголттойгоор үйлдвэрлэж байна. Мөн ах ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалт бүхий ERD-2302, ERD-2303 загварын 40-50 метрийн урт утастай, дамартай уртасгагч залгуурыг шинээр үйлдвэрлэн холбогдох мэргэжлийн байгууллагаас гэрчилгээ авсан. Тухайн бүтээгдэхүүнүүд нь Монгол улсын зах зээл дээр худалдаалагдаж буй ижил төстэй импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад чанартай, олон улсын чанар стандартад нийцсэн сав, баглаа боодолтой, өнгө үзэмж сайтай зэрэг давуу талуудыг үндэслэн Орхон аймгийн брэнд бүтээгдэхүүний лого тэмдгийг ашиглах эрхийг “Эрдмин” ХХК-д олгосон ба бүтээгдэхүүнийг сав, баглаа боодол дээр Орхон аймгийн брэндийн логог байршуулсан.</p> <p>Төгөл групп хямд, чанартай амины орон сууц барих төслийг Орхон аймагт хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих барилгын материалын 60 хувийг бүрдүүлэхээр дөрвөн үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Төгөл группийн эрчим хүчний хэмнэлттэй загварын барьсан. Төгөл группийн легион блокын үйлдвэр нь 2000 ширхэг блокыг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн. 2025 онд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас хүнс үйлдвэрлэл, газар тариалан чиглэлийн 10 аж ахуйн нэгжид 1.1 тэрбум, барилгын материал буюу салхивч үйлдвэрлэлийн чиглэлийн 1 аж ахуйн нэгжид 262.7 сая, нийт 11 аж ахуйн нэгжид 1.3 тэрбум төгрөгийн зээл олгогдсон.</p>	
79	4.2.2.Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нь орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	-	-	-	-	-	<p>Орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүн ийг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад нийлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>“Хөгжлийн шийдэл” ТББ-ын “BEST” хөтөлбөртэй хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ТӨҮГ, томоохон аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулснаар 2023 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 26 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчтэй 3.9 тэрбум төгрөгийн, 2 үйлдвэрлэгчтэй 2.8 тэрбум, ШШГЕГ-тай 2.7 тэрбум, нийт 9.5 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж ажилласан. “Ачит-Ихт” ХХК нь тайлант онд 105 иргэн, аж ахуйн нэгжээс 1.3 тэрбум төгрөгийн худалдан авалт, 92 аж ахуйн нэгж, иргэнээс 12.9 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ, “Эрдмин” ХХК нь 173 иргэн, аж ахуйн нэгжээс 1.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. “Баясгалант Бат-Очир” ХХК, “Үрт Ундрам” ХХК, БЛГЯ хоршоо нь нийт 24 цэцэрлэг болон 16 сургуулийн үдийн хоолны ногоог гэрээгээр нийлүүлж, Эрүүл мэндийн байгууллага, хоол үйлдвэрлэлийн газарт 12 иргэн, 5 аж ахуйн нэгж өөрийн тариалсан төмс, хүнсний ногоог нийлүүлэн ажиллаж байна. Ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулсан “Үндэсний үйлдвэрлэл-Намрын ногоон өдрүүд-2023” үзэсгэлэн арга хэмжээнд Жаргалант сумын 3 тариаланчийг дэмжин оролцуулсан.</p> <p>2024 онд төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлж зээл олгох, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн дэмжлэг үзүүлсний үр дүнд Урлахуйн жигүүр ХХК нь “Уран эгшиг” урлагийн сургуулийн 1200 хүүхдийн урлагийн хувцсыг урлан нийлүүлж байна. Уран хас ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдын ажлын хувцас, Гутал буян ХХК Ора металл ХХК-д ажлын 150 хос гутал, Мах маркет ХХК-д 20 хос гутал, Hard steel ХХК-д 20 хос гутал, Баяжуулагч-Одод ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хор саармагуулах бүтээгдэхүүний 40 хувийг, аймгийн 32 сургууль, цэцэрлэгт сүү, сүүн бүтээгдэхүүн, Үржих таван эрдэнэ</p>	100	

										<p>ХХК Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т дотор мах, дайвар бүтээгдэхүүн нийлүүлж байна. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад бараа бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэгчдийн тоо өмнөх оноос 20 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>2025 онд Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлж зээл олгох, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн дэмжлэг үзүүлсний үр дүнд Урлахуйн жигүүр ХХК нь “Уран эгшиг” урлагийн сургуулийн 1800 хүүхдийн урлагийн хувцсыг урлан нийлүүлж, Уран хас ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдын ажлын хувцас, Гутал буян ХХК нь Ора металл ХХК-д ажлын 150 хос гутал, Мах маркет ХХК-д 50 хос гутал, Hard steel ХХК-д 40 хос гутал, Баяжуулагч-Одод ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хор саармагжуулах бүтээгдэхүүний 40 хувийг, аймгийн 32 сургууль, цэцэрлэгт сүү, сүүн бүтээгдэхүүн, Үржих таван эрдэнэ ХХК Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т 30.0-50.0 сая төгрөгийн дотор мах, дайвар бүтээгдэхүүн нийлүүлж байна. Мөн хэвлэлийн 6 компани Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т 80.0-100.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлэн хамтран ажилласан байна.</p> <p>Ачит-Ихт ХХК нь орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд худалдах, худалдан авах гэрээний дагуу давхардсан тоогоор нийт 324 аж ахуйн нэгж, 249 хувь хүнээс 1.8 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 10.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. “Эрдмин” ХХК нь 173 иргэн, аж ахуйн нэгжээс 1.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Зэс эрдэнийн хувь ХХК нь 147 иргэн, аж ахуй нэгж байгууллагаас 2.7 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн ба хүнсний бараа материал 28.3 хувь буюу 778.5 сая төгрөг, бусад бараа материал 13.2 хувь буюу 362.9 сая төгрөг, нүүрс 56.0 хувь буюу 1.5 тэрбум төгрөг, ажил үйлчилгээ 2.3 хувь буюу 64.0 сая төгрөг байна. “Баясгалант Бат-Очир” ХХК, “Үрт Ундрам” ХХК, БЛГЯ хоршоо нь нийт 24 цэцэрлэг болон 16 сургуулийн үдийн хоолны ногоог гэрээгээр нийлүүлж, эрүүл мэндийн байгууллага, хоол үйлдвэрлэлийн газарт 12 иргэн, 5 аж ахуйн нэгж өөрийн тариалсан төмс, хүнсний ногоог нийлүүлсэн.</p> <p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд 79 аж ахуйн нэгжтэй 182 гэрээ байгуулж 149.4 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад бараа, бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэгчдийн тоо өмнөх оноос 23 хувиар нэмэгдсэн.</p>	
Ухаалаг санхүүгийн зах зээл											
Зорилт 4.3. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан, олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ:											
80	4.3.1.Татвар төлөгчдөд сургалт, зөвлөгөө өгч эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан цахим сургалт, үйлчилгээ	2020-2025	СТСХ	Орон нутгийн төсөв	45.0	-	Татвар төлөгчдөд сургалт, зөвлөгөө өгч, цахим сургалт, үйлчилгээ үзүүлнэ.	45.0	Орон нутгийн төсөв 75.0	<p>2022 онд нийт 73 удаагийн сургалтыг танхимаар, ажлын байранд ганцаарчилсан, цахимаар зохион байгуулж давхардсан тоогоор дунд сегмент 26, жижиг сегмент 287, бичил сегмент 773, ауй хүнд 6518, нийт 7604 татвар төлөгч хамрагдлаа. Орхон аймгийн Татварын газрын пэйж хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сургалт сурталчилгааг явуулж телевизэд 105, сонинд 116, радиод 8 удаагийн ярилцлага, мэдээ мэдээлэл нийлүүлсэн.</p> <p>2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг “Цахим татварын жил” уриатай уялдуулан холбогдох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, татварын ерөнхий газраас баталсан стандартыг ханган биелүүлэхэд онцгойлон анхаарч ажиллалаа.</p>	100

үзүүлнэ.									<p>Татвар төлөгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох санал асуулга авч “Шинэ татвар төлөгч”, Шинэ НӨАТ-ын суутган төлөгч, Татварын хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчил, Татварын албаны цахимжилт, Тайлан хоцроодог татвар төлөгчдөд зориулсан сургалт, Татвараа төлж хэвшээгүй татвар төлөгч, Хасагдах зардалд тавих хяналтыг сайжруулах нь, Малчид, тариаланч нарт татварын харилцаа, анхаарах асуудлууд, ХХОАТ зэрэг үндсэн 9 сэдвийг цахим хичээл болгон сургалтууд явуулсан. Судалгааны үр дүнд нийцүүлэн сургалтыг танхимаар 52, ажлын байраар 82, цахимаар 41 удаа нийт 175 удаагийн сургалт зохион байгуулж, эдгээр сургалтад давхардсан тоогоор дунд сегмент 72, жижиг сегмент 887, бичил сегмент 5342, хувь хүн 19263 нийт 25564 татвар төлөгчийг хамруулсан. Татвар төлөгчийг мэдээллээр хангах зорилгоор давхардсан тоогоор 20135 татвар төлөгчид масс мессеж илгээсэн.</p> <p>Орхон аймгийн ИТХ, СТСХ, Жаргалант сумын ЗДТГ, Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар, гэр бүл хүүхэд, залуучуудын газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ, Мал эмнэлгийн газар болон төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>Орхон аймгийн татварын хэлтсийн пэйж хуудас, or.mta.gov.mn вэб сайт, “Ибаримт-Буцаан олголт, шинэ мэдээ мэдээлэл ” болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл “Тусгал”, “Номин”, ETV, Хотын шуудан сонин, “Гэрэг” TV “Арвис” сайтаар сургалт сурталчилгааг явуулж, телевизэд давхардсан тоогоор 126 , вэб сайтад 112, FM-д 5 удаагийн ярилцлага, мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа хийсэн. Олон нийтийн цахим сүлжээнд 402 сургалт сурталчилгаа, мэдээ байршуулснаар нийт 458959 хүнд хүрч, 9243 лайк, 68178 иргэн хуваалцсан байна.</p> <p>Татвар төлөгч нарт зориулан 18 төрлийн гарын материал хэвлүүлэн тараах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Байгууллагын 108 тоот өрөөг засварлан, шаардлагатай тусгай техник хэрэгслээр тохижуулан Live, Zoom хэлбэрээр цахим сургалт хийх орчныг бүрдүүлсэн.</p> <p>2024 онд танхимаар 54, ажлын байранд 79, цахимаар 45 удаа, нийт 178 удаагийн сургалт зохион байгуулж, тус сургалтуудад давхардсан тоогоор дунд сегментийн 235, жижиг сегментийн 3289, бичил сегментийн 4268, хувь хүн 22772, нийт 30564 татвар төлөгчийг хамруулсан.</p> <p>Төрийн болон ТББ-тай хамтран 21 удаагийн сургалт зохион байгуулж 513 татвар төлөгчийг хамруулсан.</p> <p>Татварын хууль тогтоомж, журам, заавруудыг олон нийтэд хүргэх, сурталчлах зорилгоор орон нутгийн “ETV”, “Тусгал ТВ”, “Лха тэнгэр”, “Номин” телевизтэй хамтран 114 удаагийн тодруулга ярилцлага, цаг үеийн мэдээ, 10 удаагийн ярилцах цаг нэвтрүүлэгт оролцсон. “Гэрэгтв”, “Erdenetnews.mn”, “update.mn”, “Баян-Өндөр сум”, “Улсын тэргүүний Жаргалант сум”, “Орхон аймгийн Татварын газар” пэйж хуудсуудаар 746 төрлийн мэдээ, мэдээллийг 1818 удаагийн давтамжтай социал орчинд түгээж, давхардсан тоогоор 493400 орчим иргэнд хүрсэн байна.</p> <p>“Орхон аймгийн Татварын газар” пэйж хуудсыг дагагч 11.0 мянга, зочилсон хүний тоо 75 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өсөж, 2024 онд татварын хууль тогтоомжийн агуулга бүхий 64 видео, 42 бичвэр, нийт 746 постоор мэдээ, мэдээллийг түгээсэн нь 223.1 мянган хүнд хүрч 84%-иар өссөн.</p> <p>2025 онд Татвар төлөгчийн зан хандлага, хэрэгцээ шаардлагыг</p>
----------	--	--	--	--	--	--	--	--	---

									<p>тодорхойлох судалгааг 1, 4, 10 дугаар сард хуулийн этгээдүүдийн цахим хаягаар болон сургалтад хамрагдсан нийт 756 татвар төлөгчдөөс авч нэгтгэсэн. Хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны дагуу эрэлтэд нийцүүлэн тайлант хугацаанд танхимаар 55, ажлын байранд 68, цахимаар 6 удаа, нийт 129 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор дунд сегментийн 229, жижиг сегментийн 2925, бичил сегментийн 4487, хувь хүн 21405, нийт 29046 татвар төлөгчийг хамруулав. Судалгаагаар хамгийн их санал ирүүлсний дагуу татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 33 удаа хийж 448 татвар төлөгч, ХХОАТ-ын тайлагнал, хөнгөлөлт, чөлөөлөлт сэдвээр 2600 гаруй иргэнд 16 удаагийн сургалт, ААНОАТ-ын тайлагнал сэдвээр 15 удаа 501 татвар төлөгч, НӨАТ-ын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиар 14 удаа 574 татвар төлөгч, Малчин, тариалан эрхлэгч нарт зориулан 5 удаагийн сургалтаар 653 татвар төлөгчийг хамруулан сургалт зохион байгуулсан бөгөөд татварын багц хуулиар 84 удаагийн сургалт хийж 9241 татвар төлөгчийг танхимын сургалтад хамруулав.</p> <p>Малчин эмэгтэйчүүд 2, хоршоо эрхлэгч эмэгтэйчүүдэд 3, нийт 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 94 татвар төлөгч эмэгтэйчүүдийг хамруулж, и-баримт үүсгэх, баталгаажуулах, тайлан илгээх, чөлөөлөгдөх борлуулалт сэдвээр 4 зөвлөмж, заавар бүхий гарын авлагыг бэлтгэн тарааж, орон нутгийн 5, байгууллагын 2 пэйж группт түгээсэн.</p> <p>Хойд бүсийн хөгжлийг дэмжих төвтэй хамтран зохион байгуулсан “Хойд бүсийн эдийн засгийн форм”, “Хойд бүсийн хоршоо эрхлэгч нарын зөвлөгөөн”, “Хойд бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн”-үүдэд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан оролцож, нийт 360 гаруй татвар төлөгчдөд татварын хууль тогтоомж, бүс нутагт хэрэгжиж буй хөнгөлөлтийн талаар зөвлөгөө өгч, мэдээллээр ханган ажилласан.</p> <p>2025 оныг “Зөвлөн туслагч татварын алба” зорилт дэвшүүлсний хүрээнд тайлан хоцроосон 49 ААН-д ганцаарчилсан сургалтыг зохион байгуулж, зөрчил үүсгэхээс урьдчилан сэргийлж ажиллалаа.</p>		
81	4.3.2.Санхүүгийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх замаар санхүүгийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, бололцоог нэмэгдүүлнэ.	2020-2025	СТСХ	Орон нутгийн төсөв	9.8	-	Санхүүгийн байгууллага, иргэдэд сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, чадварыг бэхжүүлэх	9.8	Орон нутгийн төсөв 9.8	<p>Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран “Санхүүгийн салбарын эрх зүйн шинэчлэл” сургалт ххэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сургалт, хэлэлцүүлэгт Монгол үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, банк, үнэт цаас болон даатгалын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоо, иргэд, төрийн албан хаагчдыг хамруулсан нийт 460 гаруй хүн оролцож мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн.</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн бодлого зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал, Хорооны зохицуулалтад шинээр ороод буй мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрхзүйн орчин, зах зээлийн нөхцөл байдал мөн даатгалын салбарын хууль эрхзүйн орчны шинэчлэлт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, иргэд, олон нийтэд тулгардаг нийтлэг асуудал, санхүүгийн залилан, луйвраас хэрхэн сэргийлэх талаар мэдээллийг аймгийн төрийн албан хаагчид, иргэдэд өгсөн. Мөн Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхон, Голомт банкны захирал Д.Бадрал нар банкуудын үйл ажиллагаа болон хувьцааны талаар, Хөрөнгийн биржийн Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан төрийн өмчит</p>	100

											компаниудын хувьчлалын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Орхон аймгийн ММНБИнституттай хамтран "Хөрөнгийн зах зээл ба хуримтлал үүсгэх шинэ боломж" сургалт зохион байгуулсан ба сургалтад 450 санхүү, бүртгэлийн ажилтнууд оролцож мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн. Санхүүгийн талст сургалтын төв, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 50 хуулийн этгээдийн удирдлагуудад компанийн сайн засаглал, хувьцаа гаргах IPO, компанийн бондын санхүүжилт татах нь зэрэг сэдвүүдээр мэдлэг олгох, чадавжуулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын бүрэлдэхүүний хамт Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалтын байгууллагуудад хөрөнгийн зах зээлийн бодлого зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал, зохицуулалтын салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлт сэдвүүдээр сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан.	
82	4.3.3.Ногоон зээлийн сан, ногоон ажлын байр, инновацыг дэмжсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	Улсын төсөв Хувийн хэвшил	50.0 20.0	-	Ногоон ажлын байр, инновац шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	ШУТС ан 50.0 сая ЭТШУ ТП 20.0	ШУТСан 50.0 сая ЭТШУТП 20.0	Гадаадын төсөл хөтөлбөртэй хамтран 500.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн буцалтгүй дэмжлэгийг өрхийн болон бичил бизнес эрхлэгчид, инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлсэн. 2022 онд "Эрдэнэт ШУТП"-ийн дэргэд технологи дамжуулах төв байгуулж, "Эрдэнэт-2022" инновац, технологийн өдрүүд үзэсгэлэн зохион байгуулсан. 15 бизнес технологийн зөвлөгөө өгч, түлш үйлдвэрлэх, яс боловсруулах, арьс шир боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх 3 инновацын төсөл шалгаруулж дэмжлэг үзүүлсэн. 2023 онд Технологи дамжуулах төв нь дундын оффисын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 40 гаруй аж ахуйн нэгж, 200 иргэнд зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн чиглэлээр 1 аж ахуйн нэгжид технологи дамжуулж үйлдвэрлэлийг эхлүүлсэн. Мөн "БМОМ" ХХК, "Мөөг кластер" ХХК-иудад мөөгний технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. ЭТШУТП нь Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран халтиргаанаас сэргийлэх, цас мөс хайлуулах бодис, сахар үйлдвэрлэл, дулааны станцын хаягдал үнс дахин боловсруулах чиглэлээр судалгааны ажил хийж байна. Арилжааны 2 банкаар хүлэмжийн усалгааны систем, цахилгаан автомашин, ногоон амины орон сууцны зээлийг олгож, нийт 156 иргэнд, аж ахуйн нэгж байгууллагад 9740.3 сая төгрөгийн ногоон зээл олгогдсон. 2024 онд Рийч органик косметик, Ган компас, Стеам сургалт, Экора грийн гоулд, Ойстер гровинг субстрат, Бидэрт манхан, Талхны цех, Пенофасад, Мөөг кластер, Эко будаг гэсэн нийт 9 бизнес эрхлэгчид оффис, үйлдвэрлэлийн нийт 1,200 мкв ажлын байр ашиглуулж, улирал тутамд сургалт, арга хэмжээнд оролцуулан ажиллаж байна. БШУЯ-ны Эрдэм хакатон арга хэмжээнд Экора грийн гоулд ХХК шилдгээр шалгарч 20 сая төгрөгийн грант, ХНХЯ-аас зохион байгуулсан "Шилдэг стартап, гарааны бизнес болон залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох улсын уралдаан"-нд Ган компас компани шилдгээр шалгарч 20 сая төгрөгийн грант тус тус авсан.	90	
Бүс нутгийн хамтын ажиллагаа												
Зорилт 4.4. Харилцаа, хамтын ажиллагаат хөрш орнуудын муж, хотуудтай хамтран эдийн засгийн харилцааг хөгжүүлнэ:												
83	4.4.1.ОХУ, БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагаат	2020-2025	ТЗУХ	Орон нутгийн төсөв	37.5	5 хот, муж	7 хот муж	50.0	Орон нутгийн төсөв	2022 онд ОХУ-ын Улаан-Үд хотын Хот тохижилт, гэрэлтүүлэг, цэцэрлэгжүүлэлт, замын аюулгүй ажиллагаанд нэвтрүүлж байгаа шинэ техник, технологитой танилцсан. "Монгол-Орос шинэ нөхцөл	100	

	<p>хотуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх аж ахуйн нэгж, компаниудыг бүх талаар дэмжинэ.</p>							220.0	<p>дэх харилцаа” форум Улаан-Үд хотод 2022 оны 6 дугаар сард зохион байгуулагдаж, форумд Орхон аймгаас Худалдаа аж үйлдвэрийн танхимын шугамаар бизнес эрхлэгч 6 аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөл оролцсон. 2023 онд Монгол-Оросын найрамдлын нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр”-тэй хамтран ажиллаж, Ялалтын баярын арга хэмжээнд 1.5 сая, Турк улс газар хөдлөлтөд өртөх үед аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргаас Туркийн ард түмэнд эмгэнэл илэрхийлж, 2.0 сая төгрөгийг хандивласан. “Монгол-Оросын хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээний хүрээнд Дархан хотод 2023 оны 5 дугаар сард зохиогдсон Оросын Зам барилга, ХАА-н машин механизмын үзэсгэлэнгийн арга хэмжээнд Орхон аймгийн бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулав. Боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд Өвөр Уралын улсын Их сургууль, Буриадын Улсын Их сургууль, ХАА-н Академийн төлөөлөгчид Орхон аймагт ажиллаж мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлж, ажилласан. ОХУ-ын Буриад улсын Онцгой байдлын сайд А.Марков Орхон аймагт 2023 оны 4 дүгээр сард айлчилж, Монгол улсын Онцгой байдлын газартай 2023-2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Тус ажиллагаанд Ерөнхий газар, 6 аймгийн Онцгой байдлын газрын төлөөлөгчид хүрэлцэн ирж, ажлын туршлага солилцлоо. БНХАУ-ын ӨМӨЗО-ы Манжуур хотын Ардын Засгийн ордны даргаар ахлуулсан баг төлөөлөгчид Орхон аймагт 2023 оны 04 дүгээр сард айлчилж Орхон аймаг Манжуур хотын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2023-2025 оны хооронд хийх ажлын төлөвлөгөөг баталж хамтын ажиллагааг эрчимжүүлэн ажиллахаар тохиролцов. БНХАУ-ын Бугат хотын 3 сургуультай 14 дүгээр сургууль, Орхон аймгийн МСҮТ-тэй хамтран ажиллах санал бичгийг байгуулан сурагч солилцоо, багш солилцоо, туршлага солилцох чиглэлээр хамтарч ажиллахаар болсон. 2023 оны 09 дүгээр сард Орхон аймгийн ЗДТГ, БОАЖГ-тай хамтран зохион байгуулсан Зэс фестиваль эвент арга хэмжээнд Дархан хотод байрлах ОХУ-ын Ерөнхий консул, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Монгол улсад хэрэгжүүлэх гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн төлөөлөгчид оролцож аймгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнтэй танилцав. Монгол-Чехийн бизнес форум 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан арга хэмжээнд Орхон аймгаас Худалдаа аж үйлдвэрийн танхимын бизнес эрхлэгч 6 аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллүүд оролцлоо. 2024 онд Монгол- Оросын найрамдлын нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр”-тэй хамтран ажиллаж, Ялалтын баярын арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн. ОХУ-ын Эрхүү хотын Техникийн их сургуулийн 26 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг хүлээн авч аймгийн ЕБС-ийн төгсөх ангийнхан, Их дээд сургуулийн нэгдүгээр курсын оюутнууд Технологийн сургуулийн хамт олонтой уулзуулж, хамтран ажиллах боломжийн талаар харилцан санал солилцож хамтарсан олимпиад зохион байгуулж, шалгарсан 4 сурагчийг тус сургуульд тэтгэлгээр сурах эрх олгосон. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод зохион байгуулагдсан олон улсын “Бүс ба Зам” хөл бөмбөгийн фестивальд Орхон аймгийн 14 насны өсвөрийн охид, хөвгүүдийн шигшээ багийн тамирчид</p>	
--	--	--	--	--	--	--	--	-------	--	--

										<p>амжилттай оролцсон. Мөн БНХАУ-ын Ухань хотын удирдлагуудыг хүлээн авч санамж бичиг үзэглэсэн.</p> <p>Вьетнам улсын Даклак муж, Японы Токамачи хот, ОХУ-ын Улаан-Үд хотын удирдлагуудыг Үндэсний их баяр наадам, Илгээлтийн эздийн бүтээн байгуулалтын 50 жилийн ойд хүндэт зочноор урьж оролцуулан хамтын ажиллагааг бэхжүүлсэн.</p> <p>2025 онд ОХУ-ын 4-р хурлын хууль тогтоох хурлын депутат, Эрхүү мужийн хууль тогтоох хурлын дэг, депутатын ёс зүй, мэдээллийн бодлого, олон нийтийн холбоодтой харилцах комиссын дарга Кудрявцева Галина Фёдоровна тэргүүтэй төлөөлөгчид аймгийн удирдлагуудтай уулзсан.</p> <p>ОХУ-ын Улаан-Үд хотын “Эдийн засаг, соёлын өдөр”-ийг 2025 оны 09 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулж, хамтын ажиллагааны санамж бичгийг шинэчлэн байгуулсан.</p> <p>Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайд Шэнь Миньжуань, НҮБ-ийн Хүн Амын Сангийн тэргүүн ХалидШарифи тэргүүтэй төлөөлөгчид аймгийн удирдлагуудтай уулзалт хийж ерөнхий боловсролын 30 сурагчид Элчин сайдын нэрэмжит тэтгэлэг олгосон.</p>	
84	4.4.2.Бусад орнуудын харилцаатай хот, мужуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн, шинээр харилцаа тогтооно.	2020-2025	ТЗУХ	Орон нутгийн төсөв	37.5	9 хот, муж	11 хот муж	80.0	Орон нутгийн төсөв 250.0	<p>БНСВУ-ын Дак Лак мужийн Буон Ма Туот- Дэлхийн кофены амтлах газар сэдэвт арга хэмжээнд соёлыг сурталчилж оролцсон. БНТУ-ын Элчин сайд 04 дүгээр сард айлчлал хийж аймгийн аж ахуй нэгжтэй уулзалт хийсэн. “Хамтдаа Эрдэнэтэд хөгжье” эдийн засгийн форумд БНСУ-ын M.A.P group, Huijin Co.,Ltd зэрэг 10 байгууллагын 23 төлөөлөгчид оролцож Орхон аймагт ажилласан. БНСУ-ын барилгын төслүүд групптэй, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, ногоон барилгын материалын үйлдвэрлэл, үйлдвэр байгууламжуудыг нутагшуулах, дахин төлөвлөлтийн чиглэлээр барилгын салбарт хөрөнгө оруулалт хийх, Смарт дагуул хот төслийг БНСУ-ын Ханам хоттой хамтран хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах болсноор Бүгд Найрамдах Солонгос улсын “M.A.P” зураг төслийн групп Орхон аймагт салбар байгуулах, дахин төлөвлөлтийн төслүүдийн зураг төслийг гүйцэтгэхээр болсон. Анд энерги ХХК-тай БНСУ-ын OK green Co.,Ltd эрчим хүчний хэмнэлттэй бие даасан цахилгааны гэрлийн үйлдвэр барих, хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. БНСУ-ын Huijin Co.,Ltd Хэрэглээний ус цэвэршүүлэгч, ахуйн хэрэглээний нерж төмөр болон төмөр эдлэлийн үйлдвэрийн 20 ажилчид бэлтгэн, салбар үйлдвэр байгуулах, Солонгос хүүхдийн сургууль байгуулахаар харилцан тохиролцов. БНСУ-ын Дэгү, Пусан хоттой Орхон аймаг хамтран ажиллах санамж бичиг байгуулсны дагуу БНСУ-ын Пусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлэгтэй хамтран 2023 оны 05 дугаар сард БОЭТ-д алсын зайн оношилгоо, эмчилгээний төвийг байгууллаа. 2023 оны 07 дугаар сард БНКУ-ын ерөнхийлөгч айлчилж тус айлчлалын хүрээнд Монгол, Киргиз хоёр орны найрамдлын бэлгэдэл болгож, Эрдэнэт хотод “Ногоон төгөл” байгуулахаар шийдвэрлэлээ. БНХАУ-ын Ухань хотын захирагч 11 дүгээр сард айлчилж найрсаг хамтын ажиллагаа тогтоох санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p>2024 онд Шинээр барьж ашиглалтад авсан Номын өргөөнд АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Америкийн соёл мэдээллийн төв” байгуулах ажлаар 3 удаа хамтран ажиллаж, тус төвийн үйл ажиллагаа жигдрээд байна. Унгар улсын Элчин сайд Орхон аймагт ажиллаж удирдлагуудтай уулзан санал солилцон, Унгарт англи хэлээр сурч боловсрол эзэмших асуудлаар ЕБС-ийн сурагчдад мэдээлэл өглөө. Мөн яруу найрагч Ш.Патөфигийн нэрэмжит уран уншлагад</p>	100

										<p>шалгарсан сурагчдыг урамшуулсан. Япон улсын Элчин сайд “Инновацийн долоо хоног” нэгдсэн арга хэмжээнд оролцож мэндчилгээ дэвшүүлсэн. Энэ үеэр аймгийн Засаг дарга Элчин сайдыг хүлээн авч уулзан Япон оронтой хэрхэн хамтран ажиллаж ирсэн болон Токамачи хоттой харилцаж байгаа талаар мэдээлэл өглөө.</p> <p>2025 онд Бүгд Найрамдах Чех улсын Байгаль орчны асуудал эрхэлсэн секцийн ахлах захирал, Дэд сайд Давид Сурый тэргүүтэй төлөөлөгчид аймгийн удирдлагуудтай уулзаж хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцсон.</p> <p>Европын холбоо, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн нээлтийн арга хэмжээнд Европын холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ина Марчюлените, Монгол дахь Суурин төлөөлөгч Ханнес Такач тэргүүтэй төлөөлөгчид оролцсон.</p> <p>БНГУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд ноён Хэльмут Кулиц тэргүүтэй төлөөлөгчид аймгийн Засаг даргатай уулзан санал солилцсон.</p> <p>Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн Суурийн төлөөлөгч Эваристе Коуасси Комлан, БНСУ-ын Хүүхдэд ээлтэй хотуудын зөвлөлийн дарга, гишүүд, НҮБ-ийн Хүүхдийн сангийн хүүхдэд ээлтэй төслийг дэмжих нийгэмлэг, БНСУ дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн хорооны төлөөлөгчид манай аймагт айлчилж орон нутагт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдтэй танилцсан.</p> <p>Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн Гишүүн, Парламент Дахь Польш-Монголын Парламентын Бүлгийн дарга Станислав Горчыца тэргүүтэй төлөөлөгчид аймгийн удирдлагуудтай уулзалт хийж Монгол, Польш хоёр улсын Засгийн газрын гэрээний дагуу баригдаж байгаа хог ангилан ялгах үйлдвэрийн нөхцөл байдалтай танилцсан.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Аялал Жуулчлалын Төрийн Өмчит Корпораци, Эрүүл мэнд алжаал тайлах аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэх албаны дарга И Дунг Сог тэргүүтэй төлөөлөгчид аймгийн удирдлагуудтай уулзалт хийж хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан “Хойд бүс-Эрдэнэт 2025” 5 дахь удаагийн эдийн засгийн форумыг зохион байгуулсан. Форумд Солонгос улсын Дэгү Хани их сургууль, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөгч, Чек улсын элчин сайд нар урилгаар оролцон боловсон хүчин бэлтгэх агаарын бохирдол, цэвэр усны хангамжийг сайжруулах, нийгмийн салбарын байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлж гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр тус тус хамтран ажиллах санамж бичиг байгуулсан</p> <p>2025 оны байдлаар санамж бичгийн хэрэгжилт 90 хувийн хэрэгжилттэй байна</p>	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

ТАВ. ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ-ЭРДЭНЭТ ХҮЧ

Зорилго 5. Орхон аймаг, Эрдэнэт хотын хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал, оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий цомхон, чадварлаг төрийн албыг төлөвшүүлэн, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэн төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

85	5.1.1 “Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөр хэрэгжүүлж төрийн байгууллагад байгаа мэдээллийг	2021-2024	ТЗУХ	Орон нутгийн төсөв	4100.0	-	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	540.0	Орон нутгийн төсөв 1675.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар Мастер төлөвлөгөөг батлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 17 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас одоогийн байдлаар 11 арга хэмжээ буюу 64.7 хувь нь	90
----	--	-----------	------	--------------------	--------	---	----------------------------	-------	---------------------------	---	----

	иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг зогсоож, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.									<p>бүрэн хэрэгжиж дууссан байна. Үүнд: Смарт Эрдэнэт платформ, аймаг болон сумдын веб сайт, газарзүйн мэдээллийн систем, эмнэлгийн түргэний үйлчилгээнд ухаалаг таблет, багийн төвүүдэд ухаалаг төхөөрөмж, шилэн кабелийн хайгуул, Цахим Эрдэнэт сервер, хөдөлгөөнт холбоо, гадаад гарц, мэдээллийн аудит, дугаар илрүүлэгчтэй камер байна. Санхүүжилтэд 1.37 тэрбум төгрөг зарцуулсан ба үүний 62.5 хувь нь программ хангамж, 25.5 хувь нь тоног төхөөрөмж, 12 хувь нь ажил үйлчилгээний төлбөр байна. Төслийн нэгж, мэдээлэл сурталчилгаа, Ухаалаг байгууллага аян өрнүүлэх гэсэн 3 арга хэмжээ үргэлжлэн бизнес хөгжүүлэлт хийгдэж байна.</p> <p>Тус хөтөлбөрийн хүрээнд төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж аймгийн ЗДТГ нь дэргэдээ "Цахим төв"-ийг шинээр ашиглалтад оруулж төрийн 215 үйлчилгээг 24/7 цагийн турш үзүүлж байна. "Цахим төв"-өөс иргэн, хуулийн этгээд 16 төрлийн 37 үйлчилгээ, "E-Mongolia"- Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс 73 төрлийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаас 9 төрлийн 72 үйлчилгээ авах боломжтой юм. Төрийн үйлчилгээг олон шат дамжлагагүй, хүнд сурталгүйгээр иргэд олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор Баян-Өндөр, Жаргалант суманд E-Mongolia төвийг 2021 оноос ажиллуулж байна. 2024 оны I улиралд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд аймгийн алслагдсан гэр хорооллын үйлчилгээний нэгдсэн төвийн нэг давхарт иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулан хүргэх зорилгоор "Хурдан" төвийн байр талбайг тохижуулан байгуулж шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр ханган шинэ төвийг нээн ажиллуулсан. Баян-Өндөр сумын захын бүсийн иргэд Төрийн мэдээллийг "Хурдан" төвөөр дамжуулан 86 байгууллагын 1173 төрлийн лавлагаа тодорхойлолтыг холбогдох Төрийн байгууллага дээр очиггүйгээр хурдан шуурхай чирэгдэлгүйгээр авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн 2024 И-Монгол лавлагааны киоск машин 3 ширхгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авч Жаргалант сум, Баян-Өндөр сумын ЗДТГ-т, Хорооллын нэгдсэн байрны ХурДан төвийн үйлчилгээний хэсэгт тус тус байршуулан хэвийн үйл ажиллагааг ханган лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Мөн 2025 оны II, IV улиралд хүн ам ихээр төвлөрдөг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт үйлдвэрийн АБК цех, аймгийн автотээврийн төв болон Баян-Өндөр сумын Дэнж, Оюут багт шинээр багийн байр ашиглалтад орсонтой холбогдуулан төрийн цахим үйлчилгээний машинуудыг шинээр 10 цэгт нэмж байршуулсан.</p>	
86	5.1.2.Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна.	2020-2025	ТЗУХ	Орон нутгийн төсөв	86.0	80 %	100 %	86.0	Орон нутгийн төсөв 86.0	<p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Цахим Эрдэнэт хөтөлбөрт тусгагдсаны дагуу E-mongolia төвийг 2021 онд аймгуудаас анх удаа байгуулж байсан аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх шат дамжлагыг багасгах, иргэд, байгууллагуудад үзүүлэх үйлчилгээг шуурхай, ил тод болгоход чиглэгдсэн ажил бол төрийн үйлчилгээг цахимжуулах ажил юм. Төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим үндэстэн болох чиглэлээр Засгийн газраас томоохон зорилтууд дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд манай аймаг цахимжуулалтын ажлыг түүчээлэн ажиллаж байна. 2023 онд Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум дахь И-Монголиа төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр нийт 113 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 41883 ширхэг лавлагаа тодорхойлолт, тусгай зөвшөөрөл зэргийг гаргаж иргэдэд Тараах материал гарын авлага тогтмол өгч ажиллаж</p>	100

										<p>байна. Төлбөртэй лавлагаа, тодорхойлолт гарган тухайн байгууллагуудын дансанд нийт 99.2 сая төгрөгийн орлого оруулсан дүнтэй байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 80-90 хувьд И-Монголиа аппликейшн суулгаж, бүртгэл үүсгэж, төвийн 70351000, 70396000 лавлах дугаарт ирсэн дуудлага бүрд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.</p> <p>Төрийн байгууллагуудын албан хэргийн үйл ажиллагаанд И-Оффис систем ашиглагдаж байна. Улсын хэмжээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлагууд, төрийн байгууллагуудтай албан бичиг солилцох дундын https://docx.gov.mn/ системд интеграци хийж албан бичиг солилцох хөгжүүлэлтийг аймгийн хэмжээнд бүх төрийн байгууллагуудыг хамруулсан албан хэрэг хөтлөлтийн и-оффис системд хийж холбосон ба одоогийн байдлаар тус системд холбогдсон 2672 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломж бүрдэн ажиллаж байна. И-Оффис системийг 2018 оны 05 дугаар сарын 01-ээс нэвтрүүлэн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, сургууль цэцэрлэгүүдийг хамарсан 163 байгууллагын 2312 хэрэглэгч албан хэрэгтэй ашиглаж байна. Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, засгийн газрын тогтоол, журмын дагуу тухай бүр өргөжүүлж хөгжүүлсээр хоорондоо уялдаа холбоо бүхий бодлого хөтөлбөр, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, захиргаа, хүний нөөц, албан хэрэг хөтлөлт, бүртгэл тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөө, харилцаа холбоо гэсэн 7 үндсэн системд 31 төрлийн дэд систем болон өргөжиж баяжсан байна. 2025 онд тоон гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд И-Оффис системийг өргөжүүлж тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн нэвтрүүлж тайлант оны эцсийн байдлаар 21 байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p>	
87	5.1.3.Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахимаар хянадаг систем улам сайжирсан байна.	2020-2025	ТЗУХ	-	-	30	Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, биелэлтийг цахимаар хянадаг системийг сайжруулсан байна.	-	-	<p>Аймгийн хэмжээнд И-оффис системийг ашиглан иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд 100 хувь цахимаар хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2021-2023 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албад, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 21666 өргөдөл, гомдол ирснээс 29963 буюу 94.1 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.</p> <p>2024 онд "Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах"- төвд нийт 2734 өргөдөл, гомдол ирснээс 2624 нь буюу 96.0 хувь нь хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн, Тус төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 11986 өргөдөл, гомдол ирсний 99.7 хувь нь шийдвэрлэгдсэн, 26 буюу 0.2 хувь нь шийдвэрлэх боломжгүй, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлээр багуудын цахим булангийн ашиглалтыг нэмэгдүүлэх, www.irgen.erdenet.mn вэб сайтын ашиглалтыг сайжруулах иргэдэд сурталчлах арга хэмжээ авч ажиллах талаар ирүүлсэн чиглэлийг Баян-Өндөр, Жаргалант суманд аймгийн ЗДТГ-ын 2025 оны 04/151 дугаар албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин, ажилласнаар тус вэб сайтад 696 өргөдөл, гомдол ирүүлсэн байгаагаас авто зам засварлах</p>	100

									асуудлаар 140, цахилгаан, гэрэлтүүлгийн асуудлаар 75, хог хаягдлын асуудлаар 57, ус,дулаан хангамжийн асуудлаар 46, нийтийн тээврийн үйлчилгээний асуудлаар 58, эрүүл мэндийн асуудлаар 37, СӨХ-дын үйлчилгээний талаар 37 өргөдөл,гомдол ихээр ирсэн бөгөөд холбогдох байгууллагууд хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн иргэнд хариу мэдэгдэн ажилласан байна		
88	5.1.4.Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр үргэлжлэн хэрэгжиж, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд хангагдсан байна.	2021-2024	ТЗУХ	Орон нутгийн төсөв	100.0	100%	100%	100.0	Улсын төсөв 17200.0 Орон нутгийн төсөв 1339.6	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 22 дугаар тогтоолоор Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2021-2025 онд багуудын ажлын байрыг үе шаттайгаар шийдвэрлэн ажиллаж байгаа ба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говил, Баянцагаан, Яргуйт, Зэст, Дэнж, Оюут багуудын цогцолбор төвийг ашиглалтад хүлээн авсан. 2021-2025 онд орон нутгийн төсвийн 399.6 сая төгрөгөөр багийн байруудад урсгал засвар, 505.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 багийг суурин болон зөөврийн компьютер, өнгөт принтер, лед дэлгэц гэх мэт техник тоног төхөөрөмж, шаардлагатай эд хогшлууудаар хангасан. Багийн 130 гаруй хэсгийн ахлагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг сайжруулах чиглэлээр орон нутгийн төсвөөс харилцаа холбоо, бичиг хэргийн зардалд нийт 145.0 сая /өссөн дүнгээр/ төгрөг зарцуулсан. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор баг бүр нутаг дэвсгэрээ хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд тус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 232.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Багийн үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж, багийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, мөнгөн тусламж олгох, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, орон гэр, хашааны газар олгох зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах irgen.erdenet.mn вэб системд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх боломж олгох зорилгоор орон нутгийн төсвийн 58.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 багт "Иргэний цахим булан"-г байгуулан үйл ажиллагааг тогтворжууллаа. Багийн үйл ажиллагаанд иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд баг, Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг тогтмол зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэж ажиллаж байна. Аймгийн ИТХ-ын 2022 оны Ээлжит 8-р хуралдаанаар Баян-Өндөр сумын Эрдэнэ, Яргуйт, Цагаанчулуут багийг хувааж Чингэл, Баян-Овоот, Найрамдал, Чандмань багуудыг шинээр зохион байгуулж, 2023 оны 1 дүгээр сараас үйл ажиллагааг эхлүүлсэн. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг 2022 онд 70 хувь, 2023 онд 90 хувь, 2024 онд	100

										100 хувьтай хэрэгжүүлсэн.	
89	5.1.5.Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2025	ТЗУХ	-	-	100%	100%	-	-	Монгол улсын сангийн сайдын 2018 оны 09-р сарын 12-ны өдрийн 288 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 1-р хавсралтын дагуу иргэд олон нийтээс саналыг https://sanal.erdenet.mn/ хаягаар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу Иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг https://sudalгаа.erdenet.mn/ хаягаар авч аймгийн төрийн байгууллагуудын дотоод удирдлагын программ хангамж болох И-Оффис систем дээр нэгтгэн тухай бүр боловсруулалт хийн ажиллаж байна. Ингэснээр судалгаанд ашиглагддаг цаг хугацаа болон эдийн засгийн хувьд хэмнэлттэй үр дүнтэй байна.	100
Хариуцлагатай төрийн алба											
Зорилт 5.2. Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавхыг улам сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлого, түүний хэрэгжилтэнд салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах, мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ:											
90	5.2.1.Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх системийг үлгэр жишээ хэрэгжүүлнэ. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга, хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	2020-2025	ТЗУХ	-	-	-	100% хэрэгжүүлсэн байна.	-	-	Төрийн албан хаагчид иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр тогтмол ханган ажиллаж байна. Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийг чадавхыг сайжруулах хүрээнд 2023 онд ерөнхий шалгалт зохион байгуулахад 409 иргэн шалгалтад оролцохоор бүртгүүлсэнээс 336 иргэн буюу 82.1 хувь нь шалгалтад оролцон 136 иргэн буюу 40.1 хувь нь тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн нь өмнөх оноос 46.2 хувиар нэмэгдсэн. 2023 онд төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг 51 байгууллагын 98 сул албан тушаалын захиалгыг хүлээн авч, 24 удаа тусгай шалгалтыг зохион байгуулахад тухайн албан тушаалын тусгай шаардлагыг бүрэн хангасан, цахимаар бүрэн материалаа илгээсэн 173 оролцогч тусгай шалгалтыг өгснөөс хамгийн өндөр оноо авсан 72 оролцогчийг нэр дэвшүүлэн тухайн байгууллагуудад томилсон болно. Аймгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 оны 05 сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн танилцуулга, хууль хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлууд сэдвээр Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороотой хамтран сургалтад 38 төрийн байгууллагын удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт 100 албан хаагчийг хамруулсан. 2024 онд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч болон төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг 43 байгууллагын /давхардсан тоогоор/ 60 сул албан тушаалын захиалгыг хүлээн авч, холбогдох хууль, эрх зүйт нийцэж байгаад	100

										<p>үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах зарыг нийтэд мэдээлснээс төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа тухайн албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлага бүрэн хангасан ёс зүй, хариуцлагыг шалгуур болгож 8 төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилсон.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар 2024 оны захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх Ажлын хэсэгт ажиллан Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.</p> <p>2025 онд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч болон төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг 41 байгууллагын /давхардсан тоогоор/ 63 сул албан тушаалын захиалгыг хүлээн авч, холбогдох хууль, эрх зүйт нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах зарыг нийтэд мэдээлснээс төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа тухайн албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлага бүрэн хангасан ёс зүй, хариуцлагыг шалгуур болгож 9 төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилсон.</p> <p>Төрийн албаны шинэтгэл, төрийн албаны тухай хууль, тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож байна.</p>	
91	5.2.2.Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулсан байна.	2020-2025	ТЗУХ	Орон нутгийн төсөв	167.0	-	100%	167.0	Орон нутгийн төсөв 167.0	<p>Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нэвтрүүлэх сургагч багшаар бэлтгэгдсэн 5 багш баталсан төлөвлөгөөний дагуу 96 байгууллагын хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг хянан явцын засвар өөрчлөлтийг байгууллага, албан хаагч бүрээр хийж өгч, ажилтан, алба хаагчдын үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний шинэчлэлтийг хийлгэж гүйцэтгэсэн.</p> <p>Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын цалингийн нэгдсэн систем нь нууцын зэрэглэлд байдаг тул тус системд хамрагдаагүй болно. Төрийн албаны цалингийн нэгдсэн систем болон Хүний нөөцийн удирдлагын системийг Орхон аймгийн төсвийн байгууллагын хэмжээнд 100 хувь хамруулсан.</p> <p>Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулан, төрийн байгууллагуудад төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэж байгаа байдалд дотоодын хяналт хийж, төрийн албаны ангилал, боловсролын мэдээлэл, ажилд томилсон, чөлөөлсөн тушаалыг дутуу оруулах, албан тушаалын төрөл, даатгуулагчийн төрлийг алдаатай бүртгэх, журамд заасан хугацаанд албан хаагчийн ажлаас чөлөөлсөн түүхийг бүртгэхгүй байх, хууль эрх зүйн үндэслэлийг буруу бүртгэх, давхар ажил эрхлэлтэй албан хаагчийг үндсэн ажилтнаар бүртгэх, албан хаагчдаар баталгаажуулахгүй байх зэрэг зөрчлүүдийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч, зохион байгуулан ажиллаж байна.</p>	100

										Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, Архивын улсын үзлэгийн Ажлын хэсэг Орхон аймагт ажиллахад сумдын ЗДТГ болон төрийн үйлчилгээний байгууллагуудын "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн баяжуулалт бүрэн, сайн хийгдсэн гэж үнэлэгдсэн.	
92	5.2.3.Аймгийн хурал, захиргааны байгууллагаас гаргах бодлого, шийдвэрийн төлөвлөлтийн уялдаа холбоо хангагдан төрийн байгууллагууд мэдээллийн нэгдсэн системд шилжинэ.	2020-2025	ТЗУХ	-	-	-	Бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа хангагдаж, Төрийн байгууллагууд мэдээллийн нэгдсэн системтэй болсон байна.	-	-	Аймгийн хэмжээнд Албан хэрэг хөтлөлтийн программ хангамж И-Оффис цогц системийг 2018 оны 05 дугаар сарын 01-ээс нэвтрүүлэн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага, сургууль цэцэрлэгүүдийг хамарсан 162 байгууллагын 2480 хэрэглэгч албан хэрэгтэй ашиглаж байна. Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, засгийн газрын тогтоолуудын дагуу жил бүр өргөжүүлж хөгжүүлсээр хоорондоо уялдаа холбоо бүхий Бодлого хөтөлбөр, Ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, Захиргаа, хүний нөөц, Албан хэрэг хөтлөлт, Бүртгэл тайлан, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Харилцаа холбоо гэсэн 7 үндсэн системд 30 дэд систем болон өргөжсөн байна. Мөн иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлт, шийдвэрлэлтийн явц хэрхэн явагдаж байгааг иргэдэд нээлттэй ил тод байхаар мөн төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн И-Оффис системтэй уялдаж ажилладаг байхаар нэгдсэн вэб системийг 2022 оны 10 дугаар сараас ашиглаж эхлээд байна. Уг систем нь Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд өргөдөл гомдол санал хүсэлтийг нийтэд ил тод, нууцад хамаарах өргөдөл гомдол санал хүсэлтийг зөвхөн өргөдөл гомдол санал хүсэлт гаргагч иргэнд өөрт харагдахаар зохион байгуулагдсан. Мөн 2023 оны 2 дугаар улирлаас эхлэн улсын хэмжээнд төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны дундын систем болох https://docx.gov.mn системд холбогдсоноор 1712 байгууллагатай албан бичиг солилцох боломжтой болсон. Ингэж системүүд нэгдэж өргөжин тэлж байгаа нь ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна мэдээлэл солилцох хурд болон байгууллагын шийдвэр гаргах мэдээлэл боловсруулалтад чухал ач холбогдолтой байна.	100
93	5.2.4.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг сайжруулна.	2020-2025	ТЗУХ	Улсын төсөв Орон нутгийн төсөв	104.9 35.0	20%	Хөтөлбөрийн хэрэгжилт 50%	139.9	Улсын , Орон нутгийн төсвөөс 2865.1	Төрийн байгууллага бүр албан хаагчдыг дэмжих нийгмийн хамгааллын болон сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн дагуу судалгааг хагас, бүтэн жилээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. 2023 онд хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөрт 982 төрийн албан хаагчид 478.8 сая төгрөг, орон байраар хангагдахад 8 төрийн албан хаагчид 75.0 сая төгрөг, ажиллах хугацаандаа мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдсан 23 төрийн албан хаагчид 48.9 сая төгрөгийг тус тус олгосон. Аймгийн хэмжээнд "Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийг батлан аймгийн Засаг даргын 2023 оны А/126 дугаар захирамжаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажилласан. 2023 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсөвт 300.0 сая төгрөг батлагдсанаас тайланд хугацаанд 47 төрийн албан хаагчид 284.7 сая төгрөг, төрийн албан хаагчдын сургалтын зардалд 15.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд тогтвор суурьшилтай,	100

ажлын амжилт гаргасан 8 байгууллагын 13 төрийн албан хаагчдыг гадаад улсад туршлага судлуулах дэмжлэгт хамруулсан.

2024 онд дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 10-аас доошгүй жил ажилласан, орон нутгийг хөгжүүлэх эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, тухайн бүтээл нь орон нутагт бодит үр дүнд хүрч олон нийтэд эерэг өөрчлөлт, сайн үр дүнд хүрсэн, донорын үүрэг гүйцэтгэж буй болон эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаанд орж буй, өрхийн орлого буурч хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй байгаа, амины орон сууц барих, худалдан авах болон нөхцөл сайжруулах нийт 155 төрийн албан хаагчид нийт 233.8 сая төгрөгийн дэмжлэг, амины орон сууц барих, орон сууц худалдан авах болон орон сууцны нөхцөлөө сайжруулахад Улсын бүртгэлийн хэлтэс, Биеийн тамир спортын газар, Татварын газар, Статистикийн хэлтэс, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нийт 25 албан хаагчид 240.0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн.

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах асуудлаарх нутгийн захиргааны байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны санал, танилцуулгыг төрийн захиргааны 25 байгууллагаас хүлээн авч судлан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар 5 удаа хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүлээсэн үүргээ "Хангалттай сайн" биелүүлсэн нийт ахлах түшмэл 12, дэс түшмэл 75, туслах түшмэл 39 бүгд 126 төрийн жинхэнэ албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох болон ахиулах ажлыг зохион байгуулсан.

Мөн "Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн ажиллах журам"-ыг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

2025 онд Тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 10-аас доошгүй жил ажилласан төрийн албан хаагчдад нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх дэмжлэгийг 9 байгууллагын 11 албан хаагчдад 85.6 сая төгрөг, Төрийн албанд тогтвор суурьшилтай болон үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдыг Орхон аймагт орон сууцны нөхцөл сайжруулахад 9 байгууллагын 11 албан хаагчдад 83.9 сая төгрөг, шууд харилцаатай гадаад улсын хотуудад туршлага судлуулахад дэмжлэг 10 байгууллагын 12 албан хаагчдад 70.8 сая төгрөг, өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжих, дэмжлэг 4 байгууллагын 4 албан хаагчдад 8.0 сая төгрөг, Эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж амжилт гаргасан, төрийн албан хаагчдыг урамшуулахад 3 байгууллагын 3 албан хаагчдад 6.0 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр түүний гэр бүлийн гишүүд эс, эд, эрхтэн солиулах, шилжүүлэн суулгах эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэхэд 3 байгууллагын 3 албан хаагчдад 19.0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн.Удирдлагын академитай хамтран захиалгат 60 албан хаагчдад "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт: сэтгэлгээний өөрчлөлт" сэдэвт 16 цагийн танхимын сургалтын зардалд 3.6 сая төгрөг, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын төрийн албан хаагчдын

										"Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөн 450 төрийн албан хаагчдад зохион байгуулахад 9.5 сая төгрөг нийт 20.2 сая төгрөгийг тус тус шийдвэрлэсэн Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, төрийн албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт оруулах, дархлааг дэмжин амин дэм олгох зэрэг ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.	
Хүний эрхийг дээдэлсэн нийгэм											
Зорилт 5.3. Хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:											
94	5.3.1 Хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудад бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.	2020-2025	НБХ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	Улсын төсөв Орон нутгийн төсөв	10.0 5.0	3 ТББ	Хүүхэд хамгааллын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн ТББ-уудтай хамтран ажиллана	10.0 5.0	Улсын төсөв 10.0 Орон нутгийн төсөв 155.0	<p>Хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад зохих журмын дагуу магадлан итгэмжлэл хийлгэх асуудлаар судалгаа хийж, холбогдох материалыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт уламжлан шийдвэрлүүлэх, магадлан итгэмжлэлийн хугацааг сунгах асуудлаар холбон зуучилж ажилласан. Тухайлбал, 2023 оны 10 дугаар сард нийт 3 ТББ-д магадлан итгэмжлэл хийлгэхээр зохих материалыг хуулийн дагуу бүрдүүлэн хүргүүлээд байна. 2023 онд тус газартай гэрээгээр "Ариунсаруулбат" НҮТББ хамтран ажиллаж "Алхам алхмаар" хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд гэрээний төлбөр улсын төсвөөс 10 сая төгрөг, "Сэтгэл зүйн цогц боловсролын төв" НҮТББ-тай хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд сэтгэлт зүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байгаа ба орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>2024 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн төсвөөс нийт 242.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 93 кейсийн 203 хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 80.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгон дэмжлэг үзүүлж ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хамтран ажилласан ТББ-ын тоо 50%-иар нэмэгдсэн байна. Үүнд:</p> <p>Гэр бүлийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд Орхон аймаг дахь Улаанбаатар Эрдэм их сургуультай хамтран сургагч багш бэлтгэн ажилласан.</p> <p>"Сэтгэлзүйн цогц боловсролын төв" ТББ -тай хамтран гэмт хэрэг зөрчилд холбогдсон болон хохирогч хүүхдэд сэтгэлзүйн үйлчилгээг үзүүлэх, эрсдэлт бүлгийг 50 гэр бүлд сэтгэл заслын хөтөлбөр хэрэгжүүлсэн. Нийт 150 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Галт шувуу ТББ-тай хамтран хамтарсан багийн гишүүдийг мэргэшүүлэх, кейс менежментийн зарчим, алхмын дагуу чанартай хамгааллын үйлчилгээг үзүүлэх зорилгоор чадавжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулсан. Сургалтад хамтарсан багийн 209 гишүүн хамрагдсан.</p> <p>Монголын ураг удам" ТББ хамтран угийн бичиг хөтлөх боловсрол олгох чиглэлээр, Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв" болон "Сайн үйлс-Сайн иргэн ТББ-уудтай хамтран гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр тус тус хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад төрийн бус байгууллагуудын оролцоо нэмэгдсэн. Гэр бүлийн хөгжлийг дэмжих, урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 22 төрлийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 216 өрхийг хамруулсан.</p>	100

										Аймгийн хэмжээнд Баян-өндөр, Жаргалант сумын багуудад 27, Ерөнхий боловсролын сургуульд 29 нийгмийн ажилтан хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. 2025 онд Хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хүүхэд хамгааллын чиглэлээр 2, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр 3 төрийн бус байгууллагатай хамтран нийт 70.0 төгрөгийн дэмжлэг олгосон. Мөн хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээг Баян-өндөр, жаргалант сум болон 22 багт нийт 24 хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллаж байна. Багийн хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд 77 удаагийн сургалтыг багийн иргэдэд зохион байгуулж 4288 насанд хүрэгч хамрагдсан байна. Улсын төсвөөс 56.0 сая төгрөг зарцуулсан	
95	5.3.2.Хот тохижилтын асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн саналд үндэслэдэг болно.	2020-2025	ХЗА	-	-	-	Иргэдээс ирүүлсэн саналыг орон нутгаас хэрэгжүүлж байгаа ажилд тусгах, хэрэгжүүлэх	-	-	Аймгийн Засаг дарга иргэдтэй хийсэн уулзалтаар гаргасан оновчтой саналыг орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын саналд тусган шийдвэрлэдэг. Мөн хот тохижилт, ирэх жилийн хөрөнгө оруулалтын ажлын саналыг иргэдээс цахимаар болон өрх бүрээр биечлэн авч эрэмбэлэн, багийн иргэний танхимаар иргэдээр хэлэлцүүлэх, бүлэг, залуучууд, ахмад зэргээр хэсэгчлэн хэлэлцүүлгийг зохион байгуулж бүх талын оролцоог ханган, саналыг тусган ажиллаж байна. Хот тохижуулах газар тохижилт үйлчилгээний чиглэлээр чатбот, багийн иргэдтэй газар дээр нь биечлэн уулзах, иргэдийн санал авах 7714-5454 утсыг ажиллуулж 3 чиглэлээр иргэдээс саналыг авч шийдвэрлэж байна.	100
96	5.3.3.Эрдэнэт хотын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлэх асуудалд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авч, тусгадаг болно.	2020-2025	ТЗУХ	-	-	-	Шийдвэр гаргалтад иргэдийн саналыг тусгадаг байх	-	-	Аймгийн ИТХ-ын хуралдаанаар шийдвэрлэх асуудлыг багуудын Иргэний танхимаар иргэдээр хэлэлцүүлэх, санал хүсэлтийг багуудын цахим булан болон пэйж хуудсаар дамжуулан, ИТХ-ын хуралдааны үеэр шууд утас ажиллуулах, шууд лайвын сэтгэгдэл хэсгээр цахимаар авах, албан тоот болон өргөдөл, гомдол, санал хүсэлт авах 7035-3511 утсаар иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авч, тусган ажиллаж байна. ХЭЗХ нь иргэдэд нээлттэй сонсолыг тухай бүр зохион байгуулж, иргэдийн саналыг шийдвэр гаргахад тусгаж байна. Мөн иргэд, иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийг судалж үзэн Орон нутгийн төсөв, Болзошгүй аваарын зардлаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.	100
97	5.3.4.Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-г бүтэц, зохион байгуулалтын шинэ хэлбэрт шилжүүлж, менежментийг оновчтой болгох асуудлыг иргэдийн санал, санаачилгад тулгуурлаж хэрэгжүүлнэ.	2020-2025	ХЗА	-	-	-	СӨХ-ны хяналтыг сайжруулж, айл өрхийн ая тухтай байдал хангагдсан байна.	-	-	Орхон аймагт Сууц өмчлөгчдийн холбооны 2 салбар зөвлөл үйл ажиллагаа явуулдаг ба 32 СӨХ үйл ажиллагаа явуулж байна. Орон сууцны айл өрхийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд хяналт тавих Аймгийн засаг даргын А/782 тоот ажлын хэсэг байгуулан ажилласан. Хяналт шалгалтаар гарсан зөрчлүүдийг хугацаатай үүрэг чиглэл өгч шийдвэрлүүлсэн. СӨХ-ын үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийх чиглэлээр Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны А/76 тоот захирамжийн дагуу удирдамж гарч ажлын хэсэг байгуулагдан 2024 оны 03-р сарын 25-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл ажиллалаа. Нийт 1-6 - р хорооллын 109 байрны 629 блок подвалын хэсэг, гараашнуудыг хамруулж үзлэг шалгалт хийж 6 чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн дагуу СӨХолбоодыг иргэд оршин суугч	100

										өдрийн 02/55 дугаартай тогтоолоор “Орхон аймгийн Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох тухай” захиргааны хэм хэмжээний актуудыг баталсан. Иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх зорилгоор www.irgen.erdenet.mn вэб системийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлсэн.	
99	5.3.6.Бүх төрийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний чанар, үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг хөндлөнгийн мэргэжлийн судалгааны байгууллагатай хамтран жил бүр тогтмол хийж, үр дүнд нь үндэслэн үйл ажиллагаандаа тасралтгүй сайжруулалт хийнэ.	2020-2025	ХШҮХ	-	-	-	Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, үр дүнг тодорхойлсон байна.	-	-	Монгол Улсын Засгийн газрын хэрэг Эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар “ Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг баталсан. Энэхүү удирдамжийн дагуу төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор аймгийн хэмжээнд 2021 оноос И-оффис цахим системийг ашиглан Хэрэглэгчийн хөндлөнгийн үнэлгээ буюу сэтгэл ханамжийн судалгааг авдаг болсон. Судалгаагаар иргэдээс гарсан санал санаачилгыг эрэмбэлэн орон нутгийн хөрөнгө оруулалтад тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 онд иргэдийн хамгийн их гомдол ирдэг нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжид Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн багш нар сэтгэл ханамжийн судалгаа хийгдэж 1-5 оноогоор үнэлэхэд 2.86 оноогоор үнэлэгдсэн судалгааны үр дүн гарсан. Үүнд үндэслэн аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг үнэлэхээр шалгуур үзүүлэлт болгон тусгаж , цаашид жил бүр судалгааг тогтмол хийж нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт шинжилгээний үнэлгээний шалгуур үзүүлэлтэд Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна, Цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлнэ, Улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэнэ, Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ, Төрийн албаны сургалтын чанарыг дээшлүүлнэ, Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулна зэрэг зорилтуудыг иргэдийн сэтгэл ханамжийн судалгаагаар үнэлэхээр тусгасан.	100
100	5.3.7.Эрдэнэт хотын удирдлагын шийдвэр гаргалтад мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.	2021-2025	ХЭЗХ	-	-	-	Удирдлагын шийдвэр гаргалтад сонирхлын бүлгүүдийн оролцоог хангасан байна.	-	-	Аймгийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам боловсруулахад аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан бүрэлдэхүүнд нь иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд тэдгээрийн оролцоог хангаж байна. Мөн Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу оролцогчдын тайлбар, саналыг авах ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Үүний хүрээнд шийдвэрийн төслийг боловсруулж www.erdenet.mn вэб хуудас болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан мэргэжлийн холбоод, шинжилгээ судалгааны байгууллага болон иргэдийн санал хүсэлтийг нээлттэйгээр тогтмол авч ажиллаж байна. Ингэснээр удирдлагын шийдвэр гаргалтад иргэн болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах мөн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал, үр дүнг шийдвэрт тусгах зэргээр оролцоог	100

										<p>хангаж ажиллаж байна.</p> <p>2023 оноос Боловсролын газар, "Эрдэнэт" цогцолбор дээд сургуультай хамтран Эрдэнэт хотын тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, орон нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн гарц шийдлийг эрэлхийлэх, шинэ санал санаачилга дэвшүүлэх, харилцан туршлага солилцох, бүс нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнг сурталчлах зорилгоор "Эрдэнэт хотын тулгамдсан асуудал, гарц шийдэл" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна. Энэ хурлаас гарсан судалгаа, шинжилгээний ажлуудыг бодлогын шийдвэр гаргалтад ашиглан ажиллаж байна.</p> <p>Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахад төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон эрдэмтэн судлаачдаар хэлэлцүүлж саналыг тусгасан.</p>	
101	5.3.8.Эрдэнэт хотын удирдлага жилийн үйл ажиллагааны тайланг иргэдэд тавьдаг болно.	2020-2025	ТЗУХ, ХБТХОХ, ХШҮ	-	-	-	Жилийн үйл ажиллагааны тайланг иргэдэд жил бүр танилцуулсан байна.	-	-	<p>Засаг дарга жил бүр үйл ажиллагааны тайлангаа иргэдэд цахимаар болон хэвлэмлээр тайлагнаж хэвшсэн ба баг бүрээр зохион байгуулан танилцуулж, иргэдээс гарсан саналыг төлөвлөгөө гарган, шийдвэрлэн ажиллаж байна. 2023 оны тайлан тавих болон 2024 оны хөрөнгө оруулалтын ажилд санал авахаар иргэдийн уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 28-ны өдрүүдэд 13 удаа хуваарийн дагуу зохион байгуулж иргэдээс нийт 809 санал, хүсэлт ирснээс зам засварлах, асфальтан зам тавихтай холбогдолтой 179, нийтийн тээврийн үйлчилгээтэй холбогдолтой 84, хог хаягдлын асуудлаар 46, цахилгааны хүчдэлтэй холбогдолтой 39, инженерийн шугам сүлжээтэй холбоотой 35, камержуулалт 34, гэрэлтүүлэг 32, газрын харилцааны асуудлаар 28, түлээ, нүүрстэй холбоотой асуудлаар 28, сургууль, цэцэрлэг, СӨХ-ны засвар үйлчилгээтэй холбоотой 27, нохой, муур устгах асуудлаар 15 санал, хүсэлт ирсэн бөгөөд нийт ирсэн санал хүсэлтийн 67 хувийг эзэлж байна.</p> <p>Аймгийн Засаг даргаас Баян-Өндөр сум, Жаргалант сумын иргэдтэй 2024 оны 1 дүгээр сарын 08-наас 14-ний өдрүүдэд хийсэн уулзалтаар иргэдээс 628 санал, хүсэлт гаргасныг хүлээн авч тухайн үед нь шийдвэрлэх боломжтой 400 гаруй асуудлыг шийдвэрлэн хариу өгч, гарсан санал шүүмжлэлийн мөрөөр цаашид хийх 98 ажлын төлөвлөгөөг гарган төрийн байгууллагуудад хүргүүлж, ажилласан. 2025 онд Засаг дарга 7 хоног бүрийн пүрэв гарагт нийт 26 удаагийн уулзалтаар 300 гаруй иргэдийг хүлээн авч уулзан аймаг, орон нутгийн хөгжил, тулгамдаж буй асуудлын талаарх санал, хүсэлтийг нь сонсож газар дээр нь шийдвэрлэх арга хэмжээ авч холбогдох хэлтэс, байгууллагад 479 үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж, иргэдэд хариу мэдэгдэж ажилласан бөгөөд хэрэгжилт 85.2 хувьтай байна.</p> <p>Иргэдийн санал, хүсэлтийн дагуу тулгамдсан 111 асуудлаар газар дээр нь очиж танилцан холбогдох хэлтэс, байгууллагуудад нийт 215 үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан тухай бүр мэдээлэл бэлтгэн шуурхай хурал, хэвлэл мэдээллийн хэрэглээгээр түгээн ажиллаж байна. Засаг даргын гадуур ажиллах үед өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 82.0 хувьтай байна.</p> <p>Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалт, гадуур ажилласан ажлын өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, биелэлтийг нэгтгэн 7 хоног бүр Засаг даргад танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавин биелэлтийг тооцон ажиллаж байна.Тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд</p>	100

										мэдээллийг түгээн ажиллаж байна. Орхон аймгийн үндсэн чиглэл, жил бүрийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, тайланг ИТХ-аараа нээлттэй хэлэлцүүлж, цахим сайтад нийтэлж ил тод мэдээлэн ажиллаж байна.	
102	5.3.9.Монгол Улсын Статистикийн тухай хуульд тусгагдсан тооллого, түүвэр судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулна.	2020-2025	Статистик	Орон нутгийн төсөв	62.4	Тооллого, түүвэр судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулсан.	Тооллого, түүвэр судалгааг аймгийн хэмжээнд хуульд заасны дагуу тогтмол зохион байгуулна.	62.4	Орон нутгийн төсөв 294.1	Тайланг хугацаанд 5 тооллого, 23 түүвэр судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулан явуулж, түүврийн аргаар сонгогдсон нэгжүүдийг бүрэн хамруулсан. Тооллого, түүвэр судалгааг тодорхой давтамжит, тогтмол, цаг үеийн хэрэгцээ шаардлагаар тухайн нөхцөл байдлыг үнэлэх гэж 3 ангилдаг. 1.Хуульд зааснаар тодорхой давтамжит хугацаанд явагддаг тооллого, түүвэр судалгаа: 2021 онд Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогыг, 2022 онд Хөдөө аж ахуйн ээлжит тооллого, Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, Албадан хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, 2023 онд Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа болон Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Цаг ашиглалтын судалгаа, 2025 онд Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийг байгуулах судалгаа, Хүн ам, орон сууцны завсрын тооллогыг 2.Тогтмол явагддаг тооллого, түүвэр судалгаа: Жил бүр хагас жилийн мал тооллого, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогыг, улирал бүр Ардчилсан засаглал судалгааг, сар бүр Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгааг 3.Цаг үеийн нөхцөл байдлыг үнэлэх түүвэр судалгаа: 2021 онд Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлж буй нөлөөллийн судалгаа, Ургацын алдагдал, хорогдол тооцох туршилтын судалгаа, Жендер ба хүрээлэн буй орчны судалгаа, Бичил уурхай эрхлэгчдийн судалгаа, 2022 онд Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгаа, Түр хамгаалах байр/Нэг цэгийн төвөөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа, 2023 онд Малын ашиг шим, нэмүү өртгийн тооцооны туршилтын судалгаа, Зөвлөлдөх санал асуулгын 2 шатат судалгаа, 2021, 2024 онд Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа, 2025 онд Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа, Хүн ам, орон сууцны завсрын тооллогын туршилтын судалгаа, Дотоодын жуулчдын түүвэр судалгааг тус тус аймгийн хэмжээнд амжилттай зохион байгуулсан. Дээрх 5 тооллого, 23 түүвэр судалгаанд 5372 аж ахуйн нэгж, байгууллага, 36452 өрх, 72487 иргэнийг бүрэн хамруулж, цуглуулсан мэдээллийг ҮСХ-нд графикт хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. Улсын болон орон нутгийн төсвөөс 409.1 сая төгрөгийг зарцуулсан.	100
ЗУРГАА. НОГООН-ЭРДЭНЭТ ХОТ											
Зорилго 6. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, байгальд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлж, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулан, нөхөн сэргээлийг эрчимжүүлэх замаар байгалийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлнэ.											
Зорилт 6.1. Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ:											
103	6.1.1.Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, цагаан	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	-	-	80%	85%	-	-	"Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр"-ийн хугацаа дуусан 2022 онд 85 хувьтай дүгнэгдсэн ба аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ИТХ-ын Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороо, ажлын албаны төлөөлөл, аймгийн ЗДТГ, мэргэжлийн агентлагууд хамтран "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Хаягдлын аж ахуйн үйл ажиллагаатай	100

	тоосны дэгдэлтийг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.								<p>танилцаж, Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажилтай газар дээр нь танилцаж, тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийн талаар нээлттэй уулзалт зохион байгуулсан ба цаашид хөтөлбөр төлөвлөгөөг үргэлжлүүлэхээр шийдвэрлэн уг хөтөлбөрийг 2024-2031 оны хооронд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ-ын 2024 оны 18/04 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p>Хаягдлын аж ахуйн элстэй 1432 га хуурайшилттай талбайн 85%-ийг технологийн 4 төрлийн аргаар норголт хийж, тоосны дэгдэлтийг бууруулж байна.</p> <p>Цагаан тоосны нөлөөллийн бүсийн иргэдэд эрүүл мэндийн үзлэгийг (Орхон аймгийн Баян-Өндөр сумын Говил, Баянцагаан багийн Вокзалын хэсэг, Жаргалант сум)-ийн нийт 2500 иргэдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг зохион байгуулсан.</p> <p>Тоосны тархалтын зонхилох 3 чиглэлийн 121 га талбайд 5 төрлийн 1.8 сая.ш мод, бутыг тарьж, арчлан ургуулж байна.</p> <p>Шинэ хаягдлын аж ахуйг Орхон аймгийн Жаргалант сум, Булган аймгийн Орхон сумын нутагт нийт 7048 га талбайд байгуулахаар газрыг Засгийн газрын 2024 оны 116 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авч, суурь судалгааны ажил 100%, ТЭЗҮ, зураг төслийн ажил 80%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Тоосны автомат 2 станцын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, дүнг www.Agaar.mn-д оруулж байна.</p>	
104	6.1.2.Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжинэ.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	330.0	Pm10- ст-с 1.4 дахин давсан	pm10–100 MNS458 5:200	34.0	<p>Орон нутгийн төсөв 1582.4</p> <p>ОУБ-8.5 сая доллар</p>	90

										энгийн зуухны янданг буулгасантай тэнцэж байна.Баян-Өндөр сумын гэр хорооллын 19 м2 хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг дуусган гэрээ байгуулан айлуудад хүлээлгэн өгсөн. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон 4763 ш өрхийг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлж, Баян-Өндөр сумын 16 багийн гудамж хоорондын 0.4кВ-ын 6719ш цахилгааны модон тулгууруудыг төмөр бетон шонгоор сольж, 260.18 км СИП кабель татагдаж, 6/0.4кВ-ын 3ш дэд станц, 9 багт 6кВ-ын дэд станц сууриууллаа. 2025 онд 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 2520 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож цахилгааны хүчдэлийн уналтыг шийдвэрлэсэн.	
105	6.1.3.Хөрсний бохирдол, доройтлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хог хаягдлын нэгдсэн менежментийг бий болгоно.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	800.0	16653 ширхэг	15500 хүргэнэ.	200.0	ОУБ-135.0 Улсын төсөв 2450.0 Орон нутгийн төсөв 1200.0	Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар өөрчлөх ажлын хүрээнд 2020 онд 515ш, 2021 онд 80ш, 2022 онд 1078ш, 2023 онд 45ш, 2024-2025 онд 266ш нийт 1984ш нүхэн жорлонг улсын болон орон нутгийн төсвийн 3.78 тэрбум төгрөгийн санхүүжилтээр соруулдаг технологитой жорлонгоор өөрчилж, эх үүсвэрийн тоог бууруулсан. БОУАӨЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын отоглох цэгүүдэд аялагч, түр амрагч нарт зориулсан MNS5924:2015 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, хогийн цэг байгуулж, тухайн орон нутгийн хөрс, гүний усны бохирдол, хог хаягдлыг бууруулж, аялагч, амрагчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор улсын хэмжээнд 6 байршилд нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг Дархан нэгдэл ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд аялал жуулчлалын түр буудаллах цэг болох Эрдэнэт хаалга орчмын нийтийн ариун цэврийн байгууламжид зориулсан гүний худаг шинээр гаргах байршлыг мэргэжлийн байгууллагатай хамтран тодорхойлж, нарны гэрлээр цэнэглэгддэг шон, ангилдаг хогийн сав бүхий 3.5х7м урттай эко ариун цэврийн байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. Хөрс бохирдуулагч эх үүсвэрийн тоо 14669 байна.	100
106	6.1.4.Орчны хяналт, мониторинг судалгааг өргөжүүлж, мэдээллийн санг баяжуулна.	2020-2025	ХБТХОХ	-	-	Цэврийн зэргийн III-IV ангилал	MNS 4586:1998 Стандартын түвшин	-	-	Орхон аймгийн УЦУОШТ-ийн БОШЛ нь Хангал, Эрдэнэт, Орхон голуудаас 80 сорьц авч 23 үзүүлэлтээр нийт 1840 удаагийн давталттай чанарын хяналт-шинжилгээг “MNS 4586:1998 усан орчны чанарын үзүүлэлт ерөнхий шаардлага”-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр Хангал-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Орхон гол 2-р зэрэг буюу Цэвэр, Уртбулаг-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Чингэл-Эрдэнэт гол 2-р зэрэг буюу цэвэр түвшинд байна. Хяналт шинжилгээний дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн сан болон БОХЗТ лабораторид сар бүрийн 1-ны дотор дамжуулж байна. Мөн Орхон аймгийн УЦУОШТ-ийн http://orkhon.tsag-agaar.gov.mn/ сайт дээр сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна.	100
107	6.1.5.Орон нутгийн хамгаалалтад нэмж авах шаардлагатай	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	-	-	1716.2га	Орон нутгийн хамгаалалттай газар,	-	-	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих “Ногоон Эрдэнэт”	100

	газар нутгийг судалж, орон нутгийн хамгаалалттай газар, талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.						талбайн хэмжээг 50га-аар нэмэгдүүлсэн байна.			хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд ойн төгөл, ойн зурвас, ойжуулалтын ажил хийх 264.3 га талбайг Баян-Өндөр сумын ИТХ-ын 2023 оны 13/02 дугаар тогтоолоор, 26 га талбайг Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 01 дүгээр тогтоолоор тус тус орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авч, орон нутгийн тусгай хэрэгцээний буюу орон нутгийн хамгаалалттай газрын хэмжээг 290.3 га талбайгаар нэмэгдэж, 2006.5 га талбайд хүргэлээ.	
108	6.1.6.Хотын төв, гэр хороолол болон хотын ойролцоох суурьшлын бус газруудад үе шаттайгаар ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг хийж, таримал ойн талбайг нэмэгдүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	129.6	14га	117га	129.6	Гадаадын тусламжа ар 454.7 БХАХЗ 1.527.2 ААНБ-900.0	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, таримал ойг 2021 онд 36 га, 2022 онд 68 га, 2023 онд 206,76 га-д хүргэсэн. 2024 онд Баян-Өндөр сумын байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар эмнэлгийн арын ойн санд 2.7 га, Цагаанчулуутын аманд Япон улсын Оиска ТББ-ын дэмжлэгтэйгээр "Сайвар хээр" ХХК-иар 6 га талбайд, "Ногоон Эрдэнэт хөтөлбөрийг дэмжих оролцох тухай Ачит-Ихт ХХК-ийн гэрээний дагуу Далайн Хошууны шинэс ХХК Шар чулуутын аманд 48 га, Хүрэнбулагийн аманд 3 га талбайд, Эрдэнэтийн Дулаан цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, Шанд багийн овоот толгойд 4.7 га талбайд, Эрдэнэт хаалганы урд хэсэгт 5 га, Хангал голын голдирол дагуу 17 га, нийт 87.4 га талбайд 1.474.671 ширхэг мод тарьж өссөн дүнгээр 294.16 га талбайд ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. 2025 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Баян-Өндөр сумын байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар эмнэлгийн арын ойн санд 2.7 га талбайд хамгаалалтын хашаа барилаа, Цагаанчулуутын аманд Япон улсын Оиска ТББ-ын дэмжлэгтэйгээр "Сайвар хээр" ХХК-аар 4 га талбайд хүргэлт ойжуулалт хийлээ, "Ногоон Эрдэнэт хөтөлбөрийг дэмжих оролцох тухай Ачит-Ихт ХХК-ийн гэрээний дагуу Далайн Хошууны шинэс ХХК болон Эрдмин ХХК Хангал голын голдирол дагуу 14.5 га талбайд татмын ойжуулалт, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын үйлдвэрчдийн эвлэлийн холбооны нэрэмжит ойн төгөл болон Д.Түмэнбаярын нэрэмжит ойн төгөл зэрэг байгуулагдаж ойн төглийг 1.5 га талбайд ойн төгөл, Эрдэнэтийн Дулаан цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Цагаанчулуутын амны ойн сангийн 0.1 га талбайд, Эрдэнэт голын голдирол дагуу 1.1 га талбайд, Шанд багийн авто зам дагуу 0.5 га талбайд, нийт 22.7 га талбайд 429.5 мянган ширхэг мод шинээр тарьж, ойжуулалт, ойн төгөл байгуулах ажил зохион байгуулж, ойжуулалт, өссөн дүнгээр 316.86 га талбайд мод тарьж, ойжуулалт ойн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудад тарьц, суулгацын нөөц 7 дахин нэмэгдэж, 4 төрлийн шилмүүст модны 0.4 сая ширхэг, 20 төрлийн навчит модны 2.0 сая ширхэг тарьц, суулгацын нөөц бүрдүүллээ.	100
Байгалийн нөөцийн хариуцлагатай хэрэглээ											
Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээлтийг эрчимжүүлнэ:											
109	6.2.1.Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн,	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	-	-	-	Байгальорчны стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, иргэдийг мэдээллээр хангасан	-	-	Байгаль орчны багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ОБГ, ЦГ, МЭГ, СДОА, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ, Булган аймгийн БОГ, Булган аймгийн Орхон, Сэлэнгэ, Хангал, Бугат сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчидтай 2020-2025 онд нийт 165 удаа хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж үүнээс төлөвлөгөөт хяналт шалгалт 133 объектод, урьдчилан сэргийлэх хяналт	100

	байгаль хамгаалах үйлсэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.						байна.			шалгалтыг 27 чиглэлээр зохион байгуулж, нийт аймгийн хэмжээнд 174 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, 261 заалт бүхий 57-н улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хургуулж, 41 иргэний гаргасан зөрчилд захиргааны арга хэмжээ авч ажиллалаа. Үүнд: Ойн тухай хууль зөрчсөн 7 иргэн, Амьтны тухай хууль зөрчсөн 6 иргэн, Хог хаягдлын тухай хууль зөрчсөн 16 иргэн, Газрын хэвлийн тухай хууль зөрсөн 2 иргэн, Усны тухай хууль зөрчсөн 8 иргэн, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчсөн 2 иргэнд тус тус захиргааны арга хэмжээ авч ажилласан бол хог хаягдлын тухай хууль зөрчиж ахуйн хог хаягдлаа ил задгай хаях гэж байсан 45 иргэн, ойгоос унанги мод бэлтгэх гэж байсан 25 иргэн, цооног өрөмдөж худаг гаргах гэж байсан 18 иргэн, БОНБУ тухай хууль зөрчих гэж байсан 5 ААНБ-ын зөрчлийг тус тус газар дээр нь таслан зогсоож, зөрчлөөс урьдчилан, 2600 гаруй иргэнд ой хээрийн түймэр болон, шар усны үерээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмж, гарын авлага тарааж, салбарын багц хуулийн зөвлөгөө мэдээллийг иргэд, ААНБ-д хүргэж, мэргэжил аргагүйгээр хангаж ажилласан.	
110	6.2.2.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Хувийн хэвшил	-	12га	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 12 га	-	-	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2020-2025 онуудад биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-аар орон тусгай хамгаалалтай Баян-Өндөр хайрхны зүүн талын энгэрт 16.07 га-д, Хангал голын голдирол дагуу 6.87 га-д, Эрдмин ХХК-аар А1001 авто зам дагуух ногоон зурваст болон Хангал голын голдирол дагуу нийт 4.11га-д, Ачит-Ихт ХХК А1001 авто зам дагуух ногоон зурваст болон Хангал голын голдирол дагуу нийт 9.49га-д, Зэс-Эрдэний хувь ХХК үйлдвэрийнхээ гадна талын сайжруулсан шороон авто зам дагуух болон А1001 авто зам дагуух ногоон зурваст нийт 6.1га-д, Гал-Сэнтий ХХК Эрдэнэт голын голдирол дагуу болон А1001 авто зам дагуух ногоон зурваст нийт 2.07га, Очир төв ХХК Хангал голын голдирол дагуу 1.27га, Дэлт хошуу ХХК үйлдвэрийнхээ гадна талын сайжруулсан шороон авто зам дагуух ногоон зурваст 1.22 га талбайнуудад тус тус биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлэн мод бут сөөгийг тариулж, усалгаа арчилгааг тогтмол гүйцэтгүүлж, арчлан хамгаалуулан ажиллалаа. /нийт 43.09га / Мөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган батлуулсны дагуу ил уурхайн 3 дугаар овоолго дээр 3.9 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж, 500 ширхэг хайлаас, 500 ширхэг шинэс моднуудыг тарьж, арчлан хамгаалж, ургуулаад байна. Улсын хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон 8000 га талбайгаас Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 2021-2024 оны хугацаанд 2000 га-д техникийн нөхөн сэргээлтийг 100% хийж гүйцэтгэсэн.	100
111	6.2.3.Аймгийн хэмжээнд эвдэрч, эзэнгүй орхигдсон газруудын нөхөн сэргээлтийг үе шаттайгаар гүйцэтгүүлж, нийтийн эзэмшилд шилжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	47.5	10га	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 10га	16.0	Орон нутгийн төсөв 71.0	Аймгийн хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон газруудад техникийн нөхөн сэргээлт хийх ажлын хүрээнд 2020-2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 14.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн сэргээлтийн эрхтэй мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж өссөн дүнгээр 24.5 га талбайд хүргэлээ. Үүнд: • 2020 онд Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт "Өнөр хороолол"-ийн ард талд эвдэрч, эзэнгүй орхигдсон карьерын 2 га-д, Жаргалант сумын Дулаан уул багийн нутаг	100

										<p>дэвсгэрт "Бүтлийн ундарга" ХХК-ийн ар талд Бумбан толгойн хойд энгэрт болон төв зам дагуу эвдэрч, эзэнгүй орхигдсон 2 га-д,</p> <ul style="list-style-type: none"> • 2021 онд Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт буюу 18 карьерын зүүн хойд талын уулын аманд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га-д, Говил багийн нутаг дэвсгэрт Чингэлбөөн цагааны карьерын баруун талд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га-д, • 2022онд Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт 18 карьерын зүүн хойд талд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га-д, • 2023 онд Жаргалант сумын Улаантолгой багийн нутаг дэвсгэрт буюу Тасгийн толгойд эвдэрч, эзэнгүй орхигдсон 1.5 га-д, • 2024 онд Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын зүүн урд энгэрт техникийн нөхөн сэргээлт хийсэн 2 га талбайд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажилладаг Очир төв ХХК, Дэлт хошуу ХХК-иудаар тус бүр 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлсэн. • 2025 онд Очир төв ХХК-иар байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулсны дагуу Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын урд энгэрт 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлээ. 	
112	6.2.4.Гадаргын болон газрын доорх усны чанарын хяналт, мониторингийн сүлжээг өргөтгөх, ус бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Улсын төсөв	-	-	MNS 4586 :1998 Стандартын түвшин	12.0	Улсын төсөв 90.0	<p>2023 онд "Говил багийн нутаг дэвсгэрт байрлах байгалийн горимын цооногийг бүрэн автомат тоног төхөөрөмжөөр тоноглох, улсын сүлжээнд холбох" БӨ-08/24 тоот гэрээний дагуу газрын доорх усны өөрчлөлтөнд хяналт тавих зориулалт бүхий X 49°04'40.02", Y104°05'52.28' координаттай цооногт дараах хяналт мониторингийн бүрэн автомат багаж суурилуулан хүлээлгэн өглөө. 2024 онд аймгийн БОГ, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ-ын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоох, Ус бохирдуулагчийн тоо бүртгэл хийх, хаягдал усны дүгнэлт гаргах талаар хээрийн судалгааны ажлын зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд Ус бохирдуулагчийн тооллогоор нийт 1570 аж ахуйн нэгж, байгууллага одоогийн байдлаар бүртгэгдсэн байна. Үүнээс төвлөрсөн эх үүсвэрт 1338 үйлдвэр аж ахуйн нэгж, төвлөрсөн бус эх үүсвэрт 232 иргэн, аж ахуй нэгж байна.</p> <p>Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэглээндээ саарал буюу техникийн усыг нэвтрүүлэхэд талуудын оролцоо, санаачилгыг дэмжих зорилгоор аймгийн Галсэнтэй ХХК-тай хамтарч ус цэвэршүүлэх технологийг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа. MNS 4943:2015 стандартын шаардлага хангасан, итгэмжлэгдсэн лабораторит баталгаажуулсан саарал усыг барилга, автомашин угаалга, мод усалгаа, ноос угаах салбарт нэвтрүүлэхийг дэмжин саарал усыг хэрэглээндээ ашиглаж буй 6-н аж ахуйн нэгжид урамшуулал олгосон.</p>	100
113	6.2.5.Хөв цөөрөм байгуулах, булаг шандын эх ундаргыг хамгаалж, тохижуулна.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	284.0	Хөв цөөрөм 1ш, булаг шанд 3	Жилд Хөв цөөрөм 1ш, булагшанд 3 хамгаалах	284.0	Орон нутгийн төсөв 284.2 Гадаадын рөнгө оруулалт 60.0 Хувийн	<p>Жил бүр хамгаалж тохижуулах шаардлагатай булаг шандын байршил, төлөв байдлыг тодорхойлох ажлыг Баян-Өндөр, Жаргалант ЗДТГ-тай хамтран зохион байгуулснаар 2021 онд 4 булаг шанд, 2022 онд 3 булаг, 2023 онд 5, 2024 онд 2 булгийн эх ундаргыг бүрэн хашиж, сэргээн засварлах ажлыг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтран гүйцэтгүүлж, тухайн газар оршин суугчдын хэрэгцээнд хүлээлгэн өглөө.</p> <p>Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хөв цөөрмийн хамгаалалтын хашааны зардалд 60.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласнаар</p>	85

									хэвшил 15.0 БОХАХЗ 69.3	740м урт хамгаалалтын хашааг бариулж ашиглалтад авлаа. Бүрэнбүстийн овооны хөв цөөрмийн ажлын гүйцэтгэгчээр 2023 онд Ээлт-Өлгий ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч 2024 оны байдлаар гүйцэтгэл 45 хувьтай байна. / Шүүхийн шатанд/	
Зорилт 6.3. Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөц, чанарын хяналт, мэдээллийн шуурхай байдлыг ханган, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлэн, хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах, усыг зөв хэрэглэх, хэмнэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ:											
114	6.3.1.Ундны усны хэрэглээний хэмнэлтийг бий болгох, бохир усыг цэвэршүүлэх, дахин ашиглах, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар ус ашиглалтын үр ашгийг дээшлүүлнэ.	2020-2025	ХЗА	Орон нутгийн төсөв	3.0	38%	Ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлнэ.	3.0	Орон нутгийн төсөв 3.0	Жил бүр дэлхийн усны өдрийг тохиолдуулан усны үнэ цэн, усны өдөр тутмын зөв зохистой хэрэглээ, усыг хайрлан хамгаалах, ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгаа, сургалт, тэмцээн гэх мэт олон талт арга хэмжээг зохион байгуулж ирсэн. 2020-2023 онд хотын ус хангамж, түгээлт, нийлүүлэлтийн талаар сурагчдын дунд аялал зохион байгуулж, Бүрэнбүстийн унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрт ажилласан. Ерөнхий боловсролын сурагчдын дунд усны чиглэлээр АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд амжилттай оролцсон сурагчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. Хүүхэд, залуучуудын театртай хамтран "Ус" драмын жүжгийг сурагчдад үзүүлж, усны үнэ цэнэ, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэлээ. "Гүүд нэйборс" олон улсын ТББ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу "Ундны ус эрүүл ахуй" хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж аймгийн БОГ, ЭМГ, Баян-Өндөр сумын сумын ЗДТГ, Яргуйт, Их залуу, Эрдэнэ, Дэнж багийн ажлын албаны албан хаагчид хамрагдлаа. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэглээндээ саарал буюу техникийн усыг нэвтрүүлэхэд талуудын оролцоо, санаачилгыг дэмжих зорилгоор аймгийн Галсэнтэй ХХК-тай хамтарч ус цэвэршүүлэх технологийг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа. MNS 4943:2015 стандартын шаардлага хангасан, итгэмжлэгдсэн лабораторит баталгаажуулсан саарал усыг барилга, автомашин угаалга, мод усалгаа, ноос угаах салбарт нэвтрүүлэхийг дэмжин саарал усыг хэрэглээндээ ашиглаж буй 6-н аж ахуйн нэгжид урамшуулал олгосон.	90
115	6.3.2.Хүн амын унд ахуйд хэрэглэж байгаа усны чанар, бохирдлын түвшин, хүн амын эрүүл мэнд, өвчлөл хоорондын хамаарлыг тогтоох тандалт судалгаа хийх, мэдээллийн санг бий болгоно.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	31.7	Шинжилгээнд хамруулсан худгийн тоо 11	Шинжилгээнд хамрагдах худгийн тоо 60	12.0	Орон нутгийн төсөв 414.8	Баян-Өндөр сумын гэр хорооллын багуудын хөрс, гүний усны бохирдолтын хэмжээг тогтоох судалгаагаар 30 цэгээс дээж авснаас 1 уст цэг нитратын бохирдолттой байна. Баян-Овоот багийн нутагт орших №03 Овоотын 5-2 тоотын худгийн усны нитратын ион стандартаас 1.12 дахин их (55.8 мг/л) байна. Нитратын бохирдолттой, бичил элементүүд стандартаас давж илэрсэн худгуудад мембран болон түүнтэй адилтгах шүүх материал бүхий технологиор усны чанарыг сайжруулж илүүдэл элементийг бууруулж хэрэглэх нь зүйтэй. Кальци, магниийн ион стандартаас давсан худгуудад катионитон шүүх материал бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж болох бөгөөд өмнө нь төхөөрөмж тавьсан худгуудад зөвхөн шүүх материалыг нь солих замаар усны чанарыг сайжруулж, зөөлрүүлж хэрэглэхийг зөвлөсөн. Мөн 2024 онд Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын ундны усны худгуудыг шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллага болох Сантгидро консалтинг ХХК-тай хамтран дээж авах ажлыг зохион байгуулж дууслаа. Баян-Өндөр сумын Яргуйт багт байрлах 9, Говил 4, Баянцагаан 4,	90

										Эрдэнэ 3, Баян-Овоот 3, Чингэл 2, Рашаант 1, Их залуу 1, Дэнж 1, Бүрэнбүстийн ус хангамжийн эх үүсвэрээс 1, нийт 29 худгийн уснаас шинжилгээнүүдийг авч, ерөнхий хими шинжилгээг Газар зүй-Геоэкологийн хүрээлэнд, хүнд металлын шинжилгээг СЖС лаборатори, бактериологийн шинжилгээг Орхон аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн харьяа итгэмжлэгдсэн лабораторит тус тус шинжлүүлээ. Худгуудын уснаас авсан дээжүүдийн дийлэнх нь аль нэг юм уу хэд хэдэн үзүүлэлтээрээ ундны стандартын шаардлагыг хангахгүй дүгнэлт гарсан	
116	6.3.3. Хотын ус хангамжийн шугам сүлжээний гидравлик тооцоог мэргэжлийн байгууллагаар хийлгэж, усны шугам хоолой, барилга байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд шаардлагатай байгаа орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ.	2020-2025	ХЗА	Улсын төсөв	6.6	-	40%	6.6	Улсын төсөв 6600.0 Гадаад хөрөнгө оруулалт 5000.0 Орон нутгийн төсөв 4200.0	2021 онд орон нутгийн төсвөөс 95.0 сая төгрөг зарцуулан ШУТИС-ийн судалгааны багаар хотын хэмжээний дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийлгэснээр эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагагүй болж хотын дулааны шугамын насжилт, өргөтгөл шинэчлэлт хийх шаардлагатай шугам сүлжээнүүдийн тооцоо судалгааг гаргасан. Уг судалгааны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хотын нийтийн орон сууцууд болон ААНБ-ыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барихаар Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн Ус дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх шугам сүлжээний угсралтын ажлыг 2022 оноос эхлүүлж гүйцэтгэсэн. Мөн Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн ус, дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлыг 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр гүйцэтгэсэн. Хотын хэмжээний инженерийн шугам сүлжээнд цаашид авах шаардлагатай ажлын төлөвлөгөөг хангагч байгууллага "Эрдэнэт дулааны цахилгаан станц" ТӨХК, "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК тухай бүр гарган улсын төсөв, орон нутгийн төсөв, болзошгүй аваарын зардал болон өөрсдийн байгууллагын нөөц бололцоогоор шийдвэрлэн ажиллаж байна. 2025 онд ЕСББанкны 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэвэр усны нийт – 5.32 км шугамыг НТРЕ Марк-STR-17 турбаагаар солих ажил хийгдэж байна. Энэ турба 60 жил ашиглагдах боломжтой. Мөн орон нутгийн 4.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5ш- УДДТөвийн доторх хуучин тоноглолын шинэчлэн ашиглалтад оруулаад байна. Хотын доторх ус хангамжийн шугам сүлжээний гидравлик тооцоог мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр санал хүргүүлсэн боловч хөрөнгө батлагдаагүй байна.	100
Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил											
Зорилт 6.4. Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, түүнийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ:											
117	6.4.1. "Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл" хэрэгжүүлж хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	2355.0	-		2355.0	Орон нутгийн төсөв 4550.0	Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийг Улаанбаатар хотноо 2017 онд байгуулсан. Бүгд Найрамдах Польш улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэхээр Польш улсын "ПЭйч Мелиорекс" ХХК шалгарч, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын гэрээг Орхон аймагтай 2019 онд байгуулсан. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох хог хаягдлыг татан зайлуулах 12 ширхэг машин механизмыг бүрэн хүлээн авч 2023 оны 02 дугаар сард Хот тохижуулах газар хүлээлгэн өгсөн. Одоогийн байдлаар Үндсэн барилга угсралтын ажил 90%, дотор заслын ажил 90%, гадна тохижилт, зам талбайн ажил 80%, халаалтын ажил 90%, агаар	85

	ажиллагааны менежментийг сайжруулна.								сэлгэлтийн ажил 60%, цэвэр бохир усны ажил 90%, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлгийн ажил 90%, холбоо дохиоллын ажил 90%, гадна цахилгаан хангамжийн ажил 90%, гадна гэрэлтүүлгийн ажил эхлээгүй, нийт гүйцэтгэл 80-90 хувьтай байна. Барилга угсралтын ажил дууссан. Төмөр хийцлэлд зэврэлтээс хамгаалах түрхлэг болон галаас хамгаалах түрхлэг хийгдээгүй. хөндлөнгийн итгэмжлэгдсэн шинжээчээр дүгнэлт гаргуулах шаардлагатай. 2022-2024 онд орон нутгийн төсвөөр ХТГ-ын парк шинэчлэлтийг 90% хийж, нэмэлтээр тусгай тоноглол бүхий 49 машин техник, 110 хөдөлгөөнт чингэлгээр хангаж, гэр хорооллын хог ачилтыг 2-3 удаагийн давтамжаар нэмэгдүүлсэн. Эзэнгүй хог хаягдлын цэвэрлэгээний ажлыг жил бүр зохион байгуулж, хог хуримтлагдах цэгийн тоог 20%-иар бууруулсан. 2025 онд 32 цэгт хуримтлагдсан 650 м3 хог цэвэрлэсэн. Аюултай хог хаягдал үүсгэгч 21 ААНБ-ыг хог хаягдлын мэдээллийн сан https://www.eic.mn/waste/ -д бүртгэж, үүссэн аюултай хог хаягдлын хадгалалт, устгалын байдалд хяналт тавьж байна. 2025 онд Ерөнхий боловсролын 10 сургуульд хадгалагдаж байсан 264,7кг химийн бодисыг Элемент ХХК-д шилжүүлэн устгууллаа. Жаргалант сумын хог хаягдлын нэгдсэн цэгт Ковш-50 маркийн дугуйт ачигч худалдан авч үйл ажиллагааг сайжрууллаа.		
118	6.4.2.Ногоон хотын жишигт нийцүүлэн төлөвлөж, ногоон зээл, зам харилцаа, инженерийн дэд бүтцийг сайжруулах, барих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	Орон нутгийн төсөв	150.0	-	Ногоон амины орон сууц, инженерийн дэд бүтцийг сайжруулна.	150.0	Орон нутгийн төсөв 4300.0	НҮБХС, ШУТИС-тай хамтран газрын гүний дулааныг ашиглах технологийг нэвтрүүлээд байна. Тус ажлын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн 3500 м3 талбай бүхий 28-р цэцэрлэг, 3397 м3 талбай бүхий төрийн байгууллагуудын байранд халаалтын зориулалт бүхий 50 кВт-ын дулааны коллектор, цахилгаан эрчим хүчээр хангах 20 кВт-ын нарны зайн системээр дэмжигдсэн газрын гүний дулаанаар шийдвэрлэх 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг Смарт Энержи ХХК гүйцэтгэсэн. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллан туршил тохируулгын ажил явагдаж байна. Туршилт тохируулгын үеэр уурын зуухны галлагаа хийгдээгүй ба Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн халааж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэж байна.Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Эрдэнэ багт 2.5 га талбайд Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр Хабридхаус ХХК шалгарч, гэрээ байгуулснаар ажлын явц 30 хувьтай явагдаж байна. Мөн Оюут багт Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах зорилгоор 2022 онд 49 өрхөд, 2023 онд 60 өрхөд, 2024 онд 73 өрхөд, 2025 онд 63 өрхөл тус тус монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгож яндангийн тоог 1245 ширхгээр бууруулсан. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 2024 онд Хабрид хаус ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа.	90
119	6.4.3.Сэргээгдэх	2020-	ХБТХОХ,	Орон	656.9	14484	Гэр хороолл	656.9	Орон	НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн	70

	эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг хөнгөлөлттэй санхүүжилтээр дэмжинэ.	2025	БОАЖГ	нутгийн төсөв Дэлхийн банкны санхүүжилт	12000.0	өрх	ын цахилгааны хүчдэл сайжруулна.		нутгийн төсөв 750.0 НҮБХС-700.0	3500 м3 талбай бүхий 28-р цэцэрлэг, 3397 м3 талбай бүхий төрийн байгууллагуудын байранд халаалтын зориулалт бүхий 50 кВт-ын дулааны коллектор, цахилгаан эрчим хүчээр хангах 20 кВт-ын нарны зайн системээр дэмжигдсэн газрын гүний дулаанаар шийдвэрлэх 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг Смарт Энержи ХХК гүйцэтгэсэн. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллан туршилт тохируулгын ажил явагдаж байна. Туршилт тохируулгын үеэр уурын зуухны галлагаа хийгдээгүй ба Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн халааж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Эрдэнэ багт 2.5 га талбайд Эрчим хүчний хэмнэлтэй амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр Хабридхаус ХХК шалгарч, гэрээ байгуулснаар ажлын явц 30 хувьтай явагдаж байна. Мөн Оюут багт Сархиа уулын өнгөрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах зорилгоор 2022 онд 49 өрхөд, 2023 онд 60 өрхөд, 2024 онд 73 өрхөд, 2025 онд 63 өрхөл тус тус монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгож яндангийн тоог 1245 ширхгээр бууруулсан. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 2024 онд Хабрид хаус ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа. Гэр хорооллын Цагаанчулуут багт 1 өрх нарны эрчим хүч хураах 4 панель ашиглаж, өрхийнхөө цахилгааны хэрэглээ болон нам даралтын цахилгаан халаагуурыг халаан ашиглаж байна.
--	--	------	-------	--	---------	-----	----------------------------------	--	---------------------------------	---

ДОЛОО. АЮУЛГҮЙ, АМАР ТАЙВАН -ЭРДЭНЭТ ХОТ

Зорилго 7. Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

Зорилт 7.1. Гэмт хэрэг, уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотойгоор нийгмийн аюулгүй байдлыг хангана:

120	7.1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	2020-2025	ХЭЗХ, Цагдаагийн газар	Орон нутгийн төсөв	18.0	6	Энэ төрлийн гэмт хэргийн гарал буурсан байна.	18.0	Орон нутгийн төсөв 42.0	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 437 дугаар нээлттэй хорих ангитай хамтран хорих ангийн алба хаагч нарт "Мансуурсан этгээдэд илрэх шинж тэмдэг, биедээ авч явж болзошгүй, хэрэглүүрийг шалгах эсэх" талаар сургалт, мэдээлэл өгч, хорих ангийн хашаанд каннабисын ургамал ургаж болзошгүй байх тул хяналт шалгалтыг явуулж, хоригдогч нарын эд зүйл, биед үзлэг шалгалтыг явуулан ажилласан. Мансууруулах эм худалдах зөвшөөрөлтэй 5, сэтгэцэд нөлөөт эм худалдах зөвшөөрөлтэй 9 эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагын эмийн хяналт, хадгалалт, хамгаалалтад 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж зөвлөмж хүргүүлсэн. 2023 оны 07 дугаар сард үйл ажиллагаа явуулж буй 13 аж ахуй нэгжүүдэд Эрүүл мэндийн сайдын 2015 оны 68 дугаар тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахад ямар нэгэн зөрчил илрээгүй. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Тархцын хяналт-2023" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оноос хойш мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэрэг, мансуурсан гэх зөрчилд холбогдсон этгээдүүдийн судалгааг	90
-----	--	-----------	------------------------	--------------------	------	---	---	------	-------------------------	--	----

гаргаж, эмзэг цэгийг тогтоох чиглэлээр хяналт тавьж ажиллаж байна. "Туншил" арга хэмжээний хүрээнд эмчийн хуурамч жор үйлдэн сэтгэцэд нөлөөт эм, эмийн сангаас авч хэрэглэсэн 2 иргэнд холбогдох гомдол мэдээлэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, 1 иргэнээс анхан шатны "МЕТ" буюу Метамфетамин агууламж бүхий бодис хэрэглэсэн болох нь тогтоогдсон бөгөөд шинжилгээний дээжийг ШШХ-рүү явуулж, мөрдөн шалгах ажиллагааг тус тус явуулж байна.

Улсын хэмжээнд явагдсан "Анзаар" нэгдсэн арга хэмжээ болон аймгийн хэмжээнд "Мансуурал" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж 4101 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгч, цахим орчинд 83 мэдээлэл сэрэмжлүүлгийг байршуулж 47061 иргэнд сэрэмжлүүлэг хүргэж ажилласан.

2024 онд орон нутгийн төсвөөс 18.0 сая төгрөг, аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас 20.0 сая төгрөг, нийт 38.0 сая төгрөгийн санхүүжилтийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон "Устгал-2024" нэгдсэн арга хэмжээнд зарцуулсан.

Цагдаагийн газрын 84, иэрээт цагдаагийн хэлтсийн 103, Дотоод цэргийн 78 нийт 265 албан хаагчдад "Мансуурсан этгээдэд илрэх шинж тэмдэг, биедээ авч явж болзошгүй хэрэглүүр" сэдэвт 4 цагийн сургалтыг зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 200 ширхэг тараах хуудас тарааж ажилласан.

Урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулснаар тайлант хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн гаралт өмнөх оны түвшинд байна.

2025 оны 05 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүсийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулж энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг хэлэлцэж устгал арга хэмжээ явуулах газартай танилцсан. Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран Анзаар арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 18-ны өдрийн хооронд зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБС, цэцэрлэгийн багш, ажилтан хүүхдүүдийн ар гэр, төрийн алба хаагчид, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдад урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан.

2025 оны 06 дугаар сард аймгийн хэмжээнд олсны ургамал /канабис/ ургамлыг Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт устгах ажлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Тагнуулын газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газартай хамтран 60га талбайд устгах ажлыг зохион байгуулсан. 2025 оны 09 дүгээр сард "Тархцын хяналт-2025" арга хэмжээг зохион байгуулж, Дархан, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгаас Орхон аймагт орох гарах хөдөлгөөнд алба хаагчдыг 24 цагийн постод гаргаж хяналт тавьж ажилласан. 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс Гаалийн газартай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангуудад хяналт тавьж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар худалдаа борлуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хийж ажилласнаар тайлант хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль

										бусаар ашиглах гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
121	7.1.2.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулна.	2020-2025	ХЭЗХ, Цагдаагийн газар	Орон нутгийн төсөв	6.0	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 19	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 10	6.0	Орон нутгийн төсөв 21.0	<p>Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр бүр гудамж талбай, олон нийтийн газруудад хөдөлгөөнт болон явган эргүүлийн 8-10 чиглэлд 16-20 алба хаагчийг тогтмол ажиллуулж, хяналт тавин ажиллаж байна. Мөн Гэрээт цагдаагийн хэлтсээс долоо хоног бүрийн 3, 4, 5 дахь өдрүүдэд нэмэлтээр 10 алба хаагч эргүүл шалгалтад ажиллаж байна.</p> <p>Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж 45 төрлийн мэдэгдлийг давхардсан тоогоор 221 аж ахуй нэгж байгууллагад хүргүүлэн ажилласан. Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Шаг", "Ахуй хүрээний архидалт", "Хяналт" зэрэг 34 тусгай арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан. Архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэд осгож амь нас, эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт гудамж талбайд эргүүл шалгалтыг зохион байгуулж байна. Эргүүл шалгалтын хүрээнд архи согтууруулах ундаа худалдан үйлчилдэг 254 хүнсний дэлгүүр, 39 бар, ресторан, караоке, паб нийт 293 аж ахуйн нэгж байгууллагад 190 мэдэгдлийг хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан. Хууль тогтоомж зөрчин гар дээрээс согтууруулах ундаа худалдсан, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар хориглосон газар, хугацаанд үйл ажиллагаа явуулж архи согтууруулах ундаа худалдан борлуулсан 34 зөрчил илрүүлэн 21 иргэн, 13 хуулийн этгээдийг 71.0 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч, 20 литр архи, 70 литр пиво, 112.8 мянган төгрөгийн хууль бус орлогыг хураан авсан.</p> <p>Орон гэргүй, тэнэмэл, архи согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэж, гудамж талбайд зөрчил үйлддэг иргэдийн судалгааг гарган нийгэмшүүлэх байранд 30 иргэнийг байршуулсан. Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаагийн сургалт зохион байгуулж нийт 44 иргэнийг хамруулсан.</p> <p>Архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг, орон гэргүй 75 иргэний судалгааг гарган архи согтууруулах ундааны хор уршгийн талаар ухуулга, яриа хийж, архины албадан эмчилгээнд хамруулахад орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>Мөн "Уяралын бичээс", "Аминчхан яриа" ТББ-уудтай хамтран Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хяналтад байдаг 15 иргэнийг "Зан үйлд нөлөөлөх" 2 удаагийн сургалтад хамруулж, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сэтгэц, наркологийн төвтэй хамтран 10 иргэнийг албадан, "Ариунсаруулбат" НҮТББ-тай хамтран 20 иргэнийг тус тус сайн дурын эмчилгээнд хамрууллаа.</p> <p>Байнгын архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг 85 гэр бүлийн судалгааг гаргаж архины албадан эмчилгээнд хамруулах ажлыг төлөвлөн, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 5 удаагийн сургалт зохион байгуулж 175 иргэнийг хамруулсан. Орхон аймгийн Цагдаагийн газар пэйж хуудсанд хуурамч, гарал үүсэл нь тодорхойгүй архи согтууруулах ундаа хилээр орж ирж байгаа, цахим орчинд архи согтууруулах ундаа худалдах, худалдан авахгүй байх чиглэлээр 3 шторкийг байршуулж, 194 лайк, 63 коммент, 4200 шэйр хийн иргэд, олон нийтэд түгээн ажилласан.</p>	100

										<p>2025 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын багуудын нутаг дэвсгэрт архины хамааралтай, орон гэргүй тэнэмэл иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдохоос урьдчилан сэргийлэх согтуурах, мансуурах донтой 55 иргэний судалгааг шинэчлэн гаргаж 6.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэн эрүүл мэндийн нэгдсэн үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндээрээ тэнцсэн 34 иргэнийг албадан эмчилгээнд хамруулах зорилгоор шүүхийн шийдвэр гаргуулж, Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 437 дугаар ангид хүлээлгэн өгсөн. Мөн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас зарласан гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх тендэрт шалгарсан “Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй” НҮТББ 2025 оны 1 сарын 1-нээс 2 сарын 15 -ны хооронд, 2025 оны 11 дүгээр сарын 15-наас 12 дугаар сарын 31-ны хүртэл 2 удаа гэр оронгүй тэнэмэл, архи, согтууруулах ундааны хамааралтай иргэдийг хооллох, хоноглох үйлчилгээнд давхардсан тоогоор 60 иргэнийг хамруулж 58.5 сая төгрөг зарцуулсан. Дээрх үйлчилгээнд хамрагдсан 1 иргэнийг ар гэртэй нь холбож гэрт нь хүлээлгэн өгсөн, 1 иргэнийг Хөвсгөл аймаг дахь улсын асрамжийн төвд хүргэсэн, 2 хүн архины хамаарлаас бүрэн татгалзсан, 2 хүн барилгын түр ажил хийж байгаа үр дүн гарсан. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар хамтарч согтууруулах ундаагаар 02:00 цаг хүртэл үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 14 аж ахуй нэгж, байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, сургалт хэлэлцүүлэг хийн зөвлөмж тараасан. Цагдаагийн газраас аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, хүн амын төвлөрөл, газар нутгийн хэмжээ, онцлогт үндэслэн өдөр бүр 24 цагаар хөдөлгөөнт эргүүлийн 2 чиглэлд 4 алба хаагч, Шөнийн эргүүлийг Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв гаригуудад 20:00-00:00 цагийн хооронд, Баасан, Бямба, Ням гаригуудад 23:00-03:00 цагийн хооронд гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллуулж байна. Эргүүлийг 20 чиглэлд 40 алба хаагчтай 19:00-00:00 цагийн хооронд “Эргүүлийн салаа” байгуулах туршилт хийж зохион байгуулан ажилласан. Жаргалант суманд 1 чиглэлд 2 алба хаагч тус тус эргүүл шалгалтад үүрэг гүйцэтгэж ажилласан.</p> <p>Архинд донтох эмгэгтэй, архины архаг хэрэглээтэй иргэдийг албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, архи, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сэтгэц наркологиын төвтэй хамтран архины сайн дурын эмчилгээнд хамруулан ажиллаж байна. 2024 онд 10 иргэн 2025 онд 34 иргэнийг албадан эмчилгээнд хамруулсан.</p>	
122	7.1.3.Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн хүүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	2020-2025	ХЭЗХ, Цагдаагийн газар	Орон нутгийн төсөв	35.6	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 35	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 50	35.6	Орон нутгийн төсөв 120.6	<p>Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжих, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг ГБХЗХГ-тай хамтран ажиллуулж, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2021-2024 онд түр хамгаалах байранд нийт 249 хүнийг хүлээн авч түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр 10 төрлийн үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>2025 онд хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагаа, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын зардалд орон нутгийн төсөвт 40.0 сая төгрөгийг батлуулж, түр хамгаалах байрыг Баян-Өндөр сумын Чандмань баг “Хөүп таун” хотхонд 3</p>	100

									<p>өрөө байр түрээслэн аймгийн “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар” хариуцан ажиллуулж байна. Тайлангийн хугацаанд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байранд нийт 64 үйлчлүүлэгч хүлээн авсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Насанд хүрээгүй үйлчлүүлэгч 57 /эмэгтэй хүүхэд -40, эрэгтэй хүүхэд-17/ - Насанд хүрсэн үйлчлүүлэгч 7 хүн тус тус үйлчилгээ авсан байна. <p>Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчид дараах үйлчилгээг хүргэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль эрх зүйн зөвлөгөө 3 - Сэтгэл зүйн зөвлөгөө 22 /Хүүхэд 19, Насанд хүрсэн хүн 3/ - Эрүүл мэндийн үйлчилгээ 13 - Боловсролын үйлчилгээ 4 - Нийгмийн халамжийн үйлчилгээ 11 - Холбон зуучлах үйлчилгээ 25 - Бусад 15 байна. <p>Үйлчилгээ авсан хүүхдүүдэд сэтгэл зүй, сэтгэл заслын оношилгоо, эмчилгээ хийх чиглэлээр мэргэжлийн "Сэтгэл зүйн цогц боловсролын төв" НҮТББ-тай хамтран ажиллаж сэтгэл зүйн үйлчилгээнд 31 хүүхэд /давхардсан тоогоор 161 хүүхэд/ хамруулсан. Мөн боловсролын үйлчилгээнд 5 хүүхэд холбон зуучилж, эрүүл мэндийн үйлчилгээнд 6, нийгмийн халамжийн үйлчилгээнд 1 хүүхдийг тус тус хамруулсан.</p>		
123	7.1.4.Хохирогчдод хуульд заасан үйлчилгээг цогцоор үзүүлэх түр хамгаалах байр байгуулна.	2020-2025	ХЭЗХ	Улсын төсөв	1500.0	Барилгын ажлын гүйцэтгэл 70%	100%	1261.0	Улсын төсөв 1261.0	<p>2021-2025 онд түр хамгаалах байранд 313 хүнийг хүлээн авч түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр 10 төрлийн үйлчилгээг үзүүлж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн ажилласан. Шинээр стандартад нийцсэн хамгаалах байрны төсөл боловсруулан газрын асуудлыг шийдвэрлэж, зураг төсвийг боловсруулан улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлын гүйцэтгэл 85.0 хувьтайгаар барилгын ажил удаашралтай явагдаж байна. Гүйцэтгэгч компани гэрээт хугацааг ажлыг бүрэн дуусгаагүй тул шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхийн шатанд талууд эвлэрэн хэлэлцсэн. 2026 онд барилгыг бүрэн ашиглалтад оруулна.</p>	70
124	7.1.5.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.	2020-2025	ТЗУХ, ОБГ	Орон нутгийн төсөв	37.0	-		37.0	Орон нутгийн төсөв 70.0	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А865 дугаар захирамжаар батлагдсан хуваарийн дагуу Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний газар хөдлөлтийн гамшгийн үед удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хохирол багатай даван туулах, гамшгийн үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны онолын мэдлэгийг олгож, дадлагажуулах команд штабын сургуулийг 2023 оны 3 дугаар сард зохион байгууллаа. Онцгой байдлын газрын Урьдчилан сэргийлэх тасгийн бүрэлдэхүүн аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх танхимын болон дадлага сургуулийг 398 удаа зохион байгуулж, нийт 9498 хүнийг хамруулсан. Үүнээс гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалт 69, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдад 175, оюутан, сурагчдын сургалт 75, иргэний сургалт 55, цэргийн дүйцүүлэх албаны сургалт 2, сайн дурын бүлгэмийн сургалт 4, сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалт 2 удаа тус тус зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гарган гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг 26 багийг 16 хэсэг хувааж 6 удаагийн танхимын сургалтаар Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, Ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан</p>	100

										<p>сэргийлэх, Ахуйн ослоос урьдчилан сэргийлэх, Үер усны осол, Газар хөдлөлт, Анхны тусламж зэрэг сэдвүүдээр зохион байгуулж чадавхжуулсан. Орхон аймгийн Засаг даргын нэрэмжит "Аврагч-2024" тэмцээнд Төрийн болон хувийн хэвшил, мэргэжлийн анги албад, анхны тусламжийн 17 нөхөрлөлүүдийн 187 ажилтан, албан хаагчид хамрагдаж мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн. Аймгийн хэмжээнд гамшгийн зарлан мэдээлэх дуут дохиогоор 32700 хүн оролцож ажилласан.</p> <p>2025 онд нийт 321 удаагийн сургалтыг 14074 иргэнд буюу - удирдах албан тушаалтны сургалт-2 гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалт 85, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдад 134, иргэний сургалт-21 сургуулийн өмнөх насны хүүхдэд -12, их дээд сургууль, оюутан сурагчдад-22, ЕБС- ахлах анги -19, дунд анги-9, бага ангийн сурагчдад-4, цэргийн дүйцүүлэх албанд-2, сайн дурын иргэнд-10, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд-3 удаа зохион байгуулсан. Дээрх сургалтыг цахим бүртгэлд тухай бүрд бүртгэж ажилласан.</p> <p>Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн сайн дурын бүлгийн сургалтыг аймгийн Улаанзагалмайн хороотой хамтран гамшгаас хамгаалах мэдлэг олгох, гамшиг осолд өртсөн иргэдэд анхны тусламж үзүүлэх чиглэлээр 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сар хүртэл 10 удаа, 580 иргэнд зохион байгуулан ажилласан, 2 сумын хэмжээнд бэлэн байдлын үзлэгийг аймгийн Засаг даргын 2025 оны А/912 дугаар захирамжаар орон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөлт, хор уршгийг арилгах үйл ажиллагааг шалгаж, үнэлгээ, дүгнэлт өгөх, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж ажилласан.</p>	
125	7.1.6.Байгалийн давагдашгүй хүчин зүйл, болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг даван туулах чадавхыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2020-2025	ТЗУХ, ОБГ	Орон нутгийн төсөв	550.0	-	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг даван туулах чадавхыг сайжруулна.	550.0	Орон нутгийн төсөв 1100.0	<p>2021-2022 онд Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг даван туулах чадавхыг сайжруулах хөтөлбөр хэрэгжиж дууссан. 2023 онд орон нутагт зонхилон тохиолдож байгаа гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Үндэсний зөвлөл болон аймгийн Онцгой комисстой уялдан ажиллаж мэдээ, мэдээлэл солилцох, үндэсний зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан хэрэгжүүлж байна. Эрсдэлийг бууруулах хөрөнгө оруулалт, учирч болох хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, санал бодлоо солилцох зорилгоор Стратегийн команд штабын сургуульд 6 гишүүнийг хамруулсан.</p> <p>2024 онд нийт 88 удаагийн объектын гал түймрийн дуудлагаар, ослын болон эрэн хайх, аврах ажиллагааны 20 удаагийн дуудлага мэдээллээр гарч ажилласан, гамшиг, ослын улмаас 110 сая төгрөгийн хохирол учирч, 2 хүний амь нас эрсдэж, 3 хүн бэртэж гэмтсэн, 2.9 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд гамшгийн /Ган, Зуд, Үер, Шар усны үер, Ой хээрийн түймэр/ 5 төрлөөр эрсдэлийн ерөнхий үнэлгээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. эрсдэлийг</p>	100

										<p>бууруулах, давах туулах, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг авч ажилласан.</p> <p>Аймгийн Онцгой комисс 2024 онд аймаг орон нутгийн хэмжээнд гал түймэр, гамшиг осол, хүн малын өвчлөл, өвөлжилт хаваржилтын бэлтгэл бэлэн байдлуудыг хангуулах зэрэг урьдчилан сэргийлэх тэмцэх чиглэлээр нийт 650.0 сая төгрөг батлуулж, энэ хугацаанд 10 удаа хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гаргаж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Үүнээс хөрөнгө гаргах тухай 7 удаагийн Захирамжаар нийт 645.1 сая төгрөгийг холбогдох байгууллагуудад шийдвэрлүүлж ажиллалаа. Орхон аймгийн суурьшлын бүсэд нийт 72.8 км үерийн суваг байдгаас 25 орчим км нь бетонон хийцлэлтэй сувагтай. 2025 онд гэр хорооллын үерийн сувгийг 5 удаа цэвэрлэж, ахуйн хог хаягдалыг хогийн нэгдсэн цэгт буулгасан. Мөн “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн хүрээнд хийгдэх үерийн далан, суваг барих ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Хунан Индастриал Экүйдмент Инсталэйшн” ХХК шалгарч 9 байршлын 12.8 км инженерийн хийцлэлтэй үерийн далан, 14000м3 багтаамжтай үерийн усан сан барихаар гэрээ байгуулсан. Үерийн далангийн нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулан улсын магадлангаар хянуулж, энэ онд Уртын гол багийн А1002 авто зам дагуух 1810м сувгийг барих ажил эхлээд байна. Ажлыг 2025-2026 он дамжин хийгдэхээр гэрээ байгуулж, энэ онд хийгдэх ажил 100 хувь хэрэгжсэн, 2026 оны хавар ажлыг дахин эхлүүлэхээр ажиллаж байна. Мөн орон нутгийн төсвийн 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уртын гол багт -225м, Их залуу багт-350м, 2а хороололд-342м, Зүүн дэнжид-250м сувгийг барих ажил хийгдэж ашиглалтад оруулсан.</p> <p>Баян-Өндөр сумын Говил багийн Булагтын А, Б, В хэсгийн нутаг дэвсгэрт булгийн ус газрын хөрснөөс нэвчин халиа, тошин үүсч, айл өрх рүү орсон нөхцөл байдалд нийт 10 удаагийн татан авалтаар 79 хово автомашин буюу 936м3 хайргыг асган, 450м урттай далан босгон ажиллалаа. Мөн усанд өртөх өндөр магадлалтай 2 өрхийн 4 гэрийг нүүлгэн шилжүүлсэн. Эрдэнэт ТӨҮГ-аас 14 хово автомашин хайрга, 1 экваторыг ажиллуулж хариу арга хэмжээ авсан. Үерт өртөх магадлалтай өрхийн судалгааг гаргаж, сэрэмжлүүлэг өгч, нүүлгэх чиглэлээр ГХУХБ-ийн мэдэгдэл хүргүүлж ажилласан.</p>	
126	7.1.7.Эрсдэл учруулж болохуйц объект, барилга байгууламж, бусад эрсдэлийг мэдээлэх платформ ажиллуулна.	2020-2025	ТЗУХ, ОБГ	Орон нутгийн төсөв	50.0	-	Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувиар	50.0	Орон нутгийн төсөв 150.0	<p>2022 онд Засаг даргын А/323 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх зааврын дагуу аймгийн ерөнхий үнэлгээг хийж тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр нарийвчилсан үнэлгээ хийлгэж, “Дэлхийн зөн-Монгол” ОУБ-аас хэрэгжүүлсэн “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан.</p> <p>Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг 2023 оны 03-р сарын 09-ний өдөр хуралдуулж, 2023 онд авч хэрэгжүүлэх 13 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар хөдлөлтийн гамшигт тэсвэргүй гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан барилгуудын танилцуулга, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хуралдаж шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 2021-2022 онд ХЗА-аас эрсдэл мэдээлэх апплейкешн ажиллуулж, тухай бүрд гарсан эвдрэл, эрсдэлтэй асуудлыг шийдвэрлэн ажилласан.</p>	90

										<p>Орхон аймгийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн 2024 онд хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан, батлуулж хэрэгжилтийг 86 хувьтай хангасан.</p> <p>Орхон аймгийн Баян-Өндөр сумын 2-р сургуулийн хичээлийн 1-р байр, 7-р сургуулийн байр, 16-р цэцэрлэгийн байр, 17-р цэцэрлэгийн байр, 18-р цэцэрлэгийн байрны барилгын ашиглалтын төлөв байдалд дүгнэлт гаргуулах, паспортжуулах зөвлөх үйлчилгээний гэрээг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн барилгын материалын судалгааны төвтэй байгуулсан. Тус ажлын хүрээнд 2 сургууль, 3 цэцэрлэгийн барилга байгууламжид ашиглалтын төлөв байдлыг тогтоох паспортжуулах ажлыг хийлгэж, хүлээн авсан. Дүгнэлтээр 2-р сургуулийн хичээлийн 1-р байр, 18-р цэцэрлэгийн барилгыг ашиглах боломжгүй, 16, 17-р цэцэрлэгийн барилгын суурийн үндсэн хийц элементэд суулт өгч байгаа тул хүчитгэх арга хэмжээ авах шаардлагатай гэж гарсан. Дээрх сургууль, цэцэрлэгийн барилгуудын ашиглалтын төлөв байдалд гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн дараагийн хийх ажлуудыг төлөвлөн жил бүр үе шаттайгаар төсөв хөрөнгийг шийдвэрлүүлж ажиллахаар төлөвлөсөн. Гамшгийн орон зайн мэдээллийн системд гамшиг ослын тоо, хохирол, хамрах хүрээ, ажилласан хүн, техникийн мэдээллийг оруулж мэдээлж байна.</p>	
Хууль сахиулах, батлан хамгаалах											
Зорилт 7.2. Хууль сахиулах, батлан хамгаалах салбарын материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ:											
127	7.2.1.Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлж, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2025	ХЭЗХ, МШУТ	Орон нутгийн төсөв	695.4	Бүртгэлтэй камерын тоо 345	700	695.4	Орон нутгийн төсөв 7394.8	<p>Аймгийн хэмжээнд бүх багийг бүрэн камержуулах, тоног төхөөрөмжөөр хангах засвар үйлчилгээг найдвартай хангах үүднээс жил бүр орон нутгийн төсөвт техник тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийг тусган камержуулах ажлыг хийж ирсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 90 сая төгрөгийн үнэ бүхий камерын засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай тусгай зориулалтын автовишкатай автомашиныг худалдан авч Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэж авсан. Автовишкатай болсноор давхардсан тоогоор нийт 100 орчим камерын шон дээр 250 гаруй камерыг, дагалдах хэрэгслийн хамт бүрэн шинэчилж засварласан. Одоогийн байдлаар 1475 ширхэг камер холбогдсон байна.</p> <ul style="list-style-type: none"> • 2020 онд 104 ш камер • 2022 онд 412 ш камер • 2023 онд 150ш камер • 2024 онд 627ш камер • 2025 онд 182 ш камер суурилуулж бүртгэн хүлээн авсан. <p>Нийт 1475 ширхэг камерыг төрлөөр ангилж үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> • 1 чиглэлийн 1186 ширхэг камер • 360 градусын эргэлттэй 196 ширхэг камер • Автомашины дугаар илрүүлэгчтэй 41 ширхэг камер • Царай таних 50 ширхэг камер • Байгаль орчны дулаан мэдрэгчтэй 2 ширхэг камер тус тус бүртгэлтэй байна. <p>Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн камерын сүлжээний нийт багтаамж нь 1Гб/с учраас хяналтын камер нэмэгдэхийн хэрээр сүлжээний ачаалал нэмэгдэж гацаж байсан. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор төвийн хяналтын камерын системийн үндсэн сүлжээний дамжуулалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 2024 онд орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөгийг зарцуулж, тус ажлын</p>	100

										гүйцэтгэгчээр шалгарсан "МонТех дистрибушн" ХХК тоног төхөөрөмжийг нийлүүлэн суурилуулалтыг хийснээр сүлжээний үндсэн урсгалын багтаамж 10ГБ/с болоод байна. 2025 онд Хяналтын камерын тусламжтайгаар 407 иргэний хүсэлтийг хүлээн авч иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан 153 сая төгрөгийн хохирлоос 68 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон, хохирлыг барагдуулсан. Мөн энэ хугацаанд сураггүй алга болсон 14 иргэнийг олж тогтоон ар гэрт нь хүлээлгэн өгсөн байна.		
128	7.2.2.Мал хулгайлах хэрэгтэй урьдчилан сэргийлэх эрчимжүүлнэ.	гэмт тэмцэх, ажлыг	2020-2025	ХЭЗХ, Цагдаагийн газар	-	-	Бүртгэгдсэн эн гэмт хэргийн тоо 1	0	-	Орон нутгийн төсөв 20.0	Аймгийн хэмжээнд мал, мах худалдан борлуулдаг "Таван-Эрдэнэ" бөөний цэг, Хүлэг хүнсний зах, "Энх" худалдааны төв, гадаад орнуудад мах экспортолдог "Мон-Гема" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК, "Эрдмийт" ХХК, "Орхон-Энхбүтэмж" зэрэг 1 хиамны цех, мал мах, малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг 200 гаруй ченж, нийтийн хоолны үйлчилгээ явуулдаг 34 аж ахуйн нэгж бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Үйлдэгдсэн малын хулгайн шалтгаан нөхцөлийг судлахад Орхон аймгийн нутаг дэвсгэрт хүн ам шигүү суурьшсан дэд бүтэц сайн хөгжсөн, зах зээлийн худалдан авалт, мал махны борлуулалт бусад аймгийг бодвол харьцангуй их зэрэг шалтгаанаас малын хулгайн гэмт хэрэг үйлддэг этгээдүүд тус аймагт хулгайлсан мал, мах, түүхий эдээ борлуулах, малын хулгайн сүлжээ зохион байгуулах сонирхол ихтэй байдаг нь малын хулгайн гэмт хэрэг үйлдэгдэх нэг шалтгаан нөхцөл болж байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хил залгаа аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа мал, махны зах, болон түүхийн эдийн ченж, мал нядалгааны газрууд, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжиг бүхий этгээдүүдийг нарийвчилсан судалгаанд хамруулах, Орхон аймаг руу чиглэдэг хулгайн зам маршрутыг зурагжуулсан судалгаанд авах, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд цаг алдалгүй харилцан мэдээлэл солилцож, гэмт хэргийг шуурхай илрүүлэх зорилгоор "Ченж", "Мал", "Судалгаа", "Хулгай" зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, нийт 146 ченжийн зураг, анкетыг авч, Шүүх шинжилгээний албаны папилон санд 100 ченжийн гарын мөрийг оруулж, холбогдох судалгааг хийж ажилласан. 2023, 2024, 2025 онд улсын хэмжээнд зохион байгуулагдах "Мал мах" нэгдсэн арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан. Жаргалант сумын байнгын хөдөлгөөнт постод үүрэг гүйцэтгэх алба хаагчид нь Дархан-Уул, Сэлэнгэ аймгаас Орхон аймгийн Жаргалант сумын хойд хэсгээр орж ирэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, МЭЕГ-ийн нэгдсэн сан багажаар мал эмнэлгийн гарал үүслийн баримт бичигт үзлэг шалгалт хийн, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж цагдаагийн байгууллагын "А8АР" санд эрэн сурвалжлагдаж байгаа гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, оргодлын талаарх мэдээллүүдтэй тогтмол танилцаж, шалгасан хүмүүсийн мэдээллийг нэгдсэн сангаар шүүж ажилласан. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй 12 этгээдийн мэдээллийг Patrol2.police.gov судалгаа, хяналтын санд оруулсан. Удирдамжийн дагуу 21 хоногийн хугацаатай 2 чиглэлд 2 тээврийн хэрэгсэлтэй 4 алба хаагч, мал эмнэлгийн газрын 2 алба хаагч нийт 6 алба хаагч 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж 2 зөрчил илрүүлж Зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу 300000 төгрөгийн шийтгэл оногдуулж ажилласан. Аймгийн хэмжээнд мал, мах худалдан борлуулдаг "Таван-Эрдэнэ" бөөний цэг, Хүлэг хүнсний зах, "Энх" худалдааны төв, гадаад орнуудад мах экспортолдог "Мон-Гема" ХХК, "Эрдэнэт мах	100

										маркет” ХХК, “Эрд мийт” ХХК, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Идэрбаялаг” “Хатан-Оюу”, “Орхон-Энхбүтэмж” зэрэг 3 хиаман цех, мал мах, малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг 200 гаруй ченж, нийтийн хоолны үйлчилгээ явуулдаг 34 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан. Хяналтаар стандартад нийцэхгүй камер суурилуулсан, хадгалах хугацаа хэт богино, үзэгдэх орчныг бүрэн хянах боломжгүй зэрэг зөрчил илэрсэн 16 аж ахуйн нэгж, байгууллагаас 4 зөрчлийг газар дээр нь арилгуулж, хугацаатай 12 мэдэгдэл өгч үр дүнг тооцож ажилласан. Мал хулгайлах гэмт хэрэг 2023, 2024, 2025 онуудад бүртгэгдээгүй байна.	
129	7.2.3.Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчдод хууль зүйн туслалцаа үзүүлнэ.	2020-2025	ХЭЗХ, Хууль зүйн туслалцааны төв	Орон нутгийн төсөв	5.0	Өмгөөллийн туслалцаа а 40 иргэнд үзүүлсэн	Жил бүр 43 иргэнд үзүүлсэн байна.	5.0	Орон нутгийн төсөв 5.0	2022 онд төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох 38 хэргийг хүлээн авч 24 хэргийг шүүхээр болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлж, хууль зүйн туслалцаа үзүүлэн, 189 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. 2023 онд Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг тогтворжуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг батлуулан төвийн үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлж, иргэдэд үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох 43 хэргийг хүлээн авч 33 хэргийг шүүхээр болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлж, хууль зүйн туслалцаа үзүүлэн, 103 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна. 2024 онд Зэст багийн төрийн үйлчилгээний нэгдсэн төв ашиглалтад орсноор Хууль, зүйн туслалцааны төвийг уг барилгын нэг давхарт иргэдтэй уулзах тусдаа өрөө болон албан өрөө нийт 39.13 м.кв талбай бүхий ажлын байраар хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсад Парламентийн ардчиллыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд нийт 27.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ухаалаг дэлгэц, зөөврийн компьютер, өнгөт принтер, албан болон хурлын ширээ, сандал гэх мэт тавилга, эд хогшил, техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Тус төв 2024 онд 43 хүнд холбогдох 42 эрүүгийн хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлснээс 34 хүнд холбогдох 33 хэргийг эцэслэн шийдвэрлүүлсэн. Мөн туслалцааны төвд хандаж ирсэн 250 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. 2025 онд нийт 42 хүнд холбогдох эрүүгийн хэргийн 6 насанд хүрээгүй хохирогч, 36 сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байгаагаас шүүхийн өмнөх шатанд 5, шүүхээр 22 хэргийг эцэслэн шийдүүлж дууссан. Ажиллагаанд 13 хэрэг байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд 2 хүн өмгөөлөгчөөс татгалзсан. Мөн туслалцааны төвд хандаж ирсэн 215 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичиг 27 хүнд боловсруулж өгсөн.	100
130	7.2.4.Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах замаар иргэдэд	2020-2025	ХЭЗХ	Орон нутгийн төсөв	829.3	-	Ажиллах нөхцөлөөр хангагдсан байна	829.3	Орон нутгийн төсөв 5249.5	2021-2023 онд хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж нийт 2969.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмжийг олгосон. 2024 онд хуулийн байгууллагуудын хүний нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн төсвөөс нийт 541.8 сая төгрөгийн санхүүжилтээр Цагдаагийн газарт 40 олон нийтийн цагдаа, Улсын бүртгэлийн хэлтэст 4, Архивын тасагт 2 гэрээт ажилтан тус тус ажиллуулж байна. Мөн Техник, тоног	100

	чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.									<p>төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр Мэдээлэл шуурхай удирдлагын төвд 50.0 сая, Тагнуулын газарт ухаалаг самбар, тоног төхөөрөмж худалдан авахад 200.0 сая, Шүүхийн Тамгын газарт компьютер, тоног төхөөрөмж худалдан авахад 100.0 сая, Цагдаагийн газарт хөдөлгөөнт эргүүлийн авто машин худалдан авахад 440.0 сая, ШШГГ-т камер, тоног төхөөрөмж авахад 112.0 сая, Архивын тасагт сан хөмрөгийн өрөөнүүдэд засвар хийхэд 94.1 сая, техник тоног төхөөрөмжөөр хангахад 10.0 сая, байнга хадгалах баримтыг сэргээн засварлахад 5.0 сая төгрөгийг тусган нийт 1552.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн. Ингэснээр хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж сайжирч иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчлэх нөхцөл бүрдсэн. "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс 2 гэрээт ажилтан ажиллуулж архивын баримтыг цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>2025 онд орон нутгийн төсвөөс Цагдаагийн газрын дээвэр, гадна фасадны засвар, гэрэлтүүлгийн ажилд 109.5 сая төгрөг, энгэрийн камер, сүлжээний тоног төхөөрөмж худалдан авахад 350.0 сая төгрөг, олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, НДШ-ийн зардалд 390.0 сая төгрөг, Хөдөлгөөнт эргүүлийн машины шатахууны зардалд 20.0 сая төгрөг, Шүүх шинжилгээний хэлтсийн өрөөнүүдэд хэсэгчлэн засвар хийх ажилд 143.5 сая төгрөг, ШШХ-т хөлийн мөр илрүүлж, бэхжүүлэх иж бүрдэл, парафин цутгах аппарат худалдан авахад 52.5 сая төгрөг, Хорих ангийн дээврийн засвар хийхэд шаардлагатай материал худалдан авахад 111.8 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст иргэний бүртгэлийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн архивыг цахимжуулах гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардалд 54.0 сая төгрөг, Төрийн архивд шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллах нөхцөлийг сайжруулахад 30.4 сая төгрөг, цахимжуулалт хариуцсан гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардалд 57.0 сая төгрөг нийт 1,318.7 сая төгрөг тусган батлуулж, зарцуулан ажилласан.</p>	
131	7.2.5.Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөлгөөнт эргүүлийг хоёр дахин нэмэгдүүлнэ.	2020-2025	ХЭЗХ, Цагдаагийн газар	Орон нутгийн төсөв	659.0	Олон нийтийн цагдаагийн орон тоо 20	40	659.0	Орон нутгийн төсөв 1327.0	<p>Цагдаагийн газраас нийтийн хэв журмыг хамгаалах ажлын хүрээнд 21:00-01:00 цагийн хооронд өдөр бүр гудамж талбай, олон нийтийн газруудад хөдөлгөөнт болон явган эргүүлийн 12-15 чиглэлд 25-30 албан хаагчийг гудамж талбайд үйлдэгдэх, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илрүүлэх чиглэлээр тус тус эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж, тасгийн дарга, ахлах байцаагч нараас хяналт тавин ажиллаж байна. 2023 онд олон нийтийн цагдаагийн ажилтны тоог нэмэгдүүлж 40 орон тоогоор батлуулан, цалингийн хэмжээг нэмэгдүүлэн, цалин нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 459.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган ажилласан.</p> <p>2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөдөлгөөнт эргүүлийн 5 ширхэг авто машин худалдан авах зардалд 440.0 сая төгрөг баталж, Хьюндай Венуе маркийн 5 авто машиныг хүлээлгэн өгч албан хэрэгцээнд ашиглаж байна.</p> <p>Хөдөлгөөнт эргүүлийн авто машины шатахууны зардалд 30.0 сая төгрөгийг 2024 оны орон нутгийн төсөвт тусган батлуулж, сар бүр хуваарийн дагуу санхүүжилтийг олгон шатах, тослох материал худалдан авахад зарцуулан ажилласан.</p> <p>2025 онд олон нийтийн цагдаагийн ажилтны цалин, НДШ төлөхөд шаардагдах 359.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, Баян-Өндөр суманд 33, Жаргалант суманд 2, нийт 35</p>	100

										олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэн, багуудын хэсгийн байцаагчийн хамт болон замын цагдаагийн тасаг, урьдчилан сэргийлэх тасагт тус тус ажилласан. Мөн хөдөлгөөнт эргүүлийн авто машины шатахууны зардалд 20.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, сар бүр хуваарийн дагуу санхүүжилтийг олгон шатах, тослох материал худалдан авахад зарцуулан ажилласан. Хөдөлгөөнт эргүүлийн автомашины тоог нэмэгдүүлэн, шатахууны зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж ажилласнаар гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэлд 10 минутад очдог байсан бол 3-5 минутад очиж гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоож, илрүүлэлт нэмэгдэн ажиллаж байна.	
132	7.2.6.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, батлан хамгаалах чадавхыг дээшлүүлнэ.	2020-2025	ЦШ	Орон нутгийн төсөв	8.1	-	Орон нутгийн батлан хамагалах чадавхийг нэмэгдүүлнэ	8.1	Орон нутгийн төсөв 36.8	Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалахын Сайдын 2020 оны А/133 дугаар тушаалын дагуу жил бүр аймгийн Засаг даргын захирамж, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөг удирдлага болгон орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний сургалтыг 1 удаа, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг 3 удаа тус тус Зэвсэгт хүчний 110, 186 дугаар анги дээр гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд томилгоот нэгж нь онц болон дайны байдлын үеийн орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлтгэлийг хангах, иргэн, хуулийн этгээд, албан тушаалтныг гүйцэтгэх үүрэгт нь сурган дадлагажуулах, жигдрэлтийг хангах чиглэлээр томилгоот нэгжийн удирдлага, бие бүрэлдэхүүнтэй тайван цагт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж томилгоот бүрэлдэхүүний бэлтгэл нөөц 35 хувьтай болсон. Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын томилгоот бүрэлдэхүүнийг тодотгох ажлыг үүрэн телефон утас болон биет холбоочноор дамжуулан холбоо зохион байгуулалтыг 100 хувь зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/341 дүгээр захирамжийг тус тус үндэслэн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн "Хэрийн дадлага" сургалтыг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд 2024 оны 05 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд Баян-Өндөр сумын Зэст, Оюут багийн томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй "Улсын онц чухал объектын хамгаалалтад дэмжлэг үзүүлэх үеийн орон нутгийн томилгоот нэгжүүдийн ажиллагаа" сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх тусгай байрыг тохижуулж, хувцас хэрэглэлийн нөөцийг бүрдүүлээд байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/1004 дүгээр захирамжийг тус тус үндэслэн орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг "Баян-Өндөр, Жаргалант сумдын багийн ажлын албатай харилцан ажиллагаа" сэдвийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 17-ноос 19-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалтын танхимд зохион байгуулсан.	100
133	7.2.7.Дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгон, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо,	2020-2025	ЦШ	-	-	Төлөвлөлийн боловсруулалт хийгдсэн	100% хэрэгжүүлнэ.	-	-	"Баян-Өндөр, Жаргалант сумдын дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, Цэргийн штаб, сум багийн удирдлагатай харилцан ажиллах дарааллыг тогтоож, зарлан мэдээлэх холбоо зохион байгуулалтын журмыг харилцан тодотголоо. Дайчилгааны даалгавартай Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудтай тогтоосон хугацаанд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие	100

	чанарыг нэмэгдүүлнэ.									бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөөнд тодотгол хийсэн. Цэргийн штабын сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалт бэлтгэлийг төлөвлөгөөний дагуу тасралтгүй зохион явуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 мн/494 дүгээр тогтоолоор "Аймаг нийслэлийн дайчилгааны даалгавар" батлагдсан. Батлан хамгаалахын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн мн/03 тоот зөвлөмж, зааврыг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/398 тоот захирамжаар Орхон аймгийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан Батлан хамгаалах яамны Бодлого стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлэн батлуулсан..	
--	----------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--

Мэдээллийн аюулгүй байдал

Зорилт 7.3. Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ:

134	7.3.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр журам боловсруулж хэрэгжүүлнэ.	2020-2025	ХЭЗХ	-	-	Журмын хэрэгжилт 75%	Журмын хэрэгжилт 80%	-	-	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, ЗГ-ын 2010 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах" үндэсний хөтөлбөрийн дагуу Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах байнгын ажиллагаатай ажлын хэсгийн ажиллах, мэдээлэл солилцох журмыг боловсруулан аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/265 дугаар захирамжаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журамд заасны дагуу цаг үеийн болон ажлын тайлан мэдээг хугацаанд нь тухай бүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлж байна.	100
135	7.3.2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн албан бичиг, баримтыг тусгай программ хангамжаар дамжуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.	2020-2025	ХЭЗХ	-	-	Программын сайжруулалт, хөгжүүлэлт эхлүүлсэн	Албан бичиг, баримтыг тусгай программ хангамжаар дамжуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах	-	-	Төрийн байгууллагуудын албан хэргийн үйл ажиллагаанд И-Оффис систем ашиглагдаж байна. Улсын хэмжээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлагууд, төрийн байгууллагуудтай албан бичиг солилцох дундын https://docx.gov.mn/ системд интеграци хийж албан бичиг солилцох хөгжүүлэлт бүрэн хийгдэж ашиглалтад орсноор тус системд холбогдсон 1374 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломж бүрдээд байна. Системийг 154 байгууллагын 1792 хэрэглэгч албан хэргийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. И-оффис системийн ашиглалтыг жил бүр сайжруулан ажиллаж байна. Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, Засгийн газрын тогтоолуудын дагуу жил бүр өргөжүүлж хөгжүүлсээр хоорондоо уялдаа холбоо бүхий Бодлого хөтөлбөр, Ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, Захиргаа, хүний нөөц, Албан хэрэг хөтлөлт, Бүртгэл тайлан, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Харилцаа холбоо гэсэн 7 үндсэн системд 30-аад төрлийн дэд систем болгон баяжуулж хөгжүүлэлт хийсэн. Системийн сервер, мэдээллийн бааз нь "Үндэсний дата төв" УТҮГ-ын зогсуур түрээсийн үйлчилгээнд хамрагдаж ажилладаг тул мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан.	100

НАЙМ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ЭРДЭНЭТ ХОТ

Зорилго 8. Хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой байдал, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан өвлүүлсэн, бүс нутгийн эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвартай, тэнцвэртэй орон нутгийг хөгжүүлнэ.

Дэд бүтэц

Зорилт 8.1. Хот төлөвлөлтийн хүрээнд шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга, байгууламжийг нэмэгдүүлэн, хотын төвлөрлийг задалж, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ:

136	8.1.1.Эрдэнэт хот орчимд шинэ суурьшлын бүс байгуулах асуудлыг судалж, нийгмийн дэд бүтцийн ашиглалт, хүртээмжийн нэгдсэн төлөвлөлт хийнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	Орон нутгийн төсөв	142.0	-	Суурьшлын бүс байгуулах төлөвлөлт хийгдсэн байна.	142.0	Орон нутгийн төсөв 142.1	<p>Аймгийн хэмжээнд Цагаанчулуут багт 11.9га, Уурхайчин багт 1.3га газарт дахин төлөвлөлтийг хийж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Уурхайчин багт 1.3га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхэлсэн барилгын төслийн гүйцэтгэл 40 хувьтай, Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төслийг хийлгэн 2025 оны 12-р сарын 4-ний өдрийн тогтоолоор батлагдсан.</p> <p>Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баян-Өндөр сумын 3 байршилд хийгдэх Зэст болон Хүрэнбулаг багийн 73,64 га талбайд Уурхайчин хорооллын 1300 айлын төслийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Люксвүүд" ХХК, аймгийн ЗДТГ-ын захиалгаар Эрдэнэ багийн 3 га талбайд эрчим хүчний хэмнэлттэй 60 айлын амины орон сууцны төслийг "Хайбрид хаус" ХХК тус тус гүйцэтгэж байна. Мөн Хүрэнбулаг багт 10 га талбайд 150 айлын эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төслийн төлөвлөлтийн зураг төслийг "Скайлайн дизайн" ХХК боловсруулж байна. Мөн Оюут багт Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна.</p> <p>2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7-р хороололд 960 хүүхдийн сургууль, 2А хороололд 150 хүүхдийн цэцэрлэг болон 960 хүүхдийн сургууль тус тус төлөвлөгдөж 7-р хорооллын 960 хүүхдийн сургуулийн гүйцэтгэгчээр " Орчлон тулга " ХХК шалгарч одоогийн 35%-ийн гүйцэтгэлтэй. 2А хорооллын 150 хүүхдийн цэцэрлэгийн гүйцэтгэгчээр "Аттачир" ХХК шалгарсан. Ажлын гүйцэтгэл 30% -тай байна.</p>	100
137	8.1.2 "Миний гудамж-Бидний гэр", "Миний орц-Бидний байшин" төслийг хэрэгжүүлж, зам талбай, гэрэлтүүлэг, камержуулалтыг дэс дараатайгаар үргэлжлүүлэн хийнэ.	2020-2025	ХБТХОХ, ХЗА, "ЭБЦТС"ТӨ ХК, "ЭУДТС"ОН ӨХК	Орон нутгийн төсөв	2900.0	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 431	Төвлөрсөн шугамд холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоог нэмэгдүүлнэ.	183.0	Орон нутгийн төсөв 379.5+800 0.0 Улсын төсөв 4470.0	<p>2021 оноос аймгийн хэмжээнд Бидний гудамж бидний гэр", "Хашаандаа хаус" хөтөлбөрийг хэрэгжүүлж гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажилд орон нутгийн төсвөөс нийт 2.9 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг ажлын хүрээнд гэр хорооллын 7 багт хэрэглээний халуун хүйтэн усны 0.94 км, цэвэр усны 0.94 км, бохирын 0.5 км, Рашаант багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.63 км, цэвэр усны 1.63 км, Наран багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.14 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.52 км, Цагаанчулуут багт бохир усны 0.76 км, Баянцагаан багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 0.98 км, Дэнж багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 0.88 км, цэвэр усны 0.88 км, бохир усны 0.26 км, Говил багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 2.22 км, нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдлээ. Төслийн үр дүнд 1245 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдэж, 308 айл өрх бүрэн холбогдсон.</p> <p>Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн Ус дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх шугам сүлжээний угсралтын ажлыг 2022 оноос эхлүүлснээр одоогийн байдлаар 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч ус дулаан хуваарилах төвийн дотор тоног төхөөрөмжийг угсарч дууссан, заслын болон гадна шугам угсралт бүрэн хийгдсэн.Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад авахаар шийдвэрлэсэн.</p> <p>Улсын төсвийн 1.37 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их</p>	100

										<p>залуу багт төвийн дулаан, цэвэр усны шугам шинээр тавих, ус дулаан дамжуулах төвийн барилга барих 1.7 км 3 хос гадна инженерийн шугам сүлжээ угсралтын ажлыг хийж дуусгалаа.</p> <p>Миний орц-Бидний байшин" төслийн хүрээнд 2022 онд Оюут баг 2-3-р байранд 3 орц, 2023 онд 379.5 сая төгрөг батлуулан 14 орцны засварын хийж гүйцэтгэсэн. Үүнд: Дэнж багийн 3 байрны 6 орцны засварын ажлыг Алист констракшн ХХК, Баянцагаан багийн Вокзалын 3, 4 дүгээр байрны 8 орцны засварын ажлыг Өвөлжөөн булаг ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад өгсөн.</p> <p>2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Дэнж баг Баян-Өндөр хотхоны 3 орцонд кодтой хаалга хийх, Согоот багийн нийтийн орон сууцны байруудын хаяг шинэчлэх, сэргээн засварлах, Баян-Өндөр сумын засаг даргын аваарын зардлаар 5 СӨХ-ын 11 байрны 54900м2 талбайд ариутгал халдваргүйтгэл, шавж устгалыг хийсэн. СӨХ-ууд өөрсдийн хөрөнгөөр 13 СӨХ-ын нийт 40 орцонд хэсэгчилсэн болон бүрэн засвар /бүрэн засвар -13 орц, хэсэгчилсэн засвар-27 орц/, 11 СӨХ дулаан алдагдлаас сэргийлж 11 орцны 32 цонхыг вакум цонхоор сольж, 17 орцны 26 цонхны шилийг сольж засварласан. Зоорины давхрын 16 салхивчийг сольж сэлбэн сайжруулах, торлож нохой, муур, шувуу орохоос хамгаалсан. Мөн 7 байранд 230м заадас засварын ажил хийгээд байна. 23 СӨХ-ууд орц, подвалд 2 удаа, нийт 29264 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлсэн.</p>	
138	8.1.3.Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ХЗА, ХББЗА	-	-	-	Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгох технологи нэвтрүүлнэ	-	Орон нутгийн төсөв 750.0 НҮБХС 700.0	<p>- 17-р сургуулийн уурын зуухыг шинэчлэх, бие даасан эрчим хүчний үүсвэртэй болгож, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор "Гор газ" ХХК бүрэн автоматжуулагдсан 1400 квт-ын хүчин чадалтай, тохируулга бүхий хяналт удирдлагын систем, хийн түлшний усан халаалтын зуухыг суурилуулахаар ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар хийн хангамжийн болон дулааны хэсэг болон дулааны узелийн 10х5 метр хэмжээтэй барилга, гадна, дотор шугамын холболт, цахилгааны ажил бүрэн хийгдэж аюулгүй ажиллагааны системийг ашиглалтад оруулан туршилт тохируулга хийгдсэн. Туршилт тохируулгын үндсэн барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комиссыг ажиллуулж байнгын ашиглалтад оруулсан. Одоогийн байдлаар систем хэвийн ажилдаж байна.</p> <p>- Алслагдсан багуудын төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, айл өрхүүдийг бие даасан дулааны эх үүсвэрээр хангахаар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн 3500 м3 талбай бүхий 28-р цэцэрлэг, 3397 м3 талбай бүхий төрийн байгууллагуудын байранд халаалтын зориулалт бүхий 50 квТ-ын дулааны коллектор, цахилгаан эрчим хүчээр хангах 20 квТ-ын нарны зайн системээр дэмжигдсэн газрын гүний дулаанаар шийдвэрлэх 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг Смарт Энержи ХХК гүйцэтгэсэн. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллан туршилт тохируулгын ажил явагдаж байна. Туршилт тохируулгын үеэр уурын зуухны галлагаа хийгдээгүй ба Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн халааж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэж байна.</p> <p>- БОУАӨЯ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Баян-Өндөр сумын гэр хорооллын 19 м.кв хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын</p>	90

									бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусган айлуудтай гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.		
139	8.1.4. Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	Хувийн хэвшил	27400.0	Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцанд амьдардаг өрхийн тоо 13180 айл	Шинээр 150 айл	27400.0	Эрдэнэт үйлдвэр, Орон нутгийн төсөв 27400.0	Аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Уртын гол багт 5 блок бүхий 260 айлын орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Тус барилгын төсөвт өртөг нь 27.4 тэрбум төгрөгөөс 25.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласнаар одоогийн байдлаар тус төслийн гүйцэтгэл 87 хувьтай байна. Барилгын явц Е блок-65 хувь, А В, С, D 4 блок буюу 208 айлын орон сууц барилга 100 хувийн гүйцэтгэлтэй ашиглалтад орсон. Ашиглалтад орсон 4 блок барилгыг хүлээн авч, иргэдийг оруулах ажлыг зохион байгуулснаар 28 иргэн түрээсээр, 180 иргэн хөнгөлөлттэй үнээр худалдан авч нийт 208 айл тус орон сууцанд ороод байна. Тус төслийн хүрээнд Ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөөний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Орлогод нийцсэн орон сууцны үнэ зах зээлийн үнээс 30-40 хувиар хямд байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 400 айлын "Уурхайчин-3" амины орон сууцны хорооллын барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2021-2025 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 47 блокын 3529 орон сууц ашиглалтад орсон байна.	100
140	8.1.5. Хотын инженерийн шугам сүлжээний дэд бүтцэд гамшгийн эрсдэлийн үнэлгээг үе шаттайгаар хийж, гэмтэл, доголдлыг бууруулах, инженерийн дэд бүтцийг сайжруулах ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлнэ.	2020-2025	ХЗА, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК	Орон нутгийн төсөв	251.2	-	Инженерийн дэд бүтцийг сайжруулна.	251.2	Орон нутгийн төсөв 4300.0 Улсын төсөв 6895.0	2021 онд орон нутгийн төсвөөс 95.0 сая төгрөг зарцуулан ШУТИС-ийн судалгааны багаар хотын хэмжээний дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийлгэснээр эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагагүй болж хотын дулааны шугамын насжилт, өргөтгөл шинэчлэлт хийх шаардлагатай шугам сүлжээнүүдийн тооцоо судалгааг гаргасан. Уг судалгааны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хотын нийтийн орон сууцууд болон ААНБ-ыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барихаар 2022 оноос улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажлыг "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэсэн. 2022 онд орон нутгийн 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 35/6кВ-ын ЦРП-Өмнөд дэд станцыг 2х10000кВА-иар өргөтгөх ажлыг "Орхон тек" ХХК хийж дууссан. 2023 онд хуучин Өмнөдийн дэд станцын хэрэглэгчийг шинэ станцад холбох ажил бүрэн хийгдэж ачаалал авч ажиллаж байна. 2023 онд Орхон аймгийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор Эрдэнэ багт 35кВ-ын ЦДАШ-ыг барих ажлыг ЭБЦТС ТӨХК өөрийн хөрөнгө оруулалтаар хийж ашиглалтад 2024 оны 9 дүгээр сард оруулсан. Мөн Эрдэнэ багт 35/6 кВ-ын дэд станц шилжүүлэн барих ажлыг хийж ашиглалтад оруулан хэрэглэгчийн холбосноор цахилгааны хүчдэлийн уналт буурсан. Мөн Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн ус, дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлыг 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 28.9 тэрбум төгрөгийн 48 нэр төрлийн ажил хийгдсэн. Үүнээс хамгийн том бүтээн байгуулалтын ажил нь 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам болон Даваат дэд станц юм. Энэ дэд станц ашиглалтад орсноор гэр хорооллын 70 хувийг хангадаг хороолол	100

										<p>дэд станцын ачааллыг тэнцүүлэх, жигд хуваарилна. Хэт ачааллын улмаас шатах эрсдэлтэй байсан Хороолол дэд станцын эрсдэлийг бууруулсан. Даваад дэд станц руу 2000 хэрэглэгчийг шилжүүлж холбох ажил хийгдсэн.</p> <p>Хотын хэмжээний инженерийн шугам сүлжээнд цаашид авах шаардлагатай ажлын төлөвлөгөөг хангагч байгууллага "ЭДЦС"ОНӨХК, "ЭУДТС"ОНӨХК тухай бүр гарган улсын төсөв, орон нутгийн төсөв, болзошгүй аваарын зардал болон өөрсдийн байгууллагын нөөц бололцоогоор шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>Мөн хангагч байгууллага болох "ЭДЦС"ТӨХК, "ЭУДТС"ОНӨХК хотын шугам сүлжээнд жил бүр үзлэг шалгалт, горим тохируулга хийж, тухай бүр хэрэглэгчдийн ачааллын тооцоог хийж ажиллаж байна.</p>	
141	8.1.6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх саналыг дэмжиж ажиллана.	2020-2025	ХЗА, ХБТХОХ, ХББЗА, "ЭДЦС" ТӨХК	Улсын төсөв	910.0	-	Цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	910.0	<p>Улсын төсөв 2600.0</p> <p>Орон нутгийн төсөв 13233.0</p>	<p>Дулааны цахилгаан станцаас 9 дүгээр цэг хүртэлх дулааны шугамыг /ф700 мм-ийн 3.5 км/ өргөтгөх ажлыг 2022 оны улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн ажлын тендэрт "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэгчээр шалгарч барилга угсралтын ажил эхэлсэн 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Төв дулааны шугамыг өргөтгөж барьснаар шугамын нэвтрүүлэх чадвар нэмэгдэж шинээр барьж байгаа орон сууцны хороолол, барилга байгууламжуудыг дулааны эх үүсвэрээр хангах нөхцөл бүрдэнэ.</p> <p>2023 онд Орхон аймгийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор Эрдэнэ багт 2.9км 35кВ-ын ЦДАШ барих ажил, 35/6 кВ-ын дэд станц шилжүүлэн барих ажлыг ЭБЦТС ТӨХК өөрийн хөрөнгө оруулалтаар 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн ба 1960ш хэрэглэгч уг дэд станцын шугамд холбогдож шилжсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх, сайжруулах зорилгоор 35кВ-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд 13.1 тэрбум төгрөг төлөвлөн ажилласан. Уг ажлын хүрээнд Чингэл дэд станцаас 35/10 кВ-ын Даваат дэд станц хүртэлх 35 кВ-ын 13.059 км ЦДАШ барих ажилд "Виртуалсофт" ХХК, 35/10 кВ-ын 2х16 МВА Даваат дэд станц барих ажилд "Меса инженеринг" ХХК, Даваат дэд станцаас 35/10 кВ-ын Булаг дэд станц хүртэлх 35 кВ-ын 5.04 км ЦДАШ барих ажилд "Цацраг цог" ХХК-ийн гүйцэтгэгчээр шалгарч ЦДАШ барих ажлууд хийгдэж дууссан. Тус ажлын үр дүнд ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож хэт ачааллаас шалтгаалан хязгаарлагдах, Бугат сумын дэд станцад гарсан гэмтлээс шалтгаалан тасралт гарах, эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээнээс шалтгаалсан хүчдэлийн уналт үүсэх зэрэг асуудлууд шийдвэрлэгдэх нөхцөл бүрдсэн.</p> <p>10кВ-ын тойрог схемд оруулах 9 нэрийн ажилд 7.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн 100 хувь дуусаж ашиглалтад бүрэн оруулсан. Тус ажлын хүрээнд 3ш дэд станц /РП/, 10кВ-ын хос 12.05км цахилгаан дамжуулах кабель шугам барих ажлыг хийж дуусгаснаар дэд станцын ачаалал 59.8 хувь болж буурсан.</p> <p>Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын гэр хорооллын захын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулж, хүчдэлийн уналтыг бууруулах зорилгоор Баян-Өндөр сумын 11 багийн 22 байршилд 10 кВ-ын ЦДАШ, 10/0.4 кВ-ын 250 кВА чадалтай (КТГПН) дэд станц барихаар нийт 22 ажил төлөвлөж тус ажлууд 100 хувь дуусаж ашиглалтад оруулсан. Дээрх ажил хийгдсэнээр Эрдэнэ, Дэнж, Яргуйт, Их залуу, Уртын гол, Цагаанчулуут, Рашаант, Даваат, Наран, Баянбулаг, Баянцагаан, Чингэл, Баян-Овоот,</p>	100

Зорилт 8.2. Найдвартай, аюулгүй, хямд, хүртээмжтэй, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ:											
142	8.2.1.Нийтийн тээврийн үйлчилгээний стандартад нийцсэн замын байгууламж, автобусны зогсоол, буудал, тэмдэг, тэмдэглэгээг бий болгоно.	2020-2025	ХБТХОХ	Орон нутгийн төсөв	129.7	75 сүүдрэвч 80%	10 сүүдрэвч 25% /жил бүр/	129.7	Орон нутгийн төсөв 534.8	Орхон аймгийн Баян Өндөр сумын 26 багийн нутаг дэвсгэрийн, хотын доторх хатуу хучилттай авто зам дагуух 192 автобусны буудал, нийтийн эзэмшлийн авто зогсоолыг нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглаж байна. Цаашид стандартын шаардлага хангасан 63 автобусны буудал, сүүдрэвч шаардлагатай бөгөөд 23 карма зогсоолыг тэмдэг, тэмдэглэгээгээр тодорхойлж, түр тоноглон ашиглаж байна. Шинээр баригдаж буй орон сууц болон хотхон, гэр хорооллын хатуу хучилттай авто замын сүлжээг дагуулан шинэ чиглэл нэмэх чиглэлээр судалгааны ажил хийгдэж байна 2021-2023 онд аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 8 ширхэг автобусны буудлыг барьж ашиглалтад оруулсан. Аймгийн хэмжээнд нийт 192 автобусны буудал байгаагаас 98 нь буюу 51 хувь нь зогсоолын байгууламж бүхий 94 нь буюу 47.5 хувь нь, стандарт шаардлага хангасан нийтийн тээврийн үйлчилгээний болон сурагчдын автобусны буудал байна. 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Авто вокзалын өмнө 1 ширхэг, Эрх чөлөөний гудамжны хэсэгт /Цагдаагийн газрын урд/ 1 ширхэг, 2А хороололд 1 ширхэг, Жаргалант суманд 3, нийт 6 автобусны буудал шинээр барьж ашиглалтад оруулсан бол Баянцагаан багт 1, Жаргалант суманд 4 автобусны буудлыг стандарт шаардлагад нийцүүлэн иж бүрэн засварласан. 2025 онд Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтын 20.0 сая төгрөгөөр Рашаант багт нийтийн тээврийн автобусны 1 авто буудал барьж ашиглалтад оруулсан.	100
143	8.2.2. Хот төлөвлөлттэй уялдуулан шинээр бий болж буй суурьшлын бүсэд нийтийн тээврийн үйлчилгээний маршрут, чиглэлийг нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчиход шаардагдах нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	Орон нутгийн төсөв	1200.0	6 чиглэл, 0.8 сая.төг	Нийтийн тээврийн үйлчилгээний маршрут, чиглэл, шаардагдах нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлнэ.	1200.0	Орон нутгийн төсөв 6200.0	Аймгийн хэмжээнд шинээр бий болсон суурьшлын бүс болон асфальтбетон хучилттай авто зам ашиглалтад орсонтой холбогдуулан 2021-2022 онд "Төгөл-Вокзал" чиглэлийг шинээр баталж хэрэгжүүлсэн. Хот төлөвлөлттэй уялдуулан нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор 2023 онд аймгийн Засаг даргын А/597 дугаар захирамжаар Ч8: буюу "Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол" чиглэл, 2024 оны А/620 дугаар захирамжаар Ч5: буюу "Хүлэг зах-Автовокзал-Говил" чиглэлийг тус тус баталсан. Мөн тус чиглэлд гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны Ч8, Ч5 чиглэлүүдэд 15 ширхэг шинэ автобусыг ХТГазарт хариуцуулан 2024 оны 07 дугаар сараас эхлэн нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж байна. Иргэдийн санал хүсэлтийн хүрээнд Аймгийн Засаг даргын А/959 дугаар захирамжаар Ч9 буюу Яргуйт-Хангай бүс худалдааны төв-2А хороолол-Авто вокзал-Хүлэг зах чиглэлийг шинээр байгуулан Хот тохижуулах газар хариуцуулан үйл ажиллагааг жигдрүүлээд байна. Тус чиглэлд стандарт шаардлага хангасан дунд оврын 4 автобус иргэдэд үйлчилж байна. Шинэ чиглэл байгуулсантай холбоотой иргэдийн санал хүсэлтийн хүрээнд аймгийн Засаг даргын А/958 дугаар захирамжаар Шанд чиглэлийн маршрутыг 15-р сургууль- Халуун ус буюу дунд замаар явахаар шинэчлэн байгуулсан. Мөн Шинэ суурьшлын бүс болон авто замын шинэчлэлтэй уялдуулан иргэдийн санал хүсэлтийн хүрээнд 2 байршилд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл маршрутад өөрчлөлт оруулан	100

										иргэдийн ая тухтай зорчих нөхцөл боломжийг бүрдүүлсэн.Үүнд: <ul style="list-style-type: none"> “ББ-Од” ХХК-ийн Ч-3 буюу “Дэнж-Баян тал” чиглэлийн маршрутыг сунгаж Ёс заншлын өргөө хүртэл, “Тод од транс” ХХК-ийн Ч2 буюу Шанд чиглэлийн маршрутад өөрчлөлт оруулан Медипас эмнэлэг хүргэхээр тус тус сунгаж үйл ажиллагааг жигдрүүлсэн. Мөн 2025 оны байдлаар аймгийн хэмжээнд нийтийн тээврийн 8 чиглэлд 34 дунд оврын автобус иргэдэд үйлчилж байна. Үүнээс: Тод од транс ХХК нь Их залуу-Шанд чиглэлд 5 автобус, Тосгон-Зээл чиглэлд 4 автобус, ББ-Од ХХК нь Хороолол чиглэлд 5, Баянтал-Дэнж чиглэлд 6 автобус, Авто мастер төв ХХК нь төмөр замын вокзал чиглэлд өглөө орой цагийн хуваарийн дагуу 2 автобус, Хот тохижуулах газар нь Говил чиглэлд 4 автобус, Яргуйт чиглэлд 4, Урд хабитат чиглэлд 4 автобус үйлчилгээнд ажиллаж байна. 2025 оны 12 сарын байдлаар Тод од транс ХХК нь 642 сая төгрөг, ББ-Од ХХК нь 707.4 сая төгрөг, Автомастер төв ХХК нь 79.2 сая, ХТГазар 771.4 сая төгрөгийн нөхөн олговрыг тус тус олгосон.	
144	8.2.3.Зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн “Авто буудал”-ыг байгуулж, нийгмийн хэрэгцээг хангахуйц, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн үйлчилгээ, сүлжээг хөгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	Улсын төсөв 3900.0	3900.0	Аймгийн хэмжээнд авто буудал байхгүй	Авто буудлыг байгуулсан байна.	3900.	Улсын төсөв 3900.0	2023 оноос улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн “Авто буудал”-ын барилгын ажлыг эхлүүлж 2024 оны 8-р сард ашиглалтад авч үйл ажиллагааг эхлүүлэн жигдрээд байна. Тус Авто буудал нь 2480м.кв талбайтай, 4-н давхар / В1 давхартайгаа/, гадна авто зогсоол нь 7000м/кв талбайтай, 300 орчим тээврийн хэрэгслийн зогсоолын байгууламжтай, зорчигч тээвэрлэлтийн бүх үйлчилгээг нэг дор нэгтгэн үйл ажиллагаагаа явуулж байна. Авто буудал нь өдөрт хот хооронд, аймаг, сум хоорондын зорчигч тээвэрлэлт болон дамжин өнгөрч байгаа нийт 9 чиглэлийн 90-112 тээврийн хэрэгсэл, 1600-1800 зорчигч дамжин өнгөрүүлж байна. Мөн иргэдэд үзүүлэх үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор дараах байгууллагуудыг үйл ажиллагаа явуулах талбай болон албан өрөө тасалгаагаар хангаж, иргэдэд шаардлагатай үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэн, хамтран ажиллаж байна. Үүнд: Зорчигч тээврийн 7 байгууллага, Төрийн банк, Монгол шуудан үйлчилгээний газар, улсын дугаарын 2 үйлдвэр, даатгалын 7 байгууллага, авто үнэлгээний байгууллагууд тус тус байрлаж үйл ажиллагаа явуулж байна. Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудын АТМ, Кiosk төхөөрөмж, “Хурдан” гэрэгэ төхөөрөмжүүд суурилагдсан байна.	100
145	8.2.4.Иргэдийн зорчих хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зорилгоор аймаг дундын нисэх онгоцны буудал байгуулж, агаарын шугам нээх ажлыг эхлүүлнэ.	2020-2025	ХБТХОХ	-	-	-	Агаарын шугам нээх ажлыг эхлүүлнэ.	-	-	2020-2021 онд ИНЕГ-аас холбогдох чиглэлийн мэргэжилтнүүд ирж судалгаа хийсэн. 2022 оны байдлаар Орхон аймагт агаарын хөлөг хөөрч, буух зурвас газар сонгохоор “Тэнгэрийн улаач” ХХК, “Геосан” ХХК-аас хүсэлт ирүүлсний дагуу орон нутагт агаарын тээврийн үйлчилгээг нээх чиглэлээр судалгааны ажилд хамтран ажилласан боловч зурвас газар сонгох боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн.	0
146	8.2.5.Ухаалаг тээврийн системд тулгуурласан хотын доторх нийтийн тээврийг хөгжүүлж, тээврийн төрлүүдийн	2020-2025	ХБТХОХ	Орон нутгийн төсөв	1500.0	3 автобус парк шинэчлэлт	20 автобус 55.5%	1500.0		Нийтийн тээврийг хөгжүүлж, харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Тус ажлын хүрээнд 2023-2024 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 25 дунд оврын автобус худалдан авч нийтийн тээврийн парк шинэчлэлтийг хийсэн бол 2025 онд хувийн	100

	харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ.							Орон нутгийн төсөв 6900.0 Хувийн хэвшил 280.0	хэвшлийн хөрөнгө оруулалтаар "ББ-Од" ХХК нь 2 автобус, "Тод-Од транс" ХХК нь 2, нийт 4 дунд оврын автобусаар тус тус парк шинэчлэлтийг хийснээр нийтийн тээврийн парк шинэчлэлт 80.3 хувьд хүрсэн байна. АЗДТГ-ын БОНХОБТХ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Авто тээврийн төв болон Хот тохижуулах газар хамтран гэр хорооллын 15 баг, хотын төвийн 6 багийн иргэдээс чанар ханамжийн судалгааг цахим болон багийн ажлын албаар дамжуулан 2025 оны 04 дүгээр сараас 5 дугаар сар, 08 дугаар сараас 09 дүгээр сар хүртэл авч, нийт 2123 иргэдийг хамруулсан. Судалгаанд оролцогчдоос 1-5 онооны системээр Нитийн тээврийн маршрут,Нитийн тээврийн зогсоол сүүдрэвч, Нитийн тээврийн үйлчилгээний автобусны үйлчилгээний чанар гэсэн 3 бүлгийн хүрээнд 7 асуулт бүхий судалгааг авсан. Судалгааны дүнгээр нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмж 2.8 болж өмнөх судалгааны дүнгээс 0.3 индексээр өссөн байна. 2025 оны байдлаар нийтийн тээврийн 8 чиглэлд 34 дунд оврын автобус иргэдэд үйлчилж байна. Үүнээс: Тод од транс ХХК нь Их залуу-Шанд чиглэлд 5 автобус, Тосгон-Зээл чиглэлд 4 автобус, ББ-ОД ХХК нь Хороолол чиглэлд 5, Баянтал-Дэнж чиглэлд 6 автобус, Авто мастер төв ХХК нь төмөр замын вокзал чиглэлд өглөө орой цагийн хуваарийн дагуу 2 автобус, Хот тохижуулах газар нь Говил чиглэлд 4 автобус, Яргуйт чиглэлд 4, Урд хабитат чиглэлд 4 автобус үйлчилгээнд ажиллаж байна. Орон нутгийн төсвийн 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийтийн тээврийн үйлчилгээнд цахим картын систем нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Зэс арвид" ХХК шалгарч ажлыг эхлүүлснээр карт уншигч төхөөрөмж, хүн тоологч камер болон бусад дагагдах хэрэгслүүд, удирдлагын систем зэрэг 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн ШУТП-д хүлээлгэн өгсөн. Нийтийн тээврийн төлбөрийн системийг үндэсний дата төвийн серверт суурилуулж, холболтын ажлын туршилт хийгдсэн. Смарт Эрдэнэт аппликейшний 2.0 хувилбарыг App store, Play store программын санд байршуулах хүсэлтийг программ эзэмшигчдэд илгээсэн. Одоогийн байдлаар Смарт Эрдэнэт аппликейшний шинэ хувилбар программын санд хянагдах, хэрэглэгчийн туршилт хийгдэх, автобусны карт хэвлүүлэх, бүх төрлийн банкны карт холбох зэрэг ажлууд хийгдэж байна. 2025 онд нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг систем нэвтрүүлэх ажлыг Эрдэнэт ШУТП хийж байгаа бөгөөд ХТГ-ын 3 чиглэлийн 15 дунд оврын автобусанд карт унших төхөөрөмжийг бүрэн суурилуулж дуусгасан. Туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажил бүрэн дууссаны дараагаар хувийн хэвшлийн автобуснуудад суурилагдах ажил хийгдэнэ.		
Зорилт 8.3. Хотын хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөг төлөвлөж, зам харилцаа, инженерийн дэд бүтэц байгуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, орчныг бүрдүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ:											
147	8.3.1.Эрдэнэт хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г батлуулж хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	Улсын төсөв	-	-	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдан батлагдсан байна.	Улсын төсөв	Улсын төсөв 1300.0	"Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар"-ыг боловсруулах ажилд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулахад орон нутгийн холбогдох байгууллагууд саналаа нэгтгэн тусгаж БХБЯамд хүргүүлснээр 2024 оны 05-р сард Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан. БХБЯамнаас хөгжлийг ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулснаар 2024	30

										оны 10 сарын 31-нд “Нью урбанизм” ХХК 1094.0 сая төгрөгийн үнийн саналаар хамгийн сайн үнэлэгдэн шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд орон нутагт төрийн байгууллагуудтай уулзаж санал авсан. ХБХОСЯ-наас тус төлөвлөгөөний ажлын уялдаа холбоог хангах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж Эрдэнэт хотын байр зүйн геодезийн зураглалын алдааг засах, шинэчлэн хийх шаардлагатай байгаа талаар үүрэг өгсөн. Мөн бүс нутгийн асуудлаар Булган аймагтай санал солилцож саналыг албан ёсоор авах шийдвэр гарсан. Зэргэлдээх сумдын суурьшлын бүс эдийн засгийг тэлж хамтран ажиллах санал гаргасан. 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр “Нью урбанизм” ХХК-ийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь хүлээн авч төлөвлөгөөний санал, өөрийн үйлдвэрийн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг уялдуулах хамтран ажиллахаар тохиролцоонд хүрсэн. Мөн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний судалгааны дагуу хотын баруун талыг дулаанаар хангах дулааны станцын байршил нь Булган аймгийн Орхон сумын Халиун багт байхаар тооцоологдсон ба тус дулааны станцыг байршлын талаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Булган аймгийн Орхон сумын ИТХ-ын дарга, Засаг даргатай хэлэлцсэн ба Булган аймгийн Орхон сумаас дараагийн уулзалтыг зохион байгуулах шийдвэр гаргасан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын гүйцэтгэл нь 40 хувьтай байна. “Нью урбанизм” ХХК нь одоогийн байдлаар өнөөгийн байдлын болон иргэдийн олон нийтийн судалгаа, хотын газарзүйн ерөнхий байдал, огтлолыг хийж 1 удаа олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн. 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр эхлэлийн тайлан хүлээлгэн өгсөн.	
148	8.3.2.Хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	-	-	-	Иргэдэд мэдээлсэн байна.	-	-	Баян-Өндөр болон Жаргалант суманд зохион байгуулсан "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгөөр Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Жаргалант сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг зурагт самбар, альбом хэлбэрээр сурталчилж. 840 гаруй иргэнд мэдээлсэн. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг / https://erdenet.gazar.gov.mn/ цахим хуудаст байршуулж иргэдэд иргэдэд тогтмол мэдээлж байна.	100
149	8.3.3.Хотын инженерийн шугам сүлжээг тодорхой үе шаттай шинэчлэн сайжруулна.	2020-2025	ХЗА, ХБТХОХ,, ХББЗА, “ЭДЦС” ТӨХК, “ЭУДТС”ОН ӨХК	Орон нутгийн төсөв	1092.8	-	Хотын инженерийн шугам сүлжээг үе шаттай шинэчлэн сайжруулна.	1092.8	Орон нутгийн төсөв 16600.0	2022 онд хотын инженерийн шугам сүлжээг 8428 м-ээр шинэчилсэн. 2022 онд Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭДЦС ТӨХК-иас 9 дүгээр цэг хүртэлх Ду720мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих ажлын гүйцэтгэгчээр “Эрин гүрэн” ХХК шалгарч мөн Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн ус, дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлыг 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “Эрин гүрэн” ХХК гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар Цагаанчулуут, Наран багт УДДТ барих зэрэг ажлууд бүрэн хийгдэж дуусан барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан. 2021-2023 онд аваарын байдалтай байсан 12 ажилд нийт 2.1 тэрбум зарцуулсан бол 2024 онд болзошгүй аваарын зардлаар 32 ажилд 1.8 тэрбум төгрөг зарцуулан инженерийн шугам сүлжээний хэвийн байдлыг хангасан. 2024 онд орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажилд 895.2 сая төгрөгийг батлуулан хийж гүйцэтгэлээ. Мөн Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Бүрэнбүст багийн цэвэр усны шугамын ажилд 691.1 сая төгрөг,	90

									<p>Уурхайчин багийн цэвэр усны шугамын ажилд 833.5 сая төгрөг, Хүрэнбулаг багийн УДДТ №4-2-ын гадна 5 хос 1 км шугам шинэчлэх ажилд 1.0 тэрбум төгрөг тус тус батлагдсан ба одоогоор тендер сонгон шалгаруулалт хийн Пристиж инженерн ХХК шалгараад байна.</p> <p>2025 оны аваарын зардлаас 8.4 тэрбум төгрөгийн инженерийн шугам сүлжээний 51 ажлыг төлөвлөж ашиглалтад оруулаад байна. Орхон аймгийн инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн нийт 23 ажилд 27.7 тэрбум хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар үргэлжлүүлэн хийх, шаардлагатай шугам сүлжээний шинэчлэлт хийх 14 нэр төрлийн ажил 100% хийгдэж 9 ажил, 50%-95% ийн биелэлттэй 4 ажил, гүйцэтгэгч шалгараагүй 2 ажил байна. Нийт дулааны шугам- 25.6км, бохир усны шугам 0.59км, цэвэр усны шугам-18.6км, цахилгааны шугам-160км холбооны 1.0км шугам шинэчилдэг. ИШСүлжээний ажил ихдэхтэй холбоотой ХЗА, ХББЗА, ЭУДТС ОНӨХК-ний инженерүүд гүйцэтгэгч компаниудыг дуудаж зохион байгуулах ажлын чиглэлийг хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллаж байна. 8 инженерийн шугам сүлжээний ажил хийгдэхээр төлөвлөгдсөн 3 ажил орон сууцны хороололд хийгдэнэ. Бүрэнбүст багийн цэвэр усны шугам сүлжээ -590м, Уурхайчин багийн цэвэр усны шугам- 1100м, Хүрэнбулаг багийн УДДТ-4-2 багийн төвийн шугам сүлжээний шинэчлэлийн 1100м нийт 2.5 тэрбум хөрөнгөөр 2790м шугамыг шинэчлэгдэх төлөвлөгөөний "Престиж инженеринг" ХХК хийж байна. өнөөдөр 3 байршилд шугам сүлжээг өргөтгөж байна. Нийт 85% гүйцэтгэлтэй байна.</p>		
150	8.3.4. Аймгийн хатуу хучилттай замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөх, замын дагалдах дэд бүтцийг стандартын дагуу барина.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	Орон нутгийн төсөв	5604.6	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 92 км хатуу хучилттай авто зам ашиглагд аж байна.	Жил бүр 300 м хатуу хучилттай авто зам барьсан байна.	5604.6	<p>Орон нутгийн төсөв 21200.0</p> <p>Улсын төсөв 10900.0</p>	<p>Хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх, өргөтгөл шинэчлэлтийн ажлын хүрээнд: 2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7.2 км авто зам, 2022 онд 2.1 км авто замыг бүрэн ашиглалтад оруулсан байна.</p> <p>2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хатуу хучилттай гэрэлтүүлэг, явган хүний зам бүхий иж бүрэн нийт 1.9 км авто зам, нийт 30 км сайжруулсан шороон замыг тус тус дуусгаж ашиглалтад орууллаа. Мөн Даваат багийн Зураа хэсэгт 1, Шанд багийн 20 дугаар гудамжны баруун үзүүр, 35, 36 дугаар гудамжны дунд 1ш, Эрдэнэ багийн 2, 25 дугаар гудамжны үзүүрт 1 ширхэг нийт 3 ширхэг авто машины гүүрэн гарцыг ашиглалтад оруулсан.</p> <p>2024 онд орон нутгийн төсвийн 8.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр 698м урт асфальт бетон хучилттай авто зам, замын байгууламж, 11 багийн 14 байршил 5.8 км авто замд их засвар шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулсан. 2025 оны авто зам, замын байгууламжийн ажил хийхээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 57, Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 23, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар 2 нийт аймгийн хэмжээнд 82 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн. 2024-2025 онд авто зам, замын байгууламжийн 57 гэрээний 43 байршилд авто засвар шинэчлэлтийн ажил хийгдэж байна. Үүнээс: 2025 онд шинээр эхэлсэн 23 ажил, он дамжин хийгдэж буй 34 гэрээт ажил үргэлжлэн хийгдэж байгаагаас 12.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4.9 км авто замыг шинээр, 27.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18.6 км авто замд их засвар шинэчлэлтийн ажил хийгдэж ашиглалтад орсон байна. Дээрх ажлууд хийгдсэнээр аймгийн хэмжээнд 135.3 км авто зам, замын байгууламж шинэчлэгдсэн. 2026 онд 8 байршилд авто замын ажил үргэлжлэн хийгдэнэ Авто замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 2.8 тэрбум</p>	100

										<p>төгрөгийн хөрөнгө оруулалтаар шаардлагатай 2 байршилд авто замын уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг бүрэн хийж дуусган ашиглалтад оруулсан. Үүнд:</p> <p>Хэвтээ чиглэлд 14 метрийн өргөнтэй зорчих хэсгийг 21 метр болгох, босоо чиглэлд 7 метр өргөн зорчих хэсгийг 12 метр өргөн болгож шинэчилсэн. Шинэчлэх ажлын хүрээнд 2 байршилд явган зорчигчийн арал, гэрлэн дохио бүхий боржин чулуун хашлага, тэмдэг, тэмдэглэгээ бүхий 7 см асфальт бетон хучилт бүхий “Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замын уулзвар шинэчлэх ажил”, 1.3 км урттай, зорчих хэсгийн өргөн 7 м, 7 см асфальт бетон хучилттай, явган хүний зам 2 талдаа 1.5 м өргөн, боржин чулуун хашлага, тэмдэг, тэмдэглэгээ бүхий 19 дүгээр цэцэрлэгийн уулзвараас Оросын элчний уулзвар хүртэлх авто замд их засварын ажлуудыг тус тус хийж дуусган ашиглалтад оруулсан</p>	
151	8.3.5.Үерийн хамгаалалтын төлөвлөлт, ашиглалтыг сайжруулж, шинээр барих ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.	2020-2025	ХБТХОХ, ХЗА, ХТГ	Орон нутгийн төсөв	11.5	-	Үерийн хамгаалалтын төлөвлөлт, ашиглалтыг сайжруулсан байна.	11.5	Орон нутгийн төсөв 222.2	<p>2021-2023 онд Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Баян-Өндөр сум, Хот тохижуулах газар зэрэг байгууллагууд хамтран сар бүр 2 удаа төлөвлөгөөт үзлэг хийж 66.3 км шороон сувгийг сэргээж ухах, жилд 4 удаагийн үерийн сувгийн их цэвэрлэгээг зохион байгуулан 560куб хог хаягдал, давхардсан тоогоор авто замын 42ш гарц хог хайргаар бөглөрснийг цэвэрлэсэн. Мөн 66.3 км шороон сувгийг шинээр болон сэргээн ухах ажилд орон нутгийн төсвөөс 189.8 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>2024 онд Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Хот тохижуулах газар, Баян-Өндөр сумын ЗДТГ-аас хамтарсан ажлын хэсэг 05 дугаар сараас 07 дугаар сарыг дуустал хугацаанд инженерийн хийцлэлтэй үерийн далан, байгалийн судаг, шуудуунд тогтмол үзлэг хийж ажиллаж, нийт давхардсан тоогоор 55 км урт далан шуудуунд үзлэг хийж 160м3 хог шороо цэвэрлэж тээвэрлэсэн. Мөн хавар, намрын улиралд 23.4 км урт шороон суваг, шуудууг сэргээж ухах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хотын доторх үерийн сувгийг сэргээн засварлах, Зэст, Уртбулаг, Согоот багуудад байрлах үерийн усны трап засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үерийн үед дрон нисгэж эрсдэлийг үнэлэн иргэдэд тухай бүрд мэдээ мэдээллийг өгч сэрэмжлүүлэн ажилласан.</p> <p>Мөн гэр хорооллын үерийн хамгаалалтын сувагт үзлэг хийж нийт 11.2 км үерийн суваг сэргээх ажлыг хийж эхлүүлснээр одоогийн байдлаар Яргуйт, Баян-Овоот, Уртын гол, Эрдэнэ, Их залуу Дэнж багийн 9.6 км шороон сувгийг сэргээж, шинээр 450м сувгийг татах ажил хийгдээд байна.</p> <p>ЕСБХБ-ны 14.0 сая.ам.долларын санхүүжилтээр “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төсөл хэрэгжиж байна. Санхүүжилтийн 50 хувь нь ЕСБХБ-ны хөнгөлөлттэй зээл, 50 хувь нь Европын холбооны техникийн туслалцааны буцалтгүй тусламжаар хийгдэнэ.Энэхүү төсөл нь үерийн эрсдэлийн менежмент, усан хангамж, усны алдагдлыг бууруулах төхөөрөмж суурилуулах гэсэн 3 багц ажлаас бүрдэж байгаа бөгөөд үерийн хамгаалалтын ажлыг БНХАУ-ын “Хунан Индастриал Экүйпмэнт Инсталлэйшн” ХХК гүйцэтгэж байна. Энэхүү ажлын хүрээнд нийт 8 байршилд 12.8 км урттай үерийн хамгаалалтын далан барина. Үүний 2.6 км нь тэгш өнцөгт, түшиц хана хийцлэлтэй, 10.2 км нь трапец суваг хийцлэлтэй. Энэ онд 4 ажил эхэлсэн, 3 ажил нь эхлээгүй байна. Ажлын гүйцэтгэл 60 хувьтай, сувгийн хашлага, хамгаалалтын ажил хийгдэж байна. Тухайлбал, А суваг буюу Яргуйт багийн Овоотын хэсэгт 1671 м урттай үерийн далангийн суваг хийгдэнэ. Энэ ажил 82 хувьтай, 2026 онд үргэлжлэн хийгдэнэ. В суваг буюу Баян-Овоот багийн Хөтлийн хэсэгт 1137м урттай үерийн сувгийн</p>	80

										<p>ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, 1117м суваг хийгдээд байна. D, E, H суваг буюу Уртын голын Баянтал, Чандмань багийн Эко хороолол, Цагаанчулуут багт эхэлсэн ажил ирэх онд үргэлжлэн хийгдэнэ.</p> <p>2026 онд 3 байршилд, F суваг буюу Баянбулаг багт 1140м, C суваг буюу Наран багт 2805м, G суваг буюу Оюут баг 2а хороололд 1762м үерийн сувгийн ажил хийгдэнэ. Мөн энэ ажлын хүрээнд хүн амын суурьшлын дээд бүсэд борооны ус хадгалах 3, Эрдэнэт голын хөндийд 1, нийт 4 усан сан барина. Эрдэнэ багийн Цэцэрлэгт хүрээлэнгийн баруун урд хэсэгт байгуулж буй усан сангийн далангийн ажил хийгдсэн, 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Даваад, Яргуйт, багт байгуулах усан сангийн ажил 2026 онд эхэлнэ.</p>	
152	8.3.6.Барилга байгууламжийн ашиглалтын төлөв, газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг тодорхойлох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	Орон нутгийн төсөв	40.0	Шинээр ашиглалт ад орсон 20 барилгыг паспортжуулж гэрчилгээ олгосон	Барилга байгууламжийг паспортжуулах ажлын гүйцэтгэл 30%	40.0	Орон нутгийн төсөв 40.0	<p>Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулалт гэрчилгээжүүлэх ажлын даалгаврыг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулж худалдах, худалдан авах ажиллагаа хийгдэж байна. Энэхүү ажлын даалгаварт Жаргалант сумын сургууль, цэцэрлэгийн Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажлын зөвлөл, хөрөнгө оруулалтаас шалтгаалан хэрэгжилтгүй байна. 2023 онд Барилга байгууламжийг паспортжуулах ажлын даалгаврыг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулж худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.</p> <p>Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдлын хяналтаар: Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны ашиглалтын хугацаа дуусаж, газар хөдлөл, байгалийн хүчин зүйлийн нөлөөнд нурах эрсдэлтэйг үнэлэн тогтоосон. Ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын карказ байгалийн хүчин зүйлийн нөлөөнд нурах эрсдэлтэйг үнэлэн тогтоосон.</p> <p>Жаргалант сумын Сургууль, цэцэрлэгийн барилгын буурь суурь сууж, даацын болон даацын бус хананд 3-4 хэсэгт нэвт цууралт үүссэн</p> <p>Нийтийн зориулалттай орон сууцны барилга 2-23, 2-25, 4-20, 4-26, 4-27 байруудын буурь суурь сууж, үндсэн даацын хийцэд хэв гажилт үүссэн.</p> <p>2024 онд Аймгийн хэмжээнд баригдаж байгаа барилга байгууламжид БХБЯ-ны 02-00/08 удирдамжаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 3 ААНБ-д 30 сая, 8 иргэнд 8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барилга угсралтын ажил зогсоох акт 2, илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага 16, дүгнэлт 4, зөвлөмж 25 гаргаж хэрэгжилтийг хангуулан ажилласан.</p> <p>2025 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр сумын 2 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байр, 7 дугаар сургуулийн байр, 16 дугаар цэцэрлэгийн байр, 17 дугаар цэцэрлэгийн байр, 18 дугаар цэцэрлэгийн байрны барилгын ашиглалтын төлөв байдалд дүгнэлт гаргуулах, паспортжуулах зөвлөх үйлчилгээний гэрээг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн барилгын материалын судалгааны төвтэй байгуулсан. Тус ажлын хүрээнд 2 сургууль, 3 цэцэрлэгийн барилга байгууламжид ашиглалтын төлөв байдлыг тогтоох паспортжуулах ажлыг хийлгэсэн. Мөн түүнчлэн 26-р цэцэрлэгийн барилгын шал болон хананд суулт үүссэнийг улсын байцаагчийн дүгнэлтийн дагууд болзошгүй аваарын зардлаар 186.7 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж хүчитгэх ажлыг хийж гүйцэтгэн хэвийн</p>	70

											ажиллагаанд оруулсан. Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комисс ажилласан.	
153	8.3.7.Хотын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, боловсруулах, устгах ажиллагааны менежментийг сайжруулж, хувийн оролцоог хангана.	2020-2025	ХБТХОХ, ХЗА, ХТГ	-	-	-	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны менежментийг сайжруулна.	-	Орон нутгийн төсөв 4550.0	2021-2022 онд иргэдийн бүлэг дахин ашиглагдах боломжтой 8 нэр төрлийн 32 тонн дахивар хог хаягдлыг Улаанбаатар хотод эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудад, "Бүрэн-Өндөр Энержи" ХХК дахин боловсруулах боломжтой хог хаягдал 155 тонныг цуглуулан боловсруулах үйлдвэрт тус тус нийлүүлсэн. Иргэн Батзаяа 75тонн шил цуглуулан эдийн засгийн эргэлтэд оруулж, "Ногоон Ариусал" ХХК нь эмнэлгийн болон 13 байгууллагын 985 кг хог хаягдлыг шатааж устгасан. 2023 онд Эрдэнэт хотын эргэн тойронд, Булган аймгийн хил залгаа сумдын хилийн бүс нутгаар хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг ХХҮГ-тай хамтран 20 иргэнийг түр ажлын байраар ханган зохион байгуулж, нийт 55 цэгийн 840м.куб хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, дарж, устгууллаа. Орхон аймгийн хэмжээнд нийт 25 цэг байршилд 162 гаруй малын гаралтай хог хаягдал, сэг зэмийн байршлыг тогтоож, цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. "Орхон АЗЗА" ТӨХК-ийн Дархан-Эрдэнэт чиглэлийн А1001 дугаартай 108км, Эрдэнэт-Булган чиглэлийн А1002 дугаартай 29.7км авто замууд, Эрдэнэт Төмөр замын хариуцсан замын дагуух 2 талын 50м хүртэлх газрын 2тн хог хаягдлыг цэвэрлүүлж, бохирдлыг бууруулж ажилласан. Булган аймгийн Бугат сумын нутаг, Овоот хөтлийн баруун талд "Жавхлант харгуй" ХХК, "Өлзий хутгийн наран" ХХК-уудын гаргасан карьерын орчинд хуримтлагдсан их хэмжээний хог хаягдлыг түрүүлж, орчны тархсан 320м.куб хог хаягдлыг цэвэрлүүлээ. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 24 цех нэгжийн нийт 242 албан хаагчид Хангал голын голдирол дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, 28тн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн нэгдсэн цэгт буулгалаа. Хог хаягдлын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх хүрээнд н.Хоролсүрэн ахлагчтай иргэдийн бүлэг аймгийн хэмжээнд 150тн дахивар хог хаягдлыг төвлөрүүлж, Улаанбаатар хот руу тээвэрлэж, хог хаягдлыг дахин боловсруулдаг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэн ажиллаж байна. "Зэс эрдэнийн хувь" ХХК 5000 ширхэг шилэн савыг Витафит группэд буцаан тушаасан. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, "Бөмбөрцөгийн сүмбэ" ТББ-тай хамтран "Аюулыг авдарлая I, II" болзолт уралдааныг аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж, нийт 595.5 кг гар утасны хаягдал, бүх төрлийн хаягдал зай хураагуурыг төвлөрүүлээ. Хог татан авалтыг орон сууцны хорооллоос 116 цэгээс, гэр хорооллын 17000 айл өрхөөс хог татан авч байна. Хот тохижуулах газарт хог тээвэрт 14 машин механизм, 62 ажилтан ажилладаг. Нэгдсэн хог хаягдлын цэгт 115843м3 хог хаягдлыг тээвэрлэн хүргэж, дарж устгасан. Баян-Өндөр сумын 9 багт 14 иргэн, аж ахуй нэгж хуванцар, гялгар, шил, хөнгөн цагаан, төмөр, цаас зэрэг 7 төрлийн 385 тонн хог хаягдал цуглуулан, эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. 2024 онд аймгийн хэмжээнд зориулалтын бус газарт хуримтлагдсан хог хаягдлын судалгааны ажлыг зохион байгуулж, нийт 46 цэгт хуримтлагдсан 667м.куб хог хаягдлыг, цэвэрлэж, хог хаягдлын төвлөрсөн цэгт дарж, устгууллаа. Мөн Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд тус бүр 2 удаа цэвэрлэгээ зохион байгуулж, нийтийн эзэмшлийн 127 цэгийн 101540 м.кв талбайг	100	

хамруулж 360 м.куб хог хаягдлыг ачиж, тээвэрлэн бохирдлыг буурууллаа.

Орхон аймгийн хэмжээнд нийт 25 цэг байршилд 162 гаруй малын гаралтай хог хаягдал, сэг зэмийн байршлыг тогтоож, цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Орхон АЗЗА ТӨХК-ийн Дархан-Эрдэнэт чиглэлийн А1001 дугаартай 108 км, Эрдэнэт-Булган чиглэлийн А1002 дугаартай 29.7 км авто замууд, Эрдэнэт Төмөр замын хариуцсан замын дагуух 2 талын 50м хүртэлх газрын 2тн хог хаягдлыг цэвэрлүүлж, бохирдлыг бууруулж ажиллалаа. Булган аймгийн Бугат сумын нутаг, Овоот хөтлийн баруун талд Жавхлант харгуй ХХК, Өлзий хутгийн наран ХХК-уудын гаргасан карьерын орчинд хуримтлагдсан их хэмжээний хог хаягдлыг түрүүлж, орчны тархсан 320 м.куб хог хаягдлыг цэвэрлүүлжээ.

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 24 цех нэгжийн нийт 242 албан хаагчид Хангал голын голдирол дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, 28 тн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн нэгдсэн цэгт буулгалаа.

Баян-өндөр сумын 8 багуудад 13 иргэн, ААНБ дахивар хог хаягдал буюу гялгар уут, шил, лааз, хуванцар сав, хөнгөн цагаан, зэс, гууль зэрэг 8-н нэр төрлийн 117тн хог хаягдал, 1523 тн төмрийн хаягдлыг цуглуулан төвлөрүүлж Улаанбаатар, Дархан хотруу тээвэрлэн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Бөмбөрцөгийн сүмбэ ТББ-тай хамтран "Аюулыг авдарлая I, II" болзолт уралдааныг аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж, нийт 595.5 кг гар утасны хаягдал, бүх төрлийн хаягдал зай хураагуурыг төвлөрүүлжээ.

Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийн хүрээнд хог хаягдлыг татан зайлуулах 12 ширхэг машин механизмыг Хот тохижуулах газар хүлээлгэн өгсөн.

Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 2.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хот тохижуулах газрын парк шинэчлэлтийг хийж байна. Үүнд: Хог хаягдал ачиж тээвэрлэх 45 ширхэг хөдөлгөөнт чингэлэг, 7 ширхэг автомашиныг хүлээлгэн өгсөн. 2024 онд орон нутгийн төсвийн 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хог хаягдал ачиж тээвэрлэх ковш, бульдозер, грейдер, индүү тус бүр 1ш, зам цэвэрлэгээний машин 3ш авсан. 2025 онд сумын хөрөнгө оруулалтаар Хот тохижуулах газарт хог ачих машин 2 ширхэг, төмөр чингэлэг 40 ширхэг, хуванцар хогийн сав 200 ширхэг, гурван дугуйт тэрэг 5 ширхгийг нийлүүлсэн. Үүний үр дүнд гэр хорооллын айл өрхүүдээс хог хаягдал тээвэрлэх давтамж нэмэгдэж, хогийн бөөгнөрөл үүсэх асуудал шийдэгдсэн байна. Тухайлбал Хүрэнбулаг баг 11а, в хэсэг, Чандмань баг эко хороолол, Баянцагаан багийн цагаан байр буюу оношилгооны арын байр, Говил багийн ар булаг, дэнж баг элит хотхон, Хүрэнбулаг баг баян-өндөр мед эмнэлэг байршлуудад өдөр бүр хөдөлгөөнт чингэлэг шинээр байршуулан айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэж байна.

Парк шинэчлэлтийг хийснээр Хот тохижуулах газарт 49 машин механизм, 110 хөдөлгөөнт чингэлэгтэй болж, 2024 онд гэр хорооллын хог хаягдлыг 8-9 удаа ачиж тээвэрлээд байна. Хот тохижуулах газрын парк шинэчлэл 90 хувьд хүрсэн байна.

									Орхон аймгийн Хог хаягдлын тээвэрлэлт, үйлчилгээний хураамжийн хэмжээг Баян-Өндөр сумын 2022 оны ИТХ-ын тогтоолоор батлан мөрдлөг болгон ажиллаж, орлогыг аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэн Баян-Өндөр сумаас гүйцэтгэл, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж байна. 2025 онд хог хаягдлын тээвэрлэлт, үйлчилгээний хураамжаар 1740.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, ХТГ-ын үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 10.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож ажиллалаа. Иргэдийн буруутай үйлдлээс болж ил задгай хог хаягдал ихээр үүсэж, орчны бохирдол бий болж байгаа 5 байршилд камеруудыг шилжүүлэн байршуулж холбогдох арга хэмжээг авч ажилласнаар эзэнгүй, ил задгай хог хаягдал үүсэх байдал эрс багасаад байна. 2025 онд нийт 225010м3 хогийг тээвэрлэн дарж устгасан. Цаашид ХТГ-ын парк шинэчлэлт хийгдэж хүчин чадал нэмэгдсэнтэй холбогдуулан Хот тохижуулах газрын зарим үйл ажиллагааг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх, хувийн хэвшлээр зарим ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх талаар судалгаа хийгдэж байна. Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" НҮТББ-тай 3 хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" НҮТББ-тай 3 хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Аймгийн хэмжээнд 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 8 нэр төрлийн 447 тн хог хаягдлыг цуглуулан төвлөрүүлж Улаанбаатар хот руу тээвэрлэн үйлдвэрүүдэд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан. Мөн 10 үйлдвэр, ААНБ-ын 573.291 тн аюултай хог хаягдал, 533ш ашиглалтаас гарсан дугуй, ерөнхий боловсролын 10 сургуульд хадгалагдаж байсан 264.7 кг устгах шаардлагатай химийн бодисыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлэн өгч устгууллаа.		
154	8.3.8.Зуслан болон амралт, зугаалгын бүсүүдэд явган хүний болон унадаг дугуйн дэд бүтцийг байгуулна.	2020-2025	ХБТХОХ	Орон нутгийн төсөв	2700.0	-	Явган болон унадаг дугуйн замын талбайн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	2700.0	Орон нутгийн төсөв 3868.7	2021-2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 26264м2 явган хүний замыг стандарт шаардлагын дагуу барьж байгуулсан байна. 2024 онд MNS 5682:2006 "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам", техникийн шаардлага, стандартын хүрээнд нийцүүлэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 багийн 12 байршилд 5087м 2 явган хүний авто замыг бүрэн шинэчлэн ажилласан байна. Үүнээс: 2-р хорооллын 2-1а, 2-1б байрны орчим 654м2, 4-р хорооллын 26.27-р байрны орчимд 480м2, 1-5, 6 дугаар байрны орчимд 940.6м2, 3-8, 16, 19 дүгээр байрны гаднах явган хүний 2078м2, 10-р цэцэрлэгийн баруун, зүүн хэсгийн явган шат болон Гендрекцийн зүүн талын 32м2 явган шатны засвар, 5-13,14,15 дугаар байрнуудын орчинд 856м2 явган хүний зам, Их залуу багийн 14-р гудамжны нарийн зөрөгт 336м2 явган хүний зам, Булаг багийн 9, 25 дугаар гудамжинд 70м2 явган хүний зам, Зүүн Дэнжийн 3-р гудамжнаас 14-р сургууль руу уруудсан хэсэгт 152м2 явган хүний зам, Согоот багт амралт чөлөөт цагийн талбай тохижуулах, сэргээн засварлах ажилд 480м2 явган хүний зам, 5-р хорооллын байрнуудын дунд 689м2 явган хүний зам шинээр хийх, Хүрэнбулаг багийн нийтийн эзэмшлийн 329м2 явган хүний замын ажлуудыг хийж тус тус ашиглалтад оруулан явган болон унадаг дугуйн зам, талбайн	100

										<p>хэмжээг нэмэгдүүлээд байна.</p> <p>2025 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх авто замын ажлын зурагт тусгагдсан дугуйн замыг барьж байгуулах ажлын хүрээнд 9 багт /Баянбулаг, Говил, Рашаант, Их залуу, Яргуйт, Дэнж, Наран, Эрдэнэ, Цагаанчулуут/ багт 9,33км буюу 13996.2м2 дугуйн зам барихаар төлөвлөснөөс 8,7км буюу 13157м2 дугуйн замын ажлыг гүйцэтгэн ашиглалтад орууллаа. Мөн орон сууцны хорооллыг тойрсон 4.9 км урт дугуйн зам хийх ажлын 3.6 км дугуйн замыг 2023 онд Хөх тавилан ХХК хийж гүйцэтгэсэн бол 2025 онд тус ажлын үлдэгдэл ажил болох 1.5 м өргөн, 1.3 км урттай, 5 см асфальт бетон хучилт, резин будагтай, тэмдэглэгээ бүхий дугуйн замыг “Эрхэм нөхөр” ХХК нь гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Тус ажил хийгдсэнээр орон сууцны хорооллыг тойрсон 4.9 км дугуйн замын ажил бүрэн дууссан. Мөн стандартын шаардлагад нийцүүлэн 1.5-2 м өргөнтэй боржин чулуун болон өнгөт хавтан, асфальт бетон хучилт бүхий явган хүний замыг 15 багийг хамруулан 22 байршилд 49253м2 явган хүний замыг хийж ашиглалтад оруулсан байна. Үүнд: Оюут баг 267.5 м2, Говил баг 177.5 м2, Даваат баг 632.3 м2, Цагаанчулуут баг 1121 м2, Баянцагаан баг 2678.4 м2, Цагаанчулуут баг 720 м2, Баянбулаг баг 1538 м2, Яргуйт баг 162.2 м2, Уурхайчин баг 192.3 м2, Их залуу баг 288м2, Уртын гол багт 332,2 м2, Чингэл багт 352 м2, Рашаант багт 716 м2, Согоот багт 263 м2 явган хүний зам засварлах, Оюу цэцэрлэгийн гадна тохижилтын ажлын хүрээнд 790 м2, Хүрэнбулаг баг 4-22, 4-23-р байрнуудын гадна тохижилтын ажилд 381 м2, Соёл амралтын хүрээлэнд 5504 м2 явган хүний замыг тус тус хийгдэж ашиглалтад оруулсан байна.</p>	
155	8.3.9.Эрдэнэт хотод бүсчлэл тогтоож, иргэдийн амьдрах орчны стандартыг бүсчлэлд тулгуурласан байдлаар боловсруулж, хэрэгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ГХБХБГ	-	-	-	Бүсчлэлийг тодорхойлж, стандартад нийцүүлэн дэд бүтцийг хөгжүүлэх	-	-	<p>Хот, суурины нутаг дэвсгэрийг газар ашиглалтын нийтлэг хэлбэр болон онцлогоос хамааран газар ашиглалтын үүргийн бүсчлэл, бүсэд баримтлах бодлогыг тодорхойлж, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах нийтлэг зориулалтыг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 9 бүсчлэлээр тодорхойлж байна. Үүнд:</p> <p>1. Гэр хорооллын бүс /Тусдаа хашаатай дан байшин болон бусад барих газар, Үүнийг дагалдан сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, халуун ус, худаг усан сан, үйлчилгээний төв, түлээ нүүрс борлуулах цэг/</p> <p>2. Худалдаа үйлчилгээний бүс /Худалдааны төв, дэлгүүр, нийтийн хоол, хагас бэлэн бүтээгдэхүүн боловсруулах, савлах, худалдаалах газар, зочид буудал, хими цэвэрлэгээ, бөөний худалдааны төв, автомашины засвар үйлчилгээний газар, төвлөрсөн гарааш, шатахуун түгээх станц, халуун усны газар/</p> <p>3. Нийтийн орон сууцны бүс /Орон сууцны байшин, /Үйлчилгээтэй орон сууц/ Орон сууцны хороолол: -/сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үйлчилгээний төв, интернэтийн төв, цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолбор/ Орон сууцны хотхон: -/цэцэрлэгт талбай, хүүхдийн тоглоомын талбай, спорт цогцолбор, үйлчилгээний төв/</p> <p>4. Амины орон сууцны бүс /1-2 давхар эзэмшил газаргүй амины сууц, 2-3 давхар эзэмшил газартай амины сууц/</p> <p>5. Засаг, захиргаа нийгмийн үйлчилгээний бүс /ЗДТГ-ын байр, залуучуудын соёл амралтын зориулалтаар кинотеатр, мэдээллийн төв, номын сан, хүүхэд залуучуудын ордон, шинжлэх ухаан мэдээллийн төв, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр, банк санхүү болон томоохон зочид буудал, бизнес</p>	100

										<p>төв, аялал жуулчлалын төв/ 6. Зуслангийн бүс /Эзэмшил газартай амины орон сууц, дэлгүүр үйлчилгээний төв/ 7. Аялал жуулчлал, амралт зугаалгын бүс /Хотын чанартай цэцэрлэгт хүрээлэн, тусгай зориулалтын цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамж, цэцэрлэгт талбай/, Спортын ордон, хөл бөмбөг, мөсөн гулгуур, гольф, газрын теннисний талбай, сур байт харвааны саравч талбай, жуулчны бааз, том хүн болон хүүхдийн амралтын газар, эмчилгээ сувиллын газар/ 8. Тусгай зориулалтын агуулахын бүс /Усны нөөцийн агуулах, шатах дэлбэрэх материал агуулах, хүчтэй хорт бодисуудын суурь агуулах, хүнсний бүтээгдэхүүний суурь агуулах, бордоо ба үйлдвэрийн түүхий эд болон барилгын материалын агуулах/ 9. Үйлдвэрийн бүс /Дулааны цахилгаан станц, тоосгоны үйлдвэр, хог дахин боловсруулах үйлдвэр, арьс ширний боловсруулах үйлдвэр, ноос ноолуур боловсруулах үйлдвэр, сав баглаа боодлын үйлдвэр/ Бүсчлэлд тулгуурлан стандартад нийцүүлж, иргэдийн тав тухыг хангасан дэд бүтцийг үе шаттай хөгжүүлж байна. Мөн аймгийн ИТХ-ын 2022 оны 08/03 дугаар тогтоолоор Эрдэнэ, Яргуйт, Цагаанчулуут багуудыг бүсчлэн хувааж хүн ам, өрхийн тоо, газар зүйн байршлыг харгалзан шинээр Чингэл баг, Баян-Овоот баг, Найрамдал, Чандмань 4 багийг шинээр байгуулсан. Багуудын ажлын албыг байгуулж, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Тогтвортой аялал жуулчлал

Зорилт 8.4. Аялал жуулчлалын маркетинг болон менежментийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээний соёл, чанар, стандартыг сайжруулж, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, байгаль орчинд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ:

156	8.4.1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ажиллагсдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, үйлчилгээний соёлыг сайжруулах, улмаар стандартын өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах ажлыг эрчимжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, СХЗХ	-	-	Зэрэглэлтэй Зочид буудал-3 жуулчны баазын тоо-1	Шаардлага хангасан байгууллагын тоо 2	-	-	<p>Аймгийн хэмжээнд 532 ор бүхий 26 зочид буудал, 10 дэн буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 одны зэрэглэлтэй 2 зочид буудал, 1 одны зэрэглэлтэй 1 зочид буудал, 2 цэцгийн зэрэглэлтэй 1 амралтын бааз үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд шинээр 2022-2024 онд Соррег, Ланд марк зочид буудал шинээр ашиглалтад орж зэрэглэлийн стандартыг хангаж байгаа тул зэрэглэл авахаар хүсэлтээ хүргүүлсэн боловч Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журам засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаатай холбогдуулан түр хүлээгдээд байна. 2025 онд Дорнын чимэг ХХК-ийн Эрхт-888 зочид буудал ашиглалтад орсон байна. Зочид буудлын үйлчилгээ эрхлэгч 9 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 7 буудал, 3 дэн буудалд тохирлын үнэлгээ хийж, стандартын зарим шаардлагыг хангуулан залруулга хийлгэснээр зочид буудлын стандартын хэрэгжилт дунджаар 88.2 хувьд хүрсэн. Мөн “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын зочид буудлын стандартын хэрэгжилт 91-ээс дээш хувьд хүрч “Баталгаажсан үйлчилгээ” тэмдэг хэрэглэх эрхтэй болсон.</p> <p>"Зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудыг чадавхжуулах" сургалтыг МУИС-ийн багш нар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран тай хамтран салбарын ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зочлох үйлчилгээний салбарын ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний соёл, найрсаг харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалтуудыг жил бүр зохион</p>	100
-----	---	-----------	--------------	---	---	---	---------------------------------------	---	---	---	-----

										байгуулан ажиллаж 2023 онд 73, 2024 онд 84, 2025 онд 100 гаруй хүнийг хамруулж гэрчилгээ олгосон. "Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага" MNS 5927:2008 стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж буй томоохон зочид буудлуудад орон нутагт зохион байгуулагдсан арга хэмжээний оролцогчид, зочдыг тогтмол байрлуулж хамтран ажиллалаа.	
157	8.4.2.Монгол ёс заншлын өргөө, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн, Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн аялалын шинэ бүтээгдэхүүн гаргах, эвент арга хэмжээг зохион байгуулна.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, "Эрдэнэт ТӨҮГ	709.0	-	Жил бүр 2 эвент арга хэмжээг зохион байгуулна.	709.0	Улсын төсөв 100.0 "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хамтын ажиллагааны 574.0 Орон нутгийн төсөв /зэс фестивал ы/ 155.0	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн амралтын бүсэд Монгол хоолны газар, Бага насны хүүхдүүдийг саатуулах хэсэг, Элсэн дээр тоглох талбай, хүрээлэнгийн план зураг, самбар, 12 цэгт 48ш зүг чиг, таних тэмдэг хийж гүйцэтгүүлэн байршуулсан. Ёс заншлын өргөөг түшиглэн ЕБС-ын сурагчдыг хамруулан Монгол ахуй, соёл, түүх, Монгол хүний амьдралын мөн чанарыг хүүхэд багачуудад танин мэдүүлж, ойлгуулах зорилгоор "Хөдөлмөр" зуслан ажиллуулж байна. "Хөх Монгол цогцолбор" байгууламжийг амралт чөлөөт цагийн талбай болгох гадна тохижилтыг засварлах ажлын зургийг боловсруулан батлуулж гаднах тохижилт хийгдэж байна. БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын отоглох цэгүүдэд аялагч, түр амрагч нарт зориулсан MNS5924:2015 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, хогийн цэг байгуулж, тухайн орон нутгийн хөрс, гүний усны бохирдол, хог хаягдлыг бууруулж, аялагч, амрагчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор улсын хэмжээнд 6 байршилд нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг "Дархан нэгдэл" ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд аялал жуулчлалын түр буудаллах цэг /Эрдэнэт хаалга орчимд/-ийн нийтийн ариун цэврийн байгууламжид зориулсан гүний худаг шинээр гаргах байршлыг мэргэжлийн байгууллагатай хамтран тодорхойлсон ба нарны гэрлээр цэнэглэгддэг шон, ангилдаг хогийн сав бүхий 3.5х7м урттай эко ариун цэврийн байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн ашиглалтад орууллаа. Их шүтээн цогцолборт иргэдийн хандив тусламжаар 2021 оноос хойш нийт 4 ш суваргыг сүсэгтэн олон, иргэдийн хандив, тусламжаар барьж ашиглалтад оруулсан. Мөн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н зураг, төсвийн дагуу Их шүтээн цогцолборт 2023 онд авто замын зогсоол, 108 шатыг шинэчлэх, гэрэлтүүлэг бүхий ажлыг нийт 524.0 сая төгрөгөөр Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Монголын бүх ард түмний өвлийн спортын 16 дугаар наадам, Монголын хүүхдийн спортын 7 дугаар наадам Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт уриан дор зохион байгуулагдсан ба 12 аймаг нийслэлийн 7 дүүргийн 722 тамирчдыг оролцуулсан тэмцээнд оролцогчдыг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудлуудад байрлуулж, нэгдсэн хоол ундаагаар үйлчлэх, Эрдэнэт хотыг танилцуулах "City tour" аялал, 3 цэгт худалдаа үйлчилгээ, Эрдэнэтийн гар урлал бэлэг дурсгалын бүтээгдэхүүн худалдаалах цэгүүдийг тус тус ажиллуулж бүх нийтэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн худалдаа үйлчилгээний байгууллагуудыг уртасгасан цагаар ажиллуулах шийдвэрийг гаргуулан аймгийн ахуйн үйлчилгээний газрууд, зочид буудал, ресторана зоогийн газрууд, хүргэлтийн үйлчилгээний мэдээллээр ханган тамирчид байрласан нийт 20 орчим цэгт хүргэлтийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгууллаа. Казак түмний үндэсний баяр болох Наурызын баярыг тохиолдуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг	100

										<p>хөгжүүлэх зорилгоор Бүргэдийн баяр-2023 эвент арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд 12 бүргэдийн Баян-Өлгий аймгаас хүрэлцэн ирж Орхон аймагт анх удаа хамтарсан арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд 8000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид орлого олох боломжийг бүрдүүлэн ажилласан. 2025 онд Баян-Өндөр сумын ИТХ-ын "Суралцагч хот" хөтөлбөрийн хүрээнд "Erdenet food festival" арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Орхон аймгийн тогоочдын холбоотой хамтран "Эрдэнэт цэнгэлдэх хүрээлэн"-д 2 өдрийн турш амжилттай зохион байгуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласны хүрээнд Орхон аймаг, Эрдэнэт хотын онцлогийг таниулах, бүс орон нутгийн онцлогт тулгуурласан эвентийг бий болгох аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн соёл, урлаг, өв уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор "ЗЭС ФЕСТИВАЛЬ" арга хэмжээг 5 уул уурхайн байгууллагууд болон ААНБ-тайгаа хамтран 2023, 2024, 2025 онуудад зохион байгуулан ажиллаж байна. Тус арга хэмжээгээр уул уурхайн 5 үйлдвэрээ сурталчлах, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний худалдаа, зэс, зэсэн эдлэлийн гэр музейн үзэсгэлэн, байгальд ээлтэй цахилгаан машины үзэсгэлэнг зохион байгуулж, 18 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцсон. Үзэсгэлэн худалдаанд нийт 200 гаруй нэр төрлийн зэсэн бүтээгдэхүүн дэлгэгдэж 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулагдаж 300,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. 2025 онд Уул уурхай түшиглэсэн аялал жуулчлал, Эрүүл мэндийн аялал жуулчлал, орон нутгийн онцлогт түшиглэсэн аялал жуулчлал, дотоодын хурал, зөвлөгөөн, спортын уралдаан тэмцээн, эвэнт арга хэмжээнүүдийг зохион байгуулж 41063 жуулчин ирсэн.</p>	
158	8.4.3.Аялал жуулчлалын мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд мэдээллийн төв, цэгийг байгуулах, цахимжуулах ажлыг эрчимжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	Орон нутгийн төсөв	18.0	-	Цахимжуулах ажлыг эрчимжүүлж, аялал жуулчлалын мэдээллийн хүртээмжийг сайжруулах	18.0	Орон нутгийн төсөв 18.0	<p>Аймгийн зочид буудал, амралт сувиллын газар, ресторан зоогийн газар, үзвэр үйлчилгээ, тээврийн хэрэгслийн мэдээлэл, маршрут, түүх дурсгал зэрэг мэдээллийг багтаасан аялал жуулчлалын мэдээ, мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлэн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар пэйж хуудсаар дамжуулан Welcome to erdenet видео контент болон аялал жуулчлалын цаг үеийн мэдээ, мэдээлэл, зохион байгуулсан ажлыг 2021-2024 онд 28500 иргэнд хүргэн ажилласан. Смарт Эрдэнэт апплейкешнд Орхон аймаг, Эрдэнэт хотын аяллын талаарх зочид буудал, ресторан, музей, үзвэр үйлчилгээ, аялал жуулчлалын маршрут, кофе шопын мэдээ мэдээллийг байршуулсан Монголд зочлох жилийн хүрээнд БОАЖЯ, Аялал жуулчлалын хөгжлийн төвтэй хамтран QR хэлбэртэй мэдээллийг зам дагуух 3 самбарт байршуулан бүх нийтэд мэдээллийг тогтмол хүргэн ажилласан. Монголын аялал жуулчлалын холбооноос жил бүр зохион байгуулагддаг олон улсын "Ай-Ти-Эм -Mongolia" аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр оролцон аймгийн танилцуулга мэдээлэл, видео бичлэгийг цахимаар хүргэх ажлыг киоск, VR төхөөрөмжийн тусламжтайгаар 3 өдрийн турш 6500 иргэнд хүргэн ажиллаж байна.</p> <p>2025 онд аймгийн аялал жуулчлалын веб сайтын төсөв батлагдаагүй бөгөөд СУАЖЗГ-ын цахим хуудсаар дамжуулан 5000 иргэд, жуулчдад мэдээлэл хүргэсэн</p>	100
159	8.4.4.Орон нутгийн онцлогийг харуулсан гар урлал, бэлэг	2020-2025	ХБТХОХ, БОАЖГ	-	-	5 брэнд бүтээгдэхүүн	Гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн	-	Орон нутгийн төсөв 30.0	<p>2022 онд Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих PROGRES төсөлтэй хамтран зохион байгуулсан аймгийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт дэд төслийн уралдаанаас гар урлал, бэлэг дурсгалын 2 бүтээгдэхүүн шалгаруулж, үйлдвэрлэгч нарт</p>	100

	дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, иргэд аялал жуулчлалын салбараас орлого олох боломжийг бүрдүүлнэ.						үйлдвэрлэлийг дэмжиж, аялал жуулчлалын салбараас орлого олох боломжийг бүрдүүлсэн байна.			<p>тоног төхөөрөмж шинэчлэх дэмжлэг үзүүлсэн. 2023 онд Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт уриа дор зохион байгуулагдсан Бүх ард түмний спортын өвлийн наадмын хүрээнд 12 аймаг нийслэлийн 7 дүүргийн 722 тамирчдыг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулж Эрдэнэтийн ээжүүд групптэй хамтран тэмцээний гарын бэлгийг наадмын бэлэг тэмдэг болох арслан, гүегээр хийлгүүлж тамирчдад гардуулан өгснөөр аймгийн шинэ бэлэг дурсгалын гарын бэлэгтэй болсон.</p> <p>Мөн Казак түмний үндэсний баяр болох Наурызын баярыг тохиолдуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Бүргэдийн баяр-2023 эвент арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 6 ААНБ худалдаа, хоол үйлчилгээ үзүүлэн 8 сая төгрөг, зочид буудлын үйлчилгээнд 1.2 сая төгрөг нийтдээ 9.2 сая төгрөг, 2023 онд Зэс фестиваль арга хэмжээний хүрээнд хоол үйлдвэрлэл, зэс бүтээгдэхүүний худалдаанаас 23 сая төгрөгийн борлуулалт хийсэн. "ITM Mongolia-2023" арга хэмжээнд орон нутгийн брэнд Арьсан эдлэл-өндөрлөг брэнд, гар урлал-сампин брэнд бүтээгдэхүүнийг оролцуулан худалдан борлуулах боломжоор хангасан. Мөн Эрдмин ХХК-ний 2023 оны шинэ загвар олон үйлдэлт залгуурт аймгийн брэнд бүтээгдэхүүний логог олголоо.</p> <p>"ITM Mongolia-2024" арга хэмжээнд 8 аж ахуй нэгж оролцож, 51 нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулж 20.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн. Хүн төрөлхтний хосгүй гайхамшигт нүүдэлчин өв, соёлыг нэг дор цогцлоосон "Нүүдэлчин" дэлхийн фестивальд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 5 иргэнийг оролцуулж, бүтээгдэхүүний борлуулалтаасаа 13.0 сая төгрөгийн орлого олсон. 2025 онд "ЗЭС ФЕСТИВАЛЬ" арга хэмжээнд хоёр өдрийн турш зохион байгуулж уул уурхайн үйлдвэрүүдээ сурталчлах, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний худалдаа, зэс, зэсэн эдлэлийн гэр музейн үзэсгэлэн, байгальд ээлтэй цахилгаан машины үзэсгэлэнд 18 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцсон. Үзэсгэлэн худалдаанд нийт 200 гаруй нэр төрлийн зэсэн бүтээгдэхүүн дэлгэгдэж 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулж 300,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p> <p>"ITM MONGOLIA-2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн "ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ – ТӨВ АЗИ" уриа дор 26 дахь жилдээ 2025 оны 10 дугаар сарын 24, 25, 26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Тус үзэсгэлэнд 21 аймаг, төр хувийн хэвшил, бизнес эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэгч, зочлох, угтах, үдэх зэрэг аялал жуулчлалын бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэгч нар оролцдог. Манай аймгаас Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолбор, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын "Сэлэнгэ амралт" аялал жуулчлалын цогцолбор, "Баян цон лха" ХХК "Зэс-Агула" амралтын газар "Аянхөндий" ХХК "Танан" дэн буудал, "Дорнын чимэг" ХХК "Эрхт 888" зочид буудал, ВЭНС" ХХК "Эрдэнэт ИНН" зочид буудал, "Цултаргана" ХХК "Хуримт" зочид буудал, "Түмэн сүлжээ" ХХК ноос ноолууран эдлэл, "Ширмэг цүнх" ХХК Арьс ширэн эдлэлийн хамт олон оролцож өөрсдийн үйлчилгээ, үйл ажиллагаа, бүтээл, орон нутгаа сурталчилж 3.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p>	
Өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй											
Зорилт 8.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:											
160	8.5.1.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний	2020-2025	ХБТХОХ, ХХААГ	Орон нутгийн	75.0	Хэрэгжилтийн хувь 30%	Хэрэгжилтийн хувь 100%	75.0	Орон нутгийн	2022 оны хүн амын физиологийн хэрэгцээг тооцоход малын махны 92.7 хувь, гурилан бүтээгдэхүүний 34.5 хувь, жимс, жимсгэнийн 0.3, төмсний 86.5 хувь, хүнсний ногооны 72 хувь, өндөгний 2.3	90

	хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.			төсөв					төсөв 88.9	хувийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангасан бол шингэн сүүний 2.7 хувь, цагаан идээний 5.4 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангасан. 2024 оны байдлаар хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нийт 55 үйлдвэрийн 19 нь буюу 34.5 хувь нь баталгаажуулалтад хамрагдаж 22 нэр төрлийн 238 нэрийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийн тохирлын гэрчилгээ олгож тендерт өрсөлдөх, үйлдвэрлэлээ өргөтгөж зээлд хамрагдахад нь дэмжлэг үзүүлсэн. Үүнээс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулж байгаа 18 үйлдвэрээс 15 нь буюу 83.3 хувь баталгаажилтад хамрагдаж 20 нэр төрлийн 219 нэрийн бүтээгдэхүүн тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж, нийт үйлдвэрлэл эрхлэгчдийн /27/ 49.1 хувь нь баталгаажсан. 2024 онд 26 үйлдвэр 20.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 24.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийж, аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 51.7 хувь, сүүний 8.0 хувь, цагаан идээний 7.7 хувь, гурилын 4.0 хувь, гурилан бүтээгдэхүүний 56.0 хувь, төмсний 48.0 хувь, хүнсний ногооны 100 хувь, өндөгний 1.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангасан. 2025 онд аймгийн хэмжээнд хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 85 үйлдвэр, цех үйл ажиллагаа тогтвортой явуулж, 41.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 45.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт махны 74.2 хувь, сүүний 8.5 хувь, цагаан идээний 7.5 хувь, гурилын 3.7 хувь, гурилан бүтээгдэхүүний 59.3 хувь, төмсний 52.1 хувь, хүнсний ногооны 100 хувь, өндөгний 8.3 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.	
161	8.5.2.Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.	2020-2025	ХБТХОХ, ХХААГ	Орон нутгийн төсөв	2.8	Талбайн ашиглалтын хувь 70	Талбайн ашиглалтын хувь 100	2.8	Орон нутгийн төсөв 177.7	2022 онд аймгийн хүн амын хэрэгцээт төмсний 86 хувь, хүнсний ногооны 72 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан. 2023 онд 12 аж ахуйн нэгж, 563 өрх нийт 5584 га талбайд тариалалт хийж, ургацын мэдээгээр тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт үр тариа 100 хувь, төмс 43.3 хувь, хүнсний ногоо 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан. 2022 онд Техник дундын төв нь нийт 147 иргэний 196.5 га талбайд 5 төрлийн үйлчилгээ үзүүлсэн. 2023 онд Техник дундын үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн төсвийн 177.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж худалдан авч 10 төрлийн ажил үйлчилгээг давхардсан тоогоор 257 иргэнд үзүүлсэн нь 2022 оны мөн үеэс 70.0 хувиар өссөн. 2024 онд Агропаркийг түшиглэн Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорийг ашиглалтад оруулсан. Агропаркийн техник дундын төв нь нийт 6 зүтгэх хүчний трактор, 12 төрлийн тоног төхөөрөмжтэй үйл ажиллагаа явуулж, хаврын тариалалтад 251 иргэний 189 га талбайд 6 төрлийн үйлчилгээ, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд иргэдийн захиалгаар өвс хадах, тармах, хаман боох, төмс хураахад давхардсан тоогоор 343 иргэний 335.3 га талбайд 4 төрлийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд дундын төвийн үйл ажиллагаа жигдэрсэн. Мөн аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд "Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем"-ийг ашиглах, мэдлэг олгох сургалт, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн "Бүсийн тариаланчдын зөвлөгөөн", Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн багц сургалтуудын хөтөлбөрт "Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх" тухай	100

										<p>арга хэмжээний талаар сурталчлан таниулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд Баян-Өндөр сумын 2 тариаланч трактор, тоног төхөөрөмж худалдан авч plant.mofa.gov.mn цахим системээр илгээснээр 97.0 сая төгрөгийн буцаан олголт авсан байна. 2025 онд аймгийн хэмжээнд газар тариалангийн салбарт 13 аж ахуйн нэгж, 272 өрх үйл ажиллагаа явуулж 5691 га талбайд тариалалт хийж, ургац хураалтыг 100 хувь гүйцэтгэсэн. 2025 оны ургацаар тооцоход аймгийн хүн амын хэрэгцээт улаан буудай 100 хувь, хүнсний ногоо 100 хувь, төмс 52 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж, төмсний хангамж 11.5 хувиар нэмэгдсэн. Тариалангийн эргэлтийн талбайн ашиглалт 100 хувь байна.</p>	
	8.5.3.Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.	2020-2025	ХБТХОХ, ХХААГ	Орон нутгийн төсөв	6.0	17.3	20	6.0	Орон нутгийн төсөв 12.5	<p>2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бог малын чанарыг сайжруулж, цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор "Манхан чүг" мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжид 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, мах, ноосны чиглэлийн Барга үүлдрийн хуц 60 толгой, ноолуурын чиглэлийн Эрчмийн хар үүлдрийн ухна 40, нийт 100 толгой хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьж, 2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын 70 малчинтай түрээсийн гэрээ байгуулан олгосон.</p> <p>2023 онд Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад 4 иргэн хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн. Мөн "Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн"-д махны үхрийн аж ахуй эрхэлдэг, эрхлэх сонирхолтой 9 иргэн, аж ахуйн нэгж, "Төв түмний сүүн соёл -2023" арга хэмжээнд сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 5 иргэн, мах-ноосны чиглэлийн Суффолк үүлдрийн хонины аж ахуйтай танилцах аялалд 9 иргэн, нийт 23 иргэн, аж ахуйн нэгжийг тус тус хамруулан туршлага судлуулсан. "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран "Сүүний технологи, эрүүл ахуйн зохистой дадал" сэдэвт сургалтыг зохион байгуулж эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгж оролцуулсан.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 2 удаагийн сургалт зохион байгуулж 66 хүн хамруулан өндөр ашиг шимт малыг төрөлжүүлэн, өсгөн үржүүлэх болон мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, олон наст тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн түүхий эдээр дарш бэлтгэх арга технологи эзэмшсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол үүлдрийн хуц 40 толгой өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавьж "Шилмэл мал-2024" үзэсгэлэн худалдаанд манай аймгаас 4 эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч оролцож туршлага судалсан.</p> <p>2025 оны байдлаар 101 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна. Үүнд: 23 иргэн мах-сүүний чиглэлийн 714 толгой үхэр, 7 иргэн махны чиглэлийн 421 толгой үхэр, 4 иргэн 130 толгой гахай, 55 иргэн 4344 толгой шувуу, 12 иргэн 242 бүл зөгийг тус тус өсгөн үржүүлж үйл ажиллагаагаа явуулж байна. Засгийн газрын 92 дугаар тогтоолоор баталсан төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журмын хүрээнд үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга, Дархад омгийн хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 174 малчин өрхийн 41200 толгой мал буюу 36.1 хувийг үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтад хамруулахад 8266 толгой буюу 20.1</p>	100

										хувь нь цөм сүрэг, 29954 толгой буюу 72.7 хувь нь үржлийн сүрэг, 2980 толгой буюу 7.2 хувь нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдэж, анги чанарыг тодорхойлсон.	
163	8.5.4.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, сайжруулахад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.	2020-2025	ХБТХОХ, ХХААГ	Орон нутгийн төсөв	8.0	2	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгож, дэмжлэг үзүүлсэн байна.	8.0	Орон нутгийн төсөв 8.0 Гадаад төсөл хөтөлбөр 7.0 Улсын төсөв 8.5	2021-2022 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 5 иргэн, аж ахуйн нэгжид 332.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2023 онд Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. "Хоршоо хөгжүүлэх сан"-аас мах, сүүний чиглэлийн үхэр сүргийн чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд 6 иргэнд 138.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. "Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо"-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан авахад орон нутгийн төсвөөс 8.0 сая, Прогресс төслөөс 7.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 10 га талбайд ногоон тэжээл тариалж 30 тн дарш, 2800 боодол ногоон тэжээл хураан авч өөрийн хэрэгцээнд ашигласан. 2024 онд "Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд "Хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын төсвийн 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр "Чиглэл" ХХК-д үйлдвэрлэгдсэн хүнсний зориулалтын савыг орон нутгийн сүү боловсруулах 2 үйлдвэр болон сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 16 малчин, фермерүүдэд олгож дэмжлэг үзүүлсэн. Баян-Өндөр сумын хоршоо хөгжүүлэх сангаас мал аж ахуйн чиглэлээр "Арга билиг арвин сүрэг" хоршоонд 100 сая төгрөгийн зээл олгосон. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас махны чиглэлийн үхэр өсгөн үржүүлэхээр Төмөрт Агро ХХК 200.0 сая/төг, Тэнүүн буянт ХХК 197.5 сая/төг, сүүний үхэр өсгөн үржүүлэхээр Рояал Алтай Констракшн ХХК 300.0 сая/төг, нийт 3 аж ахуйн нэгж 697.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. 2025 онд Засгийн 47 дугаар тогтоол Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд мах-сүүний чиглэлийн үхэр худалдан авах зориулалтаар 2 иргэнд 100.0 сая төгрөг, Өрхийн болон бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих сангаас тахианы аж ахуй эрхлэгч 1 иргэнд 100.0 сая төгрөг, Баян-Өндөр, Жаргалант сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас 4 хоршоонд 344.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	100
164	8.5.5.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаална.	2020-2025	ХБТХОХ, МЭГ	Орон нутгийн төсөв	46.4	105.0 мян толгой мал	118.1 мянган толгой мал вакцинд хамруулах	46.4	Орон нутгийн төсөв 169.6 Улсын төсөв 34.2	2023 онд Малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, иргэдийн 755 сорьцод мал эмнэлгийн ариун цэврийн магадлан шинжилгээ хийхэд 7 сорьц стандартын шаардлага хангаагүй тул худалдаалахыг хориглосон. Хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж байгаа мах, сүүний 123 сорьцод 4 төрлийн эмийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийхэд шаардлага хангаж байсан. Мал, амьтны архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 111.9 мянган толгой мал, гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 51.3 мянган толгой мал, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 102.4 мянган толгой бог мал хамруулсан. Төлөвлөгдөөгүй яаралтай дархлаажуулалтаар 102.4 мянган толгой малд вакцин хийсэн. Антибиотикийн үлдэгдлийг тодорхойлох магадлан шинжилгээнд 12 аж ахуйн нэгж (давхардсан тоогоор), 24 иргэн, 19 цэцэрлэг, 3	100

									<p>сургуулийн 155 дээж хамруулахад эмийн үлдэгдэл илрээгүй. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 2458 мал, амьтны сэг зэмийг устган 565.0 мянган м.кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийсэн. Тус ажилд орон нутгийн төсвөөс 14.3 сая төгрөг зарцуулсан.</p> <p>2024 онд мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 12 төрлийн дархлаажуулалтад 155.7 мянган толгой мал, амьтныг хамруулахаар төлөвлөн 146.5 мянган толгой мал, амьтныг хамруулж гүйцэтгэл 94.0 хувьтай хэрэгжсэн.</p> <p>Мал, амьтныг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шүлхий өвчний дархлаажуулалтад 28.7 мянган толгой үхэр, 259 толгой гахай, нийт 28.9 мянган толгой мал, амьтан хамруулж 92.0 хувь, бог малын мялзан өвчний дархлаажуулалтад 84.6 мянган толгой мал хамрагдаж 79 хувьтай хэрэгжсэн. Шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд мал угаалгад 88.0 мянган толгой мал, боловсруулалтад 60.0 мянган мал хамруулж, туулгалтад 62.4 мянган мал, нийт 210.5 мал хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн. 2024 онд өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас 5,285 толгой мал, амьтан зүй бусаар хорогдож, зэргэлдээх аймгийн мал нэмэгдэж нийт 5.4 мянган мал, амьтны сэг зэмийг цуглуулан зөөвөрлөж төвлөрсөн хогийн цэгт устгаж, ариутгал халдваргүйтгэлийг нийт 368.5 мянган мкв талбайд хийж, 100 хувь хэрэгжсэн. Мал эмнэлгийн газрын лабораторийн хүнсний чанар, аюулгүй байдлын шинжилгээнд давхардсан тоогоор 306 дээж хамруулахад 98 хувь нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийг хангасан байна.</p> <p>2025 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 12 төрлийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 163.1 мянган толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөж, 158.2 мянган толгой мал хамруулж 94.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Тус ажилд орон нутгийн төсвөөс 84.0 сая, улсын төсвөөс 88.7 сая, нийт 172.7 сая төгрөг зарцуулав. Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан орон нутгаас санхүүжүүлэх 4 төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 54.2 мянган толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөж 54.9 мянган толгой мал амьтан хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн. Орон нутгийн төсвөөс 84.0 сая төгрөг зарцуулсан. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шүлхий өвчний дархлаажуулалтад 35.8 мянган толгой мал, амьтан хамруулж гүйцэтгэл 96.4 хувь, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 25.1 мянган бог малын төл хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн. Тус ажилд улсын төсвөөс 44.5 сая төгрөг зарцуулсан. Энэ онд устгалын талбай болон бэлчээрийн, худаг уст цэгийн, зорь агуулах, нийтийн эзэмшлийн талбайн 570.0 мянган м/кв талбайд орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөг зарцуулан ариутгал, халдваргүйтгэл хийсэн.</p>	
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ									95.6	